

ISSN 2957-4285

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2024 №02 (89)
22 дахь жилдээ

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Пүрэвдорж БАТБААТАР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ, ЭМЕРИТ ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ, ЭМЕРИТ ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ХВАН И ГАБ

ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

Вандан-Иш АМАРСАНАА

ДОКТОР (Ph.D)

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Вандан-Иш АМАРСАНАА

ДОКТОР (Ph.D)

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Шаравдорж АРИУНБИЛЭГ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Лувсан БАТ-ОЧИР

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Сэнгээ ГАНТУЛГА

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Энхсайхан ДАШГААДАН

ДОКТОР (Ph.D)

Буриад ЛХАГВАРАГЧАА

ДОКТОР (Ph.D)

Амарсайхан МАНЛАЙ

ДОКТОР (Ph.D)

Жаргалсайхан МӨНХБОЛД

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бат-Ерөөл МӨНХДОРЖ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жутьяа НЯМДУЛАМ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Нямдорж ОДОНТУУЛ

ДОКТОР (Ph.D)

Шархүү ЧУЛУУНБАТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батзэвэг ЭНХБОЛД

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Дорж ЭНХТӨР

ДОКТОР (Ph.D)

ГАРЧИГ

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Гэм буруугийн андуурлыг хуульчлах шаардлага	<i>Б.Баярболд</i>	5
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал	<i>Б.Энэрэл</i>	14
Конфискация имущества как уголовно-правовая мера противодействия коррупции	<i>Е.К.Николаева</i>	25
КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Замын хөдөлгөөний зөрчилд хүлээлгэж буй хариуцлагын талаарх гадаадын зарим орны туршлага	<i>Б.Хулан</i>	29
Ransomware буюу цахим мэдээлэл барьцаалах гэмт явдлын талаарх ойлголт	<i>Б.Батцэрэн Б.Өүжин</i>	40
Сургуулийн орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг ба үе тэнгийн дээрэлхэлт	<i>Д.Отгонсүрэн</i>	50
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын стандартын харьцуулалт	<i>Г.Бямбадорж</i>	64
Согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн осол, хүлээлгэж буй хариуцлага, урьдчилан сэргийлэх арга зам	<i>О.Болорцэцэг</i>	75
Монгол Улс дахь ажилгүйдлийн индекс, өнөөгийн байдал	<i>У.Уранцэцэг</i>	85
ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөх арга зүй	<i>Д.Түвшинтөр</i>	91
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь мөрдөгчийн бие даасан байдлыг бэхжүүлэх нь	<i>Д.Бат-Эрдэнэ</i>	99
Хүнийг алах гэмт хэргийг гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдал, харьцуулсан судалгаа, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд шинжлэх ухааны ололтыг ашиглах нь	<i>Х.Батбаяр</i>	103
ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Үндсэн хуулийн хяналт ба хүний эрх	<i>Б.Наргулан</i>	110
СУДЛААЧДЫН ҮЗЭЛ БОДОЛ		
Шүүмжлэлт сэтгэлгээ ба боловсрол	<i>Л.Одзаяа</i>	117
Залуусын электрон тамхи (вэйп)-ны хэрэглээ, түүнд анхаарах зарим асуудал, эрх зүйн зохицуулалт	<i>Ц.Өнөболд</i>	124

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ГЭМ БУРУУГИЙН АНДУУРЛЫГ ХУУЛЬЧЛАХ ШААРДЛАГА

THE CRIMINAL LAW OF MISTAKE OF GUILTY

Б.Баярболд

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн
багш, цагдаагийн ахлах дэслэгч*

Товч агуулга: Гэм буруугийн андуурлын тухайн ойлголтыг Монгол Улсын хувьд Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд онолын үүднээс тодорхойлж судалж ирсэн боловч хуульд бие даасан зохицуулалт болгож тусгагдаагүй байдаг. Гэвч өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйлд гэм буруугийн андууралтай шууд хамааралтай зохицуулалт болох “Нөхцөл байдлыг буруугаар төсөөлж андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн” хэмээх хөнгөрүүлэх нөхцөл байдлыг тодорхойлсон байна. Энэ нь хууль хэрэглээний явцад эргэлзээ бүхий байдлыг бий болгох хэт ерөнхий ойлголт ба гадаадын эрүүгийн эрх зүй, хууль тогтоомжид гэм буруугийн андуурал гэх ойлголтыг хэрхэн тодорхойлж, хуульчилж ирсэн талаар судалж, өөрийн орны хөрсөнд хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлсэн болно.

Abstract: In Mongolia, the concept of mistake of guilt has been defined and studied from a theoretical point of view in the science of criminal law, but it has not been included in the law as an independent regulation. However, Article 6.5 of the Criminal Code, which is in force today, defines the mitigating circumstance of "committing a crime due to a mistaken perception of the situation" which is directly related to the mistake of guilt. It is an over-general concept that creates uncertainty in the process of applying the law, and how the concept of mistake of guilt has been defined and legislated in foreign criminal law and legislation, and it has sought opportunities to apply it in the country's soil.

Түлхүүр үгс: Гэм буруугийн андуурал, алдаа, олон улсын туршлага, гэм буруу.

Keywords: Mistakes of guilt, mistakes, international experience, guilt.

Гэм буруугийн андуурал нь гэмт хэрэг үйлдсэн этгээд нь өөрийн хийж буй үйлдэл, эс үйлдэхүй түүний хор аюулын бодит үр дагавар, нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, эрх зүйн учир холбогдлын талаар буруу ойлгож, төсөөлсөн сэтгэхүйн харьцааны талаар авч үздэг. Гэм буруугийн андуурлын талаар манай улсын Эрүүгийн хуульд тусгаагүй бөгөөд Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд онолын хувьд тодорхойлж судалдаг байхад гадаадын зарим улс орнууд өөрсдийн Эрүүгийн хуульд өөр өөр байдлаар хуульчилсан жижиг байна. Эдгээр жишгийг манай улсын эрүүгийн хуульд хуульчлах хэрэгцээ, шаардлага байгааг онолын үүднээс илүү нарийн судалж, гэм буруугийн андууралтай холбоотой заалтуудыг боловсронгуй болгож хуульчлах шаардлага үүсэж байна. Ингэснээр бодит байдлын андуурлын улмаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тохирсон эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, тухайн этгээдийн эрх зүйн байдлыг тодорхой түвшинд хангах боломжийг бий болгох юм.

Гэм буруугийн андуурлын түүхийн уламжлалыг авч үзэхдээ Монголын төдийгүй гадаад улсуудын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд андуурлыг хэрхэн тодорхойлж ирсэн талаар судлах нь зүй ёсны хэрэг юм. Аливаа эрх зүйг боловсронгуй болгоход, өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулан гадаад улсын эрх зүйн зохицуулалтын сайн туршлагыг судалгаа шинжилгээний үндсэн дээр туршин, хэрэгжүүлснээр шинэчлэлт, шинэлэг байдал бий болж, салбарын хөгжилд томоохон дэвшил болдог.

Монгол Улсын орчин үеийн эрүүгийн хууль тогтоомжид аливаа этгээд нь хууль зүйн андуурал гаргасны улмаас нийгэмд аюултай, үйлдэл, эс үйлдэл хийж, тулгарсан аюулыг арилгах, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх эсхүл эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх тухай шууд заасан заалд байхгүй билээ. Гэвч практикт манай улсын иргэдийн гэмт хэрэгт холбогдох, гэмт хэрэг үйлдэхэд хүргэж шалтгаануудын нэг нь яахын аргагүй нийгэмд аюултай үйлдлийг хийхдээ удаа дараа гэм буруугийн андуурал, алдааг гаргаж, улмаар эрүүгийн эрх зүйн харилцааны субъект болох тохиолдлууд цөөнгүй байна. Тухайн иргэний андуурч хийсэн алдаатай үйлдэл, эс үйлдэхүй нь субьектийн зүгээс гаргаж буй зүйлчлэлийн андуурал хэмээх онолын ойлголт даган гарч ирэх юм. Хууль мэдэхгүй нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй байх зарчмын дагуу хууль зүйн андуурал нь эрүүгийн хариуцлагыг бий болгодог.

Харин хүн бодит байдлыг андуурч, буруугаар төсөөлөн нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл хийсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх тухай шууд заасан заалт одоогийн эрүүгийн хуульд тусгагдсан ба энэ нь гэм буруугийн андуурлыг хуульд шууд тусгаж өгсөн, дэвшил боловч хэт ерөнхий зохицуулалт болсон учир дутагдалтай юм. Эрүүгийн эрх зүйн салбар хөгжихийн хэрээр, практикт тулгамдсан гэм буруугийн андууралтай холбоотой зохицуулагдаагүй харилцаа бүрийн онцлогоос хамаарч цаашид энэхүү заалд илүү боловсронгуй болох боломжтой юм.

Гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын хувьд хууль зүйн эсхүл бодит байдлын андуурлын улмаас, түүнд хандаж буй сэтгэхүйн харьцаа, учруулсан хохирол, хор уршиг, нийгмийн аюулаас нь шалтгаалан шударга ёсны зарчмыг удиртгал болгон ялыг ялгамжтай, тохирсон байдлаар оногдуулах зохицуулалт шаардлагатай юм. Мэдээж гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр үйлдэгддэг, тэр тусмаа андуурч үйлдэгдэх боломжгүй гэмт хэргүүдэд (өмчлөх эрхийн эсрэг, авлига албан тушаалын гэмт хэргүүдэд хамаарах гэмт хэргүүд г.м) хууль зүйн андуурлыг хэрэглэхгүй байхаар нарийвчилсан зохицуулалт шаардлагатай юм. Гэсэн хэдий өнөөдрийг хүртэл гэм буруугийн андуурал гэх онолын ойлголтын хэрэглээ зөвхөн онолын хүрээнд байсаар байх бөгөөд практик хэрэглэж чадахгүй байгаа шалтгаан нь тусгайлан хуульчилж өгөөгүй байгаатай шууд холбоотой билээ.

Манай орны хувьд гэм буруугийн андууралтай холбоотой хэд хэдэн түүхийн эх сурвалжууд байдаг ч энэ нь зөвхөн бодит байдлын андууралтай холбогдож байна. Тухайлбал, 1926 онд баталсан БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийн товчооны 3 дугаар бүлгийн /Ял үл хэлэлцэх/ 20 дугаар зүйлд зааснаар “Аливаа гэмт явдлыг үйлдэхдээ зориуд санаагүй эндэгдэн ташаарсан буюу, эцэстээ гэм гарахыг үл мэдсэн ба мэдсээр боловч зогсоохыг завдаж чадсангүй учир илэрвээс санаатайгаар үйлдсэн ёсоор яллаж үл болно. Хэрэв хууль цаазад тусгай заасан зүйл бий аваас түүнийг баримталж шийтгэвэл зохионо” гэж заасан байна¹. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээд хэргийн нөхцөл байдлыг буруугаар төсөөлснийг “эгнэгдэн ташаарсан” хэмээн үгсээр тодорхойлсон ба андуурч хийсэн

¹ Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011. 284 дэх тал.

үйлдлийг гэм буруугийн санаалтай хэлбэрээс ангид байлгаж, зөвхөн болгоомжгүй гэмт хэрэгт хамааруулсан байгаагаараа онцлогтой байна.

Харин 1929 онд баталсан БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийн товчооны 3 дугаар бүлгийн /Ял үл хэлэлцэх/ 21 дүгээр зүйлд зааснаар “аливаа гэмт явдал үйлдэхээр зориуд санаагүй адагтаа ташаарсан буюу эцэстээ гэм гарахыг үл мэдсэн ба мэдсэн боловч зогсоохыг завдаж чадаагүй учир илэрвээс санаатайгаар үйлдсэн ёсоор яллаж үл болмой. Хэрэв хууль цаазад тусгай заасан зүйл буй аваас түүнийг баримталж шийтгэвээс зохимой” хэмээн заасан байна. Энэ нь өөрөө гэм буруугийн болгоомжгүй хэлбэрийг хуульчилсан мэт боловч угтаа “Гэм буруугийн андуурлын” ойлголтыг агуулж байна гэж үзэж болох юм. Учир нь андуурал гэх үгийн утга нь өөрөө эндүү, ташаарал² гэх утгатай ба энэхүү заалт дээр “...гэмт явдал үйлдэхээр зориуд санаагүй адагтаа ташаарсан...” гэх утга нь андуурлын ойлголтыг илэрхийлж байгаа юм³. Хариуцлагын талаар уг заалтад санаатайгаар “...гэмт явдал үйлдсэн ёсоор яллаж үл болмой...” “Хэрэв хууль цаазад тусгай заасан зүйл буй аваас түүнийг баримталж шийтгэвээс зохимой” гэж заасан нь хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх нөхцөлийг үүсгэж байна гэж үзэж болох юм.

1934 онд баталсан БНМАУ-ын Эрүүгийн хуульд гэм буруугийн санаатай болон болгоомжгүй хэлбэрийг тусгайлан зааж өгч гагцхүү уг хоёр хэлбэрээр үйлдсэн этгээдүүдэд ял хэлэлцэнэ гэж заасан ба 1942, 1961, 1986 онуудад мөн адил заасан байна⁴. Үүнээс үзэхэд тухайн эрүүгийн хуулиудад гэм буруугийн андуурлыг гэм буруугийн болгоомжгүй хэлбэрт нэр мөр хамааруулан ойлгож, хуульчилж ирснийг анзаарч болохоор байна.

Нийгэм, цаг үе өөрчлөгдөхийн хэрээр манай орны эрүүгийн эрх зүйн зохицуулах харилцаа улам тэлж, практикт тулгарч буй тохиолдол, асуудлуудыг илүү нарийн зохицуулах шаардлага бий болсоор байгаа билээ. Үүний нэг илрэл нь 2002, 2015 оны эрүүгийн хуулийн шинэчлэлүүд юм.

2002 онд баталсан Монгол Улсын Эрүүгийн хуульд “Гэм буруу”-гийн ойлголтыг тусдаа бүлэг болгож, хор уршиг гэм буруугүйгээр учруулах тухай шинэ ойлголтыг тусгасан нь практикаас үүссэн дэвшилтэд зохицуулалт байсан юм. Гэвч гэм буруугийн андуурлын талаарх ойлголтыг мөн тодорхойлон зааж өгөөгүй байсан юм.

Харин 2015 онд баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуульд “Гэм буруугийн андуурал”-ын ойлголтыг тусгайлан зааж өгөөгүй. Гэвч Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйл буюу “Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал”-ын 1.6 дахь хэсэгт “Нөхцөл байдлыг буруугаар төсөөлж, андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн” гэх заалтыг шинээр нэмж оруулсан нь гэм буруугийн бодит байдлын андуурлыг илэрхийлсэн дэвшилт болсон юм. Гэвч уг заалт нь “нөхцөл байдал” гэх ойлголтоор хязгаарласан байгаа нь угтаа гэм буруугийн андуурлын ойлголтыг бүрэн гүйцэт илэрхийлж чадахгүй байгаа явдал юм.

Нөхцөл байдал гэдгийг Монгол хэлний их тайлбар тольд “тухайн юм, үйлийн үүсэх, хөгжих, оршин байх үеийн төлөв” гэж заасан байна. Мөн нөхцөл байдал гэх ойлголтод гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын нэмэгдэл шинж болох гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал хамаарах юм.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал гэж гэмт хэрэг үйлдсэн цаг үеийг тодорхойлох объектив нөхцөл байдал юм. Тухайлбал, дайны цаг буюу дайн бүхий

² Монгол хэлний их тайлбар толь (mongoltoli.mn).

³ Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011. 314 дэх тал.

⁴ Мөн тэнд. 467 дахь тал.

байдал, онцгой байдал зарласан үед гэмт хэрэг үйлдэх, нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулан гэмт хэрэг үйлдэх зэргийг ойлгоно⁵.

Үүнээс үзвэл гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал нь гэмт этгээд тодорхой цаг хугацаанд өөрийн үйлдэж буй гэмт хэргийн бодит байдлын мөн чанар, нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг буруугаар ойлгон төсөөлж үйлдсэн явдлаас ялимгүй ялгагдаж байна. Учир нь гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд хүн аливаа нөхцөл байдлыг далимдуулж гэмт хэрэг үйлдэх тухай ойлголт хамаарна. Энэ нь гэмт этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулыг, мөн, түүний улмаас учрах хохирол, хор уршгийг ухамсарлан, ойлгосон атлаа түүнийг хүсэж үйлдсэн байхыг илэрхийлэх бөгөөд тухайн үйлдлээ хийхдээ гагцхүү нөхцөл байдлыг л гэмт хэрэг үйлдэхэд тохиромжтой нөхцөл болгон ашигладаг онцлогтой.

Харин Эрүүгийн хуульд тусгагдсан “Нөхцөл байдлыг буруугаар төсөөлж, андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн” тухай заалтын агуулга дахь “нөхцөл байдал” гэх ойлголт нь гэм буруугийн андуурлын нэг төрөл болох бодит байдлын андуурлыг буюу субъектийн гэмт хэрэг үйлдэж эхлэхийн өмнөх шатанд бий болж буй нөхцөл байдлыг буруугаар төсөөлөн андуурч, улмаар гэмт хэрэг үйлдсэн тухай илэрхийлж байгааг тусгасан ойлголт болохоор байна.

Гэм буруугийн андуурлын асуудлыг манай Эрүүгийн хуульд хараахан хуульчилж өгөөгүй, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд онолын үүднээс тодорхойлж судалдаг бол зарим гадаад орнуудын Эрүүгийн хуульд хуульчилж өгсөн байна. Тухайлбал, АНУ-ын Нью-Йорк муж улсын Эрүүгийн хууль /15.205/, Франц Улсын Эрүүгийн хууль /122.3§/, Герман Улсын Эрүүгийн хууль /16-17§/, Испани Улсын Эрүүгийн хууль /14§/, Беларусь Улсын Эрүүгийн хууль, ОХУ-ийн Эрүүгийн хууль, Итали Улсын Эрүүгийн хууль зэргийг дурдаж болно.

Францын Эрүүгийн хуульд зөвхөн хууль цаазын андуурлыг хуульчилсан бол Германы Эрүүгийн хуульд гэм буруугийн андуурлын хоёр төрөл болох бодит байдлын болон хууль цаазын андуурлыг тусад нь хуульчилж өгчээ.

Дээрх орнуудын Эрүүгийн хуульд гэм буруугийн андуурлыг хуульчилсан хэм хэмжээг судалж үзэхэд андуурсан бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх буюу оногдуулах ялыг хөнгөрүүлэхээр заасан байна.

Францын Эрүүгийн хуулийн 122.3 дугаар зүйлд “Субъект үйлдэж байгаа хэргийнхээ хууль цаазын шинжийн талаар төөрөлдсөн, энэ хэргийг үйлдэх нь хуульд харш биш гэж бодсон бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө” хэмээн хуульчилсан нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдлийг хууль цаазын андуурал гаргаснаар хариуцлагаас боломжийг олгосон байна. Энэ нь маш ерөнхий зохицуулалт байх ба хуулийн урвуу байдлаар, өөрт ашигтайгаар шийдвэрлүүлэх, ял завших боломжийг олгох боломжтой юм.

Болгар улсын Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлд “Субъект гэмт хэргийн бүрэлдэхүүний элементүүдийн талаар мэдээгүй бол гэм буруугүйд тооцогдоно” гэж заасан байна. Болгар Улсын эрүүгийн эрх зүй нь ОХУ-ийн эрүүгийн эрх зүйтэй төсөөтэй бөгөөд энэ нь Зөвлөлт холбоот улсын бүрэлдэхүүнд багтдаг байсан нь судалгаа шинжилгээний эх сурвалж ижил байсантай холбоотой юм. Гэвч өнөөгийн ОХУ-ын Эрүүгийн хуулиас ялгагдах нэг зохицуулалт бол гэм буруугийн андуурлын талаарх зохицуулалт хэрэгжиж буй явдал юм. Өөрөөр хэлбэл гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив, эсхүл субъектив шинжүүдийн аль нэг шинжийг л мэдээгүй байсан нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болох нөхцөлийг ерөнхийлөн хуульчилсан байна.

1995 оны Испани Улсын Эрүүгийн хуульд хууль зүйн болон бодит байдлын андуурлын улмаас хийсэн үйлдлийг тусгайлан хуульчлах бус чухамхүү “Гэмт

⁵ Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. УБ., 2020. 227 дахь тал.

хэргийг үгүйсгэх нөхцөл байдал"-д хамааруулан зохицуулалт болгон тусгасан байна. "...Эрүүгийн эрх зүйн зөрчлийг бүрдүүлж буй үйлдэлд хамаарах арилгах боломжгүй алдаа нь тухайн хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно. Хэрэв гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлын хувьд алдааг арилгах боломжтой байсан тохиолдолд гэмт хэргийг болгоомжгүйгээр үйлдсэнд тооцож хариуцлага хүлээлгэнэ" хэмээн заасан байна.

Хүчин төгөлдөр үйлчилж буй Италийн Эрүүгийн хуульд мөн гэм буруугийн андуурлыг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд хэрэглэх байдлаар хуульчилсан байна. Тухайлбал, 59 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "...Хэрэв хүн ял оногдуулахгүй байх нөхцөл байдал бий болсон хэмээн андуурч, нийгэмд аюултай үйлдэл хийсэн бол тухайн нөхцөл байдлыг үргэлж түүний талд ашигтайгаар шийдвэрлэнэ. Хэрэв хүн хайхрамжгүй байдлын улмаас алдаа гаргасан бол тухайн үйлдсэн үйлдлийг болгоомжгүйгээр үйлдсэн хэмээн үзэх бөгөөд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй" хэмээн заасан байна. Үүнээс үзэхэд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын үед хүн бодит байдлыг андуурч гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөөр байна.

Харин Бүгд Найрамдах Беларусь Улсын Эрүүгийн хуульд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын үед гаргасан гэм буруугийн андуурлыг шууд хуульчилж өгсөн байна. Тухайлбал, 37 дугаар зүйлд гэм буруугийн андуурлыг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалтай уялдуулан хуульчлахдаа "...хүн өөрийгөө аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хохирол учруулах, баривчлах таслан зогсоох зорилгоор халдах нөхцөл байдалд байна хэмээн төөрөгдөлд орж, хохирол учруулах бодит нөхцөл байдал байхгүйг мэдэх ёсгүй, мэдэх боломжгүй байсны улмаас гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй" хэмээн хуульчилсан байна. Энэхүү зохицуулалтыг ОХУ-ийн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд онолын хувьд хүлээн зөвшөөрсөн байдаг.

Английн эрх зүйн сургаалд хэрэв субъект хууль бус зүйлийг хийхдээ бодит нөхцөл байдлыг мэдээгүйн, эсхүл түүний талаарх алдаатай төсөөллийн улмаас хийж буй зүйлээ хууль бус болохыг нь мэдээгүй тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хэмээн хариуцлага хүлээлгэхгүй хэмээн тодорхойлсон байдаг. Учир нь энэ тохиолдолд хүсэл зориг болон үйлдлийн байх ёстой нэгдэл байхгүй; хүсэл зоригийн гэмт үр дагаварт хандах харилцаа саармаг болж үлдэнэ" хэмээн үздэг. АНУ-ийн эрх зүй нь Английн эрх зүйгээс эх сурвалжтай бөгөөд АНУ-ийн 1962 оны Эрүүгийн хууль 2.04 заалтад эрх зүйн болон бодит байдлын андуурлын тухай асуудлыг анх хуульчилж байсан юм. Үүний агуулга нь "Хэрэв хүн аливаа гэмт хэргийн шинжтэй үйлдлийг хийхдээ бодит байдал, хууль зүйн андуурлын улмаас гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө, гэхдээ халдлагын заавал байх элемент болох гэм буруу байхгүй байхыг шаардана. Харин аргагүй хамгаалалтын хувьд тухайн хамгаалалтыг хийх үеийн хамгаалалт хийсэн хүний сэтгэл санааны байдлыг харгалзаж хариуцлагаас чөлөөлөх эсэхийг шийдвэрлэнэ" хэмээн хуульчилсан байна.

ОХУ-ийн Эрүүгийн хуульд мөн гэм буруугийн андуурлын талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Гэвч 1995 онд боловсруулсан ОХУ-ын Эрүүгийн хуулийн төслийн 29 дүгээр зүйлд андууралтай шууд холбогдох "Хэрэв субъект өөрийн хийх гэж байгаа болон хийж буй үйлдэл /эс үйлдэхүй/ нь ялын сүрдүүлэг дор эрүүгийн хуулиар хориглосон гэдгийг ухамсарлаагүй, хэрэг үйлдэх үеийн нөхцөл байдлаас шалтгаалж ингэж ухамсарлах /мэдэх/ боломжгүй байсан нь тогтоогдвол гэм буруугүй гэж үзэх бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээхгүй" гэсэн хэм хэмжээ хэлэлцэгдэж байсан боловч хууль тогтоогчдын дэмжлэг авч чадаагүй юм. Энэ нь агуулгаараа андуурлын тухай биш гэм буруугүйгээр хохирол учруулахтай холбоотой байсан нь харагдаж байна.

Гэвч зарим улсад, тухайлбал, Германы эрүүгийн хуульд андуурлын хоёр төрөл болох хууль зүйн болон хэргийн нөхцөл бодит байдлын андуурлыг тусад нь хоёр бие даасан хэм хэмжээнд хуульчилсан нь сонирхол татаж байна. Германы Эрүүгийн хууль 16, 17 дугаар зүйл "Хэрэв субъект хэрэг үйлдэх үеийн нөхцөл байдлын улмаас өөрийн хийж буй үйлдэл, гэмт хэрэг мөн эсэхийг мэдээгүй, мэдэх боломжгүй бол эрүүгийн хариуцлага хүлээхгүй", "Хэрэв субъект өөрийн үйлдлийг /эс үйлдэхүй/ гэмт хэрэг гэж бодсон боловч тэр нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг биш бол эрүүгийн хариуцлага хүлээхгүй", "Хэрэв субъект Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэх үедээ гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний объектив болон субъектив шинжүүд, хүндрүүлэх болон онц хүндрүүлэх нөхцөл байдлуудын талаар ташаарсан /андуурал/ бол андуурсан төсөөллийн хүрээнд андуурлын шинж, агуулга, хүрээ зэргийг тал бүрээс нь харгалзан эрүүгийн хариуцлагын асуудлыг шийдвэрлэнэ" хэмээн хуульчилсан байна.

Харин Монгол Улсын Эрүүгийн хуульд "Гэм буруугийн андуурал"-ын тухай ойлголтыг тусгайлан зааж өгөөгүй бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйл буюу "Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал"-д гэм буруугийн андуурлыг "Нөхцөл байдлыг буруугаар төсөөлж, андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн" хэмээн зөвхөн гэм буруугийн бодит байдлын андуурлыг тусгасан юм.

Гэвч уг заалт нь "нөхцөл байдал" гэх ойлголтоор хязгаарласан байгаа нь угтаа гэм буруугийн андуурлын ойлголтыг бүрэн гүйцэт илэрхийлж чадахгүй байгаа явдал юм. Учир нь "Нөхцөл байдлыг буруугаар төсөөлж, андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн" гэх заалтын байгаа "нөхцөл байдал" гэх ойлголт нь гэм буруугийн андуурлын нэг төрөл болох бодит байдлын андуурлыг буюу субъектийн гэмт хэрэг үйлдэж эхлэхийн өмнөх шатанд бий болсон, улмаар буруу төсөөлөл, андуурлын улмаас гэмт хэрэг үйлдэх ойлголт бөгөөд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх үндэслэл юм.

Дүгнэлт

1. Манай орны хувьд гэм буруугийн андуурлыг хамгийн анх 1926 онд баталсан БНМАУ-ын шүүх цаазын бичгийн ерөнхий ангийн товчооны 3 дугаар бүлгийн /Ял үл хэлэлцэх/ 20 дугаар зүйлд гэм буруугийн болгоомжгүй хэлбэрийн агуулгыг андууралтай холбож зааж өгсөн анхны заалт болсон юм. Түүнээс хойш 1929 онд баталсан БНМАУ-ын шүүх цаазын бичгийн ерөнхий ангийн товчооны 3 дугаар бүлгийн /Ял үл хэлэлцэх/ 21 дүгээр зүйлд мөн төсөөтэй агуулгаар хуульчилсан хэдий ч 1934, 1942, 1961, 1986, 2002 онуудад баталсан БНМАУ-ын болон Монгол улсын эрүүгийн хуулиудад гэм буруугийн андуурлыг тусгайлан зааж өгөөгүй ба гэмт хэргийг зөвхөн гэм буруугийн санаатай болон болгоомжгүй хэлбэрээр үйлдэх зохицуулалтыг оруулсан.

2. Харин 2015 онд баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуульд "Гэм буруугийн андуурал"-ын ойлголтыг тусгайлан зааж өгөөгүй. Гэвч Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйл буюу "Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал"-ын 1.6 дахь хэсэгт "Нөхцөл байдлыг буруугаар төсөөлж, андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн" гэх заалтыг шинээр нэмж оруулсан нь гэм буруугийн бодит байдлын андуурлыг илэрхийлсэн дэвшилт болсон юм. Гэвч энэхүү зохицуулалт нь ерөнхий буюу ганцхан тохиолдолд андуурах явдлыг зохицуулахаар зааж өгсөн нь маш учир дутагдалтай бөгөөд үүнийг хуульд илүү нарийвчилж гэм буруугийн андуурлын онолын ойлголтуудыг бүрэн илэрхийлсэн байдлаар тусгаж өгөхгүй бол хийдэл бий болох, гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа хүний эрх зүйн байдлыг дордуулах нөхцөл бүрдэх эрсдэл үүсэж байгаа юм.

3. Онолын хүрээнд гэм буруугийн андуурал нь “гэм буруу” гэх бие даасан институцээс үүдэн гарсан ойлголт бөгөөд түүхийн үе шатуудад гэм буруу гэх ойлголтод хамааруулж судалсаар ирсэн юм.

4. Гэм буруугийн андуурлын асуудлыг манай Эрүүгийн хуульд хараахан хуульчилж өгөөгүй, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд онолын үүднээс тодорхойлж судалдаг бол зарим гадаад орнуудын Эрүүгийн хуульд хуульчилж өгсөн байна. Тухайлбал, АНУ-ын Нью-Йорк муж улсын Эрүүгийн хууль /15.205/, Франц Улсын Эрүүгийн хууль /122.3§/, Герман Улсын Эрүүгийн хууль /16-17§/, Испани Улсын Эрүүгийн хууль /14§/, Беларусь Улсын Эрүүгийн хууль, ОХУ-ын Эрүүгийн хууль, Итали Улсын Эрүүгийн хууль зэргийг дурдаж болно.

5. Францын эрүүгийн хуульд зөвхөн хууль цаазын андуурлыг хуульчилсан бол Германы Эрүүгийн хуульд гэм буруугийн андуурлын хоёр төрөл болох бодит байдлын болон хууль цаазын андуурлыг тусад нь хуульчилж өгчээ.

6. Дээрх орнуудын Эрүүгийн хуульд гэм буруугийн андуурлыг хуульчилсан хэм хэмжээг судалж үзэхэд андуурсан бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх буюу оногдуулах ялыг хөнгөрүүлэхээр заасан байна. Дээрээс үзэхэд улс орон бүр гэм буруугийн андуурлыг өөр өөрсдийн байр сууринаас, практикт үндэслэн тайлбарлаж, хуульчилсан байна. Зарим улс орнуудад гэм буруугийн андуурлыг гэм буруу гэх институцийн бүрэлдэхүүнд хамааруулан судалж, хуульчилсан байхад, зарим нь гэм буруугийн андуурлыг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд хамаатуулан зохицуулж байгаа бөгөөд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх бие даасан үндэслэл болгон хуульчилсан онцлогууд ажиглагдаж байна.

Санал

Энэхүү өгүүллэгийн агуулгад тулгуулсан дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол улсын эрүүгийн хуулийн 2.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт шинээр “Гэм буруугийн андуурал” гэх заалтыг оруулах;

2. “Гэм буруугийн андуурал” заалтын 1 дэх хэсэгт “Хэрэв субъект хэрэг үйлдэх үеийн нөхцөл байдлын улмаас өөрийн хийж буй үйлдэл, гэмт хэрэг мөн эсэхийг мэдээгүй, мэдэх боломжгүй бол эрүүгийн хариуцлага хүлээхгүй” гэх заалтыг хуульчлах;

3. “Гэм буруугийн андуурал” заалтын 2 дахь хэсэгт “Хэрэв субъект Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэх үедээ гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний объектив болон субъектив шинжүүд, хүндрүүлэх болон онц хүндрүүлэх нөхцөл байдлуудын талаар ташаарсан (андуурсан) бол андуурсан төсөөллийн хүрээнд андуурлын шинж, агуулга, хүрээ зэргийг тал бүрээс нь харгалзан, эрүүгийн хариуцлагын асуудлыг шийдвэрлэнэ” гэх заалтыг хуульчлах;

4. Эрүүгийн хуулийн 4 дүгээр бүлэг (Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал)-ийн 4.7 дугаар зүйлд “Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын андуурал” гэх заалтыг нэмэлтээр оруулах;

5. “Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын андуурал” заалтын 1 дэх хэсэгт “Хүн өөрийгөө аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хохирол учруулах нөхцөлд байна хэмээн төөрөгдөлд орж, хохирол учруулах бодит нөхцөл байдал байхгүйг мэдэх ёсгүй, мэдэх боломжгүй байсны улмаас гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэх заалтыг нэмэлтээр хуульчлах шаардлагатай байна хэмээн үзэж байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011.

2. Монгол хэлний их тайлбар толь (mongoltoli.mn).
3. Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. Уб., 2020.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

DOMESTIC VIOLENCE OFFENCES LEGAL REGULATION AND CHALLENGES

*Б.Энэрэл
ДХИС-ийн докторант*

Товч агуулга: Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн хамгийн том зөрчлийн нэг төдийгүй Монгол Улсад ойролцоогоор таван эмэгтэй тутмын нэг нь нөхөр, хамтран амьдрагчийн зүгээс үйлдсэн бие махбод болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн судалгаа гарсан. Хэдийгээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2015 оны Эрүүгийн хууль үйлчилж эхлэн нэлээдгүй хугацаа өнгөрсөн, нуугдмал хэлбэртэй, давтагдаж, даамжирч байдаг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн илрүүлэлт шийдвэрлэлт нэмэгдэж байгаа боловч хохирогчийн хувьд асар их хор хөнөөлтэй, сэтгэл зүйн үр дагавартай байдаг гэмт хэрэгт учирсан хохирол, хор уршгийг бүрэн тодорхойлж чаддаггүй, хууль хэрэглээний хувьд зөрүүтэй тодорхойгүй нөхцөл байдлууд үүсдэг, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгахад учирдаг хүндрэл бэрхшээл их, хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоо муутай байгааг үгүйсгэх аргагүй байна.

Иймд энэхүү өгүүлэлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн нөхцөл байдал, хохирогчид учирч буй хохирол хор уршиг, хууль тогтоомжийн зохицуулалт, тухайн төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхэд учирч буй хүндрэл, бэрхшээлийг судалж, шийдвэрлэх арга замын талаар санал дэвшүүлсэн.

Abstract: domestic violence is one of the largest human rights violations, and approximately one in five women in Mongolia have experienced physical or emotional violence committed by a husband or partner. Although the domestic violence law and the Criminal Law of 2015 have been in effect for some time, the detection and resolution of domestic violence crimes, which are hidden, repeated and progressive, is increasing, but the damage and harm caused by crimes that have devastating and psychological consequences for the victim cannot be fully determined, there are uncertain situations in the application of the law, there are many difficulties in the investigation of this type of crime, poor coordination is undeniable.

Therefore, as a researcher, this article aims to provide readers with insights into the circumstances of the crime of “domestic violence”, the consequences of harm to victims, legislative regulation, and the difficulties of solving such crimes.

Түлхүүр үгс: Бие махбодын хүчирхийлэл, гэр бүл, сэтгэл санааны хүчирхийлэл, хохирол, хор уршиг, хуваарьт хөрөнгө, хүчирхийллийн хэлбэр.

Keywords: Physical violence, family, emotional violence, damage, harm, scheduled funds, forms of violence.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.11-д ..“Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ”⁶ гэж заасан. Гэвч өнөөдөр Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэл ихээр үйлдэгдэх болж нөхөр нь эхнэр, хүүхэд ээ зодсон, хүчирхийлсэн, сэтгэл санааны дарамтад оруулсан зэрэг нийгмийн сөрөг үзэгдэл

⁶ Монгол Улсын Үндсэн хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 1992. №1. 16.11 дүгээр зүйл.

гарах болж Монгол Улсын Үндсэн хуульд заасан гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй гэсэн заалтыг зөрчиж гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүс бие биеэ сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн зэрэг төрөл бүрийн хүчирхийлэлд оруулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль: Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд (эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр) энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ⁷ гэсэн бол судлаач Г.Бямбадорж: Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан эсвэл учруулахаар заналхийлсэн үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ гэсэн байна⁸. Бидний үзэж байгаагаар гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн хэн нэгний эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг сэтгэл санаанд нь дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдаж хохирол, хор уршиг учруулсан үйлдлийг хэлнэ гэж үзэж байна.

Дээрх тодорхойлолтоос үзэхэд, гэр бүлийн хүчирхийлэл нь гэмт хэргийн шинжийг агуулж байгаа нь харагдаж байна. Учир нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5-р зүйлд гэмт хэргийн хохирол, хор уршиг хуульчилж⁹ өгсөн бөгөөд тухайн хохирол хор уршигийг учруулахдаа нэг удаагийн эсхүл үргэлжилсэн үйлдлээр хохирол, хор уршигт санаатай учруулдаг. Тиймээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг эрүүгийн эрх зүйн талаас нь дэлгэрүүлэн авч үзэх шаардлага үүнээс үүдэн гарч байна.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх асуудлыг ялган зааглаж, зөв томьёолж чадаагүйгээс болж мөрдөгч, прокурор, шүүх хуулийн агуулгыг янз бүрээр тайлбарлаж шийдвэр гаргахад хүргэсэн. Гэр бүлийн хүчирхийлэл нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хэм хэмжээгээр зохицуулагддаг. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол гэмт хэрэг, эсхүл зөрчил гэж үзэхэд хүндрэл үүсгэсэн. Ганцхан зааглаж буй томьёолол нь “байнга” гэх шинж. Үүнийг хэрхэн ойлгох бэ?

Академич С.Нарангэрэл “...янз бүрийн объектив болон субъектив нөхцөл байдалд цаг хугацааны нэлээд завсарлагатайгаар нэг гэмт хэргийг хоёроос дээш удаа үйлдэх нь гэм буруутай этгээдийн үйлдлийг байнга гэж үзэх үндэс болохгүй. Байнга гэдэг бол гэмт хэрэг үйлдэх явдал үе үе давтагдаж, тэдгээрийн хоорондын зай их бишийг харуулан гэм буруутай этгээдийн зан үйлийн тодорхой чиглэл илэрсэн, гэмт хэрэг давтан үйлдэх явдал юм. Гурав буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдэх нь байнга гэсэн ухагдахууны зайлшгүй тоон үзүүлэлт мөн” гэж тодорхойлсон бол профессор С.Жанцан “...нэг этгээд нэлээн үргэлжилсэн хугацаанд нэг гэмт хэргийг дөрөв ба түүнээс дээш удаа үйлдэж, тэдгээрийн алинд

⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №5. 5 дугаар зүйл.

⁸ Бямбадорж Г. Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал. УБ., 2014. 35 дахь тал.

⁹ Гэмт хэргийн хохирол нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

нь ч шийтгэгдээгүй бөгөөд энэ нь түүний гэмт зан төлөвийн тогтсон хандлагыг илэрхийлсэн байхыг гэмт хэргийг байнга үйлдэх гэнэ” гэж тодорхойлсон.

Дээрхээс дүгнэж үзэхэд, “байнга гэмт хэрэг үйлдэх” гэх ойлголт нь доорх шинжүүдийг агуулдаг байна. Үүнд:

- Нэг гэмт хэргийг тодорхой хугацааны завсарлагатайгаар гурав ба түүнээс дээш удаа үйлдсэн байх;

- Тэдгээрийн алинд ч ял шийтгүүлээгүй байх;

- Гэмт хэрэг үйлдсэн хүний гэмт зан төлөвийн илрэл бөгөөд энэ нь амьдралд хэвшиж тогтсон дадал зуршил гэсэн шинжийг агуулж байна.

Гэтэл Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн дээрх хэм хэмжээний ялгамжгүй байдлаас үүдэж гэмт хэрэг, зөрчлийн бүрэлдэхүүний шинжийг мөрдөгч, прокурор, шүүх тодорхойлох боломжгүй болсон. Өөрөөр хэлбэл гэр бүлийн хамаарал бүхий харилцаа хүнийг 1 юм уу 2 удаа зодсон, эсхүл 3 удаа зодсон байлаа ч 1 удаагийн үйлдэлд нь Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулсан бол гэмт хэрэг биш гэж шийдвэрлэсээр байна. Учир нь Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулсан үйлдэлд Эрүүгийн хуулийн дагуу ял оногдуулах нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан “*нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна*” гэсэн шударга ёсны зарчимтай харшлах юм гэж үзсэн байна.¹⁵

Дээрхээс үзвэл хохирогч 3 болон түүнээс дээш гэр бүлийн хүчирхийлэлд өртсөний дараа гомдол, мэдээлэл гаргасан тохиолдолд гэмт хэрэг, тухай бүр гомдол, мэдээлэл гаргасан тохиолдолд зөрчил гэж шийдвэрлэгдэх нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндсэн зорилгод нийцэхгүй гэж дүгнэхээр байна. Үүнтэй холбоотойгоор нэг талаас гэр бүлийн хүчирхийлэл өртсөн хүн хохирдог, нөгөө талаас гэмт хэрэг үйлдсэн хүн ял завших нөхцөл байдал үүсэхээр байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7-р зүйлд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг хуульчилсан бөгөөд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан үйлдлүүд хамаардаг¹⁰.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг гэдэг нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдал, гэр бүлийн ашиг сонирхолд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм¹¹ гэж тодорхойлсон байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь Эрүүгийн хуульд зайлшгүй байвал зохих нийгэмд аюултай үйлдэл эс үйлдэхүй, хор уршиг учруулдаг үйлдэл, эс үйлдэхүй байх шинжээрээ гэмт хэргийн шинжийг агуулж байгаа юм. 2015 онд батлагдсан Монгол Улсын эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх үйлдлийг гэмт хэрэгт тооцож гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш байх эрхийг эрүүгийн хууль тогтоомжоороо хамгаалсан юм.

Тэгвэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шинжээр нь авч үзвэл дараах үндсэн шинжтэй. Үүнд:

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн объект нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдал, гэр бүлийн ашиг сонирхол байна. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдал, гэр бүлийн ашиг сонирхлыг Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд: “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй¹²,” Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13-д Халдашгүй чөлөөтэй

¹⁰ Эрүүгийн хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2016. №7. 11.7 дугаар зүйл.

¹¹ Гантулга С., Энхболд Б. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Уб., 2018. 47 дахь тал.

¹² Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 3 дугаар зүйл.

байх., 11-д Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална,¹³ гэж тус тус гэр бүлийн хамаарал бүхий хүний эрх, ашиг сонирхлыг баталгаажуулж өгсөн.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн объектив тал нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, байнга харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, байнга хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах, эрхэд халдсан идэвхтэй үйлдэл байна¹⁴.

Объектив талын үндсэн шинж нь байнга гэсэн шинжийг агуулж байх ёстой бөгөөд Эрүүгийн хуульд байнга гэдгийг хэдэн удаагаар ойлгохыг тайлбарласан эрүүгийн хуулиар зохицуулсан ойлголт байхгүй байна. Практикт байнга гэдгийг өмнөх 2002 оны Эрүүгийн хуулийн 100 дугаар зүйлд “Тарчлаах” гэмт хэргийн тайлбараар ойлгож хэрэглэж байна. Өмнөх хуулийн тайлбарт “байнга” гэдгийг 3 буюу түүнээс дээш удаа үйлдсэн тохиолдлыг ойлгож байсан. Харин 2015 оны Эрүүгийн хуульд тийм зохицуулалт байхгүй.

Практикт ажиллаж буй алба хаагчдаас авсан судалгааны үр дүнгээс үзэхэд 6.7 хувь нь хууль эрх зүйн орчин боловсронгуй бус гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд Эрүүгийн хуулийн 11.7-р зүйлийн тайлбар хэсэгт “Байнга” гэсэн нэр томьёог тайлбарлах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Мөн Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн нэр томьёоны тайлбарын хувьд албан ёсны Дээд шүүхийн тайлбар гараагүй байгаа учир эрдэмтэн, судлаачид янз бүрийн утгаар ойлгох, тайлбарлах тохиолдол гараад байна. Тиймээс албан ёсны дээд шүүхийн тайлбарыг гаргах шаардлагатай.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь халдлагад өртөгч (хохилогч)-ийн эрүүл мэндэд хохирол учирсан байхыг шаардахгүй, гэр бүлийн хүчирхийлэл байнга үйлдсэнээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн субъектив тал нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн нийгэмд аюултай шинж чанарыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн¹⁵ байна. Субъектив талын нэмэгдэл шинж болох гэмт хэрэг үйлдсэн сэдэлт, зорилго, гэмт хэрэг үйлдэх үеийн сэтгэл санааны байдлыг Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хуульчлаагүй тул гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй. Энэ төрлийн гэмт хэрэг ямар ч сэдэлт, зорилгоор үйлдэгдэж болох юм.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн субъект нь Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн байна. Хэрэв гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн субъект нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн биш танихгүй хүн хүчирхийлэл үйлдвэл гэмт хэргийн субъект үгүйсгэдэг нь тиймээс энэ төрлийн гэмт хэргийг зүйлчлэх, нотлоход гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай эсэхийг анхаарах хэрэгтэй. Харин 11.7 дугаар зүйлийн 2 дах хэсэгт таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн тохиолдолд хүндрүүлэх шинжээр хуульчилсан.

Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн харилцаан дахь дарамт, шахалт үзүүлэх, зодох занчих, айлгах зэрэг хэлбэрээр үйлдэгдэж буй хүчирхийлэл нь хүний өөрийн үнэлэмжийг бууруулж, улмаар хүчирхийлэлд өртөгч хүчирхийллийн шалтгааныг өөрөөсөө хайн эцэст нь амьдралынх нь хэвийн үзэгдэл болтлоо дасан зохицдог байна. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нь хүчирхийлэл

¹³ Монгол Улсын Үндсэн хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 1992. №1. 16.11, 16.13 дахь хэсэг.

¹⁴ Гантулга С., Энхболд Б. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. УБ., 2018. 48 дахь тал.

¹⁵ Эрүүгийн хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2016. №7. 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

үйлдэгчээс хэт болгоомжлох, аргадах, уучлах, айж ичсэний улмаас тухайн нөхцөл байдлыг хууль хяналтын байгууллагад мэдээлэхгүй байх нь олонтоо байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэл нь хэдэн хэдэн төрөл байх бөгөөд түүнийг судлаачид сэтгэл санааны, бие махбодын, бэлгийн, эдийн засгийн гэсэн дөрвөн төрөлд хуваан авч үзсэн. Сэтгэл санааны хүчирхийлэл гэдэг нь хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг хэлнэ.¹⁶ Бие махбодын хүчирхийлэл гэдэг нь хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.¹⁷ Эдийн засгийн хүчирхийлэл гэдэг нь хүнийг цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсныг хэлнэ. Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг хэлдэг.¹⁸

Дээрх гэр бүлийн хүчирхийллийн төрөлд өртсөн хохирогчид өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлж чадахгүй байх тохиолдол гардаг. Тухайлбал сэтгэл санааны удаан хугацааны дарамтад байсны улмаас сэтгэл санаанд учирсан хохирлоо нөхөн төлүүлж чадахгүй байх тохиолдол гарч байна. Харин Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.1-р зүйлд хохирогч гэж гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хэлнэ гэж заасан байна.¹⁹

Эд хөрөнгийн бус хохирол нь (материаллаг бус) нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, сэтгэл санааны хүчтэй дарамтад байлгасны улмаас сэтгэл санааны зовуурь шаналал үүсэх зэрэг эд хөрөнгийн шинжгүй мөнгөөр илэрхийлдэггүй сэтгэл санааны үр дагаврыг ойлгоно.²⁰ Нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа, нь эдийн засгийн эргэлтэд арилжааны зүйл болдоггүй ба эдийн бус хохиролд хамаарна. Энэ хохирлын хэмжээг хэрхэн яаж тооцож, барагдуулах талаар эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн улмаас хохирсон иргэд өөрт учирсан хохирлоо бодитой, бүрэн дүүрэн төлүүлэх эрхээ эдэлж чадахгүй, хохирсоор байна.

Шүүхийн практикт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлаж байгаа тул эмчилгээний зардал, оршуулгын зардал, тээврийн зардлын баримт, түүнчлэн аймаг дүүргийн засаг даргын тамгын газрын санхүүгийн хэлтсийн үнэлгээний комиссын үнэлгээ зэргийг харгалзан хохирлыг тогтоож, нөхөн төлүүлэх шийдвэрийг гаргаж байна. Өөрөөр хэлбэл энэхүү зардалд эд хөрөнгийн хохирол хамаарах бөгөөд эдийн бус хохирол тооцогдохгүй орхигддог. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.2 дугаар зүйлд хохирогч нь гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах эрхтэй гэж заасан

¹⁶ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №5. 6 дугаар зүйл.

¹⁷ Мөн тэнд. 6 дугаар зүйл.

¹⁸ Мөн тэнд. 6 дугаар зүйл.

¹⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №23. 8.1 дүгээр зүйл.

²⁰ Доржпалам Х. Иргэний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. УБ., 2012. 117 дахь тал.

байдаг. Гэтэл хохирогч энэхүү эрхээ эдэлж чадахгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаагийн илэрхийлэл юм.

Практикт ажиллаж буй алба хаагчдаас авсан судалгааны үр дүнгээс үзэхэд 6.7 хувь нь хууль эрх зүйн орчин боловсронгуй бус гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэтгэл санаанд учирсан хохирлыг тогтооход баримтлах аргачлалыг бий болгох шаардлагатай юм.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн бүртгэгдсэн статистик судалгаанаас үзвэл, Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2017 онд 223, 2018 онд 210, 2019 онд 281, 2020 оны 11 сарын байдлаар 100 гэмт хэрэг бүртгэгдсэн²¹. Үүнд үндэслэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг мөрдөх онцлог, гарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох хэрэгтэй юм.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг мөрдөх онцлогт тухайн гэмт хэрэг нь ахуйн хүрээнд гэр бүлийн харилцааны явцад үйлддэг тул нуугдмал байдалтай байдаг.

- Хохирогч, холбогдогч этгээдүүд мөрдөн шалгах ажиллагааны явцад хоорондоо эвлэрч хохирогч анх өгсөн мэдүүлгээсээ буцах тохиолдол их гарч хэрэг мөрдөх хугацааг удаашруулдаг.

- Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүсийн хооронд үйлдэгддэг.
- Архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэр бүлийн үл ялих маргаанаас болж хоорондоо маргалдаж гэр бүлийн хүчирхийлэл үүсэж хохирогчийг хамгаалалтад аваагүй нь улмаас хохирогч, холбогдогч нар хамт амьдардаг зэрэг онцлог байдлууд үүсдэг.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг мөрдөхөд дараах хүндрэл бэрхшээлүүд үүсдэг. Тухайлбал алба хаагчдаас авсан судалгааны үр дүнгээс үзэхэд 46.7 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг шалгахад оролцогчдын эрх ашиг, сонирхол гэр бүлийн харилцаа, тэдний үр хүүхдүүд хохирдог учир хүндрэлтэй гэж хариулсан бол 13.3 хувь нь гэмт хэрэг мөрдөх техник технологийн хүрэлцээ муу, гэр бүлийн харилцаа, сэтгэл зүйн асуудал хүндрэл үүсгэдэг гэсэн бол 6.7 хувь нь хууль эрх зүйн орчин боловсронгуй бус, ажлын ачаалал их гэж тус тус хариулсан байна.

Дээр дурдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар арга замыг ашиглах вэ гэсэн асуултад 40 хувь нь сэтгэл зүй, гэр бүлийн харилцааны чиглэлээр мөрдөгчийг бэлтгэх, 26.7 хувь нь эрх зүйн орчныг сайжруулах (эрүүгийн болон эрүүгийн процессын хууль) 13.3 хүний нөөцийг чадавхжуулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх гэж тус тус хариулсан нь судалгааны үр дүнгээс харагдсан.

Хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор сэтгэл зүй, гэр бүлийн харилцааны чиглэлээр мэргэшсэн мөрдөгчийг практикт ажиллуулах шаардлагатай юу гэсэн асуултад 73.3 хувь шаардлагатай, 4 хувь нэн шаардлагатай гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд практикт ажиллаж буй алба хаагчид гэр бүл, сэтгэл зүйн чиглэлээр мэргэшсэн мөрдөгчийг ажиллуулах зорилгоор ДХИС-н Цагдаагийн сургуулийн 1+1 хөтөлбөрт сургаж хүний нөөцийг чадавхжуулах бэлтгэх хүсэлтэй байгаа нь ажиглагдсан.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд гэрч, хохирогч, холбогдогчийн мэдүүлэг зонхилж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан. Тухайлбал алба хаагчдаас авсан судалгааны үр дүнд 66.6 хувь нь мөрдөн шалгах ажиллагаанд хамгийн түгээмэл хийдэг ажиллагаа нь гэрч, хохирогч, холбогдогчоос мэдүүлэг авах гэж хариулсан байна. Харин Эрүүгийн

21

<http://information.police.gov.mn/resource/information/File/2020/12/04/8nqjonzvцу9v2zq1/gemt%20he reg.pdf>.

хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.3 дугаар зүйлийн 2 дах хэсэгт "...сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлгийг нотлох баримтаар тооцох боловч уг мэдүүлэг дангаараа түүнийг яллах үндэслэл болохгүй"²². Мөн хуулийн 16.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "...мэдүүлэг өгөгч мэдүүлгийнхээ эх сурвалжийг зааж чадаагүй бол тухайн мэдүүлэг нь дангаараа нотлох баримт болохгүй гэж тус тус хуульчилсан. Тиймээс мөрдөгч нар мэдүүлэгт суурилсан мөрдөх ажиллагаа зонхилж байгаа нь хэргийн илрүүлэлт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын чанар, үр дүнд нөлөөлж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдох гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа нь тухай төрлийн гэмт хэргийн криминалистик шинжээс хамаарч бусад гэмт хэрэг мөрдөх арга зүйн зөвлөмжөөс өвөрмөц онцлогтой байна. Тухайлбал: - гэмт хэргийн мэдээлэл нуугдмал, -хохирогчийн хувийн байдал харилцан адилгүй, -сэжигтэн, яллагдагчийн хувийн байдал мөн өвөрмөц, -гэмт хэрэг үйлдэгддэг нөхцөл байдал, цаг хугацаа, газар онцлогтой, -гэмт үйлдлээ нуун далдлах нөхцөл байдал бүрддэг зэргээс хамаарч мөрдөн шалгах ажиллагаанд харилцан адилгүй таамаглал дэвшүүлэх үндэслэл болдог. Ялангуяа энэ төрлийн гэмт хэргийн хувьд хохирогчийн хувийн байдал, түүний буруутай буюу гэмт хэрэг үйлдэх нөхцөл байдлыг үүсгэж байдаг нөхцөл нь тодорхой хэмжээнд нөлөөлж байдгийг мөрдөн шалгах ажиллагааны явцад анхаарах зүйн шаардлага бий.

Таамаглал дэвшүүлэх дээ "хохирогчийн буруутай эсэх, гэмт хэрэг үйлдэхэд өдөөн турхирсан эсэх", "өмчийн болон бусад /сэтгэц, эмгэг байдал/ төрлийн маргаантай эсэх", "сэжигтэн, яллагдагчийн буруу, гаж зуршил, сэтгэцийн болон бусад тулгамдсан асуудал" гэх зэргээр нийгмийн амьдралд түгээмэл тохиолдох хийгээд гэр бүлийн харилцаанд гарч байдаг таагүй нөхцөл байдлыг таамаглан, нарийвчлан судлах шаардлага гомдол, мэдээлэл шалгах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад үүснэ. Энэ нь хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь судлан, бодит байдлыг тогтоох үндэс болох юм.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэр бүл салалт, түүнээс улбаалан хүүхдийн өнчрөл, хараа хяналтгүй хүүхдийн тоо олшрох зэрэг нийгэмд сөрөг үр дагавар бий болдог.

Үүнээс үзвэл гэр бүлийн хүчирхийлэл гарч байгаа нийтлэг шалтгаан нь архидалт, ядуурал, ажилгүйдэл, хууран мэхлэлт зэрэг шалтгаанаас үүдэлтэй. Тухайлбал архидалтын улмаас 42%, ядуурлын улмаас 30%, ажилгүйдлийн улмаас 20%, хууран мэхлэлт, хардалтын улмаас 8% нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг гарсан байна²³. Гэр бүлийн хүчирхийллийн учир шалтгааныг иргэд "Хүчирхийлэгч" этгээд өөрийнхөө зан, ааш авирыг хянаж чадаагүйд, оршдог гэж буруугаар ойлгодог нь элбэг. Баримтаас үзэхэд, гэр бүлийн хүчирхийлэгч этгээд нь бусдыг эрхшээлдээ оруулах хүсэлдээ автсан байдаг нь илт байдаг. Хүчирхийлэлд өртсөн хохирогч нарт сэтгэл зүйн болон эмнэлгийн анхан шатны тусламжийг үзүүлж, иргэнийг хэвийн амьдралд нь оруулж, сэтгэл зүйн, бие бялдрын хувьд эрүүл, өөртөө итгэлтэй, дахин ажиллаж амьдрах итгэлтэй болгох шаардлагатай байна.

Дүгнэлт

1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хувьд гэмт хэргийн шинж болох объект, объектив тал, субъект, субъектив тал зэрэг 4 шинжийг агуулсан нийгэмд аюултай, хохирол, хор уршиг учруулдаг

²² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №23. 16.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

²³ Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн байдал. УБ., 2019.

үйлдэл юм. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шинжийн объектив талын шинжид “байнга” гэдгийг тайлбарласан албан ёсны тодорхойлолт байхгүй учраас практикт хүндрэл тохиолдож байгаа нь судалгаагаар ажиглагдсан.

2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч нар сэтгэл зүйн, бие махбод, эдийн засгийн, бэлгийн зэрэг хохиролд өртөж байна. Бие махбодын болон эдийн засаг хохиролд өртсөн тохиолдолд эд зүйлийн үнэлгээ болон гэмтлийн зэрэг тогтоолгож өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх боломжтой бөгөөд харин сэтгэл санааны хохиролд өртсөн тохиолдолд түүнийгээ нөхөн төлүүлж чадахгүй хохирсон хэвээр үлддэг. Учир Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2-р зүйлд хохирогч нь гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх эрхтэй гэж заасан байдаг. Харин сэтгэл санааны хохиролд өртсөн тохиолдолд энэхүү эрхээ эдэлж чадахгүй байна.

3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг мөрдөхөд дараах хүндрэл бэрхшээлүүд үүсэж байна. Тухайлбал алба хаагчдаас авсан судалгааны үр дүнгээс үзэхэд 46.7 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг шалгахад оролцогчдын эрх ашиг, сонирхол гэр бүлийн харилцаа, тэдний үр хүүхдүүд хохирдог учир хүндрэлтэй гэж хариулсан бол 13.3 хувь нь гэмт хэрэг мөрдөх техник технологийн хүрэлцээ муу, гэр бүлийн харилцаа, сэтгэл зүйн асуудал хүндрэл үүсгэдэг гэсэн бол 6.7 хувь нь хууль эрх зүйн орчин боловсронгуй бус, ажлын ачаалал их гэж тус тус хариулсан.

4. Хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор сэтгэл зүй, гэр бүлийн харилцааны чиглэлээр мэргэшсэн мөрдөгчийг практикт ажиллуулах шаардлагатай юу гэсэн асуултад 73.3 хувь шаардлагатай, 4 хувь нэн шаардлагатай гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд практикт ажиллаж буй алба хаагчид гэр бүл, сэтгэл зүйн чиглэлээр мэргэшсэн мөрдөгчийг ажиллуулах зорилгоор ДХИС-н Цагдаагийн сургуулийн 1*1 хөтөлбөрт сургаж хүний нөөцийг чадавхжуулах бэлтгэх хүсэлтэй байгаа нь ажиглагдсан.

5. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд гэрч, хохирогч, холбогдогчийн мэдүүлэг зонхилж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан. Тухайлбал алба хаагчдаас авсан судалгааны үр дүнд 66.6 хувь нь мөрдөн шалгах ажиллагаанд хамгийн түгээмэл хийдэг ажиллагаа нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах гэж хариулсан байна. Тиймээс мөрдөн шалгах ажиллагаанд орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх шаардлага үүсэж байна.

Санал

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр:

1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн тайлбар хэсэгт “Байнга” гэдгийг тайлбарлах. Учир нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан гэдгийг яг хэдэн удаа үйлдсэн бол байнга үйлдсэнд тооцож байгааг тайлбарласан хуулийн зохицуулалт байхгүй байна. 2002 оны Эрүүгийн тусгай ангийн 100-р зүйлд заасан Тарчлаах гэмт хэргийн тайлбар нь “3 буюу түүнээс дээш удаа үйлдсэн тохиолдолд”²⁴ байнга гэдгийг тайлбарласан. Тиймээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7-р зүйлийн тайлбар хэсэгт “Байнга гэж 3 буюу түүнээс дээш удаа үйлдсэнийг” ойлгоно гэж зохицуулах.

2. Гэр бүлийн хүчирхийлэл өртсөн хохирогчдын Олон улсын өвчний Х ангиллыг баримтлан гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэл зүйн (эдийн бус) хохирлын хэмжээг тогтоох аргачлалыг бий болгох талаар “Шүүхийн

²⁴ Эрүүгийн хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2002. №5. 100 дугаар зүйл.

Шинжилгээний тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шинжилгээ хийх журмыг шинжилгээний төрлөөс хамааран хууль зүйн, эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэснийг үндэслэн хохирогчийн эдийн бус /сэтгэл зүйн/ хохирлыг тогтоох талаар аргачлалыг боловсруулах. Эдийн бус хохирлыг тогтоох аргачлалд дараах зүйлсийг тусгах. Үүнд:

- Сэжигтэн, яллагдагчийн гэмт үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ;
- Хохирол учирсан этгээдийн хувийн онцлогтой холбоотой бие махбодын болоод сэтгэл санааны зовлон, зовуурь, шаналлын (хор уршиг) хэмжээ;
- Бодит нөхцөл байдал болон хохирогчийн хувийн онцлогийг тусгасан бие махбодын болоод сэтгэл санааны зовлон, зовуурь, шаналлын /гэм хорын/ шинж чанар, шударга ёсны шаардлага зэргийг тусгах.

Хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр:

3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг мөрдөхөд Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн цагдаагийн ажил-эрх зүй мэргэжлийн 1+1 хөтөлбөрөөр “сэтгэл судлал, гэр бүлийн харилцаа”-ны чиглэлээр бакалаврын боловсрол эзэмшсэн иргэнийг мөрдөгчөөр сурган практикт ажиллуулах. Ийнхүү бэлтгэснээр нөхцөл байдлын болон аюулын зэргийн үнэлгээ зэргийг хийх, хохирогч иргэнд сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, мөрдөгч магадлагаа гаргах зэрэг асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэнэ.

Орчин үеийн техник технологийг ашиглах чиглэлээр:

4. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн нотлох баримтыг судлан шинжлэх техник, технологи шаардлагын түвшинд хүрэхгүй, мэдүүлэгт суурилсан мөрдөх ажиллагаа зонхилж байна. Мэдүүлэг авахад оролцогчдын зөвшөөрлийг үндэслэн полиграфийн аппарат хэрэглэж, дүн шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар боловсруулж, мөрдөгчдөд зөвлөмж өгөх, сургалт зохион байгуулах.

Мөрдөн шалгах ажиллагааны талаар:

5. Гэр бүлийн харилцаанд оролцогчдын ухамсар, сэтгэл санааны байдал, санхүүгийн болон гэр бүлийн гишүүдийн ашиг сонирхол, тэдний төрөл садан хийгээд гэр бүлдээ эзэлж байгаа байр суурь, хүндлэл, боловсролын ялгаатай байдал, олж байгаа орлого, амьдарч байгаа газар, орчин, ойр дотно харилцаатай хүмүүсээс тухайн гэр бүлд хандах хандлага, зуршил, удам, эцэг, эхийн нөлөө, зөрчилдөөн, амьдралын хэв маяг, улс төрийн хийгээд бусад сонирхол, насны ялгаа, өмч хөрөнгийн ялгаатай байдал, удамшлын гэх зэргээр нэлээд өргөн хүрээтэй асуудлын хариуг оновчтой таамаглал, мөрдөн шалгах ажиллагааны зөв төлөвлөлт, зохион байгуулалт, хамтын ажиллагааны дүнд шийдвэрлэнэ гэдгийг анхаарч “хэргийн бодит байдлыг тогтоох” зарчмыг хэрэгжүүлэх.

6. Мөн энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг тус тусад нь тогтоох шаардлагатай. ЭХХШТХ-ийн 16.2 дугаар зүйлд “Нотолбол зохих байдал”-д “хор уршиг”-ийг нотлохоор зохицуулсан хэдий ч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад “хохирол” нотолж буй практик 2002 оны ЭБШХ-ийн жишгээр тогтсон нь мөрдөн шалгах арга зүй уламжлалт хэлбэрээрээ байгааг илэрхийлж байгааг цаашид “Хуульч ажиллагаа” арга хэмжээний хүрээнд зохион байгуулж буй уг хурлаар болон бусад зохион байгуулах арга хэмжээний хүрээнд мөрдөгчдөд ойлгуулж, гарч байгаа алдааг засах.

Ашигласан материал

1. Бямбадорж Г. Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал. УБ., 2014.

2. Гантулга С., Энхболд Б. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. УБ., 2018.
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №5.
4. Доржпалам Х. Иргэний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. УБ., 2012.
5. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн байдал. УБ., 2019.
6. Монгол Улсын Үндсэн хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 1992. №1.
7. Хүний эрхийн түгээмэл тунхаглал.
8. Эрүүгийн хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2002. №5.
9. Эрүүгийн хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2016. №7.
10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №23.
11. <http://information.police.gov.mn/resource/information/File/2020/12/04/8nqjo-nzvcu9v2zq1/gemt%20hereg.pdf>.

КОНФИСКАЦИЯ ИМУЩЕСТВА КАК УГОЛОВНО-ПРАВОВАЯ МЕРА ПРОТИВОДЕЙСТВИЯ КОРРУПЦИИ

CONFISCATION OF PROPERTY AS A CRIMINAL LAW MEASURE AGAINST CORRUPTION

*Е.К. Николаева
Магистрант 2 курса
Омского государственного университета
им. Ф.М. Достоевского, юридический факультет*

Аннотация: В статье обосновывается необходимость обновления отечественного уголовного законодательства путем корректировки регламентации конфискации имущества – закрепления ее в виде наказания за коррупционные преступления, что позволит эффективно бороться с коррупцией.

Annotation: The article substantiates the need to update domestic criminal legislation by adjusting the regulation of confiscation of property – fixing it as a punishment for corruption crimes, which will effectively combat corruption.

Ключевые слова: Коррупция, коррупционные преступления, конфискация имущества, наказание, уголовное право.

Keywords: corruption, corruption crimes, confiscation of property, punishment, criminal law.

Общество не стоит на месте и развивается во всех направлениях. Помимо позитивного направления развития, имеется и негативное, одним из проявлений которого являются преступные деяния, которые, трансформируясь, приобретают новые формы, кроме того, возникают новые виды общественно опасных посягательств. Коррупция как явление вообще и преступления коррупционной направленности в частности не являются чем-то новым. Этот порок известен обществу давно. Судебный департамент при Верховном Суде Российской Федерации приводит следующие данные судебной статистики по делам коррупционной направленности: в 2020 г. осуждено 13617 чел., в 2021 г. – 16545, в 2022 г. – 22101, в 2023 г. – 22014²⁵. Несмотря на довольно значительно число осужденных, до искоренения рассматриваемых преступлений еще далеко. Не удастся отладить четкий правовой механизм противодействия коррупции, меры борьбы с ней до сих пор недостаточно эффективны и должным образом не урегулированы в действующем законодательстве.

Коррупция является серьезной угрозой. Согласно ст. 1 Федерального закона от 25 декабря 2008 г. № 273-ФЗ «О противодействии коррупции», «коррупция – злоупотребление служебным положением, дача взятки, получение взятки, злоупотребление полномочиями, коммерческий подкуп либо иное незаконное использование физическим лицом своего должностного положения вопреки законным интересам общества и государства в целях получения выгоды в виде денег, ценностей, иного имущества или услуг имущественного характера, иных имущественных прав для себя или для третьих лиц либо незаконное предоставление такой выгоды указанному лицу другими физическими лицами»²⁶.

²⁵ Судебный департамент при Верховном Суде Российской Федерации. Официальный сайт // URL: <http://cdep.ru/>.

²⁶ О противодействии коррупции: федеральный закон от 25 декабря 2008 г. № 273-ФЗ (в ред. от 26 июля 2019 г.) // Рос. газета. 2008. 30 дек.

Из всех видов правонарушений наиболее опасными являются преступления. Наиболее эффективны в противодействии им уголовно-правовые меры. Таким образом, преступным посягательствам коррупционной направленности необходимо противостоять с помощью уголовного права. Если исходить из того, что борьба с коррупцией ведется недостаточно эффективно, то необходимо признать, что отечественное уголовное законодательство нуждается в обновлении в части противодействия коррупции. В связи с этим крайне важно усиление совокупности уголовно-правовых мер по противодействию преступлениям коррупционной направленности.

К этому можно прийти путем формулирования в УК РФ принципиально новых норм, введения изменений, нацеленных на запрет смягчения наказания за коррупционные преступления, а также за счет изменения регламентации конфискации имущества.

В соответствии с Федеральным законом от 8 декабря 2003 г. № 162-ФЗ «О внесении изменений и дополнений в Уголовный кодекс Российской Федерации»²⁷ была исключена из кодекса конфискация имущества. После этого возникла бурная дискуссия, в ходе которой ученые – специалисты в области уголовного права пришли к выводу о том, что уголовное законодательство в России, после исключения из УК РФ конфискации имущества, перестало соответствовать международным уголовно-правовым стандартам, в частности, Конвенции Совета Европы об уголовной ответственности за коррупцию (принята 27 января 1999 г.), Конвенции ООН против транснациональной организованной преступности (принята 15 ноября 2000 г.), Конвенции ООН против коррупции (принята 31 октября 2003 г.) и др. Высказывались небезосновательные предположения о том, что законодатель подобным способом стремится обезопасить преступно нажитое имущество²⁸.

Федеральным законом от 27 июля 2006 г. № 153-ФЗ «О внесении изменений в отдельные законодательные акты Российской Федерации в связи с принятием Федерального закона “О ратификации Конвенции Совета Европы о предупреждении терроризма” и Федерального закона “О противодействии терроризму”»²⁹ конфискация имущества была возвращена в УК РФ, но не как уголовное наказание, а как иная мера уголовно-правового характера.

Н.А. Лопашенко справедливо указывает: «История с исключением и новым введением конфискации в УК РФ была осуществлена по наихудшему из возможных сценариев. Точнее, по очень выгодному для кого-то сценарию, позволяющему полностью легализовать капиталы, полученные ранее в результате совершения преступлений, совершенно не опасаясь никакой конфискации – ни как вида наказания, ни как иной меры уголовно-правового характера. В течение двух с половиной лет в России конфискация присутствовала только в уголовно-процессуальном законодательстве. Поэтому в соответствии с положениями об обратной силе уголовного закона нынешняя конфискация не может быть применена к отношениям, возникшим до ее нового включения в УК РФ. Капиталы, полученные в результате преступлений в ходе приватизации,

²⁷ О внесении изменений и дополнений в Уголовный кодекс Российской Федерации: федеральный закон от 8 декабря 2003 г. № 162-ФЗ // Рос. газета. 2003. 16 дек.

²⁸ Кузнецова Н. Мнение ученых о реформе УК (или Qui prodest?) // Уголовное право. 2004. № 1. С. 26.

²⁹ О внесении изменений в отдельные законодательные акты Российской Федерации в связи с принятием Федерального закона “О ратификации Конвенции Совета Европы о предупреждении терроризма” и Федерального закона “О противодействии терроризму”: федеральный закон от 27 июля 2006 г. № 153-ФЗ // Рос. газета. 2006. 29 июля.

банковских кризисов и прочих российских социально-экономических катаклизмов, уже не могут быть конфискованы ни при каких условиях»³⁰.

А.В. Шнитенков полагает, что «сомнительно... решение о придании конфискации имущества статуса не наказания, а иной меры уголовно-правового характера. Казалось бы, неважно, в какой роли выступает конфискация имущества, главное, что она предусмотрена в УК РФ. Да, отраднее уже то, что законодатель “одумался” и уяснил необоснованность исключения конфискации имущества из уголовного закона. Однако наказание отличается от иных мер уголовно-правового характера своей целевой направленностью, обозначенной в ч. 2 ст. 43 УК РФ... конфискация имущества должна являться именно дополнительным наказанием за совершенное преступление, как это было ранее»³¹.

В.С. Минская отмечает, что «конфискация имущества, как и другие виды наказания имущественного характера (штраф, исправительные работы), была сопряжена с принудительным ограничением права собственности граждан. Это правоограничение правомерно так же, как правомерно ограничение в уголовно-правовом порядке иных субъективных прав граждан (даже право на жизнь) другими наказаниями, следующими за преступлением и являющимися неблагоприятными последствиями, претерпеть которые обязан любой гражданин, преступивший запрет государства. Законодатель не учел современное состояние и структуру преступности, в противостоянии которой карательный потенциал конфискации имущества в сочетании с другими наказаниями способен был обеспечить значительно больший успех, поэтому конфискация имущества в соответствии с волей законодателя утратила силу»³².

Учитывая изложенное, можно прийти к выводу о том, что изъятие конфискации имущества из УК РФ как наказания, юридическая общественность восприняла весьма отрицательно. Пока общей конфискации имущества не будет возвращен статус наказания, что выступает для преступности корыстной мотивации серьезным заслоном, об эффективной борьбе с названными посягательствами говорить не приходится³³.

Только при разработке должного объема средств борьбы с коррупцией и их реализации на практике правоохранительными органами можно прийти к тому, что цели, поставленные государством в борьбе с коррупцией, перестанут быть утопическими и приобретут реальный характер.

Судебный департамент при Верховном Суде Российской Федерации приводит следующие данные судебной статистики применения конфискации имущества по делам коррупционной направленности: в 2020 г. конфискация имущества применена к 782 чел., в 2021 г. – 961, в 2022 г. – 993, в 2023 г. – 598³⁴.

Обращает на себя внимание резкое снижение применения конфискации имущества за преступления коррупционной направленности. Стоит отметить, что конфискация имущества применяется недостаточно. Из всех регистрируемых

³⁰ Лопашенко Н.А. Конфискация имущества. М., 2012. С. 30.

³¹ Шнитенков А.В. Новое в уголовном законодательстве // Уголовный процесс. 2006. № 8. С. 5.

³² Минская В.С. Законодательство о конфискации имущества нуждается в совершенствовании // Актуальные проблемы совершенствования законодательства по вопросам конфискации имущества: материалы круглого стола (22 апреля 2008 г.). М.: Издательство Государственной Думы, 2009. С. 56-57.

³³ Бавсун М.В., Николаев К.Д., Самойлова С.Ю. Конфискация имущества в российском уголовном законодательстве: монография. М., 2016. С. 194.

³⁴ Судебный департамент при Верховном Суде Российской Федерации. Официальный сайт // URL: <http://cdep.ru/>.

преступлений около половины – это деяния корыстной направленности. Подавляющая масса из них – хищения, но распространены и коррупционные преступления.

Так, приговором Верховного Суда Российской Федерации по ч. 3 ст. 290; ч. 3 ст. 30, ч. 3 ст. 159 УК РФ был осужден Г., который занимая государственную должность Российской Федерации – федерального судьи городского суда, получил взятку в виде денег за действия в пользу взяткодателя, входящие в его служебные полномочия, и покушался на мошенничество, то есть хищение чужого имущества путем обмана и злоупотребления доверием с использованием своего служебного положения. В соответствии ст. 104¹ УК РФ в собственность государства были конфискованы деньги, полученные Г. в результате совершения преступления, предусмотренного ч. 3 ст. 290 УК РФ³⁵. Однако, эти деньги могли быть изъяты и как предмет преступления. На другое имущество осужденного за корыстные деяния Г. взыскание обращено не было. Отсутствие конфискации имущества в системе видов наказаний затрудняет противодействие названным посягательствам.

Таким образом, в целях усиления противодействия коррупционным преступлениям уголовно-правовыми мерами необходимо восстановить общую конфискацию имущества в виде дополнительного наказания за названные преступные посягательства.

Список источников

1. Судебный департамент при Верховном Суде Российской Федерации. Официальный сайт // URL: <http://cdep.ru/>.

2. О противодействии коррупции: федеральный закон от 25 декабря 2008 г. № 273-ФЗ (в ред. от 26 июля 2019 г.) // Рос. газета. 2008. 30 дек.

3. О внесении изменений и дополнений в Уголовный кодекс Российской Федерации: федеральный закон от 8 декабря 2003 г. № 162-ФЗ // Рос. газета. 2003. 16 дек.

4. Кузнецова Н. Мнение ученых о реформе УК (или Qui prodest?) // Уголовное право. 2004. № 1.

5. О внесении изменений в отдельные законодательные акты Российской Федерации в связи с принятием Федерального закона “О ратификации Конвенции Совета Европы о предупреждении терроризма” и Федерального закона “О противодействии терроризму”: федеральный закон от 27 июля 2006 г. № 153-ФЗ // Рос. газета. 2006. 29 июля.

6. Лопашенко Н.А. Конфискация имущества. М., 2012. 158 с.

7. Шнитенков А.В. Новое в уголовном законодательстве // Уголовный процесс. 2006. № 8.

8. Минская В.С. Законодательство о конфискации имущества нуждается в совершенствовании // Актуальные проблемы совершенствования законодательства по вопросам конфискации имущества: материалы круглого стола (22 апреля 2008 г.). М., 2009. 79 с.

9. Бавсун М.В., Николаев К.Д., Самойлова С.Ю. Конфискация имущества в российском уголовном законодательстве: монография. М., 2016. 240 с.

10. Верховный Суд Российской Федерации. Приговор от 24 декабря 2010 г. по делу № УКПИ10-7 // URL: <https://sudact.ru/vsrf/doc/7xE5wQ47h4Yn/>.

³⁵ Верховный Суд Российской Федерации. Приговор от 24 декабря 2010 г. по делу № УКПИ10-7 // URL: <https://sudact.ru/vsrf/doc/7xE5wQ47h4Yn/>.

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЗӨРЧИЛД ХҮЛЭЭЛГЭЖ БУЙ ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

EXPERIENCES OF SOME FOREIGN COUNTRIES ON LIABILITY
FOR ROAD SAFETY VIOLATIONS

Б.Хулан

*ДХИС-ийн ЭЗНУС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор,
доктор (Ph.D), цагдаагийн ахмад*

Товч агуулга: Энэхүү сэдвийн хүрээнд ОХУ, Япон, ХБНГУ-ын замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд хүлээлгэж буй хариуцлага, эрх зүйн зохицуулалтыг судаллаа. Мөн зарим төрлийн зөрчил, тухайлбал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд хүлээлгэж буй хариуцлагын төрөл, хэмжээг 18 улсын жишээн дээр авч үзлээ.

Abstract: In the framework of this topic, the responsibility and legal regulation of the Russian Federation, Japan, and Germany for violations against traffic safety were studied. Also, the type and amount of liability imposed for some types of violations, such as drunk driving, were compared on the examples of 18 countries.

Түлхүүр үгс: Замын хөдөлгөөний аюулгүй байдал, зөрчил, хариуцлагын төрөл, хэмжээ

Keywords: Traffic safety, violations, type and amount of responsibility.

Дэлхийн ихэнх улс орнууд замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг буруулах, Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг нэмэгдүүлэхийн тулд торгуулийн системийг ашигладаг. Гэсэн хэдий ч жолооч нар Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэлийг ногдуулсан хэдий ч дахин дахин зөрчил гаргаж, удаа дараа зөрчдөг байдал нь шийтгэлийн систем нь үр нөлөөгүй гэж үзэж болохоор байна. Тиймээс шийтгэлийн хэмжээ нь тухайн зөрчилдөө тохирсон шударга байх шаардлагатай бөгөөд энэ нь замын хөдөлгөөний дүрмийг дагаж мөрдсөнтэй холбоотойгоор илэрч болно.

ОХУ-ын туршлага. Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд жолооч төдийгүй явган зорчигчид хариуцлага хүлээлгэдэг байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд хариуцлага хүлээлгэх нь аюулгүй байдлыг хангах чухал хэрэгсэл болдог. Тиймээс ОХУ-д зөрчил гаргагч-явган зорчигчдод захиргааны хариуцлага (үүнийг ихэвчлэн ашигладаг), эрүүгийн хариуцлага, иргэний хариуцлагыг тус тус хүлээлгэдэг байна.

ОХУ-д захиргааны хариуцлага гэдэг нь захиргааны зөрчил гаргасныхаа төлөө төрөөс хариуцлага хүлээлгэх эрх бүхий субъектээс шийтгэл оногдуулах замаар субъектийн үүргийг тодорхойлдог хуулийн хариуцлагын нэг төрөл юм. ОХУ-д захиргааны хариуцлагыг ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулиар зохицуулдаг байна. Тус хуулиар захиргааны хариуцлагын онцлогийг зааж өгсөн бөгөөд үүнд: ОХУ-ын иргэдийн захиргааны хариуцлага, гадаадын иргэн, гадаадын хуулийн этгээд, харьяалалгүй хүний захиргааны хариуцлага, тээврийн хэрэгслийн өмчлөгч (эзэмшигч) -ийн захиргааны хариуцлага, албан тушаалтнуудын захиргааны хариуцлага, цэргийн албан хаагчдын захиргааны хариуцлага, ОХУ-ын хуулийн этгээдийн захиргааны хариуцлага, газар болон бусад үл хөдлөх хөрөнгийн

өмчлөгч, бусад өмчлөгчийн захиргааны хариуцлага, түүнд хүлээлгэх захиргааны хариуцлагыг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулсан байдаг.

ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 1.1-т “холбооны болон бүс нутгийн гэсэн хоёр түвшинд захиргааны хариуцлагыг тогтоож болно” гэж заасан. Захиргааны хариуцлага хүлээх субъект нь 16 нас хүрсэн эрүүл ухаантай иргэн, байгууллага, хуулийн этгээд байж болно.

Захиргааны зөрчлийн шинжийг ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 2.1-д заасан бөгөөд “хувь хүн, хуулийн этгээдийн хууль бус, гэм буруутай үйлдэл (эс үйлдэхүй) нь энэ хууль эсхүл ОХУ-ын бүрэлдэхүүн хэсгүүдийн захиргааны зөрчлийн тухай хууль тогтоомжоор захиргааны хариуцлага хүлээлгэж, захиргааны зөрчилд тооцсон байна” гэжээ. Энэхүү тодорхойлолтыг үндэслэн захиргааны зөрчлийн дараах шинж тэмдгүүдийг нэрлэж болно.

- Үйлдэл - хүчтэй хүсэл эрмэлзэлтэй, ухамсартай зан үйлийн үйлдэл нь үйлдэл (гудамжны улаан гэрлэн дохио руу хөндлөн гарах) эсвэл эс үйлдэхүй (тангарагтны шүүгчийн үүргээ биелүүлэхийн тулд шүүхэд ирээгүй) байж болно;

- Нийгмийн эсрэг шинж чанар - иргэн, төр, нийгмийн ашиг сонирхлыг зөрчих: ийм ашиг сонирхлын ерөнхий жагсаалтыг Урлагт өгсөн болно. ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 1.2, түүнд агуулагдах эрх зүйн хэм хэмжээнд заасан байдаг;

- Гэм буруу нь санаатай, хайхрамжгүй байдлаар эрүүгийн хуультай төстэй барилга байгууламж юм³⁶;

- Хууль бус байдал гэдэг нь халдлагын объект нь хувь хүн, төр, нийгэмд тодорхой үнэ цэнийг илэрхийлээд зогсохгүй хуулиар хамгаалагдсан байдлыг хэлнэ.

- Шийтгэлийн тухай ойлголт нь чухал ач холбогдолтой бөгөөд үүнд захиргааны шийтгэл нь захиргааны зөрчил үйлдсэнийхээ төлөө төрөөс тогтоосон хариуцлагын арга хэмжээ юм³⁷.

- Захиргааны шийтгэлийн талаар ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 3.2-т захиргааны зөрчил гаргасан тохиолдолд дараах захиргааны шийтгэл ногдуулна гэж заасан. Үүнд:

1. Анхааруулах. Энэ шийтгэлийг хувь хүн, хуулийн этгээдийн үйлдсэн зөрчилд албан ёсоор бичгээр хүргүүлж буй захиргааны шийтгэлийн арга хэмжээ.

2. Мөнгөн торгууль ногдуулах. Захиргааны торгууль гэдэг нь хууль тогтоомжид заасан тохиолдол, хүрээнд захиргааны зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдэд ногдуулах мөнгөн торгууль юм.

3. Захиргааны зөрчил үйлдсэн хэрэгсэл, эд зүйлийг хураах. Захиргааны зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах нь эргэлтээс хасагдаагүй зүйлийг холбооны өмчид эсхүл ОХУ-ын бүрэлдэхүүн хэсгийн өмчид албадан үнэ төлбөргүй шилжүүлэх явдал юм. Энэ шийтгэлийг шүүгч ногдуулдаг.

4. Хувь хүнд олгогдсон тусгай эрхийг (ан хийх, тээврийн хэрэгсэл жолоодох гэх мэт) хасах; Тусгай эрхээ хасуулах шийтгэл нь тухайн хүнийг тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг хассан явдал юм. Тусгай эрх хасах шийтгэлийг шүүгч нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар ногдуулдаг байна.

5. Баривчлах шийтгэл. Энэ нь зөрчил гаргагчийг нийгмээс тусгаарлан 15 хүртэл хоног, терроризмын эсрэг ажиллагаа явуулж буй бүсэд онц байдал, дэглэмийн шаардлагыг зөрчсөн бол 30 хүртэл хоног баривчлахыг хэлнэ;

6. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ОХУ-аас захиргааны журмаар хөөх;

³⁶ ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 2.2-р зүйл "Гэм буруугийн хэлбэрүүд".

³⁷ ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 3.1-р зүйл.

7. Эрх хасах. Энэ нь хувь хүнийг хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын байгууллагад удирдах албан тушаал эрхлэх, төлөөлөн удирдах зөвлөл (хяналтын зөвлөл) -ийн гишүүн байх, хуулийн этгээдийг удирдах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хассан явдал юм. түүнчлэн бусад тохиолдолд хуулийн этгээдийг удирдах;

8. Үйл ажиллагааг захиргааны түдгэлзүүлэх.

9. Албадан ажил хийлгэх;

10. Албан ёсны спортын тэмцээн зохиогддог газруудад зочлохыг захиргааны журмаар хориглох³⁸.

ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуульд хэд хэдэн томоохон өөрчлөлт орсон бөгөөд энэ нь бусад салбаруудын дотор замын хөдөлгөөний салбарт гарсан зөрчлийн захиргааны хариуцлагыг нэмэгдүүлсэн. Өөрөөр хэлбэл, нэгдүгээрт, машины зогсоол их хэмжээгээр нэмэгдэж байна; хоёрдугаарт, жолооч нар замын хөдөлгөөний дүрмийг үл тоомсорлох, гуравдугаарт, замын хөдөлгөөнд оролцогчдын эрх зүйн нийтлэг соёл дутмаг байгаатай холбоотойгоор аюулгүй байдлыг хангахад чиглэсэн. ЗХАБ хангахад дээрх шийтгэлээс зургаан шийтгэлийг замын хөдөлгөөний чиглэлээр захиргааны зөрчилд оногдуулж байна. Үүнд: анхааруулах, захиргааны торгууль ногдуулах, захиргааны зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, объектыг хураах, тусгай эрхийг хасах, захиргааны журмаар баривчлах, албадан ажил хийлгэх зэрэг шийтгэл ногдуулдаг.

ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 12.27 дугаар зүйл. Захиргааны нэг зөрчлийн хувьд үндсэн буюу үндсэн болон нэмэлт захиргааны шийтгэл ногдуулж болно. Мөн хуулийн 12.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 12.26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан захиргааны зөрчил үйлдсэн тохиолдолд зохих төрлийн тээврийн хэрэгсэл жолоодох эрх хэлбэрээр тусгай эрхийг хасах нь захиргааны нэмэлт шийтгэл юм.

Замын хөдөлгөөний зөрчилд анхааруулах нь захиргааны шийтгэлийн “хамгийн зөөлөн” төрөл юм. Жишээлбэл, ... улсын стандартын шаардлагыг зөрчиж, уншигдах боломжгүй, стандартын бус буюу улсын бүртгэлийн дугаартай тээврийн хэрэгсэл жолоодох, ... явган зорчигч, тээврийн хэрэгслийн зорчигч замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн бол ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 1, 2-р хэсэгт анхааруулах хэлбэрээр шийтгэхийг тусгасан байдаг. Мөн хуулийн 12.3, 1-р хэсэг, 12.5, 1-р хэсэг, 1.1, 3-р зүйл, 12.14-ийн 1-р хэсэг, 12.16 болон ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 12-р бүлгийн бусад зүйлд анхааруулдаг. Анхааруулах шийтгэлтэй хамт захиргааны торгууль ногдуулж болно. Мөн сануулга авсан этгээдийг нэг жилийн дотор захиргааны хариуцлага хүлээлгэдэг бөгөөд хожим нь хүндрүүлэх нөхцөл байдалд тооцож болно. Захиргааны торгууль нь рублиэр илэрхийлэгддэг мөнгөн торгууль юм. Замын хөдөлгөөний зөрчил үйлдэхэд торгуулийн доод хэмжээ 500 рубль, дээд тал нь 50 мянган рубль байна. Харин албан тушаалтнуудын хувьд торгуулийн дээд хэмжээг 50 мянган рубль, хуулийн этгээдэд 1 сая рубль гэж тогтоосон.

Япон улсын туршлага. Замын хөдөлгөөний зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэж буй шийтгэл, түүний хэмжээ. Япон улсад жолооч нар замын хөдөлгөөний ноцтой зөрчил гаргасан (зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл жолоодсон, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон) тохиолдолд эрүүгийн болон гэр бүлийн шүүхээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр шилжүүлж, баривчлах арга хэмжээ авдаг.


Харин замын хөдөлгөөний бага хэмжээний зөрчил гаргасан тохиолдолд дараах байдлаар мэдэгддэг схем байдаг. Уг схемийн дагуу зөрчил гаргасан этгээд

³⁸ <https://ru.wikipedia.org/wiki/>.

замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлүүдээс бага хэмжээний зөрчлийн торгуулийг тодорхой хугацаанд төлж барагдуулсан тохиолдолд эрүүгийн хариуцлагад татахгүй, гэр бүлийн шүүхээр хэлэлцүүлэхгүй, хэргийг хаадаг байна. Харин торгуулиа төлөхгүй тохиолдолд анхан шатны шүүхээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлнэ.

Тээврийн хэрэгсэл жолоодох зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, осол гаргахад хүргэсэн зөрчил гаргасан этгээдүүдийг шүүхээр шийдвэрлэдэг байна.

Ялимгүй зөрчил гаргасан этгээдийн зөрчлийг шийдвэрлэх ажиллагааны дарааллыг дараах зургаар харууллаа.



Дээрх зургаас харахад, Япон Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийн шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэхэд илүү анхаарсан процессын ажиллагаа байна. Өөрөөр хэлбэл, зөрчил гаргасан этгээд шийтгэлээ 8 хоногийн дотор биелүүлээгүй бол дахин 11 хоног төлбөрийг төлүүлэхээр шуудангаар шийтгэлийн хуудсыг хүргүүлж байна. Хэрэв энэ хугацаандаа торгуулиа төлөөгүй бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдэхээр байна.

Японы засгийн газар 1874 онд иргэний цагдаагийн тогтолцоотойгоор Европын-загвартайгаар дотоодын хямралт нөхцөл байдал болон хэв журам сахиулахаар байгуулагдсан.

Японы цагдаагийн байгууллага нь Үндэсний олон нийтийн аюулгүй байдлын комисс, Үндэсний цагдаагийн газар, Цагдаагийн захиргаа, удирдлага товчоо, эрүүгийн хэрэг мөрдөх товчоо, замын цагдаагийн товчоо, хамгаалалтын товчоо, Бүсийн Олон нийтийн аюулгүй байдлын товчоо, Цагдаагийн харилцаа холбооны хэлтэс, Эзэн хааны хамгаалалт, орон нутгийн цагдаагийн байгууллагууд байдаг.

Япон Улс нь 47 мужаас бүрдэх бөгөөд Япон Улсад Улсын Цагдаагийн газар нь мужийн цагдаагийн газраараа дамжуулан хууль сахиулдаг. Улсын Цагдаагийн газар нь Улсын Олон нийтийн аюулгүй байдлын хорооны удирдлага дор, засгийн газрын шууд хяналтаас хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг. Улсын Цагдаагийн газрын үйл ажиллагаанд бие даасан шүүх, чөлөөт хэвлэл хяналт тавьж ажилладаг. Япон Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт болон түүнийг хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар авч үзэхдээ дараах агуулгын хүрээнд судалсан³⁹. Үүнд:

1. Зам тээврийн ослын нөхцөл байдал;
2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын арга хэмжээ;
3. Эрх зүйн зохицуулалт, дүрмийн талаар дурдъя.

Япон Улсад 1970 он хүртэл зам тээврийн ослоос улбаалан нас барсан хүний тоо авто машины өсөлттэй уялдан нэмэгдсээр байсан бөгөөд түүнээс хойш замын хөдөлгөөний аюулгүй байдлын янз бүрийн арга хэмжээ авсны ачаар буурч байсан. Тухайлбал замын хажуугийн явган хүний зам, дугуйн зам, замын тэмдэг, тэмдэглэлийг тодорхой болгосон гэх мэт. Мөн 1970 Traffic Safety Policies Basic Act буюу “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндсэн бодлогын хууль” батлагдсан. Хэдий хууль батлагдсан ч 1980 оны үед зам тээврийн осол, гэмтсэн хүний тоо жилээс жилд нэмэгдэж, энэ талаар анхаарал хандуулан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах практик арга хэмжээг авч эхэлсэн. Тухайлбал замын хажуугийн явган хүний зам, дугуйн зам, замын тэмдэг тэмдгийг тодорхой болгох зэрэг арга хэмжээг авсан.

Япон улс хэдийгээр замын зүүн гар талын хөдөлгөөнтэй боловч замын хөдөлгөөний тухай олон улсын Конвенц (Женев, 1949)-д нэгдсэн орон учраас замын хөдөлгөөний дүрмийн нийтлэг шаардлага, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний ерөнхий журмууд нь бусад орныхтой адил юм. Зарим ялгаатай зүйлүүдийг харахад. Тухайлбал: Манай дүрмээр гүйцэж түрүүлэх үйлдлийг урд яваа тээврийн хэрэгслийнхээ зүүн гар талаар нь гүйцэтгэдэг бол Японд баруун гар талаар нь гүйцэтгэнэ. Манайд тойрох хөдөлгөөнтэй уулзварыг нэвтрэх чиг цагийн зүүний эсрэг байдаг бол Японд цагийн зүүний дагуу байна. Манайд уулзвараар баруун гар тийш эргэх хялбар, харин зүүн гар тийш эргэх үйлдэл эсрэг хөдөлгөөнтэй огтлолцдог тул бэрхшээлтэй байдаг. Тэгвэл Японд эсрэгээр. Өөрөөр хэлбэл зүүн гар тийш эргэх нь хялбар бөгөөд харин баруун гар тийш эргэхдээ эсрэг урсгалтай огтлолцож, хөндлөн замынхаа цаад урсгал руу орох тул бэрхшээлтэй байна.

Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолоочид хариуцлага тооцох, хөдөлгөөний аюулгүй байдлыг чанд сахиж явахад нь хөшүүрэг болгох үүднээс Япон улсад торгуулийн онооны системийг хэрэгжүүлдэг байна. Зам тээврийн осол гаргах, замын тэмдэг, тэмдэглэлийн заалтыг зөрчих, хурд хэтрүүлэх, тээврийн хэрэгслээ зогсоолд буруу байрлуулах гэх мэт ноцтой зөрчлүүдэд торгуулийн оноог тооцдог гэнэ. Торгуулийн нийт оноо нь тодорхой хязгаараас хэтэрсэн тохиолдолд тухайн жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг түдгэлзүүлэх буюу хүчингүй болгоно. Ялангуяа согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд хатуу

³⁹ Traffic Safety Measures in Japan. http://www.mlit.go.jp/road/management-e/e_pdf/0403_5.pdf.

шийтгэл хүлээлгэх ба мөн зөрчил гаргасны улмаас хүний амь нас хохироосон бол шоронд хорьж шийтгэдэг байна.

Замын хөдөлгөөний дүрмийн зөрчил гаргагсдад хүлээлгэх хариуцлагаараа Япон улс дэлхийн хамгийн хатуу улсын нэгд зүй ёсоор тооцогдоно. Тухайлбал, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэлийг замын хөдөлгөөний дүрмийн их, бага ямар ч зөрчил гаргасан жолоочид ногдуулах үндэслэлтэй байна.

Жолооч хориглосон гэрэл дохиогоор нэвтэрсэн тохиолдолд 400 доллароор торгуулаад зогсохгүй хагас жилийн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил гүйцэтгэх хорих ялаар шийтгүүлж ч болзошгүй юм. Мөн хурдны тогтоосон хязгаарыг хэтрүүлсэн тохиолдолд тухайн хэтрүүлсэн хэмжээнээс нь хамааруулж, хамгийн багадаа 800 доллароор торгох бөгөөд жолоодох эрхийг хасах, хагас жилийн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийх хүртэл давхар шийтгэл ногдуулна.

Япон улсад тээврийн хэрэгслийн зогсоолын журам зөрчих явдлыг замын хөдөлгөөний дүрмийн хамгийн ноцтой зөрчлүүдийн нэгэнд тооцно. Ийм зөрчил гаргасан этгээд 835 долларын торгуулиас гадна жолоодох эрхээ хагас жилийн хугацаатайгаар хасуулах шийтгэл ч хүлээж болно.

Япон улс тээврийн хэрэгслийн хурд болон зогсоолын журмын биелэлтэд хатуу хяналт тавьдаг бөгөөд үүний тулд ихэнх замуудад видео болон теле камер, фото аппарат зэрэг хяналтын төхөөрөмжүүдийг байрлуулсан ажээ.

Тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон этгээдэд 400 долларын торгууль ногдуулахаас гадна жолоодох эрхийг хагас жилийн хугацаагаар хасах, мөн гурван жил хүртэл хугацаагаар хүнд ажил гүйцэтгэх хорих ял шийтгэх үндэслэлтэй байна.

Японы хуулиар замын хөдөлгөөний дүрмийг зөрчсөн дараах зөрчлүүдэд хорих ял ногдуулдаг байна:

- техникийн шаардлага хангаагүй тээврийн хэрэгслийг ашигласан бол 3 сар хүртэл хугацаагаар;
- төмөр замын гарам нэвтрэх журам зөрчсөн бол 6 сар хүртэл хугацаагаар;
- жолоодох эрхийн үнэмлэхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон бол 2 жил хүртэл хугацаагаар;
- согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон буюу согтуурсан этгээдэд тээврийн хэрэгслээ шилжүүлэн жолоодуулсан бол 3 жил хүртэл хугацаагаар;
- замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийг эвдсэн бол 5 жил хүртэл хугацаагаар.
- Замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хариуцлагаараа Наран улс дэлхийн хамгийн чанга орнуудын тоонд зүй ёсоор тооцогдоно.

ХБНГУ-ын туршлага. Замын хөдөлгөөний дүрмийг зөрчих нь зам тээврийн ослын ноцтой шалтгаан эсвэл дагалддаг. Иймд замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийн түвшинд чиглэсэн стратеги, арга хэмжээнүүд нь хөдөлгөөний аюулгүй байдлыг нэмэгдүүлнэ гэж үздэг байна.

Германы хууль тогтоомжид захиргааны зөрчил нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулаагүй боловч хууль бус эрх зүйн зөрчилд шийтгэл оногдуулахуйц зөрчлүүд байдаг. Энэ нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй бол

Захиргааны зөрчлийн хуулийн үр дүнд торгууль ногдуулдаг (§ 1 Abs. 1 OWiG)⁴⁰. Захиргааны зөрчлийн тухай хуулийн дийлэнх хэсгийг захиргааны эрх зүйд (захиргааны шийтгэл) хамааруулж үздэг боловч Захиргааны зөрчлийн тухай зохицуулалтаар жишээлбэл, замын хөдөлгөөний хууль, хар тамхины тухай хууль, хүнсний хууль, бүртгэлийн хууль гэх мэт асуудалд хариуцлага хүлээлгэхээр заасан.

Захиргааны зөрчил гаргасан хүнд хүлээлгэж байгаа шийтгэл нь зарчмын хувьд эрүүгийн гэмт хэрэгт хүлээлгэдэг ял шийтгэлээс зөөлөн байх зарчим баримталдаг байна⁴¹. Ихэвчлэн дараах шийтгэлийг хүлээлгэдэг байна.

1. Эрх чөлөөг хязгаарлах шийтгэл: Эрх чөлөөг хязгаарлах шийтгэлийн хүндрэлтэй тал нь хүний эрх, эрх чөлөөнд халдаж байгаа асуудал тул Европын Холбооны хүний эрх эрх чөлөөг хамгаалах конвенцын 5 дугаар зүйлийн 3, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 9-р зүйлийн 3-т заасны дагуу захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэхдээ шийтгэлийн бусад төрлийг хэрэглэхийн нэгэн адил хялбаршуулсан журмаар явуулах боломжгүй болгож, заавал шүүгчийг татан оролцуулна.

2. "Мөнгөн торгууль" нь зөвхөн тухайн зохицуулалтыг амьдралд хэрэгжүүлэх зорилготой бөгөөд, нийгмийн ёс зүйн үүднээс яллах, гэм буруутныг цээрлүүлэх зорилгыг агуулаагүй. Иймээс Эрүүгийн хуульд (40,46-р зүйл) заасан ажлын хоногийн хөлсөөр тооцох, торгох ялын хэмжээтэй адилтган хэрэглэж болохгүй" гэж тайлбарлажээ.

3. Захиргааны байгууллагаас анхааруулах: Ихэнх орны захиргааны зөрчлийн тухай хуульд шийтгэлийн нэг төрөл болж анхааруулах зохицуулалт ордог (ОХУ-ын ЗЭЗК-ийн 3-р зүйлийн 2,6; Беларусь Улсын ЗЭЗК-ийн 6-р зүйлийн 2,4; Австри Улсад 1971 оноос хойш "сануулах" гэсэн нэр томъёогоор, ЗЭХ-ийн 21-р зүйл)

Германы Захиргааны зөрчлийн хуульд тусгай зохицуулалт болж орсон. Хуулийн процессын хэсэгт "сануулах арга хэмжээ" гэсэн нэртэйгээр зохицуулагдаж байгаа (ХБНГУ-ын ХЖЗТХ-ийн 56-58-р зүйл). Энэхүү шийтгэлийг зөвхөн ялимгүй захиргааны зөрчилд ногдуулдаг бөгөөд шийтгэх шийдвэр гаргахгүйгээр, торгуулийн хуудас олгодог (ХБНГУ-ын ХЖЗТХ-ийн 56-р зүйлийн 3). Ингэснээр захиргааны байгууллагын ажиллагааг хөнгөвчилдөг. Тухайн зөрчилд 5-аас 35 еврогийн мөнгөн торгууль ногдуулдаг. Австри Улсад мөн ялимгүй захиргааны зөрчилд "сануулах" шийтгэл ногдуулдаг (Австри Улсын ЗЭХ-ийн 21-р зүйл).

Г. Шийтгэлийн бусад төрөл: Зөрчил үйлдэхэд хэрэглэсэн эд зүйл болон захиргааны зөрчил гаргаж олсон орлогыг хураах зохицуулалт зайлшгүй байх ёстой.

Тус улсад автомашины жолооч нараас шалтгаалсан ослын хамгийн түгээмэл шалтгаанууд нь: түрүүлэх дүрэм зөрчсөн (26%), дасан зохицоогүй хурд (21%), эргэх, эргэх хөдөлгөөний урсгалд орох дүрэм зөрчсөн (21%) байна. Мөн

⁴⁰ <https://criminal-law-germany.lawyer/administrative-offences/>.

⁴¹ Фридрих-Кристиан Шрёдер. Захиргааны хариуцлагын тухай хуулийн төсөл боловсруулахад зориулсан удирдамж. Эргэцүүлэл. Уб., 2010.

шийтгэлийн дийлэнх нь (осол гарсан шалтгаан, оролцооноос үл хамааран) хурдны дээд хязгаарыг хэтрүүлсэн зөрчил (77%), гэрлэн дохио болон бусад гүйцэж түрүүлэх дүрмийг дагаж мөрдөөгүй 11%, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил 10%, байна. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ осол гарсан нь тогтоогдсон зөрчил буюу нас баралтын түвшин 4.9%, хүний гэмтэл, эд материалын хохирлын ослын дундаж зардал нэг осолд ойролцоогоор 100 000 евро тус тус байна⁴².

Холбооны Бүгд Найрамдах Герман улсад замын хөдөлгөөний зөрчлийг Захиргааны зөрчлийн хууль, Эрүүгийн хууль гэсэн хоёр түвшинд шийтгэдэг байна. Замын хөдөлгөөний зөрчлийн дийлэнх нь захиргааны зөрчилд тооцогдоно.

Замын хөдөлгөөний зохицуулалтыг захиргааны зөрчлийн хувьд шийтгэлээр хамгаалдаг. Захиргааны зөрчлийн тухай хуулийн гол шийтгэл бол торгууль бөгөөд түүний хэмжээ нь тухайн зөрчлийн нөхцөл байдлаас хамаарч өөр өөр байдаг. Шийтгэлийг Холбооны Тээвэр, Барилга, Хот Байгуулалтын Яамны (BKatV) StVG-ийн § 26-д заасан зөвшөөрлийн дагуу гаргасан журам болгон гаргасан торгуулийн улсын хэмжээний каталогийн дагуу тогтмол явуулдаг. Каталогт дурдсан зөрчил бүрд 5 еврогийн торгууль (35 евро хүртэл анхааруулах торгууль), дээд тал нь 3000 еврогийн торгууль ногдуулдаг. Зэрэглэл нь пропорциональ байдлын шаардлагыг, ялангуяа зөрчил, торгуулийн хоорондох пропорциональ байдлыг хангахад үйлчилдэг.

Мөн Замын хөдөлгөөний тухай хуулийн 25-р зүйлийн 1-д заасны дагуу тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг гурван сар хүртэл хугацаагаар хасаж болзошгүй бөгөөд торгуулийн жагсаалтад илүү ноцтой зөрчил гаргасан тохиолдолд тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглодог. Олон тооны зөрчил гаргасан тохиолдолд замын хөдөлгөөний нэгдсэн бүртгэлд торгуулийн онооны системээр нэмэлт шийтгэл ногдуулдаг бөгөөд энэ нь хэд хэдэн удаа зөрчил гаргасан жолоочийн жолооны үнэмлэхийг хураах хүртэл арга хэмжээ авах боломжтой.

Харин Эрүүгийн хууль бол зөвхөн ноцтой гэж үзсэн замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг. Эрүүгийн хууль нь “нийгмийг хамгаалахаас зайлсхийх боломжгүй тохиолдолд л хязгаарлалт тогтоож болно” ба “эцсийн харьцааны зарчим” гэж нэрлэгддэг. Зөвхөн онцгой буруутай үйлдэл хийсэн хүмүүст хариуцлага хүлээлгэнэ.

ОХУ, Япон, ХБНГУ-ын туршлагыг судалж үзэхэд Захиргааны зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээс гадна Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэж байна. Япон улсын туршлагыг судалж үзэхэд илүү шийтгэлийн үр нөлөөг нэмэгдүүлэхээр процесст илүү анхаарч, зөрчил гаргагчаар төлүүлэхэд чиглэсэн байна. Харин шийтгэлийг төлөөгүй тохиолдолд эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэхээр байна.

Эдгээр улсын туршлагаас гадна зарим төрлийн, тухайлбал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчилд хүлээлгэж буй шийтгэлийн хэмжээг дараах хүснэгтээр харьцуулан авч үзлээ.

⁴² <https://www.udv.de/resource/blob/78144/>.

Хүснэгт 1. Гадаадын зарим орны шийтгэлийн хэмжээ

№	Улс орны нэр	Хүлээлгэх хариуцлага	Эрх хасах	Баривчлах
1	Австрали	1100-5500 ам.доллар	6 сараас 3 жил эрх хасах	2 жил хүртэл хорих
2	АНУ	390-1000 доллар	6 сараар эрх хасах	48 цагаас 6 сараар баривчлах, жолоо барьсан дэмжсэн хүнд хариуцлага тооцох
3	Андорра улс	4500 евро	1 жил эрх хасах	1 жил баривчлах
4	Беларусь	525000-1225000 рублиэр	3 жил хүртэл хугацаагаар хасах	Баривчлах хугацаа тодорхойгүй
5	Грек	700-2000 евро	3 сараас 5 жил хугацаатай эрх хасах	6 сар хүртэл хугацаагаар баривчлах
6	Дани	3000 еврогоос эхэлнэ	1 жил эрх хасах	3 дахь удаагаа согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдол 10 жил хүртэл хугацаатай хорих
7	Ирланд	5000 евро	-	-
8	Их Британи	3000 фунтээс 5000 фунтээр	1 жил хүртэл хугацаатай хасах	6 сар хүртэл баривчлах, согтуугаар ЗТО гаргаж хүний амь нас хохирсон тохиолдолд 14 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
9	Литва улс	1000-5000 литээр	-	-
10	Турк	1000 доллар	-	-
11	Унгар	800-1400 еврогоор	-	-
12	Франц	150 000 евро	10 жил хүртэл хугацаагаар хасна.	-
13	Япон	25 сая төгрөг	3 жил	

Дээрх хүснэгтээс харахад, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчилд хүлээлгэж буй хариуцлагын хэмжээ 3 сараас 10 жил хүртэл хугацаагаар эрх хасаж, 390-5000 доллар хүртэл, 700-150 000 евро хүртэл, баривчлах, хорих ял, шийтгэлийг 48 цагаас 10 жил хүртэл хугацаагаар оногдуулдаг байна. Эдгээр шийтгэлийн хэмжээг өөрийн улстай харьцуулан авч үзэхэд 400 000 төгрөгөөр торгож, эрх хасаж, давтан үйлдэхэд 7-30 хоногийг баривчлах шийтгэл (торгууль оногдуулахгүй) оногдуулж байгаа нь харьцангуй бага шийтгэл байна.

Дүгнэлт

1. Гадаадын зарим орны туршлагаас судлахад олон төрлийн шийтгэлийн төрлийг ашиглаж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуульд 10 төрлийн шийтгэлийг ногдуулж байгаа нь ач холбогдолтой гэж үзэж байна. Тухайлбал, сануулах, зөрчил гаргахад ашигласан эд зүйлийг хураах, баривчлах зэрэг. Тиймээс зарим төрлийн шийтгэлийн аюулын нөхцөл байдлыг судалж, түүнд тохирсон шийтгэлийг ногдуулах талаар тусгаж өгөх нь зүйтэй юм.

2. Япон, ХБНГУ-ийн торгох шийтгэлийн хэмжээ маш өндөр байна. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил гаргасан тохиолдол өндөр торгууль ногдуулах, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж, шалгах ажиллагааг явуулж байна.

3. Зам хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил гарах шалтгаан нь жолоочийн шууд буруутай үйлдэл байдаг бөгөөд энэхүү шалтгааны дийлэнх хувийг согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, анхаарал болгоомжгүй жолоодох, хурд хэтрүүлэх, зогсоох арга хэмжээ авахгүй байх зэрэг зөрчлүүд дийлэнх хувийг эзэлж байна. Тиймээс зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд жолоочид чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Санал

Монгол Улсад согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчилд хүлээлгэх хариуцлагыг олон улсын жишигт нийцүүлэн, эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт оруулж хэрэгжүүлэх. Үүнд:

- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон төрийн албан хаагч, том оврын ачааны автомашины жолооч, нийтийн тээврийн хэрэгслийн жолоочид хүлээлгэх хариуцлагыг ялгамжтай оногдуулах;

- Бүх нийтийн баяр, амралтын өдрүүдэд согтууруулах ундааны зүйл хэрэглэж замын хөдөлгөөний дүрмийн зөрчил гаргасан этгээдэд ногдуулах шийтгэлийг хоёр дахин нэмэгдүүлэн хүлээлгэх;

- Согтолтын зэргээс хамааран тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, торгууль оногдуулах, баривчлах шийтгэлийг ялгамжтай оногдуулах;

- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил үйлдэх үед тухайн жолоочийг дэмжсэн, тээврийн хэрэгсэлд нь хамт зорчиж явсан зорчигчдод жолоочид хүлээлгэх торгуулийн 25%-тай тэнцэх хэмжээний торгууль оногдуулдаг болгох;

- Тухайн зөрчил үйлдсэн жолоочийн унаж явсан тээврийн хэрэгслийг эрх хасагдсан хугацаагаар хөдөлгөөнийг хязгаарлах. /журмын хашаанд байрлуулах, автомашины дугуй түгжигч ашиглах гэх мэт/.

Ашигласан материал

1. ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 2.2-р зүйл "Гэм буруугийн хэлбэрүүд".

2. ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 3.1-р зүйл.

3. <https://ru.wikipedia.org/wiki/>.

4. Traffic Safety Measures in Japan. http://www.mlit.go.jp/road/management-e/e_pdf/0403_5.pdf.
5. <https://criminal-law-germany.lawyer/administrative-offences/>.
6. Фридрих-Кристиан Шрёдер. Захиргааны хариуцлагын тухай хуулийн төсөл боловсруулахад зориулсан удирдамж. Эргэцүүлэл. УБ., 2010.
7. <https://www.udv.de/resource/blob/78144/>.

RANSOMWARE БУЮУ ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ БАРЬЦААЛАХ ГЭМТ ЯВДЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

E-DATA PLEDGE PERCEPTION OF SIN

*Б.Батцэрэн
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн дэд профессор,
цагдаагийн хошууч*

*Б.Өүжин
Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
суралцагч*

Товч агуулга: “Ransomware” гэдэг нь хүмүүсийн цахим бүртгэл, компьютерт хадгалагдаж буй нэн чухал хэрэгцээтэй мэдээлэл, өгөгдөл болон файлуудыг тусгай аргаар шифрлэж, дахин ашиглах боломжгүй төрөлд хувирган, форматыг өөрчилдөг хортой код юм. Энэ өгүүллээр халдлагад ашигладаг программ хангамжийг ransomware-ийн тухай ойлголт, шинжийн талаар тодорхойлсон.

Abstract: Ransomware is a type of malicious code that encrypts and changes the format of files and data stored on people’s electronic records and computers in a .. way. This article describes the concept and characteristics of ransomware, the software used in the attack.

Түлхүүр үгс: Мэдээллийн аюулгүй байдал, цахим мэдээлэл барьцаалах (ransomware), онлайн төлөөс нэхэх, цахим өгөгдөл.

Keywords: Information security, ransomware, threat to obtain other’s property in online, data, extortion.

Монгол Улс 2010 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 141 дүгээр тогтоолоор “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах” үндэсний хөтөлбөр гаргасан нь компьютерын мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн асуудлыг хөндсөн анхны үндэсний баримт бичиг болсон. Үүнээс хойш компьютерын мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, кибер гэмт хэргийн талаар тусгайлан баримт бичиг гараагүй, зөвхөн эрүүгийн хуулийн 26 дугаар бүлгийн заалтуудыг шинэчлэн найруулж компьютерын болон кибер гэмт хэргийн зарим шинжийг тодорхойлон оруулсан.

Цахим гэмт хэрэг гэж компьютерын эсвэл кибер орон зайг (Интернэт сүлжээ) харилцаа холбооны хэрэгсэл болгон ашиглаж үйлдэгдсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийг хэлдэг. Кибер гэмт хэрэг гэсэн албан ёсны тодорхойлолт байдаггүй боловч “Компьютерын гэмт хэргийн судалгааны төв”-ийн тодорхойлсноор “Компьютерыг гэмт хэрэг үйлдэх хэрэгсэл болгон ашиглаж, эсхүл компьютерыг гэмт хэргийн халдлагын зүйл болгож интернэт ашиглан эсхүл интернэт орчинд үйлдсэн гэмт хэргүүдийг кибер гэмт хэрэг гэнэ” хэмээн тодорхойлсон байдаг⁴³. Бүх төрлийн цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэрэгт компьютер, түүний ард суугаа хохирогч хүнийг хоёуланг нь хамруулж үздэг буюу зөвхөн энэ хоёрын аль нь халдлагын зүйл болж байгаагаас хамаарч уг гэмт хэрэг нь өөр өөр ангилалд хуваагддаг.

⁴³ Internet Crime Complaint Center-ийн мэдээлэл. 2014 оны 06 сарын 10.

Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг нь хувь хүний эсрэг, өмчлөх эрхийн эсрэг, төр, байгууллагын эсрэг, нийгмийн эсрэг гэсэн үндсэн 4 төрөлд хуваагддаг ч үйлдлийн арга нь хэдэн арваар тогтохгүй байна.

Кибер гэмт хэргийн концепц нь уламжлалт гэмт хэргийн концепциос зарчмын хувьд нэг их ялгаа байхгүй. Аль аль нь үйлдэл, эс үйлдэхгүйгээр дамжин үйлдэгддэг, эрүүгийн юм уу кибер гэмт хэргийн хуулийн заалт, хэм хэмжээг зөрчсөн, төрийн санцаар тэнцвэрждэг. Гэхдээ гэмт хэрэг үйлдэх арга, орчин, нотлох баримт зэрэг зүйлүүдээр ялгаатай ойлголтууд.

Эртний Грекийн “Cyber”, “Kubernetes” гэдэг үг удирдлага, засаглал гэсэн утгатай бөгөөд анх 1940 онд АНУ-ын математикч Норберт Винер удирдахуйн ухааны тухай номоо “Cybernetics-Кибернетика” хэмээн нэрлэж гаргаснаар энэ үг дэлхий даяар хэрэглэгдэх эхлэл тавигдсан. Улам хурдсаж буй компьютерын хөгжил, тэднийг хүнтэй төстэй болгох оролдлогуудаас үүдэн өнөө үед кибернетик нь хиймэл оюун ухаан болон автоматжуулалттай нягт холбогдож, мэдээллийн онолын салбарын санаануудаас олныг өөриймшүүлэн авч байна⁴⁴.

Монгол Улсын үндэсний хууль тогтоомжийг кибер гэмт хэргийн талаарх дэлхийн улсуудын хууль тогтоомжтой нэг мөр болгон уялдуулах, олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орох, хууль хамгаалах байгууллага, шүүхийн чадварыг хөгжүүлэх нь нэн тэргүүний тулгамдаж байгаа асуудал гэж үзсэн. Дэлхийн бусад улсууд ч эрүүгийн болон кибер гэмт хэргийн чиглэлээр шуурхай хамтран ажиллах механизм бий болгох нь маш чухал болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Кибер гэмт хэргийн тодорхойлолт нь энэ нэр томъёог ашиглаж буй зорилгоос ихээхэн хамааралтай. Кибер гэмт хэрэг гэдэгт компьютерын өгөгдөл, системийн бүрэн бүтэн, хүртээмжтэй, нууцлагдсан байдлын эсрэг чиглэсэн, ихэвчлэн кибер орчинд үйлдэгддэг гэмт үйлдлүүдийг ойлгодог. Гэхдээ кибер гэмт явдал гэдэг ойлголтод компьютерын мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, компьютерын гэмт хэрэг, компьютер ашиглахтай холбоотой гэмт хэрэг зэрэг бусад олон ойлголтууд, компьютер ашиглан ашиг олох, хувийн болон санхүүгийн хохирол учруулах, хувийн өгөгдлийг ашиглан гэмт хэрэг үйлдэх, өгөгдлийг хуулан авах, компьютер, тооцоолох төхөөрөмж ашиглан хуурамч баримт бичиг үйлдэх гэх мэт маш олон төрлийн гэмт хэрэг хамаардаг. Тиймээс бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт гаргахад их төвөгтэй.

Кибер гэмт хэрэг гэдэгт юуг ойлгох талаар судлаачдын олон янзын байр суурь байдаг. Тухайлбал судлаач Ц.Хүрэл-Очирын тэмдэглэснээр кибер гэмт хэрэг гэдэг нь товчхондоо компьютерийн гэмт хэрэг болон интернэтийн гэмт хэргийг нэрлэж буй нэр томъёо юм. Интернетийн гэмт хэрэг гэдгийг “компьютерийн сүлжээгээр хийгдэж буй өөр өөр төрлийн гэмт хэргүүдийн нийлбэр” гэж томъёолж болох юм. Үүнд:

Дэлхийн улс орнуудад нийтлэг байдлаар Компьютерийн гэмт хэргийн тухай хууль, Эрүүгийн хуульд дараах хууль бус үйлдлүүдийг компьютерийн гэмт хэрэг хэмээн хуульчилжээ⁴⁵.

- Компьютер, тооцоолох төхөөрөмж, систем, сүлжээнд хууль бусаар хандах;
- Программ, өгөгдөл, мэдээллийг зөвшөөрөлгүй өөрчлөх, гэмтээх, ашиглах, задлах, хуулах, хаах, хязгаарлах, түгжих;
- Вирус, өт, троян гэх мэт хортой кодыг тооцоолох төхөөрөмжийн системд оруулах;
- Компьютерийг залилангийн гэмт хэрэг үйлдэхдээ ашиглах;

⁴⁴ Britannica. Ширээний нэвтэрхий толь. 1530 дахь тал.

⁴⁵ Отгонбаяр Б. Технологийн эрин дэх хууль зүйн боловсрол: тулгамдсан асуудал, чиг хандлага. Магистрын зэрэг горилсон бүтээл. Уб., 2020.

- Бусад этгээд өөрийн тооцоолох төхөөрөмж, компьютертээ хандахал нь хөндлөнгөөс оролцох, саатуулах;
- Гэмт хэрэг үйлдэхийн тулд шифрлэлт ашиглах;
- Тооцоолох төхөөрөмжид хадгалагдаж буй өгөгдөл, мэдээллийн эх сурвалж, зохиогч, огноо гэх мэт нарийн мэдээллийг зөвшөөрөлгүй өөрчлөх, устгах;
- Имэйлийн эх сурвалж мэдээллийг хуурамчаар үйлдэх, өөрчлөх;
- Үйлчилгээ үзүүлэгчийн аль нэг цахим үйлчилгээг хулгайлах гэх мэт.

Кибер гэмт хэргийн дараах үндсэн шинжүүдийг тодорхойлон гаргаж болохоор байна. Үүнд:

- Кибер гэмт хэрэг маш хурдан үйлдэгддэг, ихээхэн үр дүнтэй;
- Кибер гэмт хэрэг газар зүйн байрлал, хязгаарлалт, хил зайнаас үл хамаарна;
- Кибер гэмт хэрэг кибер орон зайд зайнаас үйлдэгддэг;
- Кибер гэмт хэрэг нь төсөөлөхийн аргагүй хор хохирол учруулж болно;
- Кибер гэмт хэргийн нотлох баримтыг цуглуулах маш хүндрэлтэй, нэгэн зэрэг хэд хэдэн улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэх боломжтой;
- Кибер гэмт хэргийг илрүүлж, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад тусгай мэдлэг, боловсрол шаардагддаг.

Кибер гэмт хэргийн хохирогч нь ихэвчлэн хувь хүмүүс байгаа бөгөөд тэдний 90 хувь нь цагдаад мэдэгдэх бодолгүй байдаг байна. Кибер сүрдүүлэг, гүтгэлэг нийт үйлдлийн 34 хувийг, онлайн залилан, хувийн өгөгдөл хулгайлах, фишинг, бүртгэлийн мэдээлэлд нь хууль бус хандсан үйлдэл үлдэх хувийг эзэлж байна.⁴⁶ Монгол улсын иргэд хөгжиж буй улсуудтай ойролцоо түвшинд хохирч байгаа бол өндөр хөгжилтэй улсын иргэд хохирогч болох нь харьцангуй бага хувьтай байна.

Монгол Улсын бизнесийн салбарын байгууллагууд кибер гэмт хэргээс хохирсон талаараа мэдээлэл хуваалцах тун дургүй, ихэнх нь бизнесийн нууц хэмээн татгалзсан нь энэ талын мэдлэг сул, мэдээллийн аюулгүй байдлаа хангаж чаддаггүй, статистик мэдээллийн ач холбогдлыг огт ойлгодоггүй болохыг нь харуулж байна. Хөгжингүй улсуудын бизнесийн салбарынхан энэ статистик мэдээллийг ил тод байлгадаг учир төрийн бодлого боловсруулах, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлэхэд ихээхэн тус дөмтэй байдаг.

Кибер гэмт хэргийн өсөлтийн шалтгаан

Сүүлийн жилүүдэд кибер гэмт хэргүүд уламжлалт гэмт хэргээс тоо, хохирлын хувьд давж гарлаа хэмээн зарим эх сурвалжууд мэдээлж байна. Эрсдэл болон зардал бага, унац ихтэй тэр газарт түүнийг ашиглах гэсэн хүмүүс борооны дараах мөөг шиг олширдог. Яг энэ байдал кибер орон зай, интернет орчинд үүсээд байна. Компьютер, мэдээллийн технологийн багахан ч гэсэн мэдлэг чадвартай, ашиг олохыг хүссэн, шударга бус хэн бүхэн энэ орон зайг ашиглан ашиг олохын төлөө улайран зүтгэх болсон. Түүнээс гадна энэ чиглэлийн эрх зүйн орчин сул, зарим улсад огт бүрэлдэн тогтоогүй, компьютер, тооцоолох төхөөрөмж, программ хангамжид эмзэг сул байдал, цоорхой их байдаг, байгууллага, хүмүүс мэдээллийн аюулгүй байдлаа хангах, сүлжээ, интернетэд зөв, зохистой ажиллах чадвар, мэдлэг туршлага муутай, кибер орчинд ул мөр бага үлддэг, нотлох баримт нь тогтвортой бус, бэхжүүлж авахад хүндрэлтэй, хууль хяналтын байгууллагуудын чадвар төлөвшөөгүй, чадварлаг мэргэжилтэн ховор зэргээс илрэх магадлал нь уламжлалт гэмт хэргүүдээс хэд дахин бага байдаг нь кибер гэмт хэрэгтнүүдийн дураар аашлах боломжийг олгож байна.

⁴⁶ Сумъяацэрэн Д. Монгол Улс дахь кибер гэмт хэргийн өнөөгийн байдал, дүгнэлт санал. Эрдэм шинжилгээний өгүүлэл. Уб., 2013.

Дэлхийн хүн амын 55 хувь буюу 5,2 тэрбум хүн интернэт хэрэглэдэг бөгөөд манай орны хувьд интернэт хэрэглэгчдийн тоо 2,9 саяд хүрсэн. Монгол Улсын хүн амын бүтэц нь харьцангуй залуу ба цахим орчны хэрэглээгээр Ази тивд өндөртөө ордог, тухайлбал, Монголд фейсбүүк хэрэглэгчдийн тоо 2012 онд 654 мянга байсан бол өнгөрсөн жилийн байдлаар 2.7 сая болж нэмэгдсэн, хүн амын 80 гаруй хувь интернэт ашигладаг ба үүнээс 96 хувь нь фейсбүүк ашигладаг гэсэн судалгаа байна.⁴⁷

2020 оны цахим засаглалын хөгжлийн индексээр Монгол улс 92 дугаар байранд бичигдсэн бөгөөд Төрийн 56 байгууллагын 539 үйлчилгээг цахимжуулсныг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар мэдээлсэн.

Манай улсын хувьд мэдээллийн аюулгүй байдал хурцадмал нөхцөлд байгаа буюу Олон улсын BIG DATA” хэрэгжүүлэх байгууллагаас гаргасан дүгнэлтээр аюулд өртөх магадлал дэлхийд 5-т эрэмбэлэгдэж байна.⁴⁸ Монгол Улсын хувьд кибер орчны хэрэгцээ, интернэт хэрэглээ нь хүн амын тоотой харьцуулахад дэлхийн дундаж үзүүлэлтээс харьцангуй давсан байдаг нь анхаарах ёстой асуудлын нэгт зүй ёсоор багтана.

Кибер халдлага, пишинг, онлайн мөрдлөг, заналхийлэл, скиминг буюу картны гэмт хэрэг, онлайн залилан, садар самуун дүрс бичлэг тараах, интернэтэд суурилсан оюуны өмчийн эсрэг гэх мэт гэмт хэргүүдийг багтаан ойлгодог Кибер гэмт хэргийн талаарх ойлголт нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн төрлүүдээр хязгаарлагддаггүй. Манай Улсын хувьд цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн тоо сүүлийн жилүүдэд харьцангуй өссөн үзүүлэлттэй байгаа нь цахимжсан өнөөгийн нийгэмд хэн бүхэн аюулд өртөх магадлал өндөр болж байгааг харуулж байна.

Өнөө үед банкны салбарт үйлдэгдэж буй төрөл бүрийн цахим гэмт хэргүүд, криптовалюттай холбоотойгоор шинээр гарч ирсэн кибер гэмт хэргүүд, онлайн төлөөс нэхдэг цахим гэмт хэргүүд Монгол Улсын Эрүүгийн хуульд учир дутагдалтай байгаа нь гэмт этгээдүүдэд ял завших боломжийг олгож байна. Эрүүгийн хуулийн 26-р бүлэгт заасан “Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-үүд нь ихэд хуучирсан ойлголт дээр тулгуурласан, орчин үеийн кибер гэмт хэрэг болоод цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргүүдийн шинжүүдийг огт зааж оруулаагүй, дээр үеийн компьютерын гэмт хэргүүдийн зарим шинжийг хуульчилсан байгаа нь Монгол улс кибер гэмт хэрэгтнүүдийн хувьд диваажингийн улс болж хувирсныг харуулж байна.

Хэдийгээр Эрүүгийн хуульд уламжлалт гэмт хэргүүдийг хуульчилсан боловч тэдгээртэй ижил төстэй цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргүүдэд ял шийтгэл оноох боломжгүй, төсөөтэй хэрэглэх боломжгүй байна. Кибер орон зай нь виртуал хийсвэр шинжтэй учир бусдын өмчийн эсрэг нийгэмд аюултай үйлдлүүд нь биет, бодит эд зүйлс рүү чиглэсэн бус, харин тэдгээртэй эдийн засгийн ижил үнэ цэнтэй криптовалют, цахим мөнгө, бэлэн бус мөнгө гэх мэт бусад зүйлсэд чиглэсэн байдаг.

Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийг сүлжээгээр дамжин зайнаас үйлддэг учир өмчлөх эрхийн эсрэг цахим гэмт хэргүүдийг компьютер, тооцоолох төхөөрөмж, мэдээллийн сүлжээ, түүний үүсгэсэн цахим орчныг ашиглан үйлддэг гэж хэлж болно. Мэдээж энэ төрлийн гэмт хэргийн төрлийн объект нь эдийн засгийн харилцаа байна. Өөрөөр хэлбэл, өмчлөх эрхийн эсрэг цахим гэмт хэргүүд зөвхөн мэдээллийн технологи, компьютерын хүрээн дахь харилцаанд аюул

⁴⁷ Тагнуулын ерөнхий газрын албан ёсны цахим сайт.

⁴⁸ Отгонбаяр Б. Технологийн эрин дэх хууль зүйн боловсрол: тулгамдсан асуудал, чиг хандлага. Магистрын зэрэг горилсон бүтээл УБ., 2020.

учруулаад зогсохгүй нийгмийн бусад олон харилцаанд аюул учруулдаг. Энэ нь цахим орчинд нэгэн зэрэг хэд хэдэн төрлийн гэмт хэргийг үйлдэх болон нэг эсхүл хоёр объектод гэмт хэргийг нэгэн зэрэг үйлдэх боломжтой байдаг гэсэн үг юм.

Тэгвэл RANSOMWARE гэж юу вэ?


Цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргүүдийн нэг төрөлд багтдаг бөгөөд Ransomware-ийн "Ransom" гэдэг нь золиос, барьцаа гэсэн утгатай үг юм.⁴⁹ Ransomware гэдэг нь хүмүүсийн цахим бүртгэл, компьютерт хадгадагдаж буй нэн чухал хэрэгцээтэй мэдээлэл, өгөгдөл болон файлуудыг тусгай аргаар шифрлэж дахин ашиглах боломжгүй төрөлд хувирган форматыг өөрчилдөг хортой код юм. Ransomware хүмүүсийн компьютерт зүсээ хувилган email attachment хэлбэрээр ирэх бөгөөд санамсаргүйгээр нээх аваас компьютер дээрхи файлуудыг encrypt-кодлон түгжиж тухайн хэрэгцээт файлуудаа нээх боломжгүй болж орхидог байна. Ransomware үйлдэж байгаа гэмт этгээд нь файлыг encrypt хийсний дараа хохирогчоос төлбөр нэхэх ба тухайн файлууд, болон бусад мэдээллүүд нь үнэхээр чухал хэрэгцээтэй, хувийн нууцтай холбоотой, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь нөлөөлөхүйц баримт, сэлт, мэдээлэл байвал тэдгээр мэдээллийг барьцаалан түүнийг устгах эсхүл задруулахаар сүрдүүлж мөнгө төлөхийг шаарддаг бөгөөд төлбөрөө төлсөний дараа цоожилсон файлыг decrypt хийж эргүүлж өгдөг (зарим тохиолдолд өгөхгүй) хууль бус үйлдэл юм. Ерөнхийдөө ийм халдлагад ашигладаг программ хангамжийг ransomware гэж нэрлэдэг. Тодруулбал, хакерууд аль нэг байгууллагын чухал файл өгөгдлийг шифрлэхийн (encrypt) тулд ransomware ашигладаг бөгөөд өөрийнх нь хандах системээс хаадаг. Дараа нь хакерууд дахин нэвтрэх эрхийг авахын тулд төлбөр төлөхийг шаардаж төлбөрөө төлөхгүй бол таны мэдээллийг задруулна, эсвэл устгана гэж заналхийлдэг байна.

Энэ төрлийн хортой код буюу вирусыг хөгжүүлэгчид нь сүүлийн үед идэвхижиж ажиллах чадварыг нь улам сайжруулсаар байгаа бөгөөд нэгээс нөгөөд дамжуулахдаа имэйл болон вэб сайт, зөөврийн төхөөрөмжийг ашигладаг байна. Халдагч хортой кодоо файлд хавсарган файл хэлбэрээр өнгөлөн далдлалт хийн имэйл болон зөөврийн төхөөрөмжид хийн явуулдаг. Хэрэглэгч тухайн файлыг нээх үед файлд хавсаргасан хортой код идэвхжин хэрэглэгчийн оролцоогүйгээр хортой кодоо татан суулгадаг байгаа. Уг вирусны халдвар хувь хүн, байгууллагатай хамтран ажилладаг гэрээлэгч компаниудын нэрийг хуурамчаар ашигласан имэйл (фишинг-phishing email), freeware, shareware, torrent, Dropbox зэрэг онлайн суурьт аппликэйшнүүд, сонирхол татсан зар суртчилгаа, Facebook, LinkedIn - ийн урилга, Zeus ботнет зэргээр дамжиж хэрэглэгчдэд хүрсэн байна. Энэхүү хортой кодыг зарим антивирусын програмууд одоог хүртэл нээн илрүүлж чадаагүй байгаа юм.

Ransomware-ийг "Check Point" компанийн мэргэжилтнүүд үүнийг Оросоос гаралтай гэж үзэж байгаа юм. Гэтэл үүнтэй ижил төстэй халдлага анх 1989 онд бүртгэгдэж байсан нь үүнд эргэлзээ төрүүлсэн ч хамгийн анхны тохиолдлыг ОХУ-д бүртгэгдсэн хувилбараар тодорхойлсон. Ransomware нь анх 2005 онд Орост бүртгэгдэн GPCode Trojan гэсэн нэрээр олонд танигдах болжээ Kaspersky ийн ажилтан шинжээч уг вирусийн кодыг зохиосон зохиолчийн алдаан дээр ажиллаж вирусийг эвдэж чадсан боловч одоо улам боловсронгуй болж маш ярвигтай болсоор байна.


⁴⁹ Britannica. Ширээний нэвтэрхий толь. 3156 дахь тал.

Зураг 1. Ransomware буюу цахим мэдээлэл барьцаалах халдлагын хөгжлийн үе шат



Судалгаанаас үзэхэд, доорх улсууд уг халдлагад хамгийн их өртдөг болох нь тогтоогдсон бөгөөд эдгээр орнуудын ихэнх нь хуучин үеийн BLOCKER төрлийн халдлагад өртдөг байна. Тэрчлэн АНУ, Герман, Итали зэрэг орнуудын 40% нь Ransomware дотроо хамгийн аюултайд тооцогддог CRYPTOR төрлийн халдлагад өртөн хохирогч болоод байна. Ransomware вирусээс болж мянга мянган компани, корпораци, хувь хүмүүс маш их хэмжээний төлбөрүүдийг төлсөөр байна. Харин Монгол улсын хувьд уг төрлийн халдлагад өртөх өндөр магадлалтай орны тоонд багтаж байгааг шинжээчид үзэж байна⁵⁰.

Зураг 2. Ransomware буюу цахим мэдээлэл барьцаалах халдлагад хамгийн их өртөж байгаа улс орнууд



⁵⁰ Отгонбаяр Б. Технологийн эрин дэх хууль зүйн боловсрол: тулгамдсан асуудал, чиг хандлага. Магистрын зэрэг горилсон бүтээл УБ., 2020.

Ransomware нь маш олон төрөл байдаг бөгөөд Blocker болон CryptoLocker гэсэн төрлүүд хамгийн түгээмэл байдаг. Blocker нь CryptoLocker-г бодвол арай эрт гарч ирсэн хортой код юм. Blocker нь хэрэглэгчийн файлуудын форматыг алдагдуулдаг бол CryptoLocker нь хэрэглэгчийн бүх файлыг encryption буюу шифрлэдэг байгаа. CRYPTO валют нь дижитал төлбөрийн систем ба данс эзэмшигчийн цаана хэн байгааг илрүүлэх ямар ч боломжгүй тул тэднийг барих тун хэцүү юм. Тэд өмнө нь Интернет хөтөч болон үйлдлийн системрүү хандах хандалт зэргийг блок хийдэг байсан бол одоо хэрэглэгчийн хард диск дээр хадгалагдаж буй файлуудыг ENCRYPT /цоожлох/ хийж байна. Ransomware нь дараах төрөлтэй. Үүнд: wannacry, ryuk, scareware, locky, maze, gandcrab, notpetya/petya, cryptowall, samsam, leakware, double extortion, bad rabbit, cerber, jigsaw, reslacrypt, torrentlocker, golden eye гэх мэт.

Зөвхөн 2019 онд гэхэд л 1100 гаруй төрлийн “Ransomware” хортой кодыг илрүүлсэн.⁵¹ Эдгээрээс хамгийн их аюул учруулсан нь Bad Rabbit, Cerber, Dharma, GandCrab, Jigsaw, Katyusha, LockerGoga, PewCrypt, Ryuk, SamSam хэмээх хортой кодууд юм.⁵² Мөн хамгийн түгээмэл үйлдэгддэг хэд хэдэн төрөл байдаг ба тэдгээрээс дурдвал:

- Extortionware нь ransomware-ийн хамгийн түгээмэл төрлийн нэг бөгөөд ихэнх тохиолдолд компьютерийн дижитал систем рүү нэвтэрч бүх файл, мэдээллийг шифрлэж цоожлосны дараа хохирогчийн болон ойр дотны бусад хүмүүсийн эмзэг, ичгүүртэй эсхүл хууль бус зэрэг аливаа мэдээллүүдийг түүн авч мөнгө, биткоин төлүүлэх байдлаар тэдгээрийн эсрэг сүрдүүлэн ашигладаг. Энэ төрлийн ransomware-ийг эмнэлэг, томоохон компаниуд, банк, улс орнуудын цагдаагийн газрын цахим сан зэрэг бусдын эрх ашиг, сонирхолд нөлөөлөхүйц хувийн нууц мэдээлэл ихээр агуулагддаг, тэр хэмжээгээрээ их мөнгө, ашиг, олж болохоор салбаруудад нарийвчилсан зохион байгуулалттайгаар үйлдэх тохиолдол их байдаг. Гэвч арай бага ашигтай гээд хувь хүн рүү огт халдахгүй гэсэн үг биш юм. Өөрөөр хэлбэл, их мөнгө олж болохоор байгууллага, хуулийн этгээд рүү халдахын тулд маш өндөр түвшний мэдлэг, ур чадвар, шаарддаг их эрсдэлтэйгээс гадна баригдахгүйн тулд бүхий л боломжоо дайчлан зохион байгуулалттайгаар бүлэглэн үйлддэг байна. Харин хувь хүний хүн рүү чиглэн халдвал эрсдэл бага, баригдах магадлал харьцангуй бага, тул энэ төрлийн халдлага ч цөөнгүй.

- Blocker нь анх гарсан үедээ хэрэглэгчдийн үйлдлийн системийг гэмтээх, файлуудын форматыг алдагдуулах, веб браузерийн хандах хандалтыг хаах зэрэг хохирол учруулан хэрэглэгчээс багахан хэмжээний төлбөр төлөхийг шаардан хэрэглэгч рүү (таны явуулсан мөнгийг буяны үйлд зориулах болно) гэсэн мессеж илгээдэг. Харин орчин үед хэрэглэгчийн хэрэглээний файлуудыг шифрлэж хохирогчоос төлбөр нэхэмжлэн, онлайнаар шилжүүлэг хийхийг шаарддаг болсон. Хэрэв та нэгэнт Ransomware-т өртсөн бол нэн түрүүнд энэхүү вирусээс салахын тулд өөрийн файлуудыг яаралтай decrypt хийх буюу шифрлэлтийг буцаах замаар вирус халдагч этгээдтэй холбогдох юм. Халдагч этгээд өөрт холбогдох онлайн төлбөрийн дансаа үлдээж таны файлуудтай дүйцэх хэмжээний төлбөрийг нэхэмжилнэ. Төлбөрийг Bitcoin буюу онлайн мөнгөний хэрэгслийг сонгож нэхэмжлэх ба төлбөрийн энэ аргыг ашигласан тохиолдолд дансны эзэмшигч этгээдийг олж илрүүлэх боломжгүй байдаг. Төлбөрөө хэдий төлсөн ч таны файлыг сэргээнэ гэдэгт итгэж болохгүй.

⁵¹ Мөн тэнд.


⁵² Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын албан ёсны цахим сайт дах 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн нийтлэл.

• CryptoLocker нь 2014 оны есдүгээр сард Ransomware вирусыг хүн амын шилжилт хөдөлгөөн ихтэй Австралийн хэрэглэгчдэд зориулан CryptoWall болон CryptoLocker гэсэн хоёр төрөл гаргасан байна. CryptoLocker нь таны компьютер дээрхи бичиг баримт, зураг, аудио, зиплэсэн файл гэх бүхий л хэрэгтэй файлуудыг encrypt буюу шифрлэж хэрэгцээт файлуудыг чинь нээх боломжгүй болгож орхидог. Encrypt хийлгэсэн файлаа аюулгүй болгохын тулд Decrypt хийх шаардлагатай. Ингэхийн тулд тухайн хортой програмыг зохиосон хүнд мөнгө төлөх ёстой. Хэрэв та мөнгө төлөхгүй бол таны бүх файл encrypt чигдээ үлдэх болно. Ransomware вирус танд email attachment хэлбэрээр ирэх бөгөөд санамсаргүйгээр нээх аваас таны компьютер дээрхи файлуудыг encrypt буюу шифрлэн түгжиж та хэрэгцээт файлуудаа нээх боломжгүй болж орхидог байна. Үүний дараагаар хард драйверуудыг хайж дараах өргөтгөлтэй файлуудыг шифрлэдэг. Үүнд: 3fr, accdb, ai, arw, bay, cdr, cer, cr2, crt, crw, dbf, dcr, der, dng, doc, docm, docx, dwg, dxf, dxg, eps, erf, indd, jpe, jpg, kdc, mdb, mdf, mef, mrw, nef, nrw, odb, odm, odp, ods, odt, orf, p12, p7b, p7c, pdd, pef, pem, pfx, ppt, pptm, pptx, psd, pst, ptx, r3d, raf, raw, rtf, rw2, rwl, srf, srw, wb2, wpd, wps, xlk, xls, xlsb, xlsx, xlsm, xlsx. Та файлаа сэргээхийн тулд хортой код халдаагч этгээдэд төлбөр төлөснөөр файлаа сэргээх боломжтой болно.

Хэрэглэгч компьютерийг барьцаанаас чөлөөлөх мөнгийг төлж файлуудын шифрийг тайлуулсан тохиолдолд CryptoLocker-ийн хакерууд таны компьютерийг дахин халдварлуулдаггүй байна. Мөн Cryptolocker техникийн бус вирус бөгөөд хохирогч компьютерт имэйлээр болон интернэтээс програм хангамж татаж суулгахад л давхар орж ирдэг.

Зураг 3. Ransomware буюу цахим мэдээлэл барьцаалах халдлагын барьцаа төлөөсний хэмжээ (өсөлт)

Ransom Payments By Quarter



Манай улсын хувьд хамгийн эрсдэлтэй орчин буюу фэйсбүүк цахим орчинд энэ төрлийн халдлага түгээмэл гардаг бөгөөд иргэд өөрсдөө тухайн халдлага, заналхийллийн талаар мэдлэггүй, ойлголтгүй тул өөрсдөө хохирогч болж байгаа гэдгээ ч мэддэггүй, хууль хүчний байгууллагууд тэдгээрийг ялган салгаж чадахгүй,

нэг бол кибер гэмт хэрэг, эсхүл цахимаар үйлдэгдэж байгаа залилах гэмт хэрэг хэмээн зүйлчилж ихэнх тохиолдолд хэргийг хаах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэх явдал түгээмэл байна. Ийм нөхцөл байдалд байгаа хамгийн том хүчин зүйл бол тухайн үйлдэлд тохирсон хууль байхгүй, хууль байхгүй тул энэ төрлийн гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх боломжгүй байна.

Манай улсад сүүлийн 3 жилд “компьютер хакердуулчихлаа, фэйсбүүкээр мөнгө нэхсэн, фэйсбүүкээ хакердуулсан, цахимаар харилцаж байсан хүн сүрдүүлээд байна” гэх зэрэг утгатай гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл цагдаагийн байгууллагад тийм ч их ирүүлэхгүй байгаа нь энэ талын мэдлэг дутмаг, эрх бүхий байгууллагад итгэх итгэл сул байгааг илтгэж байна. Гэтэл үүнээс гадна хэн нэгэнд мэдэгдэхээс айж эмээсэн, хохирч байгаагаа мэдээгүй, заналхийлэлд одоо ч өртсөөр байгаа, хаана хандахаа мэдэхгүй иргэд далд хэлбэрээр байсаар байгаа нь энэ төрлийн цахимаар заналхийлэх гэмт хэргийг хуульчилан, иргэдэд таниулах хэрэгцээ шаардлага үүссэнийг харуулж байна. Гэтэл цахим хэлбэрээр заналхийлэх явдал нь улс орнуудад зохион байгуулалттайгаар түгээмэл тохиолдон, их хэмжээний хохирол учруулах томоохон халдлагууд гарч, цахим мэдээлэл барьцаалан заналхийлэх арга хэлбэр нь илүү нарийсаж байгаа нь дэлхий нийтийн санааг зовоож байгааг дурдах нь зүйтэй.

Хууль эрх зүйн орчин хангалтгүй, кибер аюул, халдлагаас урьдчилан сэргийлэх, хариуцах арга хэмжээ авах эрх бүхий байгууллага байхгүй, олон улсын хамтын ажиллагаа дутмаг зэрэг хэд хэдэн үндсэн хүчин зүйлээс шалтгаалж ITU (International Telecommunication Union- Олон улсын цахилгаан холбооны байгууллага)-аас гаргадаг Олон улсын Кибер аюулгүй байдлын 2023 оны индексээр Монгол улс 120 дугаар байрт жагсжээ.⁵³ Энэ нь Монгол улс цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэрэгт өртөх магадлал маш өндөр байгааг илтгэж байна.

Одоо үед цахим банкнууд хөгжиж, мөнгө хөрөнгө цахим орон зайд шилжиж, цахим түрийвч мөнгө, криптовалюта хөгжиж байгаа нь энэ төрлийн цахим гэмт хэргүүд улам олширч, арга техник нь хөгжих таамаглалыг бий болгож байна. Тиймээс Монгол улсын эрүүгийн хуульд эдгээр гэмт хэргийг нэн даруй хуульчлан тусгах шаардлага тулгарах нь гарцаагүй.

Дүгнэлт

- Ransomware буюу цахим мэдээлэл барьцаалах гэмт халдлагын талаарх ойлголт Монгол Улсад байхгүй боловч эдгээр үйлдлийн аргаар гэмт хэрэг нэгэнт үйлдэгдэж, дийлэнх хувь нь шунахайн сэдэлтээр өмчлөх эрхийн эсрэг үйлдэгдэж байна. Нийгмийн хөгжлөө даган өмч хөрөнгө, эд зүйл цахим хэлбэрт шилжиж (цахим түрийвч, бэлэн бус мөнгө, цахим гарын үсэг, криптовалюта зэрэг), цахимжиж байгаатай холбогдуулан цахим мэдээллийн аюулгүй байдалд заналхийлэн, бусдын өмчид халдах гэмт хэргийн гаралт дэлхий нийтээр өсөх хандлагатай байгаа бөгөөд манай улсын хувьд тэр хэмжээгээрээ өсөх эрсдэл өндөр байна;

- Дэлхий нийтэд Ransomware буюу цахим мэдээлэл барьцаалах явдлыг үйлдлийн аргаар нь тусдаа бие даасан гэмт хэрэгт тооцож байгаа бол манай улсын Эрүүгийн хуульд тухайн гэмт хэргийг хуульчлан тодорхойлсон тодорхойлолт нь зөвхөн нэг бүлгийн хоёр зүйл заалтын хүрээнд объектив талын арга болох зөвхөн нууц далд аргаар, хууль бусаар нэвтэрсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байгаа нь учир дутагдалтай байна. Монгол Улсад үйлдэгдэж байгаа зарим төрлийн гэмт хэрэг нууц далд аргаар бус, илээр цахим мэдээлэл олж авч, түүнийгээ барьцаалан дараагийн гэмт хэргээ үйлдэж байна. Жишээлбэл: Цахим

⁵³ NCSI Ranking- National Cyber Security Index. 2023.

чатаар танилцан улмаар хувь хүний эмзэг мэдээлэл, зургийг өөрөөс нь олж авч бусдыг хүчиндэх, дээрэмдэх зэрэг гэмт хэргүүд сүүлийн жилүүдэд өсөж байгаа нь анхаарал татаж байна;

- Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг тодорхойлох үед үүсэж буй хүндрэл болон эрүүгийн хуулийн хуучирсан заалт, цагдаагийн байгууллагын чадамжтай холбоотойгоор Монгол Улс дахь цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн статистик өгөгдөл маш хомс байна;

- Ransomware буюу цахим мэдээлэл барьцаалах гэмт явдал жил ирэх тусам өсөн нэмэгдэх хандлага судалгаагаар тогтоогдсон бөгөөд учруулж буй хохирлын хэмжээгээр өндөр байгаа нь олон улсад энэ төрлийн халдлагатай тэмцэх арга замыг эрэлхийлэх хүчин зүйл болж, энэ асуудлыг анхааралдаа авсан боловч манай улсын хувьд тодорхой шийдэлд хүрээгүй байна.

Санал

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Ransomware буюу цахим мэдээлэл барьцаалах гэмт явдлыг Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомж, зохицуулалтыг олон улсын жишигт хүргэж, нэг мөр болгон Эрүүгийн хуулийн урьдчилан сэргийлэх зорилтыг хэрэгжүүлэх боломжтой болгох;

2. Эрүүгийн хууль бусад хуульд мэдээллийн аюулгүй байдлын үндсэн суурь ойлголт, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан үндсэн заалт болох мэдээлэл, мэдээллийн дэд бүтцийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлын эсрэг гэмт хэргүүд гэдэг хандлагыг тусгах;

3. Кибер гэмт хэрэг буюу интернэт, кибер орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг гэдэг үүднээс тодорхойлохоос гадна энэ төрлийн гэмт хэрэг дан ганц кибер аюулгүй байдлын эсрэг бус хуулиар хамгаалагдсан бусад эрх, ашиг сонирхолд халдах боломжтойг харгалзан үзэж зүйлчлэх, хамаарах заалтууд оруулах. Эдгээр заалтыг компьютер ашиглан үйлдэгдэж байгаа, компьютер, системд хадгалагдаж байгаа мэдээллийн эсрэг чиглэсэн, аливаа тооцоолох төхөөрөмж ашиглан үйлдэгдэж байгаа гэх мэт "ердийн" бусад гэмт хэргүүдэд нэгэн адил хамаарах байдлаар томьёолох шаардлагатай;

4. Монгол Улсын хувьд төрийн маш олон үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж байгаа нь сайшаалтай боловч эдгээр мэдээллийн хадгалалт, хамгаалалтын асуудлыг зөвхөн эрх зүйн хүрээнд бус, хүний нөөцийн чадвар чадамжийн хувьд нь анхаарч цогцоор нь шийдэх зэрэг саналыг гаргаж байна.

Ашигласан материал

1. Britannica. Ширээний нэвтэрхий толь.
2. Internet Crime Complaint Center-ийн мэдээлэл. 2014 оны 06 сарын 10.
3. NCSI Ranking- National Cyber Security Index. 2023.
4. Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын албан ёсны цахим сайт дах 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн нийтлэл.
5. Отгонбаяр Б. Технологийн эрин дэх хууль зүйн боловсрол: тулгамдсан асуудал, чиг хандлага. Магистрын зэрэг горилсон бүтээл. Уб., 2020.
6. Сумъяацэрэн Д. Монгол Улс дахь кибер гэмт хэргийн өнөөгийн байдал, дүгнэлт санал. Эрдэм шинжилгээний өгүүлэл. Уб., 2013.
7. Тагнуулын ерөнхий газрын албан ёсны цахим сайт.

СУРГУУЛИЙН ОРЧИНД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭМТ ХЭРЭГ БА ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТ

CAUSES, CONDITIONS AND CONSEQUENCES OF JUVENILE DELINQUENCY IN THE SCHOOL ENVIRONMENT AND PEER BULLYING

*Д.Отгонсүрэн
ДХИС-ийн ЭЗНУС-ийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш,
цагдаагийн дэслэгч*

Товч агуулга: Өсвөр насны хүүхдүүдийн гэмт хэрэг үйлдэх шалтгаан нь эцэг, эх, асран хамгаалагчийн хүүхдийг хүмүүжүүлэх арга зүй болон гэр бүлийн харилцаа, үе тэнгийнхний нөлөө буюу сургуулийн орчин дахь багш, сурагчдын хандлага, харилцаа маш их нөлөөлж байгаа нь харагдаж байна. Энэхүү сөрөг үр дагавраас сэргийлэх арга замыг дэлхийн олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага болон Монгол Улсын хэмжээнд цагдаагийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудаас тодорхойлж, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Abstract: The main causes of crime among today's teenagers are the health and family relationships of their parents and guardians, followed by peer influence, or the attitudes and relationships of teachers and students in the school environment it appears that there is. Ways to prevent these negative consequences are identified and implemented by international organizations for the protection of children's rights, police organizations and general education schools throughout Mongolia.

Түлхүүр үгс: Өсвөр насны хүүхэд, үе тэнгийнхэн, сургуулийн орчин, гэр бүл, багш сурган хүмүүжүүлэгч, гэмт хэрэг, хүчирхийлэл

Keywords: Adolescents, peers, school environment, family, teachers, educators, crime, violence.

Сургуулийн орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн тоо жилээс жилд огцом өссөөр байгаа нь доорх мэдээллээс харагдаж байна. Цагдаагийн байгууллагаас гаргасан судалгаагаар 2023 оны 2 дугаар сарын байдлаар 15 хүртэлх болон 16-17 насны буюу гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний тоо 105 байсан бол 2024 оны байдлаар 202 болж нэмэгдсэн 51.9 хувийн өсөлттэй байгааг харуулж байна.

Мөн гэмт хэрэг үйлдэгсдийг нийгмийн байдлын үзүүлэлтээр нь гаргасан статистик мэдээнээс үзэхэд 2023 оны байдлаар сурагч болон сургууль завсардсан хүүхдийн тоо 79 байсан бол 2024 онд сурагч 134, сургууль завсардсан хүүхэд 11 болж 54.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эдгээрээс үзэхэд өсвөр насны тэр дундаа гэмт хэрэг үйлдэж сурагчдын маш их хувиар нэмэгдсэн байх бөгөөд нийслэлд хамгийн их хувийг эзэлж байгаа харамсалтай үр дүн харагдаж байгаа юм.

Хүүхэд хамгааллын бодлогод хүүхдэд ээлтэй нийгэм, сэтгэлзүйн харилцааны орчныг бий болгоход анхаарч ажиллаж байгаа хэдий ч хүүхдийн тусламжийн 108 утсанд багшийн ёс зүй, үе тэнгийн дээрэлхэлт, дарамттай

холбоотой дуудлага нэлээд хувийг эзэлсээр байна. Үе тэнгийн дээрэлхэлт, дарамт нь хүүхдийн хөгжилд сөргөөр нөлөөлдөг гэмт явдал мөн бөгөөд урт хугацаандаа нийгмийн хөгжлийн тогтвортой байдалд нөлөөлдөг нийгмийн үзэгдэл юм. Монгол улсын хүүхэд хамгааллын салбарын нэг хэсэг болох сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалал нь боловсролын салбарт тогтсон асуудал болох үе тэнгийн дээрэлхэлт, дарамттай тэмцэх үүрэг бүхий салбар юм.

Сургуулийн орчинд үе тэнгийн дарамт, дээрэлхэлт нь хамгийн их үйлдэгдэж байгаа ба үүнд тохирсон арга хэмжээ хангалтгүй байгаа⁵⁴ нь тус төрлийн хүчирхийллийн цар хүрээг тэлэх нөхцөлийг бий болгож байна. Монгол улсын нийгэмд ядуурал, тэгш бус байдал ихэссэнтэй холбоотой олон сөрөг үр дагавар гарсны нэг нь маргинал⁵⁵ бүлгийн хүүхдүүдэд нийгмийн амьдралд оролцох эрхээ эдэлж, үе тэнгийн найз нөхдөөсөө суралцах явцад хүчирхийллийн арга замаар асуудлыг шийдвэрлэх нөхцөл байдалд хүрэх, харилцааны явцад гардаг аливаа зөрчлийг шийдвэрлэх арга замыг зааж өгөх насанд хүрэгч байхгүй байх зэргээс үүдэн үе тэнгийн дээрэлхэлт сургуулийн орчинд үйлдэгдэж байна⁵⁶.

Тэгш бус байдал нэмэгдсэн нь эрх мэдлийн хувьд тэнцвэргүй байдлыг улам өөхшүүлж сөрөг харилцаа тэр дундаа үе тэнгийнхний дарамт, хүчирхийллийг өдөөх нөхцөл болж байгаа юм.

Үе тэнгийн дээрэлхэлтийн илрэх хэлбэрүүд нь бие махбод болон эд хөрөнгөд халдах, ялгаварлан гадуурхах, нийгмийн харилцаанаас хязгаарлах, үгэн болон үгэн бус хэлбэрээр дарамтлах хэлбэрүүдээр илэрдэг бөгөөд эдгээр хэлбэрүүд сургуулийн орчинд хамгийн ихээр үйлдэгддэг байна. Мөн сүүлийн үед үе тэнгийн дээрэлхэлт нь цахим орчинд үйлдэгдэх хандлага өсөж байна.⁵⁷

Хүснэгт 1. Гэмт хэрэг үйлдэгсдийн тоо насны үзүүлэлтээр⁵⁸

Дээрэлхэлт гэдэг нь хэн нэгнийг хүсээгүй байхад өөр хэн нэгэн болон бүлгийн хэн нэгэн түүнд түрэмгий зан авир гаргахыг хэлнэ⁵⁹. Харин дарамт нь сэтгэл зүйн байдалд чиглэсэн буюу хүнд хэцүү байдлыг улам дэвэргэх хүчин зүйл, дахин дахин түвэг удах явдлыг илэрхийлнэ⁶⁰. Үе тэнгийн дээрэлхэлт, дарамт нь тодорхой цаг хугацаа, давтамжтай, янз бүрийн орчин орон зайд явагддаг ба анги бүлэг, нас, хүйс, амьдралын нөхцөл, сурлагын дүн, найз нөхдийн хүрээлэл зэргээс хамааран дараах байдлаар үйлдэгдэж байна.

Хүүхэд аюулгүй, хамгаалагдсан орчинд өсөх нь түүний бие махбод болон тархины хөгжил эрүүл явагдахад чухал байдаг бол байнга айдастай амьдрах нь тархины хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг⁶¹. Гэтэл судалгаанд хамрагдсан хүүхдүүд

⁵⁴ Бүх нийт боловсролын төлөө. Иргэний нийгмийн үндэсний эвсэл. Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аргачлал. Гарын авлага. УБ., 2020. 7 дахь тал.

⁵⁵ Маргинал бүлэг – Нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэйгээр урт хугацаанд гадуурхагдаж, боловсролын бодлого, төсөвлөлтийн хийдлээс сурч боловсрох эрх нь зөрчигдсөн бүлэг.

⁵⁶ Бүх нийт боловсролын төлөө. Иргэний нийгмийн үндэсний эвсэл. Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аргачлал. Гарын авлага. УБ., 2020. 7 дахь тал.

⁵⁷ Мөн тэнд. 12 дахь тал.

⁵⁸ Цагдаагийн байгууллагын 2024 оны 2 дугаар сарын мэдээ.

⁵⁹ Reiney, E6 (2017 09). Bullying Prevention and Response Training and Continuing education online program. Retrived from <https://www.stopbullying.gov/sites/default/files/2017-09/training-module-2016.pdf>.

⁶⁰ Цэвэл Я. Монгол хэлний их тайлбар толь. УБ., 2024.

⁶¹ <https://developingchild.harvard.edu/science/key-concepts/toxic-stress/>.

График 1. Хүүхдүүд хэнээс хамгийн их айдаг талаарх хариулт⁶²



⁶² Хүний Эрхийн Үндэсний Комисс. (2023). Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл. УБ., 2024. 15 дахь тал.

50

График 3. Дээрэлхүүлсэн, доромжлуулсан бол энэ нь юунаас болсон байх гэж бодож байна вэ? гэх асуултын хариулт⁶⁴



Түүнчлэн шалтгааны талаар тэднээс асуухад, зан байдлаас болоод 24.5 хувь, гадаад байдлаас болоод 20.3 хувь, найз нөхдөөс нь болж 17.2 хувь нь үзсэн байна. Хүүхдийн эрхийн зөрчилд хүүхдийн гэр бүлийн орчин болон багш зэрэг насанд хүрэгчдийн зүгээс үйлдэх зөрчилд илүү ач холбогдол өгсөөр ирсэн бол дээрх судалгаа үе тэнгийн дээрэлхэлт, дарамтад ч онцгой ач холбогдол өгөх

шаардлагатайг харуулж байна.

Үе тэнгийнхний хүчирхийлэл нь насанд хүрэгчдийн нүдээр харахад бага залуу насанд тохиолдож богино хугацаатай үргэлжилдэг энгийн зүйл мэт харагддаг хэдий ч энэхүү түрэмгийллийн алсын үр дагавар нь хоруу чанар өндөртэй, архаг явцтайгаар үргэлжилдэг бөгөөд хувь хүний амьдралын чанарыг эрс доройтуулж өөртөө итгэлгүй байдлыг үүсгэж, нийгмийн айдас, сэтгэл түгшилт, сэтгэл гутрал зэрэг сэтгэцийн олон эмгэгийг үүсэхэд ихээхэн нөлөөлж байна.

Судалгааны үр дүнгээс харахад хүүхдийн эрхийг зөрчиж, хүчирхийлэл үйлдэгч гол этгээдээр дээд ангийнхан (47.6%), хойд ээж аав (38.6%). үе тэнгийнхэн (38.4%), багш (15.0%), эцэг эх асран хамгаалагч (12.4%) нарыг нэрлээд байна. Үүнээс үзэхэд хүүхэд хүүхдэдээ үзүүлэх дарамт, хүчирхийлэл өндөр хувийг эзэлж байна⁶⁵.



⁶⁴ Мөн тэнд. 14 дэх тал.

⁶⁵ Ганцэцэг Т нар. Ахлах ангийн сурагчдын дундах үе тэнгийнхний хүчирхийлэл. УБ., 2020.

Үе тэнгийн дарамт хүчирхийлэлд өртсөнөөр хүүхэд бусдыг буруутгах хий харддаг хандлагатай болох, хичээлийн идэвх буурах, цаашлаад хичээл таслах, өөрийгөө тайвшруулахын тулд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх бусадтай эрүүл харилцаа тогтооход асуудал үүсэх, улмаар бүлгээс тусгаарлагдах ялгаварлагдан гадуурхагдах зэрэг маш олон эрсдэлд ордог байна. Түүнчлэн өсвөр насны хүүхэд анги сургууль дотроо ганцаардмал, зожиг болж өөртөө итгэл муутай сэтгэлийн гутралтай байх юм бол сурах идэвх буурахаас гадна хүрсэн хүнд итгэх итгэл буурч ганцаардан өөрт нь туслах хүн байхгүй юм шиг санагдаж, сэтгэлийн дарамтад орж мэднэ. Энэ байдлаас болж эрүүл мэнддээ хортой, аюулгүй байдалдаа халтай зан үйл гаргаж эхлэх магадлалтай⁶⁶.

График 4. Сургуулийн орчинд сурагчдын өртдөг дарамт хүчирхийллийн хэлбэрүүд



Сурагчдын 30,5% нь надад нэр хоч өгдөг, 25,07% үгээр доромжилдог, 12,09% нь мөнгө нэхдэг, 9,5% нь зодож, бие махбодод хүрдэг, 7,5% нь гадуурхдаг гэж хариулсан бол бусад гэсэн хариултыг 11,8% нь сонгожээ. Үүнээс үзвэл сурагчдын 55% нь харилцааны шинжтэй сэтгэлзүйн дарамт хүчирхийлэлд өртдөг болох нь харагдаж байна. Мөн мөнгө нэхэх, зодох гэсэн сонголтууд тус бүр 10% орчим хувийг эзэлж байна⁶⁷. 11-18 насны сурагчдын 16,5% нь багшаасаа айдаг гэж хариулсан байна. Сургуулийн орчинд багшийн зүгээс хүүхдийн эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх үүднээс сургалт, семинарт хамруулж түүнчлэн зөрчсөн тохиолдолд тодорхой арга хэмжээ авдаг байх хэрэгтэй байна. Чанарын судалгааны үр дүнгээс үзвэл багш хүүхдийн эрхийг зөрчдөг эсэх талаарх асуултад сурагчид өөртөө болон бусдадаа тохиолдсон маш олон баримт жишээнүүдийг дурдсан нь багш хүүхдийн эрхийг зөрчиж байгааг мөн энэ зүй бус үйлдэлдээ зохих ёсны хариуцлага хүлээдэггүй сурагчид л бие махбод, эрүүл мэнд, сэтгэл санаагаараа хохироод үлдэж байгаа нөхцөл байдлыг харуулж байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл

⁶⁶ Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал. УБ., 2021.

⁶⁷ Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын судалгаа. УБ., 2023.

хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие мах бодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг ойлгоно⁶⁸.

Хүүхэд хамгаалал гэж нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагааг хэлнэ. Хүүхдийн эрхийн талаарх хандлага, хэрэглээг тодорхойлох нэгэн чухал үзүүлэлт бол хүүхдийн эрхийн аливаа зөрчилд хүүхэд хариу үйлдэл үзүүлэх, зөрчлийг мэдээлэх явдал гэж үздэг⁶⁹. Хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл нэмэгдэхэд түүнийг мэдээлэхгүй байгаа явдал голлох нөлөө үзүүлж байна. Хүчирхийллийн асуудлыг мэдээлэхгүй байгаагийн шалтгааныг эцэг, эх болон хүүхдүүдээс тодруулахад хүүхдүүдийн 35.7 хувь нь, эцэг, эхчүүдийн 24.4 хувь нь хүчирхийлэгч өс санах вий гэдгээс айдаг. Хүүхдүүдийн 19.2 болон эцэг, эх асран хамгаалагчдын 16 хувь нь “энэ бол байдаг л асуудал” гэж үздэг ба хүчирхийлэлд өртсөн гурван хүүхэд тутмын нэг нь ямар нэгэн тусламж авч чадахгүй үлддэг гэсэн судалгаа байна⁷⁰. Үүнээс үзэхэд, сургуулийн орчин дахь хүчирхийлэл нь илрүүлэхэд хүндрэлтэй төдийгүй түүнийг үл ойшоох явдал ч багагүй байна.

Аливаа сургуулийн орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг тэр тусмаа үе тэнгийн дээрэлхэлт, дарамт, хүчирхийлэл нь хүүхдийн эрхийн зөрчил төдийгүй ирээдүйд өөртөө итгэх итгэл, амьдралаа амжилттай удирдан залах, сэтгэлзүйн эмгэгээс өөрийгөө хамгаалахад сөргөөр нөлөөлж байдаг. Тиймээс сурагчид энэ асуудлын талаар насанд хүрэгчидтэй ил тод, нээлттэй ярилцаж тусламж авснаар өөрийгөө хамгаалахаас гадна дахин ийм үйлдлийн хохирогч болох эрсдэлтэй хэн нэгнийг хамгаалж буй хэрэг юм.

Монгол дахь Хүүхдийг Ивээх сангийн хийсэн “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаанд 1236 хүүхдийг хамруулсан ба 19.9 хувь нь амиа хорлох оролдлого хийж байсан, 12.4 хувь нь амиа хорлох талаар бодож байсан, 8.6 хувь нь амиа хорлох оролдлогыг хэд хэдэн удаа хийж үзсэн, 4.5 хувь нь найз нөхөд байхгүй гэж хариулжээ.⁷¹ Тус судалгаагаар 84.2 хувь нь дарамтлуулж шоовдорлуулсан, 40.7 хувь нь бусад хүүхдүүд зодуулж дээрэлхүүлж байхыг харсан, 37.9 хувь нь өнгөрсөн онд ямар нэг байдлаар дээрэлхүүлж байсан гэсэн дүгнэлтүүд гарчээ. Хүүхдүүд үе тэнгийнхэндээ дээрэлхүүлсэн бол хэнд хандахаа мэдэхгүй байна гэж 81.4 хувь нь хариулжээ. Монгол улсад 1 жилд 500-600 хүн амиа хорлодог бөгөөд үүний шалтгааны ихэнх хувийг нь үе тэнгийн дээрэлхэлт, дарамт эзэлдэг байна⁷². Дээрх үзүүлэлт нь Монгол Улсад үе тэнгийн дээрэлхэлт нь хүүхдийн амь нас, эрүүл мэндэд шууд сөрөг нөлөө үзүүлж байгааг илэрхийлж байх тул үүнийг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай бөгөөд ингэхдээ үе тэнгийн дээрэлхэлт үйлдэж буй субъектүүдийн эрх зүйн чадамж болон хэрэг хариуцах чадварт суурилж эрх зүйн зохицуулалтуудыг хийх шаардлага гарна.

⁶⁸ Хүүхэд хамгааллын тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2024.

⁶⁹ Хүний Эрхийн Үндэсний Комисс. (2023). Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл. УБ., 2024. 13 дахь тал.

⁷⁰ Мөн тэнд. 13 дахь тал.

⁷¹ Save the Children. Өсвөр үеийнхний дуу хоолой. УБ., 2017. 42 дахь тал.

⁷² Мөн тэнд. 44 дэх тал.

ДЭМБ-ын судалгаагаар дэлхий дахинаа хүүхэд, өсвөр үеийнхний 20 хувь нь буюу 5 хүүхэд тутмын 1 нь сэтгэцийн болон зан үйлийн эмгэгтэй байна гэж дүгнэсэн байдаг.⁷³ Энэ нь хүүхэд эрүүл, аюулгүй орчинд сурч, боловсрох, хүчирхийлэл, дээрэлхэлтээс ангид байх эрх нь зөрчигдөж байгаатай шууд холбоотой.

Дээрх гэмт явдлын хор уршгийг тодруулбал, нийгмийн системийн онолоор нийгэм нь бүхэллэг байдлаар оршиж байдаг тул нэг хэсэгт асуудал үүсэхэд бусад хэсэгт сөрөг үр дагавар үүсгэдэг жамтай. Сургуулийн орчинд үйлдэгдэж буй гэмт явдлаас үүдэн хүүхдэд дараах төрлийн хор уршгууд илэрдэг байна⁷⁴.

Эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй эрсдэлт зан үйл: Өсвөр насандаа хүчирхийлэлд өртсөнөөр хүний бие, сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг нөлөөллүүд үүсдэгийг олон судалгаа батлаад байна. Жишээлбэл, үе тэнгийнхний хүчирхийлэл нь тамхи, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, хөдөлгөөнгүй, идэвхгүй амьдрал, стресс зэрэг эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй зан үйлтэй холбоотой. Эдгээр зан үйлийн хэд хэд нь зүрх судасны өвчин зэрэг халдварт бус өвчлөлийн шалтгаан болдог. Сургуульд түшиглэсэн эрүүл мэндийн олон улсын судалгаа (GSHS)-нд оролцсон. Африкийн 8 улсын мэдээллийг харьцуулж үзэхэд үе тэнгийнхний дарамт нь архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, бэлгийн эрсдэлт зан үйл нэмэгдэхэд шууд нөлөөлж, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй эрсдэлт зан үйлийн өсөлт нь дарамтлуулж дээрэлхүүлсэн өдрийн тоотой шууд холбоотой байгаа нь харагдсан байна⁷⁵.

Эрүүл мэндийн эрсдэлт зан үйлүүд нь хүчирхийлэлд өртсөний шууд үр дагавар болох сэтгэл гутгалтайгаа тэмцэх арга хэлбэр болдог ажээ. Эрүүл мэндийн асуудалтай өсвөр насныхан хүчирхийлэлд өртөх нь их байдаг ч нөгөө талаас хүчирхийлэл нь эрүүл мэндийн олон асуудлын шалтгаан болдог тул залуучуудын хувьд хүчирхийлэл ба эрүүл мэндийн эрсдэлтэй зан үйл нь харилцан нөлөөлөх мөн чанартай байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үр дагавар: Хүчирхийлэлд өртөх нь хүний сэтгэцийн эрүүл мэндэд насан туршид нь нөлөөлдөг. Өсвөр насандаа үе тэнгийнхний хүчирхийлэлд өртсөнөөс болж гэмтлийн дараах стрессийн эмгэг, сэтгэл гутрал, айдсын эмгэг, сэтгэлзүйн хэвийн үйл ажиллагаа алдагдах олон үр дагавар үүсдэг. Эдгээр асуудал өсвөр насны туршид, цаашилбал, насанд хүрсэн үед ч үргэлжлэх магадлалтай. Өсвөр насандаа үе тэнгийнхэндээ дээрэлхүүлж байсан хүн хожим нь сэтгэл гутралын эмгэгтэй болох илүү өндөр магадлалтай болохыг олон судалгаа батлаад зогсохгүй сургуульд байхдаа дээрэлхүүлж, хүчирхийлэлд өртөж байсан хүмүүс 7-36 жилийн дараа сэтгэл гутралд орох магадлал бусдаас 30-50 хувиар илүү байдгийг мета түвшний шинжилгээгээр тогтоожээ⁷⁶.

Хүчирхийлэлд дахин холбогдох эрсдэл нэмэгдэх: Бага, өсвөр насандаа хүчирхийлэлтэй тулгарч байсан хүүхэд өсөж том болохын хэрээр хүчирхийллийн

⁷³ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв. (2020). (<http://hdc.gov.mn/post/646/> -с үзэв).

⁷⁴ Нээлттэй нийгэм форум. Залуучуудын дундах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь: нотлох баримтын тойм. УБ., 2019. 10 дахь тал.

⁷⁵ Мөн тэнд. 10 дахь тал.

⁷⁶ Мөн тэнд. 11 дахь тал.

өөр хэлбэр болох залуучуудын дундах хүчирхийлэл, хүүхэдтэй зүй бус харьцах, бэлгийн харилцагчийн хүчирхийлэл гэмт хэрэгт холбогдох магадлалтай байдаг. Бага байхдаа хүчирхийлэлд өртсөн юм уу үйлдсэн бол насанд хүрсэн амьдралынхаа туршид хүчирхийлэл үйлдэх магадлал нь 3 дахин их байдаг бөгөөд эцэг эх нь хүчирхийлэл үйлдэж байгааг харсан хүүхдийн өсвөр болон идэр насандаа өөрөө хүчирхийлэл үйлдэх магадлал нь бусдаас илүү байдаг байна. Англи Улсад хийсэн нэгэн судалгаагаар, ноцтой хүчирхийлэлд холбогдоод байгаа эрэгтэйчүүдийн тал нь өмнө нь өөрсдөө хүчирхийллийн хохирогч болж байсан бол 12 хувь нь л хүчирхийлэлтэй тулгарч байгаагүй залуус байжээ. Үе тэнгийнхнээ дээрэлхэх зан үйл нь хожим хүчирхийлэл үйлдэх эрсдэлийг 50 хувиар нэмэгдүүлдэг бол хохирогч болох нь өөрөө хүчирхийлэгч болох эрсдэлийг 10 хувиар өсгөдөг байна⁷⁷.

Гэр бүл, найз нөхдөд үзүүлэх нөлөө: Залуучуудын дундах хүчирхийлэл, түүний үр дагавар нь хохирогчийн амьдралыг өөрчлөөд зогсохгүй түүний гэр бүл, найз нөхдөд нөлөөлдөг. Хүчирхийллийн хохирогч болсон залуу хүний хамаатан садан, ойрын найзуудад сэтгэл гутралын шинж тэмдгүүд илрэхээс гадна дүрэм журам зөрчих, биеийн хүчээр түрэмгийлэх, нийтийн болон бусдын эд хөрөнгийг сүйтгэн танхайрах зэргээр нийгмийн хэв журмын эсрэг зан үйл гаргах, мансууруулах бодис, архи хэрэглэх нь нэмэгдэх зэрэг эрсдэл өндөр байдаг байна.

Сурлагаар хоцрох: Нийгэм, эдийн засгийн өргөн хүрээтэй үр дагаврын хувьд, залуу хүн хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөх нь сурлагаар хоцрох явдалтай холбоотой байна. Хүчирхийлэлд оролцдог залуучууд хичээл сурлагаар тааруу, хичээлээ таслах, сургууль завсардах өндөр эрсдэлтэй байдаг. АНУ-д хийсэн судалгаагаар сурагчдын 6 хувь нь сургууль дээрээ, мөн сургуульд хүрэх, буцах замдаа аюулд өртөхөөс айж судалгаанаас өмнөх нэг сарын хугацаанд нэг ба түүнээс олон хоногоор хичээлдээ яваагүй гэж мэдээлжээ. Дунд ангийн хүүхэд түрэмгий зан гаргах нь сургууль завсардахын урьдач шинж тэмдэг болдог байна⁷⁸.

Эдийн засгийн зардал: Залуучуудын дундах хүчирхийллийг эд зүйлс, дэд бүтцийг эвдэн сүйтгэх явдал дагалдах нь их байдаг бөгөөд хүчирхийллийн “халуун цэг” буюу хүчирхийлэл их гардаг газар үл хөдлөх хөрөнгийн үнэ ханш буурах хамаарал байдаг ба тухайн орчны сургуулийн нэр хүнд унадаг. Насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн хүчирхийлэл нийгэмд онцгой өндөр үнэтэй тусдаг. Хохирогчтой холбоотойгоор эмнэлгийн үйлчилгээний шууд зардал, ирээдүйн орлогын алдагдал, олон нийтийн хөтөлбөр хэрэгжүүлэх төсөв, эд хөрөнгийн хохирол, амьдралын чанарын алдагдал зэрэг зардал гардаг.

Хүчирхийлэл үйлдэгчтэй холбоотойгоор тэнсэн харгалзах, баривчлан түр хорих зардал, засан хүмүүжүүлэх хөтөлбөрийн зардал, шоронд хорих зардал, боломжит орлогын алдагдал зэрэг зардал гардаг. Залуучуудын дундах хүчирхийлэл ихтэй орон нутагт бизнес, эдийн засгийн сөрөг нөлөөлөл мэдрэгдэж, засаг захиргааны уг нэгжийн эрүүл мэнд, шүүхийн зардал нэмэгддэг. Үүнээс гадна, нийгэмд аюулгүй байдлын баталгаа алдагдах, айдас, зовлон нэмэгдэх, нийгмийн эв нэгдэл алдагдах зэрэг материаллаг бус ачаалал учирна. АНУ-д залуучуудын

⁷⁷ Мөн тэнд. 11 дэх тал.

⁷⁸ Мөн тэнд. 12 дахь тал.

дундах хүчирхийлэлтэй холбоотойгоор алдагдсан орлого, эмнэлгийн шууд зардал нь жил бүр 20 тэрбум доллароор хэмжигддэг байна⁷⁹.

Төрөлжсөн хуулиудаас Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан. Мөн тус хуулиар хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг баталгаажуулсан байдаг боловч үе тэнгийн дээрэлхэлт нь дээрх эрхүүдийг нь бүгдийн зөрчдөг өндөр хор уршигтай үйлдэл, эс үйлдэхүй болж байгаа юм. Иймд энэ хуулийн хэрэгжилт, хүүхдийн эрхийн хамгаалалт нь сургуулийн орчны үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг хэрхэн бодитой үр дүнгээ өгөх талаар нарийвчилсан зохицуулалтууд дээр онцгой ач холбогдол өгөх шаардлагатай.

Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Тус хуулийн 6 дугаар зүйл буюу Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын хүрээнд 2 дахь хэсэгт “Сургалтын байгууллага, албан тушаалтан, багш, ажилтан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талуудад заавал мэдээлнэ”, 3 дахь хэсэгт “Сургалтын байгууллагад суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодын шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төрлүүдийг хуульчилжээ”.

Эдгээр зохицуулалт нь үе тэнгийн дээрэлхэлт, дарамтаас урьдчилан сэргийлэх болон боловсролын байгууллага дахь бусад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалах зохицуулалт байна. Мөн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7-д зааснаар “хүүхдэд хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль дээдлэх ёс, эрх зүйн боловсрол, соёлыг төлөвшүүлэх талаар гэр бүл, нийгэм, сургуулийн орчныг хамарсан цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх” буюу ерөнхий чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд тусгажээ. Ийнхүү сургуулийн орчинд хүүхэд үе тэнгийн дээрэлхэлт, дарамтад өртөж түүний сурч боловсрох эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үүднээс төрөлжсөн хуульд үүнтэй холбогдох харилцааг ерөнхий байдлаар хуульчилж өгсөн байна. Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон бусад хүүхдийн эрхийг хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ыг 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан А/190, А/280 дугаар тушаалын хавсралтаар шинэчлэн баталсан.

⁷⁹ Мөн тэнд. 12 дахь тал.

Үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой нарийвчилсан зохицуулалтын хувьд хуульчилсан актаар буюу 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/239 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Боловсролын байгууллагын сургалтын орчин ба дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам" болон 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А/476 тоот Боловсролын сайдын тушаалын хавсралтаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого" зэргээр зохицуулагдаж байна. Энэ хоёр журам нь сургуулийн орчинд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилготой ба сургуулийн захиргаа түүний бүтэц бүрэлдэхүүнд энэ чиглэлээр хийх ажиллагаа, чиг үүргийг зохицуулж өгсөн. Гэвч энэ журмын цар хүрээ, зохицуулалт нь хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ерөнхий агуулгатай төдийгүй зохицуулж буй харилцаа нь сургуулийн орчин дахь үе тэнгийн дээрэлхэлт, дарамтыг зохицуулахад хязгаарлагдмал байна.

Өнөөдөр манай улсын хувьд нийт хүн амын 34.6 хувийг 0-18 насны хүүхэд эзэлж байгаа бөгөөд хүүхдийн эрхийг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд гэр бүл, эцэг, эхийн оролцоо хамгийн чухал юм.

Учир нь хүүхдийн өв тэгш хүмүүжил, төлөвшилд гэр бүлийн халуун, дулаан уур амьсгал нэн чухал төдийгүй аз жаргалтай, бие биеэ ойлгодог, хүндэлдэг, сонсдог гэр бүлд хүүхэд бие бялдар, оюун ухааны хувьд өв тэгш хүмүүждэг байна.

Хүүхдийг зөв хүн болгон хүмүүжүүлэх, төлөвшүүлэх асуудал бол гэр бүл, эцэг эхээс шууд хамаардаг гэдгийг мэддэг хэдий ч, өдөр тутмын алба, амины ажил гэж зүтгэсээр нэг мэдэхэд хүүхэд гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн улмаас эрх ашиг нь хохирох, хүчирхийлэлд өртөх, зам тээврийн осолд орох, хаягдах, төөрөх, архи дан согтуурах, мансуурах, цахим тоглоомд донтох, биеэ үнэлэх, гал түймэр, гол усны аюул, ахуйн осолд өртөх зэрэг олон асуудлын улмаас амь нас, эрүүл мэнд нь хохирсоор байна.

Хүүхдээ зөв хүн болгон хүмүүжүүлэх, төлөвшүүлэх, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах нь зөвхөн сайн эцэг, эхийн ухамсар, амьдралын туршлагатай холбоотой бус, бүх эцэг, эхчүүдийн хуулиар хүлээсэн заавал биелүүлэх ёстой үүрэг юм. Энэ талаар 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хүүхдийн эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Хүүхдийн хүмүүжил, төлөвшил"-ийн талаар, 10 дугаар зүйлд "Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг, хариуцлага"-ын талаар тодорхой тусгасан байдаг.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Зөрчлийн тухай хуульд "Хүүхдийн эрхийг зөрчих" гэсэн бүлгийг шинээр оруулж хүүхдийн эрхийг хангах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, хүүхдийн дэргэд архи дан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хоёр зуун нэгжээс гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, дээрх үйлдлийн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хор уршиг учирсан, амь нас хохирсон бол Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн 16.11 дүгээр зүйлд заасны дагуу дөрвөн зуун тавин

нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Хүүхэд бүр айдасгүйгээр сургуульдаа явах эрхтэй. Сургуулиудад чанартай, хүртээмжтэй, аюулгүй боловсрол олгох үед хүүхдүүд сурч, нөхөрлөлийг бий болгож, нийгмийн нөхцөл байдлыг удирдахад шаардлагатай чухал ур чадваруудыг олж авах боломжтой. Хамгийн сайн нөхцөлд сургууль нь хүүхдүүдийг ирээдүйтэй ирээдүйн замд оруулдаг.

Гэвч дэлхий даяар дэндүү олон охид, хөвгүүдийн хувьд сургууль бол хүчирхийлэлд өртдөг газар юм. Дээрэлхэх, дарамтлах, хэл амаар доромжлох, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, бие махбодын шийтгэл болон доромжлолын бусад хэлбэрүүд нь үе тэнгийнхэн, багш эсвэл бүр сургуулийн удирдлагуудын гарт тохиолдож болно. Мөн олон хүүхэд бүлэглэлийн соёл, зэвсэг, зодоонтой холбоотой сургуулийн хүчирхийлэлд өртдөг. Сургууль дахь хүчирхийлэл нь хүүхдийн сэтгэл зүй, бие махбодын эрүүл мэндэд ноцтой нөлөө үзүүлдэг.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд бие махбодын гэмтэл, бэлгийн замын халдварт өвчин, сэтгэлийн хямрал, түгшүүр, гэмтлийн дараах стрессийн эмгэг (PTSD) болон амиа хорлох бодолтой байдаг. Тэд бас эрсдэлтэй, түрэмгий, нийгэмд харш зан гаргаж эхэлдэг. Хүчирхийллийн эргэн тойронд өссөн хүүхдүүд хүчирхийллийн хохирогчдын шинэ үеийнхэнд үүнийг давтах магадлал илүү өндөр байдаг.

Сургууль болон түүний эргэн тойронд хүчирхийлэл хамгийн туйлдаа хүрвэл үхэлд хүргэх аюултай. Мөргөлдөөнд нэрвэгдсэн бүс нутагт амьдарч буй хэдэн арван сая хүүхэд, өсвөр үеийнхний хувьд сургууль нь ихэвчлэн тэргүүн эгнээнд ордог. Үүнээс гадна, сургууль дахь хүчирхийлэл нь сургуулийн ирцийг бууруулж, сурлагын амжилтыг бууруулж, сургууль завсардалтыг нэмэгдүүлдэг. Энэ нь хүүхдүүд, тэдний гэр бүл, нийт хамт олны амжилт, хөгжил цэцэглэлтэд аймшигтай үр дагавартай.

НҮБ-ын Хүүхдийн сан нь засгийн газар, сургууль, багш, гэр бүл, хүүхэд залуучуудтай хамтран сургууль дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр ажилладаг. НҮБ-аас засгийн газар болон түншүүд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөдөг⁸⁰. Үүнд:

- Бие махбодын шийтгэл болон хүчирхийллийн бусад хэлбэрийг хориглосон хуулийг батлах;
- Сургуулиудад ёс зүйн дүрэм болон бусад хамгаалах арга хэмжээг боловсруулах. Сургуулиудад тайлагнах нууц, аюулгүй механизмыг бий болгох;
- Хариулах үйлчилгээнд шилжүүлэх механизмыг бий болгож, сургуулиуд дахь хүчирхийллийн талаарх мэдээллийг хянаж, цуглуулах;
- Багш, сургуулийн ажилтнуудыг эерэг сахилга бат, анги танхимын менежмент, мөргөлдөөнийг тайван замаар шийдвэрлэх талаар сургах;

⁸⁰ <https://www.unicef.org/>.

- Хүүхэд, залуучуудын дасан зохицох чадвар, хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхийн тулд амьдрах ухаан, нийгэм, сэтгэл хөдлөлийн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх;

- Сургууль дахь хүчирхийллийн талаарх судалгаа, хяналт, мэдээлэл цуглуулах;

- Сургууль болон хүрээлэн буй орчны хүчирхийллийг таслан зогсоох зорилготой байгууллага хоорондын болон олон орны санаачилга болох "Аюулгүй Суралцах" хөтөлбөрийн нэг хэсэг болох НҮБ-ын Хүүхдийн сан нь хүүхдийн хамгааллыг нэмэгдүүлэх, сургалтын үр дүнг сайжруулах, боловсролд хөрөнгө оруулалтыг сайжруулах, хүчирхийллийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх.

Дэлхий даяар 13-15 насны сурагчдын тал хувь нь буюу 150 сая орчим нь сургууль болон түүний эргэн тойронд үе тэнгийнхний хүчирхийлэлд өртдөг тухай мэдээлэл байна. 13-15 насны 3 сурагч тутмын 1 нь бие махбодын хүчирхийллийг үе тэнгийнхэндээ үйлддэг. Сургуулийн насны 720 сая орчим хүүхэд бие махбодын хүчирхийллээс бүрэн хамгаалагдаагүй улс оронд амьдарч байна⁸¹.

Дүгнэлт

1. Сургууль дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах нь хүүхдийн боловсролын үр дүнд хүрэхэд тусалдаг. Хүчирхийллээс сэргийлэх, тухайлбал харилцаа холбоо, сэтгэл хөдлөлийг удирдах, шийдвэрлэх зөрчилдөөн, асуудлыг шийдвэрлэх нь сургуулийн орчин дахь хүчирхийллийг бууруулахад тустай.

2. Хүүхдүүд сургуульдаа амжилттай суралцаж, бусад хүмүүсээр хамгаалуулж согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ гэх мэтээс ангид байхад суралцана. Эдгээрийн хор нөлөө нь анхаарал төвлөрөхгүй байх, сургуулиа орхих зэрэг байж болох бөгөөд сөрөг үр дагавар үүсгэдэг. Хүчирхийлэлд өртөх нь бас суралцахад нь саад болж буй сорилттой зан үйлийг харуулах шалтгаан болно. Эдгээр бэрхшээлүүд нь багш нарыг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд саад болдог.

3. Цагдаагийн байгууллагаас Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр Цагдаагийн албаны тухай хуульд тусгайлсан заалтыг оруулж, холбогдох журмуудыг боловсруулан батлуулж, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр чиг үүргийнхээ хүрээнд хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг, өдөрлөг, сургалт, сурталчилгааны ажлуудыг тасралтгүй зохион байгуулж, хориhoос өөр төрлийн ял шийтгэлтэй хүүхдэд захиргааны хяналт тогтоох, хараа хяналтгүй хүүхдийн асуудлыг шийдэхэд туслалцаа үзүүлэх зэрэг ажлуудыг тогтмол зохион байгуулж байгаа боловч хүүхэд бүрд хүрч чадахгүй байна.

4. Цахим хэрэглээний замбараагүй байдал нийгмийн эмх цэгцийг алдагдуулах нэг суурь шалтгаан болж өсвөр насны хүн хэмээх оюун ухаан санаа, сэтгэлгээний төлөвшил бүрэн бүрэлдээгүй залуу үеийн сэтгэл зүйг гэмтээж байгааг нийгэм анхааралдаа авч таслан зогсоох цаг нь болжээ. Цахим хэрэглээ нь зарим

⁸¹ <https://www.unicef.org/>.

тохиолдолд хүүхдийн бодол сэтгэлээ хуваалцах, зөвлөгөө хүсэх гэх мэтчилэн эцэг эх асран хамгаалагчийг орлох арга зам болсонд томчууд бид дүгнэлт хийж амьдрах хэв маяг, ажил амралт, үр хүүхдэдээ тавих анхаарал халамжаа эргэж харах нь зүйтэй.

5. Ирээдүйн Монгол хүн ямар байх ёс суртахуун, сэтгэлгээ, үнэт зүйлийн үнэлэмжийг судлан хэрэгжүүлснээр улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулах нь дамжиггүй юм гэж судлаачдын зүгээс үзэж байна.

Санал

Дээрх судалгаанд үндэслэн, доорх саналыг гаргаж байна. Үүнд:

- Сургуулийн орчинд аюулгүй, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах; (сургуулийн хэмжээнд өсвөр үеийнхний оролцоог хамарсан эерэг хөтөлбөр болоод тэдэнд сэтгэл зүйн болон зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлэх)
- Сургуулийн дүрмийг танилцуулж, тэдэнд тулгарч болзошгүй асуудлуудыг сургуулийн удирдлагуудад мэдэгдэхийг зөвлөх;
- Үе тэнгийнхнээс ирэх дарамтыг эсэргүүцэхийн чухлыг суралцагчдад сануулах;
- Сургуулийн орчинд нэргүй мэдээлэх системийг бий болгох (Жишээлбэл, энэ талаарх мэдээллийг хүлээн авах харилцах утас, санал хүсэлтийн хайрцаг гэх мэт);
- Сургуулийн хамгаалалтын системийг (камержуулалт) сайжруулах;
- Сургуулийн өмчөөс гадна сурагчдын аюулгүй байдлын арга хэмжээг сайжруулахын тулд сургууль, олон нийтийн хамтын ажиллагааг бий болгох;
- Сургуулийн дарамт, хүчирхийллийн түвшинг тодорхойлох судалгааг тогтмол хийх;
- Гэмт хэргээс сэргийлэхийн тулд зөрчил гаргасан өсвөр насны хүнд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хууль болон бусад хэм хэмжээний актад тодорхой тусгаж өгөх;
- Сургуулийн орчинд үе тэнгийнхний дээрэлхэлт үйлдсэн хүүхдийг эцэг эх асран хамгаалагчийн хамт тодорхой үе шаттай “Хүний эрх”-ийн талаарх сургалтад хамруулж байх гэсэн саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан материал

1. Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын судалгаа. УБ., 2023.
2. Бүх нийт боловсролын төлөө. Иргэний нийгмийн үндэсний эвсэл. Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аргачлал. Гарын авлага. УБ., 2020.
3. Ганцэцэг Т нар. Ахлах ангийн сурагчдын дундах үе тэнгийнхний хүчирхийлэл. УБ., 2020.
4. Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал. УБ., 2021.
5. Нээлттэй нийгэм форум. Залуучуудын дундах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь: нотлох баримтын тойм. УБ., 2019.
6. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв. (2020). (<http://hdc.gov.mn/post/646/> -с үзэв).

7. Хүний Эрхийн Үндэсний Комисс. (2023). Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл. УБ., 2024.
8. Хүүхэд хамгааллын тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2024.
9. Цагдаагийн байгууллагын 2024 оны 2 дугаар сарын мэдээ.
10. Цэвэл Я. Монгол хэлний их тайлбар толь. УБ., 2024.
11. Save the Children. Өсвөр үеийнхний дуу хоолой. УБ., 2017.
12. Reiney, E6 (20178 09). Bullying Prevention and Response Training and Continuing education online program. Retrived from <https://www.stopbullying.gov/sites/default/files/2017-09/training-module-2016.pdf>.
13. <https://developingchild.harvard.edu/science/key-concepts/toxic-stress/>.
14. <https://www.unicef.org/>.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ХАРЬЦУУЛАЛТ

CRIME PREVENTION INTERNATIONAL COMPARISON OF STANDARDS

Г.Бямбадорж

*Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, доктор (Ph.D)*

Товч агуулга: Судлаач энэхүү илтгэлдээ олон улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төв байгууллагын үүсэл хөгжил, НҮБ-аас баталсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандартад тусгагдсан улс орнууд дотоодоо хэрэгжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар хэрэгжүүлэх хөтөлбөрийн төрөл агуулга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын үйл ажиллагааг дэмжиж оролцох арга хэлбэр, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд орчин үеийн техник технологи онол загварыг бий болгож ашиглах, НҮБ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандартад нийцүүлэн өөрийн орны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандартыг батлан хэрэгжүүлэх талаар авч үзсэн.

Abstract: The author describes in this report the standards set forth by the International Center for Prevention of International Crime and the Prevention of Crime Prevention adopted by the United Nations in support of the International Crime Prevention Action Program and the Prevention of Crime Prevention to increase the roles and responsibilities of the public, government and non-governmental organizations in the prevention and remedial action of crime and crime, before the crime and to adopt and apply the existing technology of the theory of prevention, to adopt and implement standards for the prevention of domestic crimes in accordance with the UN standards for prevention crime.

Түлхүүр үгс: Онол, стандарт, загвар, үйл ажиллагаа, урьдчилан сэргийлэх, олон улс.

Keywords: Theory, standart, design activity, crime prevention, international.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын төв (ICPC) байгууллага нь НҮБ-ын дэргэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах зорилгоор 1994 онд байгуулагджээ. ICPC байгууллагын эрхэм зорилго нь гэмт хэргийг бууруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой стратегийн болон төрөл бүрийн үр дүнд суурилсан төсөл хөтөлбөр, санал санаачилгыг дэмжин хэрэгжүүлэх замаар аюулгүй амгалан нийгмийг бий болгох, олон нийтийг дэмжих явдал юм.

Ялангуяа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын хэм хэмжээ, стандартыг дагаж мөрдүүлэх, улс, хот, байгууллагуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд хөрөнгө оруулалт хийх мэтээр тус олон улсын төв үйл ажиллагаагаа явуулж байна.

ICPC байгууллага бий болгоход хүргэсэн томоохон алхам нь:

- 1986 онд Страсбург, Францад Европын холбооны улсуудын аливаа хүчирхийллээс сэргийлэх бодлогын талаар хамтран ажиллахын тулд зохион

байгуулсан юм. Энэ нь хот улсуудын аюулгүй байдал байдлыг хангах тухай Европын чуулга уулзалт (EFUS) бий болгоход хүргэжээ⁸².

Энэ бага хурлаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, туршлага солилцох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг арилгахын ач холбогдлыг нь онцлон тэмдэглэсэн байна.

- 1989 онд Хот аюулгүй байдал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Европ, Хойд Америкийн бага хурал Канад улсад болж өнгөрөв.

Энэхүү хуралд EFUS байгууллага оролцож хотуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх холбоо байгуулж. Төгсгөлд нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар харилцан туршлага мэдээлэл солилцох байнгын үйл ажиллагаа явуулах талаар судалж болно гэж мэдэгджээ.

- 1990 онд EFUS болон FCM АНУ-ын Бага хурлын дэмжлэгтэйгээр Монреаль хотноо олон улсын байгууллага байгуулах, орон нутгийн аюулгүй байдлыг хангах, засаг захиргааны хоорондын техникийн хамтын ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.

- 1991 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын төв бий болгох тухай Парисын бага хурлаас баталсан саналыг үндэслэн НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба Эрүүгийн эрх зүйн хөтөлбөр бий болгох тухай сайд нарын уулзалт болжээ.

- 1992, 1993 онуудад хэд хэдэн орны төлөөлөгчдөөс бүрдсэн олон улсын түр хороо, хотын засаг захиргаа, эрдэмтэн судлаачид, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байгууллага, мэргэжилтнүүд, Канадын Монреаль хотноо гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төв байгууллагын зохион байгуулалт, чиг үүрэг талаар хэлэлцэх уулзалт болсон байна.

- 1994 онд, Канад, Франц улсын засгийн газар FCM, EFUS оролцож Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын төв (ICPC) байгууллагыг Монреаль-д бий болгосон тухай мэдэгдсэн байна⁸³.

Ийнхүү Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын төв ICPC байгууллага бий болж уг байгууллага үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлээ тодорхойлж дараах үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Гэмт хэргийг бууруулах;
- Урьдчилан сэргийлэх зорилготой стратегийн болон үр дүнд суурилсан хөтөлбөрийн санал санаачилгыг дэмжих, хэрэгжүүлэх;
- Улс орнуудад эрүүл аюулгүй нийгэм бий болгох бодлого боловсруулан хэрэгжүүлэх;
- Улс орнуудын бүтээлч санал санаачилга, урьдчилан сэргийлэх ажилд хөрөнгө оруулалт хийх;
- Иргэд байгууллагын үйл ажиллагааг чадваржуулах тэдний үйл ажиллагааг дэмжих зэрэг үйл ажиллагааг явуулж байна.

Мөн НҮБ гишүүн орнуудын дагаж мөрдөх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стандартыг НҮБ батлан гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын стандарт

НҮБ-аас баталсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандартын гол агуулга нь улс орнуудын засгийн газар нь үйл ажиллагаандаа урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх талаар байнга тусгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, оролцох, гишүүн орнуудад бүс нутгийг хамарсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж байгаа үйл

⁸² Crime prevention and community safety international report 2008, 8 sheet.

⁸³ Crime prevention and community safety international report 2008, 8 sheet.

ажиллагаанд санхүүжилт олгох, олон улсын болон бүс нутгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны цогц төлөвлөлт хийж хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж буй улс орнуудад дэмжлэг, туслалцаа, урам зориг өгөх, туршлагыг харьцуулж солилцох ажлыг зохион байгуулах, насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын удирдамж боловсруулж, хэрэгжүүлэх, олон улсын хэмжээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх цогц стратегийг боловсруулж хэрэгжүүлэх, тэдгээрийн үр дүнг үнэлэх арга хэрэгслээр хангах⁸⁴ гэх мэт үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь НҮБ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандартын гол агуулга бөгөөд уг стандартад нийцүүлэн зарим улс орнууд өөрийн орны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандартыг батлан хэрэгжүүлж байгаа зарим улс орнуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандартыг товч авч үзье.

Канад улсын стандарт

Канад улс нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандартыг тус улсын Хууль зүйн яам баталсан бөгөөд уг стандартад дараах хоёр үндсэн чиглэлийг тодорхойлсон байна. Үүнд:

- Орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, хөрш зэргэлдээ орон нутгийн засаг захиргааны нэгжийн санаачилгыг хэрэгжүүлэх замаар олон нийтийн санаачилгыг дэмжих;

- Шилдэг туршлага санаачилга солилцох, иргэд олон нийтийн санаачилгаар зохион байгуулж буй ажилд цагдаагийн байгууллага, алба хаагч, сайн дурын ажилтан оролцох үүрэг хүлээдэг нь цагдаагийн байгууллагаас явуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг иргэд олон нийтэд түшиглэх, тэдний санал санаачилгыг дэмжих зарчмыг баримтлан ажиллаж байна⁸⁵.

Тухайлбал: Уг стандартын гол агуулга нь олон нийтэд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх гаргасан иргэд олон нийтийн байгууллагын санал санаачилгыг дэмжиж цагдаагийн үйлчилгээг үзүүлэх, бүс нутгийн болон орон нутгийн хэмжээнд олон нийтэд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санаачилгыг дэмжиж хэрэгжүүлэх төрийн үүргийг гэрээгээр хэрэгжүүлэх эрх бүхий хэд хэдэн байгууллагатай гэрээ хэлцэл хийх.

Мөн иргэд олон нийтэд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд цагдаагийн болон төрийн үүргийг гэрээгээр хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, сайн дурын ажилтан, олон нийтийн цагдаагийн ажилтныг оролцуулна гэж стандарт тогтоосон явдал нь иргэд олон нийтийн зүгээс зохион байгуулж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дэмжиж буй нэг хэлбэр юм.

Цаашилбал уг стандартад олон нийтэд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санал санаачилга, хэрэгжүүлсэн арга хэмжээг олон нийтэд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын загвар бий болгож бүс нутагт хэрэгжүүлэх үүргийг цагдаагийн газрын даргад даалгасан нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандартыг тогтооход чухал үүрэгтэй ажээ.

Тухайлбал: Уг стандартын дагуу цагдаагийн газрын удирдах албан тушаалтан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгцээг тодорхойлж, цагдаагийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил үйлчилгээний төрөл хэлбэрийг тодорхойлон хэрэгжүүлэх, гэмт хэрэг, дуудлага, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж улмаар орон нутгийн онцлогт тохирсон

⁸⁴ www.google.com UN Crime prevention standart.

⁸⁵ www.google.com Canad crime prevention standart.

иргэд, олон нийтэд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санаачлан төлөвлөн хэрэгжүүлнэ.

Түүнчлэн иргэд, олон нийтэд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санал санаачилгыг хэрэгжүүлэхэд орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг оролцох арга хэмжээний талаар мэдээллээр хангаж хамтран ажилладаг бөгөөд үйл ажиллагаанд нь тогтмол хяналт-шинжилгээ хийж үр дүнг үнэлэх арга хэмжээг хэрэгжүүлдгээрээ онцлогтой.

Үүнээс гадна иргэд олон нийтэд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санал санаачилга, шилдэг арга туршлагыг хуваалцаж, олон нийтийн болон бизнесийн байгууллагуудтай хамтран олон нийтэд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санал санаачилга, арга хэмжээний талаар нийтэд түгээх үүргүүдийг зааж өгсөн нь иргэд олон нийтийн болон бизнесийн байгууллагын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх талаар заасан нь чухал ач холбогдолтой.

Виржиниа мужийн стандарт

Энэ стандартыг батлах болсон шалтаан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарахгүй байгаа нь гол шалтгаан нь цагдаагийн ажилтнуудын үүрэг хариуцлагатай холбоотой асуудал биш орон нутаг засаг захиргаа, бүх байгууллага, нийт иргэд оршин суугчдын асуудал гэдгийг танилцуулснаар бүх байгууллага иргэдийн үүрэг хариуцлага хэмээн хүлээн зөвшөөрч энэхүү стандартыг баталж дараах үйл ажиллагааг тогтоож өгсөн байна⁸⁶. Үүнд:

- Үндэсний гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стратеги төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг сахиулах байгууллагын төсөвт суулгасан байх;
- Аливаа хууль сахиулах байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүтэц нэгж байгуулан олон нийтийн цагдаагийн ажилтан ба сайн дурын ажилтныг томилон ажиллуулах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгжийг аливаа агентлагийн бүтцэд оруулсан байх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөлтийн үйл явцыг үйлдэгдсэн гэмт хэрэг болон шинэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд иргэд олон нийтэд түшиглэн явуулах стратеги боловсруулж хэрэгжүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зорилго зорилтыг хангахын тулд орон нутаг засаг захиргааны нэгж байгууллага, иргэд олон нийттэй хамтран ажиллах;
- Тухайн орон нутгийн хууль сахиулах чиг үүрэгтэй байгууллага бүр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан хэрэгжүүлэх;
- Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийг авч ажиллуулах, чадваржуулах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтнууд үйл ажиллагааны үр ашигтай төлөвлөлт хийх;
- Ажилтнууд харилцааны ур чадварыг эзэмшсэн байх бусдыг урамшуулсан ба чиглүүлэх чадвартай байх;

⁸⁶ Gerald Holy. Crime prevention standart of Virginia hand book. 9 sheet.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй ажилтнуудад гэмт хэргийг бууруулах, эсвэл гэмт хэрэг үйлдэх боломжийг арилгах арга талаар зохих сургалтад хамруулсан байх;

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгж байгууллага дотор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын эргэх холбоог хангах харилцах төвтэй байх;

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгж, алба хаагч нар нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг идэвхжүүлэхийн тулд бусад төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд олон нийтийн байгууллагад сургалт явуулах, техникийн туслалцаа үзүүлэх;

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй нэгж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хичээлийн төлөвлөгөө бэлтгэж, агентлаг байгууллага, бусад олон нийтийн арга хэмжээний мэдээ мэдээлэл бэлтгэх⁸⁷ гэх мэт стандартыг тогтоосон бөгөөд уг стандартаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зорилго зорилтуудыг хангахад чиглэгдсэн ажил арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тодорхой тусгасан нь олзуурхуштай.

Түүнчлэн уг стандартаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил үйлчилгээг хүргэх үүргийг байгууллагын бүх ажилтнуудын үүрэг хариуцлага гэж заагаад агентлаг байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйлчилгээг үр дүнтэй уялдуулан зохицуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгж үйл ажиллагааны болон засаг захиргааны нэгж, салбар аль аль нь тэгш эрхтэй байх ёстой гэжээ.

Мөн уг стандартаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйлчилгээг хүргэх орон нутгийн онцлогт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудалд тохирсон байх ёстой. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгжийн үндсэн үүрэг нь нэг агентлагийн төлөвлөлтийн үйл явцад олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх гэж заасан илүү үр дүнтэй байна.

Нийтийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны ололт амжилт орчин үеийн техник технологи дээр тулгуурлан явуулах, шинэ техник технологийг нэмэгдүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд ахиц гарна гэсэн үзэл баримтлалыг орхигдуулаагүй нь оновчтой.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага сайн дурын иргэд орон нутагт үйлдэгдэж буй гэмт хэргийн цар хүрээ, гэмт хэргийн төрөл, ангиллын талаар тодорхой ойлголт мэдлэгтэй байж, гэмт хэрэг үйлдэгдэх боломжийг багасгах талаар зохих арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах нь иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах нэг үндсэн нөхцөл болно гэж үзсэн нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандартын ач холбогдлыг тодорхойлж чаджээ.

Харин манай Монгол улсад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн стандарт” байхгүй бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиас гадна урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлт үйл ажиллагааны хүрээ, чиглэлтэй холбоотой тогтоол, тушаал журам батлагдан хэрэгжиж байна. Тухайлбал: Улсын Их Хурлын 2003 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Архидан согтуурахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2012 оны дугаар сарын 25-ны өдрийн 252 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр”, 2015 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 257 дугаар тогтоолоор батлагдсан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөр, *Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2015 оны долоодугаар сарын 04-ний өдөр “Хөршийн хяналтын хөтөлбөр, журам”, мөн Засгийн газрын 2007 оны 9*

⁸⁷ Gerald Holy. Crime prevention standart of Virginia hand book. 12 sheet.

дугаар сарын 12-ны өдрийн 255 дугаар тогтоол “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр” гэх мэт тогтоол, хөтөлбөр журмуудыг дурдаж болно.

Дээр дурдсан хөтөлбөр тогтоолуудад зөвхөн хөтөлбөр тогтоолуудад дурдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна. Өөрөөр хэлбэл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төрөл болох тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэх ажлуудыг тусгасан нь учир дутагдалтай.

Мөн Цагдаагийн байгууллага нь Улсын Их хурал, Засгийн газар, яам агентлагаас баталсан эдгээр олон тооны төсөл, хөтөлбөр тогтоолыг хэрэгжүүлэх үүргийг хүлээдэг бөгөөд тэдгээрийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж буй дараах хүчин зүйлс байна гэж бид үзэж байна. Үүнд:

- Улс орны нийгэм, эдийн засгийн бодлого уялдаагүй;
- Төсөл, хөтөлбөр тогтоолд дурдсан зарим үүрэг давхацдаг;
- Хэрэгжүүлэгч байгууллагын алба хаагч, хүн хүч дутмаг;
- Шинэчлэг арга технологи, техник хэрэгсэл дутмаг;
- Хэрэгжүүлэгч нэг субъектэд хэт олон үүрэг оногддог;
- Нэг төсөл хөтөлбөрийн тайланг нөгөө төсөл хөтөлбөрийн тайлан болгож ашигладаг;
- Төрийн болон төрийн бус байгууллагын хамтран ажиллах идэвх чармайлт сул;

- Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ хангалтгүй;
 - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн стандарт батлагдаагүй.
- гэх мэт хүчин зүйлсийг дурдаж болно.

Өнөөгийн байдлаар гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга явуулах, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах, албан мэдэгдэл шаардлага хүргүүлэх төдийхнөөр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа нь нууц биш.

Харин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр нийгэм, эдийн засгийн арга хэмжээг хослуулан хамтад нь асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх хууль эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авах шаардлагатай байна.

Мөн Цагдаагийн байгууллага өмнөө тавьсан зорилго зорилтоо хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд гэмт хэрэг үйлдэгдсэн орчин нөхцөл, цаг хугацаа, газар орон, гэмт хэргийн шалтгаан нөхцөл зэргийг судлан мэдэх шаардлага тулгардаг ба энэхүү нөхцөлийг судлахдаа хүрээлэн буй орчны онолыг ашиглах нь үр дүнтэй болохыг эрдэмтэн судлаачид тайлбарласан байна. Иймд хүрээлэн буй орчны онолын талаар товч авч үзье.

Хүрээлэн буй орчны онолыг АНУ-ын судлаач Бурнс болон Сталкер нар санаачилсан юм. Тэд нөхцөл байдлыг сайтар судалж “хүрээлэн буй орчныг нь сайтар уншиж, тухайн байгууллагад тохирсон бүтцийн загвар болон үйл ажиллагааг тодорхойлон сонгох ёстой гэж үздэг юм⁸⁸.

Иймээс энэхүү онолд үндэслэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ орчны нөхцөлийг сайтар судалж түүнд тохирсон арга зүй, үйл ажиллагааг тодорхойлох боломжтой.

Нөөцийн хамаарлын онолыг үндэслэлтэй тайлбарлаж чадсан судлаачид бол Преффер болон Сланцик нар юм. Тухайн онолын үндсэн санаа нь аливаа байгууллага нэгж үйл ажиллагаа явуулахын тулд заавал хүрээлэн буй орчноос нөөц хэрэгслийг авах ёстой гэсэн үзэл санааг дэвшүүлсэн юм⁸⁹. Өөрөөр хэлбэл,

⁸⁸ Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration , 2011. 124-139 дэх тал.

⁸⁹ Мөн тэнд. 124-136 дахь тал.

гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хүрээлэн буй орчныг зөв үнэлж чадахгүй бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй алдагдаж, тухайн нөхцөл байдлаас хамааралтай болж зөвхөн түүнд тохирсон үйл ажиллагаа явуулж түүнийг хянаж чадахгүйд хүрнэ. Иймд нөхцөл байдлыг хяналтдаа авсны дараа түүнээс хамааралгүй болж байгууллага нэгж амжилтад хүрнэ хэмээн үзжээ.

Нөгөө талаар цагдаагийн байгууллага хүн хүч, чадавхаа нэмэгдүүлэх, нөөц хэрэгслийг хангах нь амжилтад хүрэх чухал хэрэгсэл гэдгийг нотолжээ.

Хүн амын экологийн онолыг Герман Улсын эрдэмтэн Ханнан болон Фриман нар үндэслэсэн бөгөөд 1970-аад оны сүүл үеэс эхлэн газар авч эхэлсэн ба уг онолоор нэг чиг үүрэгтэй олон байгууллагууд өрсөлдөн хүн амын нягтаршил, газар нутгийн байрлал, түүний онцлог зэрэгт илүү анхаарал хандуулснаар байгууллагууд илүү их амжилтад хүрнэ гэдгийг тодорхойлох оролдлого хийжээ⁹⁰. Өөрөөр хэлбэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй алба тасаг нэгж хариуцсан нутаг дэвсгэрийн хүн амын тоо, оршин суух иргэдийн нягтаршил газар нутгийн хэмжээ, байрлал онцлог зэргийг судалж, дүн шинжилгээ хийснээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Зэргэлдээ орших аймаг, дүүрэг, сум, баг, хорооны хүн амын нягтаршил, газар нутгийн байрлал, түүний онцлог зэргийг судлан мэдэж байх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг илүү амжилттай хэрэгжүүлэх үндэс болно хэмээн тайлбарлаж болох юм.

Мөн дээрх онолуудад тулгуурлан орчны нөхцлийг судлах нь дараах ач холбогдолтой байна хэмээн бид үзэж байна. Үүнд:

- Үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн гаралтийг тодорхойлох;
- Үйлдэгдсэн гэмт хэргийн ангилал, төрлийг тодорхойлох;
- Үйлдэгдсэн гэмт хэргийн нягтрал байршил тодорхойлох;
- Үйлдэгдсэн гэмт хэргийн циклийг тодорхойлох;
- Гэмт явдлын прогноз гаргах;
- Гэмт явдлын шалгаан нөхцлийг тогтоох, арилгуулах;
- Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Цагдаагийн байгууллагаас авч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой болгох;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын алдаа дутагдлыг ирүүлж, арилгуулах;
- Цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглээр зохион байгуулсан үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт өгөх гэх мэт ач холбогдолтой байна.

Дээрх бүхнээс үндэслэн судлаач бид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дээр дурдсан онолыг үндэслэл болгон орчны нөхцөл байдлыг судлах дараах загварыг бий болгож, ашиглаж болно гэж үзэж байна. Үүнд:

Хүснэгт 1. Орчны нөхцөлийг судлах загвар

Д\д	Ангилал	Хүрээлэн буй орчин	Хүрээлэн буй орчны хүчин зүйлс
1	Дотоод орчин	Чиг үүрэг бүхий алба хаагч нарын орон тоо	Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт
2		Чиг үүрэг бүхий алба хаагч нарын үр чадвар арга тактик	Албаны сургалтын агуулга, чанар үр дүн

⁹⁰ Мөн тэнд. 124-129 дэх тал.

3		ЦАХ нарын ажлын ачаалал	Нэг алба хаагчид ногдох хүн амын тоо, дэд бүтэц
4		Гүйцэтгэх ажлын мэдээлэл	Тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн судалгаа, тэдний байр байдал, үйлдэж буй гэмт хэрэг, зөрчил
5		Хорих ял эдлээд сулдагдсан ХӨТЯШ хүмүүстэй ажиллаж буй байдал	Гэмт хэрэг үйлдээд суллагдсан болон гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийн ажил хөдөлмөр эрхлэлт, тэдний нийгмийн байдал
6		Туслах хүчний байдал	Туслах хүч, сайн дурын ба олон нийтийн цагдаагийн ажилтны тоо, тэдний үйл ажиллагаа үр дүн
7		Удирдлагын манлайлал	Удирдлагын манлайлал, арга, мэдлэг үр чадвар, нөлөөлөл Байгууллагын үйл ажиллагааны үялдаа холбоо хамтын ажиллагаа
8		Бусад байгууллага нэгжийн үйл ажиллагаа	Үндсэн чиг үүрэгтэйгээс бусад алба нэгжийн үйл ажиллагаа, тэдгээрийн нөөц боломж Бусад агентлагууд байгууллагуудын үйл ажиллагаа Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, оролцоо
9	Гадаад орчин	Эдийн засгийн орчин	Эдийн засгийн өнөөгийн байдал Эдийн засгийн төлөв Эдийн засгийн уналт Эдийн засгийн өсөлт Үнийн хөөргөдөл
10		Улс төрийн орчин	Улс төрийн төлөв байдал Улс төрийн тогтвортой байдал ЗГ-ын бодлого үйл ажиллагаа Эрх мэдэлтнүүдийн нөлөөлөл
11		Улс орны нийгмийн байдал	Ажилгүйдлийн тоо Ядуурлын түвшин Архидалт Мансуурах явдал Биеэ үнэлэлт Үйлдвэр, аж ахуй эрхлэлт Нийгмийн халамжийн үйлчилгээ, тэтгэвэр тэтгэмж
12		Үйл явдал гэмт хэрэг	Байгалийн гамшиг, жагсаал цуглаан бослого тэмцэл, томоохон үйлдвэрлэлийн осол, олныг айдаст автуулсан хүнд, онц хүнд гэмт хэрэг аллага, мансууруулах бодис, хүний наймаатай холбоотой гэмт хэрэг зэрэг улс төр, нийгэм, эдийн засагт хор хохирол учруулсан гэмт хэргийн

			ертөнцтэй холбоотой үйлдэл, нэмэлт төсөв хөрөнгө шаардлагатай ажил арга хэмжээнүүд
13		Эрх зүйн орчин	Үндсэн хууль бусад хууль тогтоомж Үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж Тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам Эрх зүйн хамгаалалт бий болсон орчин Эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдэл
14		Хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа	Хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа Шүүхийн ял оногдуулалтын байдал Захиргааны шийтгэл ногдуулалт Ялтныг нийгэмшүүлэх ажил, түүний үр дүн Ялтныг хүмүүжүүлэх ажил, түүний үр дүн Өмгөөллийн үйл ажиллагаа Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа
15		Техник технологи	Үйл ажиллагааны ил тод байдал, цахим үйлчилгээний төрөл, хэлбэр шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ашиглалт шинэ арга, технологи

Түүнчлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаандаа орчны нөхцөлийг үнэлэх, шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник технологи ашиглах талаар цагдаагийн албаны тухай хууль заасан зарчмыг хэрэгжүүлж ажиллахын тулд гадаадын зарим орны онол загваруудыг нэвтрүүлж ашиглах шаардлагатай. Тухайлбал: АНУ-ын Нью-Йорк хотын цагдаагийн газрын дарга, комиссар Уильям Брантон анх 1994 онд мэдээлэлд суурилсан удирдлагын Comp.Stat загварыг танилцуулсан бөгөөд энэхүү загвар нь АНУ даяар маш хурдан тархаж энэ нь гэмт хэрэг бууруулахад чиглэсэн орчин үеийн менежментийн загвар болж чадсан байна⁹¹.

Comp.Stat загвар нь гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, стратегийн ач холбогдолтой асуудлыг шийдвэрлэх, тодорхой үйл ажиллагаанд анализ хийх, гэмт хэргийн гаралт, төрөл, гэмт хэрэг гарсан цэг бусад нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлоход ашиглагдаж байгаа мэдээ мэдээлэл, түүний үнэн зөв эсэхийг цаг хугацаанд нь дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлж байна.

Энэхүү нөхцөл байдлын үнэлгээн дээр тулгуурлан, тохирсон хариу арга хэмжээ авах, алба хаагч ажилтан болон нөөц хүчийг зохих газар хурдацтай байршуулах, байдлаар хэрэгжүүлж, гэмт хэрэг бууруулах зорилго, зорилтыг хэрэгжүүлдэг байна⁹².

Иймд Comp.stat системийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж ашигласнаар тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл

⁹¹ <http://www.compstat.umd.edu>.

⁹² Мөн тэнд.

байдалд долоо хоног бүр дүн шинжилгээ хийж тухайн долоо хоногт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэргийн төрөл, гэмт явдлын шалтгаан нөхцөл, тохироо, гэмт хэрэг үйлдэгч, хохирогч, халдлагын зүйл зэрэгт дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээг төлөвлөж ямар ямар гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байна түүнийг бууруулах урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа оновчтой тодорхойлох, гэмт явдалд прогноз хийх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Мөн “Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал үйлдэх системийг бүрэн ашиглаж болно.

“Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал нь: Гэмт явдлын гаралт, төрөл, ангилал, нягтаршил, өдөр гариг, цаг хугацаа зэрэгт дүн шинжилгээ хийхийн тулд хууль сахиулах байгууллага ашигладаг систем юм.

Энэ нь гэмт хэрэгт дүн шинжилгээ хийх, цагдаагийн стратегийн Comp.Stat загварын нэг гол бүрэлдэхүүн хэсэг юм. “Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал үйлдэх системийг газар зүйн мэдээллийн систем (GIS) ашиглан гэмт явдлын төлөв байдлыг шинжээчийн тусламжтайгаар тодорхойлж гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй цэгүүдийг тодорхойлох боломжийг олгодог систем юм⁹³.

Энэхүү системийг ашигласнаар тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг зураглал дээр тусгай тэмдэглэлээр тэмдэглэж ямар төрлийн гэмт хэрэг өссөн, аль дүүрэг хороонд хэд хэчнээн гэмт хэрэг үйлдэгдсэн, ямар төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгааг аль ч үед (шаардлагатай үед) харж болох боломжтой бөгөөд энэхүү зураглалыг “Comp.stat системтэй хослуулан ашиглавал илүү үр дүнд хүрч болно.

Тэрчлэн үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралтад дүн шинжилгээ хийж аль дүүрэг хороо, хэсэгт ямар төрлийн гэмт хэрэг өсөж байна тэр дүүрэг хороонд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг түлхүү зохион байгуулж, уг ажилд цагдаагийн алба хаагч болон урамшилт эргүүл, сайн дурын цагдаагийн ажилтныг ажиллуулж цагдаагийн хүн хүч, техник хэрэгслийг зөв хуваарилснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарч болох юм.

Дүгнэлт

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд орчны нөхцөл байдлын үнэлгээг шинжлэх ухааны онол, аргуудыг ашиглан хийж, түүнд түшиглэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг гадаадын зарим улс орнуудын засгийн газартай хамтран урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх талаар санал санаачилга гаргаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа идэвхтэй үр дүнтэй явуулж буй улс орнуудын туршлагыг судалж нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, олон улсын хэмжээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх цогц стратегийг боловсруулж хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагааг дэмжиж оролцох, НҮБ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандартад нийцүүлэн өөрийн орны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандартыг батлан хэрэгжүүлэх шаардлагатай хэмээн дүгнэж байна.

Санал

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандартыг боловсруулж батлуулж, хэрэгжүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

⁹³ http://en.wikipedia.org/wiki/Crime_mapping.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд орчны нөхцөл байдлын үнэлгээг шинжлэх ухааны онол, загвар арга зүйд тулгуурлан хийх загвар болгож, хэрэгжүүлэх;
- Орчны нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ comp.stat, crime mapping зэрэг дүн шинжилгээ хийхэд тус дөхөм болох системүүдийг нэвтрүүлж ашиглах;
- Орчны нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгжийг аливаа агентлаг байгууллагын бүтцэд оруулах;
- Төрийн чиг үүргийг гэрээгээр хэрэгжүүлэх (гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй) төрийн бус байгууллагуудыг тоог нэмэгдүүлж, тэдний ажиллах эрх зүйн үндсийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд тусгаж өгөх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийг чадваржуулах төрөл бүрийн ажил арга хэмжээг зохион байгуулах;
- Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгжид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын эргэх холбоог хангах харилцах төв бий болгох;
- Тодорхой нутаг дэвсгэр ялангуяа хөдөө орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын стандарт үйл ажиллагааны загвар бий болгож хэрэгжүүлэх гэх мэт саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан материал

1. Crime prevention and community safety international report 2008, 8 sheet.
2. Gerald Holy. Crime prevention standart of Virginia hand book. 9 sheet.
3. http://en.wikipedia.org/wiki/Crime_mapping.
4. <http://www.compstat.umd.edu>.
5. Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration , 2011. 124-139 дэх тал.
6. www.google.com Canad crime prevention standart.
7. www.google.com UN Crime prevention standart.

**СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХҮЛЭЭЛГЭЖ
БУЙ ХАРИУЦЛАГА, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ**

DRUNK TRAFFIC ACCIDENT, WAITING

О.Болорцэцэг
ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны
сургуулийн лаборант

Товч агуулга: Согтууруулах ундаа нь хүн төрөлхтний дунд олон зуун жилийн турш, өргөн хэрэглэгдэж ирсэн хүнийг донтуулах, сэтгэцэд нөлөөлөх шинж чанартай бодис юм. Үүнийг хэтрүүлэн хэрэглэх нь хувь хүний эрүүл мэндэд шууд хортой төдийгүй гэр бүл, найз нөхөд, хамтран ажиллагчдад дам байдлаар хор хөнөөл учруулж, улмаар нийгэм, эдийн засагт дарамт үүсгэдэг байна. Согтууруулах ундаа хэрэглэх нь нэг хэрэг, хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох нь өөр хэрэг юм. Тодруулбал, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцох нь аюултай үзэгдэл болохын хувьд хууль тогтоомжоор хориглож, зөрчлөөс гадна учирсан хохирлын хэмжээнээс хамаарч гэмт хэрэгт тооцдог. Бид өгүүлэлд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагын талаар судалж, үр ашигтай дүгнэлт, санал гаргахыг зорилоо.

Abstract: Alcohol is a substance that has addictive and psychotropic properties for a person, which has been widely used among mankind for hundreds of years. Its overuse is not only directly harmful to the health of the individual, but also indirectly harmful to family, friends and co-workers, thereby creating social and economic stress. Drinking alcohol is one thing, driving a vehicle while consuming it is another. Specifically, driving a vehicle while intoxicated, as a dangerous phenomenon, is prohibited by law and criminalized depending on the amount of damage caused in addition to the violation. In our article, we aim to examine liability for drunken crimes and draw effective conclusions and suggestions.

Түлхүүр үгс: Архи, согтууруулах ундаа, технологи, спирт, зам тээврийн осол, гэмтэл, зөрчил, ял, хариуцлага.

Keywords: Alcohol, Technology, alcohol, traffic accident, injury, violation, sentence, responsibility.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын тогтоосон стандартаар нэг хүнд жилд 8-9 литр архи, согтууруулах ундаа ноогдож байгаа тохиолдолд үндэсний аюулгүй байдалд эрсдэлтэй гэж тооцдог ажээ. Монгол улсад 2022 онд жилд нэг хүнд оногдох архи согтууруулах ундааны хэрэглээ 8.9 л болж өссөн судалгаа гарчээ⁹⁴.

Архины хэрэглээ хөгжингүй орнуудад буурч, харин хөгжиж буй орнуудад нэмэгдэн, жилд дэлхий нийтийн хэмжээнд архины улмаас 3.3 сая хүн нас барж, өвчний улмаас нас барсан хүмүүсийн 5.1 хувийг, нийт нас баралтын 5.9 хувийг, цаг бусын нас баралтын 3.2 хувийг архинаас үүдэлтэй гэж үзсэн байна.⁹⁵ Дэлхийн өндөр хөгжилтэй ихэнх орнуудад архи согтууруулах ундааны үйлдвэрлэл,

⁹⁴ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2022 оны үзүүлэлтээр нэг хүнд ноогдох архины хэмжээ 8.9 л болж өссөн үзүүлэлттэй байна.

⁹⁵ Эрүүл мэнд, эдийн засагт учруулах архины дарамтыг судлах. Судалгааны ажлын тайлан.

худалдаа, борлуулалт, сурталчилгаа нь өндөр хяналтын дор явагддаг бөгөөд Швед, Норвеги, Финланд, Исланд, Фарерын арал, Турк, Канад, Катар зэрэг улсуудад тусгай хуулийн дагуу зохицуулж, тодорхой нөхцөлүүдийн үндсэн дээр худалдаалдаг. Тухайлбал: Швед улсад System Bolaget, Норвеги улсад Vinmonopolet, Финланд улсад Alko нэртэй худалдааны сүлжээг ашиглан, төрийн байгууллагын зохицуулалтаар, тусгай хяналтад архийг зарж борлуулдаг байна. Улс, орнууд архины хэрэглээнээс үүдэн хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгэм, эдийн засагт гарах сөрөг нөлөөг багасгахад үр дүнтэй, уялдаа холбоотой олон талт арга хэмжээ, бодлогыг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, согтууруулах ундааны маркетинг, сурталчилгаа болон борлуулалтыг хуулиар зохицуулах (ялангуяа залуучуудад чиглэсэн); согтууруулах ундаа худалдах, худалдан авах боломжийг хязгаарлах, зохицуулах; согтуугаар жолоо барихыг хориглох бодлого хэрэгжүүлэх; үнэ болон татварын механизмаар дамжуулан эрэлтийг бууруулах; олон нийтэд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхэд эрүүл мэндэд учруулах хор нөлөөг таниулах, мэдлэг олгох үр дүнтэй бодлогыг дэмжих; архинаас хамааралтай хүмүүст хүртээмжтэй, үр дүнтэй эмчилгээг хүргэх; архи хэтрүүлэн хэрэглэх явдлыг хянах бодлого, хөтөлбөрийг эрүүл мэндийн үйлчилгээнд нэвтрүүлэн хэрэгжүүлэх зэрэг байна.

Манай Улсын хувьд сүүлийн 10 жил /2013-2022 он/-ийн хугацаанд, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ замын хөдөлгөөнд оролцсон үйлдлийн улмаас Эрүүгийн хуульд заасан авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих төрлийн нийт 3167 гэмт хэрэг бүртгэгдэж, үүний улмаас 1278 хүний амь хохирч, 2089 хүн гэмтсэн харамсалтай тоо баримт байна. Дээрх мэдээллээс дүгнэж үзэхэд жилд дунджаар согтуу жолоочийн буруутай үйлдлийн улмаас 120 хүний амь нас хохирдог байна. Зам тээврийн ослын улмаас амь хохирсон нийт хүмүүсийн 24% нь согтуу жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан байна.⁹⁶

Он гарснаар эхний 9 сарын байдлаар согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцож яваад зам тээврийн осол гаргасан 639 тохиолдол бүртгэгдэж, 75 хүний амь нас хохирсон байна. Хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулсны үр дүнд энэ оны эхний 9 сарын байдлаар согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн осол өмнөх оны мөн үеэс 20.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэвч согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил буурахгүй байна. Энэ зөрчлийг бууруулахын тулд хяналт шалгалт, ял, хариуцлагын бодлогыг өндөржүүлэх нь хамгийн чухал ажил юм.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил өнгөрсөн оны үзүүлэлтээс 47,7%-иар өсжээ. Үүнд:

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 52.3%-иар өсөж, Эрхээ хасуулсан үедээ давтан согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1,7%, Жолооч биш хүн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 5,1%-иар үзүүлэлттэй байна.

⁹⁶ Тээврийн цагдаагийн албаны дүн шинжилгээний мэдээлэл. 2013-2022.

Улсын хэмжээнд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн зөрчилд 46051 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 8740 хүнд баривчлах арга хэмжээ оногдуулсан.

Зураг 1. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн илрүүлэлт

№	Илрүүлсэн зөрчил	Үүнээс		
		Эрхийн үнэмлэхтэй үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	Эрхээс хасуулсан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	Эрхийн үнэмлэхгүй буюу жолоодох эрхгүй этгээд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон
1	Улсын хэмжээнд			
	54924	45993	5227	3704
2	Улаанбаатар хот			
	30323	27421	2043	859
3	Орон нутаг			
	24601	18572	3184	2845

Статистик мэдээллээр Монгол Улсад 2022 оны байдлаар 1127813 автомашин бүртгэлтэй байна. Өнгөрсөн онд цагдаагийн байгууллагаас "Уусан бол буу жолоод хяналт шалгалтыг зохион байгуулсны үр дүнд 54924 жолооч согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийг илрүүлж зөрчил гаргасан жолоочийн жолоодох эрхийг Зөрчлийн тухай хуулийн 14.7.3.1 дэх хэсэгт зааснаар 1 жилийн хугацаатай хасаж ажилласан байна. Эрхээ хасуулсан жолоочид тавих хяналт шалгалт сул учраас нийт бүртгэлтэй 1127813 автомашины 54924 буюу 4.8 хувь эрхгүй жолоочтойгоор хөдөлгөөнд оролцож байж болзошгүй юм. Өөрөөр хэлбэл замын хөдөлгөөнд оролцож байгаа 20 авто машин тутмын 1 жолооч нь эрхээ хасуулсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон байх магадлалтайг статистик мэдээллээс харж болно.

Монгол Улсын хэмжээнд 2022 онд согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс 1210 осол үйлдэгдэж, явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцож өртөж хохирсон осол 179 бүртгэгдсэн байна. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан жолооч Улаанбаатарт 59,6%, орон нутагт 14,9%-иар, баривчлах арга хэмжээ Улаанбаатарт 93,1%, орон нутагт 13,2%-иар өсжээ. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон 8601 эмэгтэй байгаагийн 5462 буюу 63,5% нь Улаанбаатарт зөрчил гаргажээ.

Зөрчил гаргагч эмэгтэйчүүдийн: 7532 (87.6%) нь тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, 1069 (12,4%) нь баривчлах арга хэмжээ авчээ. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан эмэгтэй жолоочийн 65,5% нь Улаанбаатарт зөрчил

гаргасан бол баривчлах арга хэмжээ авагдсан эмэгтэй хүний 50,4% нь орон нутагт зөрчил гаргажээ.

Зураг 2. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед үйлдэгдсэн зам тээврийн осол

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед үйлдэгдсэн зам тээврийн осол				
Он	Зам тээврийн осол	Нийт осолд эзлэх хувь	Явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсон	Нийт осолд эзлэх хувь
Улсын хэмжээнд				
2020 он	1103	5.1	174	0.8
2021 он	1479	6.6	163	0.7
2022 он	1210	5	198	0.8
Улаанбаатар хот				
2020 он	580	3.1	119	0.6
2021 он	919	4.8	137	0.7
2022 он	635	3.1	179	0.9
Орон нутаг				
2020 он	523	16.1	55	1.7
2021 он	560	17.2	26	0.8
2022 он	575	15.1	19	0.5

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед автомашин жолоодох нь жолооч хурд хэтрүүлэх, гэрэл дохио болон өөдөөс ирэх саадыг анзаарахгүй, зогсоох арга хэмжээ авч чадахгүй, анхаарал төвлөрөхгүй байх зэргээр өөрийгөө хянах чадварт муугаар нөлөөлж ноцтой зам тээврийн осол гарах үндэс болдог байна. Архи согтууруулах ундаа нь автомашин жолоодож буй хүний оюун ухаан, жолоодох ур чадвар, самбаачлах хугацаа, оюун санаанд шууд нөлөөлдөг учраас согтолт их байх тусам эрсдэл нь өндөр байдаг байна.

Аливаа улс оронд хууль тогтоомжийн шинэчлэл хийхдээ бусад улс орнуудын туршлагыг судалдаг жишгийн дагуу манай улсын хувьд мөн гадаадын сайн туршлагыг судлах замаар алдаа, оноогоо дүгнэх нь зүйтэй. Гэхдээ үүнд шалгуур байх хэрэгтэй. Тухайлбал, харьцуулж болох судлагдахуун, харьцуулах боломжгүй судлагдахуун гэж байдаг. 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулийг ажиглавал эрүүгийн эрх зүйд хамаарах хэм хэмжээ зонхилсон байна гэж олон судлаачид үзэж байна. Эндээс үзвэл хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсэг эсхүл хууль тогтоогчид зарим талаараа захиргааны зөрчил гэдгийг АНУ-д байх "жижиг гэмт хэрэг" гэсэн ойлголттой адилтган авч үзсэн байх магадлалтай. Цаашлаад харьцуулан судалсан улс орнуудын эрх зүйн эх сурвалжийг ажиглахад хариуцлагын үр дагаврыг хуульчлаагүй хууль гэж байдаггүй ажээ. Чухам ямар үндэслэлээр ийнхүү салбарын хуулиудаас бүх хариуцлагын хэм хэмжээг салган авч төрөлжүүлэн нэгтгэх болсныг үзэл баримтлалын хүрээнд илүү нарийвчлан оновчтойгоор тайлбарлаж чадахгүй байгаагаас үүдэж практикт маргаан өрнөж

байна гэж үзэж байна.⁹⁷ Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон жолооч, жолооч биш, эрхгүй этгээдэд Зөрчлийн хуулийн 14.7.3 болон 14.7.1-14.7.3 дах заалтуудаар арга хэмжээ тооцож байна. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эрхээ хасуулсан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг бууруулах чиглэлээр:

Зураг 3. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд авагдсан арга хэмжээ (2022 оны байдлаар)



Эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:

1. Эрхээ хасуулсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил гаргасан бол жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргэх хугацааг 6 сараар хойшлуулдаг болгох саналыг Зөрчлийн тухай хуулийн 14.7.1 дэх хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах. Хэрэгжилтийг хангахын тулд цагдаагийн алба хаагчдын бэлэн бус торгуулийн багажаар 14.7.1 дэх хэсгээр арга хэмжээ тооцуулсан жолоочийн эрх сэргэх хугацаа 6 сараар хойшлогдох программын нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

2. Жолоодох эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтад орох хугацааг 3 жилээр хойшлуулах, цахим санд иргэний мэдээллийг оруулах. Энэ Швед улсад хэрэгждэг хуулийн заалт бөгөөд огт жолооч биш хүн тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх нь ноцтой зам тээврийн осол гарах эрсдэлийг бууруулдаг болох нь тухайн улсын туршлагаар батлагдсан⁹⁸.

Давуу тал: Жолооны эрхээ хасуулсан ч гаргахгүй, дугаарын хязгаарлалттай өдөр хөдөлгөөнд оролцохгүй бол замын цагдаа тэр болгон зогсоож шалгадаггүй гэсэн ойлголт иргэдийн дунд байдаг. Энэ нь согтуугаар тээврийн хэрэгсэл

⁹⁷ Баярсайхан Д. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2011.

⁹⁸ [Traffic Violations | The Swedish Police Authority \(polisen.se\)](https://polisen.se/).


жолоодох зөрчилд хүлээлгэх ял, хариуцлагын зохицуулалт бага, эрхээ хасуулсан жолоочид тавих хяналт шалгалт сул байгааг илэрхийлж байна

Дээрх хуулийн нэмэлт өөрчлөлтүүдийг хийснээр иргэдийг согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохоос татгалзах, эрхээ хасуулахаас айх, эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодохоос татгалзах нийгмийн сэтгэлзүйг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.



Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох нь АНУ-ын зам дээр 10,000 гаруй хүний амь насыг авч, хохирол учруулдаг нас баралтын 1 дүгээр зэргийн шалтгаан юм. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөөх автомашины эвсэл (ACTS),

АНУ-ын Тээврийн яамны харьяа Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний алба (NHTSA) төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд жолоочийн согтууруулах ундааны аюулгүй байдлыг илрүүлэх систем (DADSS)



хөтөлбөрийг хэрэгжүүлснээр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдал нь 30 хувиар буурсан тоон үзүүлэлт байдаг байна.

Энэхүү шинэ технологи нь жолоочийг BAC-д жолоочийн согтуурлыг хэмжих, нарийн тодорхойлоход зориулагдсан бөгөөд 0.08%-иас дээш бол ихэнх улсын хууль ёсны хязгаар бөгөөд

тээврийн хэрэгслийг хөдлөхөөс сэргийлдэг. DADSS технологи нь хамгийн сүүлийн үеийн технологи юм. Хэрэв ямар нэгэн хэмжээгээр согтууруулах ундаа илэрсэн тохиолдолд машин асахгүй бөгөөд учирч болзошгүй эрсдэлт хүчин зүйлээс хамгаалж, урьдчилан сэргийлэх шилдэг арга барил юм. ⁹⁹

DADSS технологи нь цусан дахь спиртийн концентрацийг хэмжих шинэ арга барил бөгөөд жолоочийн хуруу эсвэл гарын алган дахь архины хэмжээг хэмжихэд эдийн спектроскопи ашигладаг мэдрэгчтэй систем ба жолоочийг согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг илрүүлж, гарч болзошгүй гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх хүчирхэг технологийг өөрийн оронд нэвтрүүлэх боломж бололцоог дэлгэрүүлж судлах шаардлагатай юм.

Амьсгалын систем ба гарын алга, хурууны мэдрэгчтэй систем бөгөөд архины хэмжээг хэмжиж, нарийн тодорхойлох зориулалттай, тээврийн хэрэгслийн бүхээгт мэдрэгч нь жолоочийн байгалийн амьсгалыг татаж, хэт улаан туяаны

⁹⁹ Dadss - Driver Alcohol Detection System.

тусламжтайгаар архины концентрацийг хэмждэг байна. Жолоочийн амьсгал болон зорчигчийн амьсгалыг ялгах зориулалттай.

Мэдрэгч систем нь цусан дахь спиртийн хэмжээг хэмжихэд эдийн спектроскопи ашигладаг,



хурууны үзүүр эсвэл алган дээр хэт улаан туяа тусах замаар араа солих, асаах товчлуур эсвэл жолооны хүрд зэрэгт жолооч хүрэхэд автоматаар мэдрдэг байна.

Америкийн Нэгдсэн Улсад сургалтын журмаар “Drunk Buster” нүдний шил нь жолооны курсийн дадлагын явцад

ашиглагддаг согтууруулах ундаа, болон мансууруулах бодисын нөлөөллийн талаарх мэдлэг, сургалтын хөтөлбөрийн үр нөлөөг сайжруулдаг. Тухайн улсын Хууль сахиулах байгууллагын ахмад ажилтан бүтээсэн нүдний шилийг Америкийн цагдаагийн алдрын танхим, музейд байрлуулан ашиглаж байгаа бөгөөд өөрийн орны жолооны сургалтын төвүүдэд нэвтрүүлэхээр илтгэлд дурдаж байна¹⁰⁰.

“Drunk Buster” нүдний шил - Харааг гажуудуулдаг линзийг ашиглан согтууруулах ундааны хэрэглээ нь хүний биед жолоо барих явцад хэрхэн нөлөө үзүүлэхийг дуурайлган хийгдсэн. Амьсгалын спиртийн концентрацийн (BAC) таван өөр тохиргоо нь 0.04-ээс 0.35 хүртэл согтолтын түвшинг мэдрүүлдэг бөгөөд эдгээр нүдний шилийг жолооны дадлагын хөтөлбөрүүдэд ашиглахад төгс хэрэглүүр болох юм.

Нүдний шил нь сонор сэрэмж багасах, хариу үйлдэл үзүүлэх хугацаа удааширч, төөрөгдөл, харааны гажуудал, гүн болон зайны ойлголт өөрчлөгдөх, захын хараа муудах, давхар хараа, булчингийн зохицуулалт дутагдах зэрэг үр нөлөөг буюу согтуурсан мэдрэмжийг авдаг байна. Нүдний шилийг шугамаар алхах, зоос авах, ширээн дээр эд зүйл байрлуулах тээврийн хэрэгсэл жолоодох дадлагын гэх мэт төрлүүдэд ашиглах мөн Их сургуулийн Цагдаагийн сургуулийн Замын цагдаагийн тэнхимийн хичээл сургалтад ашиглах нь өндөр үр дүнтэй аргын нэг юм.

Drunk Buster нүдний шил нь- Орон нутгийн замд тээврийн хэрэгсэл жолоодох, анхаарал төвлөрөл ихтэй ажлуудын үед ядарсан нойрмоглосон үеийг мэдрүүлэх тохируулагчтай бөгөөд Drunk Buster Snooze Goggles™ нь нойргүй хоносон эсвэл унтаагүй шөнийн дараа нойр дутуугийн нөлөөг дуурайлган хийгдсэн байна. Нүдний шилээ зүүгээд чиг баримжаа алдагдах, хариу үйлдэл үзүүлэх хугацаа удааширах, хараа муудах, гэрэл мэдрэмтгий болох, нойрмоглох зэрэг шинж тэмдгүүдийг тухайн хүн мэдрэгдэх, мөн тээврийн хэрэгслийн ойлголтыг Drunk Buster Red-Eye Goggles™ нь муу чанарын гэрэлтүүлгийн үед бүдэг харааны нөлөөг дуурайлган хийгдсэн байна.

Эдгээр техник технологийн дэвшлүүдийг Монгол Улсад нэвтрүүлэх санал, санаачилгыг хэрэгжүүлэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон жолооч нарт

¹⁰⁰ <https://lifeloc.com/goggles>.

хүлээлгэх ял, хариуцлагын эрх зүйн зохицуулалтыг чангатгах шаардлагууд тулгарч байна.

Дүгнэлт

1. Цагдаагийн байгууллагаас согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчилд тавих хяналт шалгалтыг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд үр дүнтэй зохион бай тулж байгаа боловч, эрхээ хасуулсан жолоочид тавих хяналт шалгалт сул байгаа нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил буурахгүй байна.

2. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил буурахгүй бол жил бүр 120 хүртэлх хүний амь нас согтуу жолоочоос болон согтуу явган зорчигчоос шалтгаалан иргэд эд хөрөнгө, эрүүл мэндээрээ хохирох явдал буурахгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

3. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчилд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, жолоодох эрхээ хасуулсан жолоочид тавих хяналтын мэдээллийн санг камерын технологитой уялдуулан хяналтдаа авснаар иргэдийн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил буурах, иргэдийн ухамсар нэмэгдэх, хариуцлага өндөржих боломжтой.

4. Ингэснээр цаашид Монгол Улсад согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил буурч, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийн улмаас үйлдэгдэх зам тээврийн осол хэрэг буурах бүрэн боломжтой боломжтой.

Санал

1. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон ноцтой зам тээврийн гэмт хэрэг үйлдсэн хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хязгаарлахаас гадна нийгэмд тустай ажлыг зайлшгүй хийлгэх шаардлагатай. /Цагдаагийн алба хаагчдын ажилд туслах үүргээр, эмнэлгийн болон онцгой байдлын алба хаагчдын энэ төрлийн гэмт хэргийн газар ажиллахад туслалцаа үзүүлэх/ Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож байгаа зөрчлийг бууруулах, хариуцлагын тогтолцоог олон улсын жишигтэй харьцуулан чангатгах ажлыг эхлүүлэх;

2. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил үйлдэх үед тухайн жолоочийг дэмжсэн, тээврийн хэрэгсэлд нь хамт зорчиж явсан зорчигчдод жолоочид хүлээлгэх торгуулийн 25%-тай тэнцэх хэмжээний торгууль оногдуулдаг болгох;

3. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийг гадны орны туршлагын хүрээнд судлан DADSS технологи, Drunk Buster хэрэглэгдэхүүнийг урьдчилан сэргийлэх сургалтын чиглэлээр өөрийн оронд нэвтрүүлэх төсөл хөтөлбөрийг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулах, нэвтрүүлэх;

4. Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон; Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол *тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг гурван жилийн хугацаагаар хасаж хүнийг найман зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;*

5. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй (жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд), эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож *тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх хугацаа дахин 1 жилээр сунгах арга хэмжээ тооцох*;

6. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулж, *тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх хугацааг дахин 1 жилээр хойшлуулах арга хэмжээ тооцно*.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах санал

№	Зүйл, заалт	Зөрчлийн тухай хуулийн заалт	Нэмэлт өөрчлөлт оруулах санал
1	14.7.3.1 14.7.3.2	Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон; Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон; Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол <i>тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг гурван жилийн хугацаагаар хасаж хүнийг найман зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно</i> .
2	14.7.1	Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгоно.	Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож <i>тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх хугацаа дахин 1</i>

		жилээр сунгах арга хэмжээ тооцно.	
3	14.7.5	Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон согтууруулах ундаа мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.	Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хун согтууруулах ундаа, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулж, <i>тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргэх хугацааг дахин 1 жилээр хойшлуулах арга хэмжээ тооцно.</i>

Ашигласан материал

1. Эрүүл мэнд, эдийн засагт учруулах архины дарамтыг судлах. Судалгааны ажлын тайлан.
2. Тээврийн цагдаагийн албаны дүн шинжилгээний мэдээлэл. 2013-2022.
3. Баярсайхан Д. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2011.
4. Traffic Violations | The Swedish Police Authority (polisen.se).
5. Dadss - Driver Alcohol Detection System.
6. <https://lifeloc.com/goggles>.

МОНГОЛ УЛС ДАХЬ АЖИЛГҮЙДЛИЙН ИНДЕКС, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

UNEMPLOYMENT INDEX IN MONGOLIA, CURRENT SITUATION

У.Уранцэцэг
ДХИС-ийн магистрант

Товч агуулга: Өгүүлэлд Монгол Улс дахь ажилгүйдлийн түвшний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, ажилгүйдэлд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийг тодорхойлохыг эрмэлзлээ.

Abstract: The article analyzes the current state of unemployment in Mongolia and seeks to identify some factors that contribute to unemployment.

Түлхүүр үгс: Ажилгүйдлийн түвшин, гэр бүл, хөдөлмөр, эдийн засаг.

Keywords: unemployment rate, family, labor, economy.

Дэлхийн даяаршил улс орнуудын хөгжил, дэвшилд эерэг үр дагавар бүхий шинэ боломжуудыг нээсэн, сайн талтай ч, нөгөө талаас, гэр бүлийн харилцааны үнэт зүйлс, зан заншлууд орхигдон гээгдэж, үүний хор уршгаар гэр бүлийн харилцаа тогтворгүй, таарамжгүй болох, салах, гэр бүлийн гишүүд өөр хоорондоо хүч хэрэглэсэн гэмт явдал ихсэх байдлаар үндэсний сэтгэл зүй хувьсахад хүргэж байна.

Манай орны хувьд 1990 оноос эхлэлтэй зах зээлийн эдийн засагт нийгмийн шинэчлэл нь баруун европ маягийн боловсролын тогтолцоо, үзэл суртлыг дэлгэрүүлж, шинэ цагийн соёл, хүн төлөвших зэрэг эерэг үр дагавруудыг авчрахын зэрэгцээ, зальхай нь хөрөнгөжиж, шударга нь хоосрох, үйлдвэрлэлүүдийн салбаруудын хөгжил унасантай холбоотойгоор ажилгүйдэл буй болж зарим хүмүүс нь архидаж, зарим эмэгтэйчүүд биеэ үнэлэх, өрх толгойлсон эмэгтэйчүүд олшрох, гэр бүлээрээ хулгай хийх, залилан мэхлэх зэргээр зүй бусаар амьдрах болсон. Энэ нь гэр бүлийн хүчирхийлэл үүсэх, ихсэх нэгэн боломж бүрдэж эхэлсэн гэж үзэж болно.

Эдийн засгийн болон орлогын тэгш бус байдлаас шалтгаалан олон өрх гэр амьжиргааны асуудлаас хэрүүл тэмцэлтэй амьдрах төдийгүй эхнэр, нөхрөө, хүүхдээ байнга дарамталж амьдрах нь түгээмэл болж, гэр бүлийн хүчирхийлэл тархцаараа нийгмийн бүхий л хүрээ, давхаргыг хамран, өнөөгийн тулгамдсан асуудлуудыг тэргүүлэх болсон. Энэ нь нэгэнт хүчирхийлэл болсон учраас үүнээс тодорхой нэг хэсэг нь хохирогч болж байна.

Хохирсон байх явдлыг хүн төрөлхтөнд хүний эрхийн байдалтай холбож үзэж ирсэн нь хэзээний юм. Төр анх үүссэн тэр цаг мөчөөс эхлэн нийгмийн харилцаа төлөвшин хөгжиж, боловсронгуй болсоор ирсэн бөгөөд тэрхүү харилцаа нь нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санаа гэх мэтчилэн бүхий л хүрээг хамарч, төрөөс нийгмийн харилцааг зохицуулах үүднээс зан заншил, уламжлал, улс төр, шашин, эрх зүй гэх зэрэг хүчин зүйлийн нөлөөллийг байнга эрэлхийлсээр ирсэн ба эрх зүй хэмээх хүчин зүйлийг онцгойлон судалж, хөгжүүлснээр эрх зүйн хэм хэмжээгээр аливаа харилцааг зохицуулах болжээ.

Нийгмийн харилцааны үүсэл, хөгжил, төлөвшил түүнд гарч буй чиг хандлага, өөрчлөлт, хэрэгжүүлэх цаашдын нөхцөл боломжийг бүрдүүлэхэд эрх зүй нь өөрийн хэм хэмжээгээр байнга нөлөө үзүүлдэг, эрх зүй нь нийгмийн харилцаа тогтолцооны хувьд төлөвшүүлэх чухал хүчин зүйлийн үүрэг гүйцэтгэж, бүтээлч шинж чанартай байдаг бөгөөд энэ ч үүднээс нийгмийн харилцааны мөн чанар, агуулга, шинж нь эрх зүйгээр тодорхойлогдон тогтоогдож, төлөвшил хөгжлөө олж, тодорхой хууль, журамд нийцэн хэв загварт орж байдаг нь эрх зүйн үйлчлэлийн үр дүн юм.

Гэр бүлийн хямрал даамжирвал нийгмийн тогтолцооны хямрал болж хувирах аюултай талаар гэр бүл судлаач Ч.Нарантуяа “Орчин цагт гэр бүлийн хүчирхийлэл, салалт их байгаа нь нийгэмд задрал явагдаж буйн шинж, үндэстэн мөхөх шалтгаан болно гэсэн үг”¹⁰¹ хэмээн анхааруулсан байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн үндсэн шинжүүдийн нэг болох хүүхэдтэй харгис хэрцгий харьцах нь хүүхдийн эрх, эрх чөлөөг хязгаарласан, дахин давтагдах шинж чанартай гэдэгт эрдэмтэн судлаачид нэгдмэл байр суурьтай байна.

Гэр бүлийн хямралыг үүсгэж байгаа томоохон хүчин зүйлсийн нэг нь ажилгүйдэл юм. Аливаа хүн хөдөлмөрлөж байж өөрийгөө болон гэр бүлээ тэжээдэг. Амьтад хүртэл үр төлөө хүйтэн өвөл хөлдөж үхэхээс хамгаалахын тулд үүр засдаг бөгөөд хооллохын тулд нэгэн хэлбэрийн хөдөлмөр эрхэлдэг. Тэгэхээр ажиллах нь амьдрахын гол шаардлага буюу ажиллах – амьдрах хоёр нь харилцан хамааралтай зүйл юм. Амьдрахын тулд ажиллах хэрэгтэй болж, ажилласнаар амьдрах нөхцөл бүрдэх юм.

Эдийн засгийн ямар ч харилцаа, тэдгээрийн зөрчил нь гэмт явдлыг төрүүлж байдаг. Зах зээлийн харилцаа нь гэмт явдалтай анхнаасаа л цуг байдаг. Энэ нь өрсөлдөөн дээр, ажиллах хүчний илүүдлээр, өөрөөр хэлбэл, ажилгүйдэл дээр, түүнчлэн хүмүүсийн нийгмийн болон эд хөрөнгийн давхарга дээр үндэслэдэг. Зах зээлийн эдийн засаг бий болоход олон зуун жил шаардагдсан боловч, түүнд олон сөрөг үр дагавар байгаа, эдийн засгийн хувьд тааламжтай орнуудад гэмт хэргийн гаралт өндөр байгаа нь бодит зүйл болоод байна¹⁰².

Манай оронд оршиж байсан захиран тушаах эдийн засгийн систем нь гэмт явдлыг төрүүлж байсан ба тийм систем оршин тогтнож байсан бусад улс оронд ч гэмт явдал гарсаар л байсан. Хэрвээ зах зээлийн харилцаанд “Баяжигтун” гэж нээлттэй тунхагласан лозунгаас салшгүй байдаг бол захиран тушаах системийн үед гэмт хэрэгт тооцогдож байсан дамын наймаа хийх, хувийн үйлдвэрлэл явуулах зэрэг үйлдлүүд зах зээлийн үед гэмт хэрэгт тооцогддоггүй байна¹⁰³.

Эрдэмтдийн судалгаанаас үзэхэд, аль ч нийгэм дэх эдийн засгийн системийг туйлын сайн гэх буюу бурхан тэнгэрийн юм шиг бодож болохгүй нь тодорхой байна. Тийм ч учраас гэмт явдлыг нэгэнт төрүүлсээр байгаа эдийн засгийн системийг хий хөөрөгдөн, магтах нь үзэл суртлын хувьд хортой болох нь нотлогдсоор байна. Эдийн засгийн харилцаанаас хамааралгүй нэг ч иргэн нийгэмд байхгүй гэж хэлж болно. Жишээлбэл, зах зээлийн харилцаа нь зөвхөн бараа,

¹⁰¹ Нарантуяа Ч. Иргэдийн эрх зүй. Сэтгүүл. 2014. №14. 25 дахь тал.

¹⁰² Жанцан Н. Криминологи. Сурах бичиг. УБ., 2000. 33 дахь тал.

¹⁰³ Мөн тэнд. 33 дахь тал.

үйлчилгээний зах зээл төдийгүй, ажиллах хүчний зах зээл юм. Хэрвээ захиран тушаах системийн үед ажилгүйдэл нь харьцангуй цөөн бөгөөд нуугдмал байсан бол зах зээлийн харилцаанд ажилгүйдэл нь нээлттэй, албан ёсны байдаг. Харин ажилгүйдэл бол гэмт явдлын нөөц, бэлтгэл болох нь хүн төрөлхтний түүхийн хөгжлөөр батлагдсаар байна¹⁰⁴.

“Өнөөдөр Монголын залуучуудын дотор боловсролтой залуучуудын тоо өсөн нэмэгдэж буй эерэг үзүүлэлт байгаа боловч тэдгээрийн дунд ажил, хөдөлмөр эрхэлдэггүй залуусын тоо өсөж, улмаар тэдний дунд хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгчдийн тоо нэмэгдсээр байна. Чухам яагаад эсрэг үзүүлэлт нь нөгөө талдаа сөрөг үр дагавар дагуулаад байна гэдэгт төрийн бодлогын түвшинд дүгнэлт хийх шаардлага тулгараад байна”¹⁰⁵ гэж профессор Н.Жанцан өөрийн үзэл бодлыг нэгэнтээ илэрхийлсэн байдаг.

Ажилгүйдлийн түвшин нь тухайн улсын нийт ажиллах хүчинд ажилгүйчүүдийн эзлэх хувь юм. Нийт ажиллах хүч нь цалингийн буюу гэрээт ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй гэсэн гурван ангиллаас бүрдэнэ. Хөдөлмөр эрхлээгүй ч ажиллах эрхгүй хүмүүс (жишээ нь, хүүхэд, ахмадууд) ажиллах хүчний тооноос хасагдана. Тиймээс үндэсний ажилгүйдлийн түвшин нь ажилгүй иргэдийн тоог нийт ажиллах боломжтой хүмүүсийн тоонд эзлэх хувийг харуулдаг.

Ажилгүйдлийн түвшний тайлан нь ажилгүйдлийн чиг хандлагыг тодорхойлох эдийн засгийн гол үзүүлэлт юм. Эдийн засгийн *хоцрогдолтой* үзүүлэлт учраас хөдөлмөрийн зах зээлийн өнгөрсөн үеийн гүйцэтгэлийг хянаж, ажил олсон хүмүүсийг хасаж, саяхан ажил хайж эхэлсэн хүмүүсийг нэмж ажилгүй иргэдийн тоог хэмждэг. Төвлөрсөн болон өмнөх үеийн ханшийг харьцуулж үзэхэд их, бага хүмүүс төрөөс дэмжлэг хүсэж байгаа эсэхийг хэмжиж, ажилгүйдэл өсөж байгаа эсвэл буурч байгаа эсэхийг тодорхойлж болно.

Ажилгүйдлийн чиг хандлага нь бизнес эрхлэгчдийн үндэсний эдийн засагт итгэх итгэлтэй хүчтэй хамааралтай байдаг. Өргөжин тэлж буй эдийн засагт бизнесийн өндөр идэвх нь компаниудын итгэлийг нэмэгдүүлж, олон хүнийг ажиллуулах замаар үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд түлхэц болно. Нөгөө талаар эдийн засаг зогсонги, тогтворгүй байвал одоогийн үйл ажиллагааны түвшингээ хадгалж, бизнестээ шинэ хөрөнгө оруулалт хийхээс татгалзахыг зорино. Ханшийн уналт, цар тахал гэх мэт хямралын үед гол зорилго нь компанийн оршин тогтнох байдлыг хангах, ажлын байрны бууралт нэмэгдэх болно¹⁰⁶.

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр, 2017 онд Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны хүн ам 2.1 сая болж, тэдний 62 хувь нь эдийн засгийн идэвхтэй хүн ам байгаагаас, 92 хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа ба өнгөрсөн буюу 2016 оны мөн үеэс 1.8 пунктээр буурсан дүнтэй байна. Нийт ажиллагсдын 30 хувь нь хөдөө аж ахуй, 51.6 хувь нь үйлчилгээ, 18.4 хувь нь үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна. Ажилгүйдлийн дундаж түвшин нь нэг талаас нийгмийн үзүүлэлт

¹⁰⁴ Мөн тэнд. 34 дэх тал.

¹⁰⁵ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016. Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. УБ., 2017. 9 дэх тал.

¹⁰⁶ <https://www.avatrade.mn/education/economic-indicators/fundamental-indicators/unemployment-rate>.

мэт боловч нөгөө талаас ажилгүйдлийн түвшин өссөнөөр өрхийн бодит орлого буурч, бизнесийн ашиг орлогод шууд нөлөөтэй байдаг бөгөөд дараа, дараагийн бизнесийн шийдвэрт чухал нөлөөтэй, макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн нэг юм¹⁰⁷. 2017 онд судалгаанд оролцогсдын 51 хувь нь “ажилгүйдлийн түвшин өссөн” гэсэн хариулт өгсөн ба энэ дүн нь өмнөх оноос 6 нэгж хувиар буурсан байна. Харин ажилгүйдлийн түвшин буурсан тухайн үнэлгээ нь 2017 онд 13 хувь байгаа бол судалгаанд оролцогсдын 36 хувь нь “өөрчлөгдөөгүй, эсвэл мэдэхгүй” гэсэн хариулт өгчээ¹⁰⁸.

Хүн амын шилжилт, хөдөлгөөн ихсэж, ялангуяа Улаанбаатар хотод шилжин ирэх иргэдийн тоо жил ирэх тутам өсөж байгаа нь ажилгүйдлийг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байгаа хэдий ч, төрийн зохистой, зөв бодлого, шийдвэр, үйл ажиллагаа дутагдаж байгааг онцлон анхаарах шаардлагатай байна.

Статистик мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллээр инфляцын түвшин 2024 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар 7.6 хувьтай, ажилгүйдлийн түвшин 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3.9 хувьтай байна.

Хүснэгт 1. Ажилгүйдлийн түвшин¹⁰⁹

Статистик үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022	2023
Ажилгүйдлийн түвшин (хувиар)	7.8	10	7	8.1	6.7	5.3

Хүснэгтээс үзэхэд, 2019 онд ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн бол 2020 онд буурсан, харин 2021 онд өссөн үзүүлэлттэй байгаа бол 2021 оноос хойш буурчээ.

Хүснэгт 2. Ажилгүйдлийн түвшний тайлбар.

№	Нэр	Монгол
1	Салбар	Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн дутуу ашиглалт, дундаж цалин
2	Дэд салбар	ТХЗ болон зохистой хөдөлмөр
3	Тодорхойлолт	Ажилгүйдлийн түвшин гэдэг нь ажилгүйдлийн түвшин буюу эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-д ажилгүйчүүдийн эзлэх хувь нь ажиллах хүчний нийлүүлэлтийн ашиглагдаагүй хэмжээг харуулдаг хэмжигдэхүүн юм
4	Аргачлал, арга зүйн нэр	Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал (ҮСХ-ны дарга, НХХ-ийн сайдын 2009 оны 6 дугаар сарын 16, 19-ний өдрийн 01/68/94 тоот тушаал)
5	Тооцох аргачлал	Ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцно

¹⁰⁷ Монгол үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим. Бизнес итгэлийн индекс. 2017 оны судалгааны тайлан. 11 дэх тал.

¹⁰⁸ Мөн тэнд. 12 дахь тал.

¹⁰⁹ https://www.1212.mn/mn/statistic/statcate/573055/table-view/DT_NSO_0400_020V2.

6	Тооцож эхэлсэн хугацаа	1992.1.1
7	Үзүүлэлтийг тооцох давтамж	Улирал, жил
8	Хэмжих нэгж	%
9	Эх үүсвэр	Ажиллах хүчний судалгаа

Хүснэгт 3. Ажилгүйдлийн түвшний дэд индекс. 2017-2021 онд.

Он	Хэмжих нэгж	Ажилгүйдлийн түвшин	Хамгийн баг утга	Хамгийн их утга	Индекс
2021	Хувь	8	1.0	28.2	47.7
2020	Хувь	6.3	1.0	28.2	55.2
2019	Хувь	11.0	1.0	28.2	37.0
2018	Хувь	7.6	1.0	28.2	49.4
2017	Хувь	7.5	1.0	28.2	49.8

Хүснэгт 4. Ажилгүй хүний тоо (Нийслэлээр, насны бүлгээр)¹¹⁰

Бүс нутаг	Насны бүлэг	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2020	2021
Улаанбаатар	15-19	1318	829	1035	1561	1946	2461	3072	2307	2287
	20-24	7184	4736	4168	8258	9641	7375	8019	6705	4550
		8502	5565	5203	9819	11587	9836	11091	9012	6837
Ажилгүйдлийн түвшин (хувиар) 15-24 нас										
Ангилал	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Улаанбаатар	7.1	4.6	5.1	6.9	9.1	7.5	7.6	8.2	6.3	5.2

Хүснэгт 5. 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал¹¹¹

Статистик үзүүлэлт	Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
Нийт	Ажилгүй хүн	105.614	127.736	87.696	99.778	84.736
	Ажилгүйдлийн түвшин (%)	7.8	10	7	8.1	6.7
	Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин (%)		14	12	13.2	9.9

¹¹⁰ https://1212.mn/mn/statistic/statcate/573055/table-view/DT_NSO_0400_049V1.

¹¹¹ https://www.1212.mn/mn/statistic/statcate/573055/table-view/DT_NSO_0400_006V1.

Хөдөлмөр бол хүний нийгмийн үндэс суурийг бий болгох үнэт зүйл гэж тодорхойлж болно. Энэхүү тайлбар нь зөвхөн эдийн засгийн шалтгаанаар биш, харин хөдөлмөр бол хүний хувийн шинж чанарыг нийгэмд илэрхийлэх хамгийн тохиромжтой хэрэгсэл юм. Түүнчлэн, энэ нь бусад хүмүүс болон бүх ертөнцтэй харилцахдаа өөрийгөө илэрхийлэх гэсэн хүний үндсэн хэрэгцээнд нийцдэг. Тиймээс ажилгүйдлийн түвшин нь эдийн засгийн идэвхжилт, хүн төрөлхтний илүү дээр байдлын үзүүлэлтүүдийн нэг юм. Ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь хотын эдийн засагт сөргөөр нөлөөлж, хөдөлмөрийн зах зээл дэх бүтцийн асуудлуудыг харуулж өгдөг. Түүгээр ч зогсохгүй хөдөлмөрлөх хүсэлтэй боловч хийж чадахгүй байгаа хүмүүс орлогоо хасаад зогсохгүй, сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн харилцаа муудаж, эмзэг мэдрэмтгий байдалд ордог. Түүнчлэн ажилгүйдлийн түвшин нэмэгдэж байгаа нь хэрэглээ, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл буурахад хүргэдэг, макро эдийн засгийн тодорхойгүй байдлыг харуулж байна. Чинээлэг хот ажилгүйдлийг бууруулж, бүх оршин суугчдын эдийн засгийг илүү сайжруулах боломжтой.

Дүгнэлт

1. Манай улсын хувьд ажилгүйдлийн түвшин өндөр байгаа гэхэд болно. Ажилгүйдэл их байхын хэрээр, гэр бүлийн наад захын хэрэгцээг хангах боломж хомсодно гэсэн үг. Амьдралын наад захын хэрэгцээг хангах боломжгүй тохиолдолд иргэдийн дунд бухимдал үүсэж, үүнийг даван туулахын тулд архиан согтуурах, эсхүл ашиг олох зорилгоор гэмт хэрэг үйлдэх явдал ихсэх бөгөөд эдгээр нь бүгд нийгмийн болон гэр бүлийн тогтвортой байдалд шууд нөлөөлж, үр дүнд нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх нөхцөл болох боломжтой байна.

2. Хүн амын шилжилт, хөдөлгөөн ихсэж, ялангуяа Улаанбаатар хотод шилжин ирэх иргэдийн тоо жил ирэх тутам өсөж байгаа явдал нь иргэд нийслэлд хэт ихээр төвлөрөх сөрөг талтай бөгөөд хөдөө орон нутагт ажиллах хүн хүчний дутагдалд орох эрсдэлтэй.

Ашигласан материал

1. Жанцан Н. Криминологи. Сурах бичиг. УБ., 2000.
2. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016. Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. УБ., 2017.
3. Монгол үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим. Бизнес итгэлийн индекс. 2017 оны судалгааны тайлан.
4. Нарантуяа Ч. Иргэдийн эрх зүй. Сэтгүүл. 2014. №14.
5. https://1212.mn/mn/statistic/statcate/573055/table-view/DT_NSO_0400_049V1.
6. https://www.1212.mn/mn/statistic/statcate/573055/table-view/DT_NSO_0400_020V2.
7. https://www.1212.mn/mn/statistic/statcate/573055/table-view/DT_NSO_0400_006V1.
8. <https://www.avatrade.mn/education/economic-indicators/fundamental-indicators/unemployment-rate>.

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨХ АРГА ЗҮЙ

MONEY LAUNDERING ENFORCEMENT PRACTICES

Д.Түвшинтөр

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн

*Мөрдөх арга зүйн тэнхимийн дэд профессор,
цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Монгол Улсад 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэл, уг зүйл ангиар эрүүгийн хариуцлагад татахад учирч байгаа хүндрэлтэй нөхцөл байдал, 2002 оны Эрүүгийн хуулийн 166¹¹² дүгээр зүйлд заасан мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлийн ялгаатай байдлыг уг илтгэлээр товч авч үзлээ.

Abstract: the report summarizes the differences between the criminal code in effect in Mongolia as of 2017-07-01, article 18.6 of the Criminal Code for money laundering, the difficult situation to bring to criminal liability under this article, and the Criminal Code of 2002, article 166 of the Criminal Code.

Түлхүүр үгс: Эдийн засгийн аюулгүй байдал, мөнгө угаах гэмт хэрэг.

Keywords: economic security, money laundering.

Мөнгө угаах нь эдийн засаг, нийгмийн ихээхэн сөрөг үр дагавартай. Хууль бус мөнгө гаднаас орж ирсэн бол зорилгодоо хүрээд гэнэт орж ирсэн шигээ гэнэт буцаж гарна. Их хэмжээний мөнгө гэнэтийн шилжилт нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг эвдээд зогсохгүй хямралд ч хүргэж болох юм. Үүний зэрэгцээ олон улсын тавцанд дотоодын банк, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд унах, банк, санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээг саатуулан шалгах, тэдгээртэй харилцахаас татгалзах хүртэлх арга хэмжээг гаднын орнууд авах тохиолдол байна. Хууль бус мөнгө дотоодынх бол энэ нь хээл хахууль, авлигыг гааруулах, шударга өрсөлдөөнийг хавчих, шударгаар бизнес эрхлэгчдийг зах зээлээс шахаж монопол байдал бий болгох зэрэг олон сөрөг үр дагавартай. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо дутуу хөгжсөн орнуудыг мөнгө угаагчид ашиглах эрсдэл өндөр байдаг гэсэн практик судалгаа байдаг ба манайх шиг жижиг эдийн засагтай улс оронд хөрөнгө оруулалт, мөнгөний хэрэгцээ их байгаа нь өнөөгийн нийгэм, улс төрийн нөхцөл байдлаар хэнд ч тодорхой харагдана. Тэр ч хэмжээгээр банкнуудад хуримтлал үүсгэх, хөрөнгө оруулалтыг дэмжих сонирхол их байгаагийн зэрэгцээ банкаар дамжиж байгаа орлого, хөрөнгийн цаад эх үүсвэр, бизнесийн мөн чанарын талаар сонирхох,

¹¹² Эрүүгийн хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2002. №5.

судлах хэрэгцээ байхгүй мэт ойлгосоор байна. Гэтэл энэ байдал нь эргээд санхүүгийн системийн найдвартай, тогтвортой байдалд заналхийлж болзошгүй байна.

Монгол Улсад 2006 оны 7 дугаар сард “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хууль батлагдаж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны үндэс суурь тавигдсан. Энэ хуулийн дагуу 2006 оны 11 дүгээр сарын 29-нд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн мэдээллийн алба (СМА) Монгол банкны харьяанд байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба тус алба нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий ч Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкууд шаардлагатай мэдээллийг тухай бүр өгдөггүй, гадаадын улс орнуудын төв банкуудаас ч хүссэн мэдээллээ тэр бүр авч чадахгүй байгаа нь энэ чиглэлээр Засгийн газрын тууштай бодлого шаардлагатай байгааг цухас дурдахгүй өнгөрч болохгүй болов уу. 2012 оны 07 дугаар сарын 18-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын даргын 459 дүгээр тушаалаар Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст шинээр Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн байгуулсан¹¹³ нь дээрх гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулсан бодит ажлын нэг гэж үзэж болох юм.

Үндэсний ардын хувьсгал ялснаас хойш батлагдан гарсан баримт бичгүүдээс дурдвал 1926 онд баталсан Монгол Улсын Шүүн таслах газраас аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хуулийг баталснаар Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан боловсронгуй болох эхлэл тавигдсан ба 1926, 1929, 1934, 1942 оны Эрүүгийн хуульд мөнгө угаах гэмт хэргийн талаарх талаар ойлголтогүй байсан ба түүнд хүлээлгэх хариуцлагыг зохицуулан, хуульчлаагүй байсан байна.

Мөнгө угаах гэмт хэргийн онол эрх зүйн ойлголтыг анх Монгол улсад 1961 оны Эрүүгийн хуулийн 170 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг авах буюу борлуулах” гэж тодорхойлоод, “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг мэдсээр байгаад удаа дараа буюу их хэмжээгээр авсан буюу худалдан борлуулбал, хөрөнгийн заримыг буюу бүгдийг хураах буюу хураахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл хөрөнгийн заримыг буюу бүгдийг хураах буюу хураахгүйгээр уг нутгаас зайлуулна”¹¹⁴ гэж тусгаж хуульчилсан байна.

Уг зүйл анги нь мөнгө угаах гэмт хэргийг ойлголтыг анх тусгасан бөгөөд удаа дараа буюу их хэмжээгээр авсан буюу худалдан борлуулсан объектив үйлдэлд хариуцлага хүлээлгэхээр тусгагджээ. Эндээс үзэхэд, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг мэдсээр байж нэг удаа авсан, эсхүл бага хэмжээгээр авсан, худалдан борлуулаагүй тохиолдолд гэмт хэрэг гэж үзэхгүй байх боломжтой байна¹¹⁵.

БНМАУ-ын Их Хурлын тэргүүлэгчдийн зарлигаар 1986 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг (Нийгмийн аюулгүй байдал,

¹¹³ Цагдаагийн ерөнхий газрын даргын 459 дүгээр тушаал. УБ., 2012 оны 07 дугаар сарын 18-ны өдөр.

¹¹⁴ Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль, тогтоомжийн хөгжилт. I дэвтэр. УБ., 1998. 196 дахь тал.

¹¹⁵ Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал: 1911-2009 он. Сурах бичиг. УБ., 148 дахь тал.

нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг)-ийн 240 дүгээр зүйлд “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэрэг болгон хуульчилсан. Уг хуульд мөнгө угаах гэмт хэргийг үндсэн, хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр тусгасан¹¹⁶. Үүнд:

- Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг мэдсээр байж урьдчилан амлахгүйгээр авсан бол нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу нэг мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэх, эсхүл олон нийтийн нөлөөллийн арга хэмжээ авхуулна;

- Энэ хэргийг их хэмжээтэй буюу байнга хийсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ;

- Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр борлуулахаар олж авсан буюу хадгалсан, эсхүл борлуулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

- Энэ зүйлийн гурав дах хэсэгт заасан хэргийг их хэмжээтэй буюу байнга хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр, нутаг заах буюу заахгүйгээр долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ¹¹⁷.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 1986 онд баталсан Эрүүгийн хуульд мөнгө угаах гэмт хэргийг дээрх байдлаар хуульчилж байсан. “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийн нийгмийн аюул, хохирол, хор уршиг, ялын зорилгыг хангах Эрүүгийн хуулийн нөлөөллийн аргыг удиртгал болгодог байв. Ял шийтгэлийн хүчийг ашиглан нөлөөлөх арга замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийг энэ төрлийн гэмт хэргээс зайлсхийлгэж, ард иргэдийн сэтгэхүйд болохгүй гэсэн үзэл суртлыг суулгаж байсан цаг үе гэж ойлгож болно. Нөгөөтээгүүр, социалист нийгмийн үзэл суртлын үе байсантай холбоотойгоор өмчийн харилцаа, эрх зөвхөн төрд зонхилж байсантай холбоотой. Социалист нийгэмд мөнгө угаах гэмт хэргийн үйлдэгдэж болохуйц салбар нь төрийн эрх бүхий албан тушаалтнууд байв. Социалист нийгмийн үед мөнгө угаах гэмт хэргийн хэлбэр нь бараа солилцоо, бартер хийх, хөрөнгө мөнгийг дамлан зарж борлуулж, байсан байна. Үүнээс үзэхэд, нийгмийн шинж нөхцөл байдалтай холбоотойгоор мөнгө угаах гэмт хэрэг хэрэг үйлдэгдэх нөхцөл боломжууд бага байсныг харуулж байна. Учир нь оффшор банк, гадаад банкны дансыг ашиглах, бизнесийн хөрөнгийн оруулалт, санхүүгийн зах зээлд оруулах боломж бололцоо хомс, хувийн өмч гэх ойлголт байхгүй, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай байсантай холбоотой. Манай оронд ардчилсан хувьсгал ялснаар 1990 оноос эхлэн ардчилсан нийгэм, чөлөөт эдийн засаг бий болж нийгмийн бүхий л харилцаа хөгжих суурь эхлэл болсон. Ардчилсан үндсэн хууль батлагдсанаас хойш олон төрлийн чөлөөт эдийн засагтай барууны улс орнуудад үйлдэгддэг гэмт хэргүүд даяаршлын нөлөөгөөр манай улсад гарах нөхцөлийг бий болгосон.

¹¹⁶ Мөн тэнд. 178 дахь тал.

¹¹⁷ Баярсайхан Б., Жанцан С., Энхсайхан Ж., Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. Сурах бичиг. УБ., 2011. 583 дахь тал.

Хууль тогтоох байгууллагаас анх мөнгө угаах гэмт хэрэг гэх нэршлийг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 178² дугаар зүйл буюу “Терроризмыг санхүүжүүлэх” гэмт хэрэг болон, Эрүүгийн хуулийн 268¹ дугаар зүйлд “Мөнгө угаах” гэмт хэргийн зохицуулалтыг нэмж хуульчилсан явдал юм.

Эрүүгийн хуулийн 268¹ дугаар зүйлд Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан буюу гэмт хэргийн бүрэлдэхүүний халдлагын зүйл, объектив талын үйлдлийн шинжийг энэ гэмт хэргийн заавал байх шинж болгож нийгэмд аюултай гэмт хэрэгт тооцсон.¹¹⁸ Олон улсын түвшинд мөнгө угаах гэсэн ойлголтыг өргөн хүрээнд хэрэглэдэг. Уг ойлголт нь гэмт хэрэг үйлдэж олсон орлогоо нуусан, халхалсан, шилжүүлсэн үйлдэлд нь тухайн гэмт этгээдэд анх үйлдсэн гэмт хэрэг дээр нь давхардуулж ял, шийтгэл оноох эсхүл гэмт хэрэгт нь биечлэн оролцоогүй ч түүнээс олсон орлогыг хууль бус гэдгийг нь мэдсээр байж хүлээн авч, нууж, шилжүүлсэн бусад этгээдийг яллан шийтгэхэд уг томъёоллыг ашигладаг.

Мөнгө угаах гэмт хэргийг гэмт хэрэгт тооцсон үеэс хойших эрүүгийн эрх зүйн зохицуулалтад дүгнэлт хийхэд Монгол Улс өнөөдрийг хүртэл хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгож чадаагүй бөгөөд мөнгө угаах гэмт хэрэгт холбогдох өндөр эрсдэлтэй гэмт хэрэг буюу суурь гэмт хэргийг зөв тодорхойлоогүйгээс мөнгө угаах гэмт хэргийг хуучин буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 155 дугаар зүйл буюу "Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах"¹¹⁹ гэмт хэргийн шинжээс ялгаж чадахгүй байгаа нь одоогийн дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл болоод байна. Өнөөдрийн байдлаар ахуйн хүрээний гэж хэлж болох хулгайн гэмт хэрэг үйлдэж олсон мөнгө, эд зүйл, мал амьтныг худалдан авсан, нуусан, дамжуулсан, зарж борлуулсан зэрэг үйлдлүүдэд ч мөнгө угаах гэмт хэрэг болж зүйчлэгдэхээр болоод байгаа нь Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тодорхойлолгүй "Гэмт хэрэг" гэдэг томъёоллоор хуульчилсан нь уг гэмт хэрэгтэй тэмцэх тэмцэл ахуйн хүрээнд маш "үр дүнтэй" хийгдэж мөнгө угаах гэмт хэргээр тэмцэх тэмцэлд үр дүнд хүрэхээр байгаа ч 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш энэ зүйл ангиар шүүхээр ял шийтгэгдсэн тохиолдол төдийлөн их биш байна.

Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх түр хороо (ФАТФ)-ны тайланд Монгол Улсад бий болсон мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх ноцтой эрсдэлүүдэд авлига, хээл хахууль, татвараас зайлсхийх явдал, хүн болоод амьтдыг хууль бусаар хил давуулан худалдаалах, техник технологийн шинэ ололтуудыг хэрэглэх, оффшор банкнуудыг ашиглах, хууль бус үнэт цаасны арилжаа, хар тамхины хууль бус наймаа, хууль бусаар валют арилжих ажиллагаа,

¹¹⁸ Дотоод хэргийн их сургууль. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал. УБ., 2012. 37 дахь тал.

¹¹⁹ Эрүүгийн хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2002. №5.

Монголын эдийн засагт бэлэн мөнгө зонхилж буй байдал, Монгол Улсын хил хязгаар нь мөнгө угаахад бэлэн мөнгө тээвэрлэгчдийг ашиглах эрсдэлийг бий болгож буйг дүгнэсэн нь мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх суурь, хөрс, боломж, аюулын цар хүрээг тодорхойлжээ¹²⁰. Уг тайланд Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгасан шиг бүх төрлийн гэмт хэргийг хамруулаагүй бөгөөд мөнгө угаах гэмт хэргийн үндсэн буюу суурь гэмт хэргийн төрлүүд (designated categories of crimes)-ийг тодорхой тусгажээ.

Мөнгө угаахтай тэмцэхийн гол зорилго нь хэн нэгэн хүнд гэмт үйлдэлд нь давхар ял онооход бус харин бусад этгээдийг гэмт этгээдэд тус дэм үзүүлж болохуйц үйл ажиллагаа явуулахыг хязгаарлахад оршдог. Энэ нь нэг талаас мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх түүнд татагдан оролцохоос сэргийлэх ач холбогдолтой байдаг.

Олон улсын стандарт буюу НҮБ-ын 2000 оны Палермогийн конвенцод мөнгө угаах үйлдлийг тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл үндсэн гэмт хэргийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх, тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах, тухайн эд хөрөнгийг олж авах үед түүнийг гэмт хэргийн улмаас олсон орлого, гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах, мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, үгсэн тохиролцох, үйлдэхийг завдах болон хамжих, хатгах, туслах болон зөвлөх гэж тодорхойлсон байдаг¹²¹.

Мөнгө угаах гэмт хэрэг нь дараах үе шаттай үйлддэг.

Эхний үе шат: Мөнгө угаах нь гэмт хэрэгтнүүдийн хувьд хууль бус орлогын эх үүсвэрээ аливаа эрсдэлд оруулалгүйгээр түүнээс олсон ашиг, орлогоо тааваараа ашиглахад туслах, санхүүгийн аюулгүй байдлаа хамгаалахад чиглэгдсэн маш чухал үйл явц юм. Мөнгө угаах гэмт хэрэг нь байршуулах, тараах буюу гүйлгээнд оруулах, буцааж төвлөрүүлэх гэсэн шаттайгаар хийгддэг. Эхний үе шат буюу байршуулах үе шатанд хууль бусаар олсон мөнгөө хаа нэгтээ байршуулах шаардлагатай байдаг. Тухайлбал, гэмт этгээд өөр хүний нэр дээр банканд нээлгэсэн дансанд хууль бусаар олсон мөнгөө анхаарал татахааргүй хэмжээтэйгээр таслан хийх, дотоод болон гадаадын иргэд үнэт цаас, чек, хувьцаа байр, байшин худалдан авах, гадаадын улсад ялангуяа оффшор гэгдэх бүсийн улсуудын банкнууд дахь өөрийн эзэмшиж байгаа болон өөрийн хамаарал бүхий этгээдүүд, аж ахуйн нэгжүүдийг данс руу шилжүүлэх замаар байршуулдаг.

Дараагийн үе шат: Гарал үүслийг нь нуун далдлах, хууль ёсны орлого мэт харагдуулах зорилготойгоор нэгэнт байршуулсан мөнгөө эргэлтэд оруулдаг. Жишээлбэл, худалдан авсан үнэт цаас, хөрөнгийг эргүүлэн зарах эсвэл гадаад худалдаа эрхэлж буй мэт харагдуулах зорилгоор мөнгө угаахтай тэмцэх хяналтын механизм бүрдүүлээгүй орнууд руу шилжүүлэх гэх мэт аргыг хэрэглэнэ.

¹²⁰ Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх түр хороо (ФАТФ).

¹²¹ НҮБ-ын 2000 оны Палермогийн конвенц.

Гурав дахь үе шат: Нэгэнт гарал үүслийг нь тогтооход бэрх болсон эсхүл хууль ёсны юм шиг харагдах болсон мөнгөө эргүүлэн өөрийн нэр дээр төвлөрүүлэх юм.

Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр нь терроризмыг санхүүжүүлэхтэй ижил төстэй явагддаг тул энэ хоёр гэмт хэргийг нягт холбодог. Гэвч агуулгын хувьд энэ хоёр нь тусдаа явагддаг. Тухайлбал, мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны юм шиг харуулахыг зорьдог байхад терроризмыг санхүүжүүлэх нь хууль ёсны болон хууль бус орлогоор уг үйл ажиллагаанд зарцуулахыг зорьдог.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх арга хэмжээний хүчийг сулруулах улмаар мөнгө угаалтыг хөнгөвчлөхөд хүргэж болзошгүй авлига (албан тушаалтнуудад хахууль өгөх, үүнд улс төрийн нөлөөтэй хүмүүсийн нөлөөлөл багтана). Валютын арилжаа (бэлэн мөнгөний хөрвүүлэлт, илрүүлэлтийн эрсдэлийг багасгахын тулд улс хооронд зөөвөрлөх, эсвэл валютын арилжааны тайлагналтад сул шаардлага тавьдаг байдлыг ашиглах, тухайлбал, мөнгийг өөр улс руу тээвэрлэхийн тулд замын чек худалдан авах). Бэлэн мөнгө зөөвөрлөгчид (валют зөөвөрлөх, гүйлгээний) бэлэн мөнгөний тайлагнах арга хэмжээнээс бултахын тулд валютыг нууцаар шилжүүлэх.

Мөнгө тушаах бүтцийг өөрчлөх (Structuring/smurfing)

Мэдээлэх үүрэг хүлээлгэн тогтоосон босго хэмжээнээс зайлсхийхийн тулд олон гүйлгээг (дансанд мөнгө тушаах, данснаас зарлагдах, шилжүүлгүүд) янз бүрийн хүмүүс их хэмжээний мөнгийг жижиг дүнтэйгээр зарим үед олон тооны дансанд шилжүүлэх арга юм.

Зээлийн картууд, чекүүд болон энгийн вексель гэх мэт ихэвчлэн өөр улсын санхүүгийн байгууллага дахь мөнгөнд /санд/ нэвтрэх хэрэгслээр ашигладаг. Шилжүүлэх боломжтой үнэт эдлэлийг худалдан авах (үнэт чулуу, үнэт металл зэрэг), өмчлөлийг нь нуух, эсвэл илрэлтэд өртөхгүй байдлаар зөөх болон санхүүгийн салбар дахь МУТСТ арга хэмжээнээс зайлсхийх жишээ нь очир үнэт эдлэлийг өөр улс руу зөөх. Үнэтэй хөрөнгө худалдан авах зэрэг болно.

Гэмт хэргийн орлогоор өндөр үнэ бүхий арилжих боломжтой бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийснээр гэмт хэргээс олсон орлого гэдгийг нь нууж, тайлагнах шаардлагад бага хамааралтай байдлыг ашиглах. Бараа солилцоо /бартер/, санхүүгийн салбарын МУТСТ арга хэмжээнээс зайлсхийхийн тулд мөнгө болон санхүүгийн хэрэгслийг хэрэглэхгүйгээр героиныг алтны гулдмайгаар шууд солилцох.

Бэлэн бус шилжүүлгийг хэрэглэхдээ илрүүлэлт болон хураан авах арга хэмжээнээс зайлсхийхийн тулд санхүүгийн байгууллагуудын хооронд ихэвчлэн нөгөө улс орон руу электрон шилжүүлэг хийх. Нууц банк, албан бус гуйвуулгын үйлчилгээ, итгэлцлийн сүлжээн дээр суурилсан албан бус механизмыг ашиглан мөнгө гуйвуулдаг явдлууд дэлхий нийтэд элбэг байна. Энэ нь голдуу уламжлалт банкны салбартай зэрэгцэн оршдог бөгөөд зарим улс оронд хууль бус гэж тооцогддог байна. Уг сүлжээг мөнгө угаагч болон терроризмыг санхүүжүүлэгч этгээдүүд ашиглан хөрөнгийг илрүүлэлтэд өртүүлэхгүй, өөрсдийн хяналтад буй мөнгөний гарал үүслийг нуун шилжүүлдэг.

Худалдаанд суурилсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх ажиллагаа

Санхүүгийн тунгалаг байдлын хууль зохицуулалтуудаас зайлсхийхийн тулд худалдааны санхүүжилтийн замууд болон бараа бүтээгдэхүүнийг ашиглан ихэнх тохиолдолд нэхэмжлэхийг өөрчлөх. Казино,морин уралдаан, интернэтээр бооцоотой тоглох зэрэг тоглоомын үйл ажиллагаанууд юм. Мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах буюу хууль ёсны тоглогчоос хожлын тасалбарыг худалдан авах, казиногийн чипийг гэмт хэрэгтэй холбоотой гүйлгээнд төлбөрийн хэрэгсэл болгон хэрэглэх, онлайн мөрийтэй тоглоомыг гэмт хэргийн орлогыг нуухад ашиглах. Ашгийн бус байгууллагыг ашиглах (ТББ),Террорист санг өсгөн арвижуулах, мөнгөний эх үүсвэр болон мөн чанарыг нуун далдлах, террорист санг түгээхэд ашиглах. Санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх, арилжих боломжтой хэрэгслүүдийг худалдан авах замаар гэмт хэргийн орлогын эх үүсвэрийг нуун далдалж, тайлагналтын харьцангуй доогуур шаардлагыг ашиглах.

Мөнгө угаалтын үндсэн алхам буюу гэмт хэргийн орлогыг хууль ёсны мөнгөтэй холилдуулан эх үүсвэрийг нь нуун далдлах юм. Ингэхдээ халхавч компаниуд ашиглах, хөрөнгийг хянаж буй этгээдийг таньж мэдэхээс зайлсхийж, тайлагналтын харьцангуй доогуур шаардлагыг ашиглах. Оффшор банкууд бизнес, итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгч компанийг ашиглах. Дотоодын эрх бүхий байгууллагын хориг хязгаарлалтаас зайлсхийхийн тулд мөнгийг шилжүүлэхдээ итгэмжлэгдэгч, итгэлцлүүд, гэр бүлийн гишүүд болон гуравдагч талуудыг ашиглах. Бусдын хувийн мэдээлэл /баримт бичгийг хулгайлан ашиглах/ (identity fraud/false identification), Мэргэжлийн үйлчилгээний “хаалгач”-дыг (хуульчид, нягтлан бодогчид болон брокерууд) ашиглах. Хөрөнгийн эцсийн өмчлөгчид болон хууль бус мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах зорилготой юм. Түүнчлэн гэмт хэрэгтнүүдэд мөнгө угаах “Мэргэжлийн” зөвлөгөө өгөхөөр авлига авсан мэргэжилтнүүдийг хамааруулж болно.

Мөнгө угаах гэдэг нь гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлс, ашиг, орлогын эх үүсвэрийг нуун далдалж уг мөнгө болон эд зүйлсийг хууль ёсны мэтээр халхавчлан эдийн засгийн эргэлтэд оруулах, хэлбэр дүрсийг хувиргах бүхий л үйлдлийг ойлгодог. Богино хугацаанд их хэмжээний ашиг олох нь уг гэмт хэргийн зорилго байдаггүй бөгөөд гол нь гэмт хэрэг үйлдэж олсон гэх ул мөр үлдээхгүй байх нь чухал байдаг.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх зорилго бол ахуйн хүрээнд эсхүл хохирол багатай эдийн засгийн гэмт хэргийн халдлагад өртсөн эд зүйлийг хамгаалахад чиглэдэггүй бөгөөд албан тушаал, авлигын бүх төрлийн гэмт хэрэг, татвар төлөхөөс зайлсхийх, хүний наймаа, хууль бус зэвсгийн худалдаа, мансууруулах төрлийн гэмт хэрэг, үндэстэн дамнасан гэмт хэргүүд, терроризм, байгалийн баялагтай холбоотой гэмт хэргээс олсон хууль бус орлого, эдийн болон эдийн бус давуу талыг илрүүлэх, олон улс болон тухайн улсын эдийн засгийн цэвэр урсгалыг хар зах зээлээс хамгаалж бохир мөнгөний урсгал нөгөө талаар хууль бус санхүүжилтийг таслан зогсооход чиглэгддэг.

Мөнгө угаах гэмт хэрэг үүсэж хөгжсөн түүхийн цаг үе, байдлаас харахад эдийн засгийн хувьд тогтворгүй, ядуу буурай эсхүл жижиг эдийн засагтай гаднын

зээл, буцалтгүй тусламж хөрөнгө оруулалтад тулгуурлан хөгжиж буй орон мөн гадаадын хөрөнгө оруулагчдын мөнгөний эх үүсвэрийг шалгах боломж муутай улсад үйлдэгдэх нь түгээмэл байдаг.

Монгол Улсад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх ноцтой эрсдэлүүд тулгараад байна. Монгол улсын хувьд гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус орлогын дийлэнх хэсэг нь авлига, хээл хахууль, татвараас зайлсхийх явдал, хүн болоод мал, амьтдыг хууль бусаар хил давуулан худалдаалах үйл ажиллагаанаас бий болж нийт авлигын хэмжээ 2006-2010 онуудад ойролцоогоор 337 сая ам.доллар хүрсэн тухай Монгол Улсын авлигын индексийн судалгаанд дурджээ. Монголын эдийн засаг дахь бэлэн мөнгө зонхилох байдал болон Орос, Хятад улсуудтай хиллэдэг Монгол Улсын уудам хил хязгаар нь мөнгө угаахад бэлэн мөнгө тээвэрлэгчдийг ашиглах эрсдэлийг бий болгоход мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байгааг дээрх судалгаагаар сануулжээ.

Дүгнэлт

1. Терроризм, үндэстэн дамнасан гэмт хэрэг, авлига, албан тушаалын гэмт хэрэг, олон улсын байгууллага, банк, гаднын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй сан, буяны байгууллага, татвар төлөхөөс зайлсхийх, хар зах зээл дэх бэлэн мөнгөний эргэлтийг зогсоох, мансууруулах бодис, галт зэвсгийн худалдаа, хүний наймаа, хууль бус эсхүл халхавчилсан үнэт цаасны арилжаа зэрэг зохион байгуулалттай үйлдэгддэг гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх арга нь дээрх гэмт хэргийн улмаас олсон орлогыг илрүүлэх бөгөөд энэ бүх нөхцөлийг харгалзаж Монгол улс эрх зүйн орчиндоо мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоо оновчтой тодорхойлох шаардлагатай.

2. Мөнгө угаах гэмт хэрэг ахуйн хүрээнд, тохиолдлын шинжтэй үйлдэгддэггүйг анхаарч хууль боловсруулах, батлах шатанд уг гэмт хэргийн зорилго, учруулж болох аюул, хор уршиг, дэлхий нийтээр уг гэмт хэрэгтэй тэмцэх болсон зорилго, ач холбогдлыг анхаарч 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдан 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах талаар эргэн харах шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль, тогтоомжийн хөгжилт. I дэвтэр. УБ., 1998. 196 дахь тал.

2. Баярсайхан Б., Жанцан С., Энхсайхан Ж., Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. Сурах бичиг. УБ., 2011. 583 дахь тал.

3. Дотоод хэргийн их сургууль. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал. УБ., 2012. 37 дахь тал.

4. НҮБ-ын 2000 оны Палермогийн конвенц.

5. Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх түр хороо (ФАТФ).

6. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал: 1911-2009 он. Сурах бичиг. УБ., 148 дахь тал.

7. Цагдаагийн ерөнхий газрын даргын 459 дүгээр тушаал. УБ., 2012 оны 07 дугаар сарын 18-ны өдөр.

8. Эрүүгийн хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2002. №5.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ МӨРДӨГЧИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

IN CRIMINAL PROCEEDINGS STRENGTHENING THE DETECTIVE'S INDEPENDENCE

Д.Бат-Эрдэнэ

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн

*Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн багш,
цагдаагийн ахмад*

Товч агуулга: Дэлхий нийт даяарчлагдаж хүн амын өсөлт, цахим техник технологи хөгжихийн хирээр гэмт үйлдэл, санаа бодол, улам нарийсаж, улмаар дэвшилтэд технологи ашиглан гэмт хэрэг үйлдэх арга улам бүр боловсронгуй болсоор байна. Харин шинэ үеийн алба хаагчдад тулгамдаж буй асуудал нь хувь хүний ур чадвар, бие даасан байдал, олон талын мэдлэг чадвар, харилцаа хандлага, маш чухал байсаар байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний зөрчигдсөн эрхийг сэргээх, төрийн эрүүгийн ялын бодлогыг хэрэгжүүлэх, нэг талаас төрийг төлөөлж, нөгөө талаас эрх ашиг, сонирхол нь зөрчигдсөн иргэний эрх ашгийг хамгаалах ажиллагааг явуулахдаа түргэн шуурхай, хуульч ажиллагаатай, иргэд олон нийтийн итгэл хүлээсэн зөв оновчтой шийдвэр гаргах, мөрдөгчийн бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлага, ёс зүй өндөр, мэдлэг чадвар сайтай, мөрдөгчийн хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

Abstract: Due to the globalization of the world, the growth of the population and the development of electronic technology, criminal acts and ideas are becoming narrower, and the methods of committing crimes using advanced technology are becoming more and more sophisticated. However, the problems faced by the new generation of servicemen are personal skills, independence, multifaceted knowledge, and communication skills, which are still very important. Criminal proceedings are fast, legal, and rational decisions that are trusted by citizens in the process of restoring violated human rights, implementing the state's criminal punishment policy, representing the state on the one hand, and protecting the interests of citizens whose rights and interests have been violated on the other hand. to strengthen the independence of detectives, and the need for detectives with high responsibility, ethics, and knowledge is increasing more and more.

Түлхүүр үгс: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, мөрдөн шалгах ажиллагаа, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, цагдаагийн албан хаагч, мөрдөгч, мөрдөгчийн шийдвэр.

Keywords: Criminal proceedings, investigation, investigation, investigation, Police officer, detective, detective's decision.

Орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэж хөгжөөд 102 жилийн түүхэнд ард иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах үйл хэргийг чин шударгаар гүйцэтгэж ирсэн арвин их түүхтэй, хийж бүтээсэн гавьяатай алба юм.

Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага болсон бөгөөд Цагдаагийн байгууллагын чиг үүргийг гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэж тодорхойлжээ¹²².

Дээр дурдсан Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн нэг болох “Гэмт хэрэгтэй тэмцэх” үүргийг Мөрдөн байцаах алба, Эрүүгийн цагдаагийн алба Монгол улсын үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Цагдаагийн албаны тухай хууль, бусад дүрэм, журам хууль эрх зүйн актуудыг удирдлага болгон Аймаг, Нийслэл, нутаг дэвсгэр хариуцсан Цагдаагийн байгууллагын нэгжүүдийн Мөрдөн байцаах алба, хэлтэс, тасгийн мөрдөгч албан тушаалд ажиллаж гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах зорилгоор хууль сахиулах ажиллагаа явуулах гэж ойлгох бөгөөд гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг шийдвэрлэх ажиллагааны явцад “Олзлох” гэсэн шинэ утга нэмэгдэв¹²³.

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгт:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах зорилгоор хууль сахиулах ажиллагаа явуулахыг гэмт хэрэгтэй тэмцэх гэнэ;

- Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд доор дурдсан эрх хэмжээг хэрэгжүүлнэ;

- Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах олж авмагц, таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх;

- Гэмт хэрэг, зөрчил гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах;

- Цагдаагийн алба хаагч биечлэн, эсхүл техник хэрэгсэл ашиглан нийтийн эзэмшлийн газарт хяналт тавих, эргүүл ажиллуулах;

- Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах;

- Гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл, хөтлөх, лавлагаа гаргах, гэх мэт үүргийг тусгаж өгсөн байна¹²⁴.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд мөрдөгчийн эрх үүргийг дараах байдлаар тусгаж өгсөн. Үүнд:

- Гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох;

- Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх;

- Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах санал прокурорт гаргах;

- Гэрч, хохирогч, иргэний хариуцагч, иргэний нэхэмжлэгч, шинжээч, яллагдагчийг дуудан ирүүлэх;

- Оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх;

¹²² Ганболд Ч. Дэлхийн зарим улсын цагдаа. Уб., 2016. 328 дахь тал.

¹²³ Ганболд Ч. Дэлхийн зарим улсын цагдаа. Уб., 2016. 328 дахь тал.

¹²⁴ Цагдаагийн албаны хууль тогтоомжийн эмхэтгэл I. Уб., 2014. 11 дэх тал.

• Мөрдөгч авахаар хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, хүчингүй болгох, шүүх, прокурор авахаар хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, хүчингүй болгох, өөрчлөх тухай санал прокурорт гаргах;

• Хуульд заасны дагуу сэжигтнийг баривчлах;
• Сэжигтнийг баривчлах шүүхийн зөвшөөрөл авах тухай санал прокурорт гаргах;

• Шинжилгээ хийлгэхээр шинжээч томилох;
• Прокурорын даалгавраар мөрдөн шалгах ажиллагаа явуулах, даалгаврыг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор тухайн прокурорын газрын дээд шатны прокурорт саналаа бичгээр нэг удаа гаргах;

• Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл 5 хоногийн дотор дээд шатны прокурорт бичгээр саналаа гаргах;

• Прокурорын зөвшөөрлөөр мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулахаар эрх бүхий байгууллагад даалгавар бичиж, гүйцэтгүүлэх;

• Өөр нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрэн сурвалжлах шаардлага гарвал энэ тухай даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамтаар ирүүлэх;

• Энэ хуульд заасан бусад эрхтэй гэж заажээ¹²⁵.

Мөрдөгчийн албан тушаалын тодорхойлолтын зорилгод “Монгол улсын эрүүгийн хуулийн тусгай ангид заасан харьяалах гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, гэмт хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах” гэж тусгайлан заагаад доорх байдлаар дэлгэрэнгүй задалжээ. Үүнд:

1. Харьяалах гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, гэмт хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах;

2. Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох талаар цагдаагийн бусад албадтай хамтран ажиллах;

3. Удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлэх;

4. Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилтод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

5. Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх;

6. Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөх;

7. Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.

Онцгой нөхцөл – Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц

¹²⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №23.

ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд уртасгасан цагаар болон өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах¹²⁶.

- Цагдаагийн байгууллагад харьяалал харгалзахгүйгээр гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл хүлээн авч шалгадаг болсон нь мөрдөгч нарын ажлын ачаалал нэмэгдэх шалтгаан болж байгаа бөгөөд гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэргийн ул мөрийг хамгаалах, бэхжүүлэх арга хэмжээ авна;

- Оргон зайлсан яллагдагч, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг олж тогтоох ажлыг Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах асап санд зарлахаас гадна, түүнийг олж тогтоох чиглэлээр бүхий л ажлыг зохион байгуулах;

- Дээд газар, хэлтсээс ирсэн хугацаатай үүргийн биелэлт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил аян ажил арга хэмжээнд оролцох, түүнийг биечлэн хариуцах биелэлт үр дүнг тооцох;

- 24 цагийн хугацаагаар жижүүрийн мөрдөгчийн үүрэг гүйцэтгэж, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулж, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох, жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн өдрийн маргааш нь хэргийн хугацаа сунгах, өөр хэрэгт ажиллагаа хийх, гэрч хохирогчоос мэдүүлэг авах;

- Үндэсний их баяр наадам, цагаан сар, гадаадын зочин төлөөлөгчийн хамгаалалт, нийтийн хамарсан эмх замбараагүй байдлын үед татагдан оролцдог бөгөөд энэ хугацааны өдрүүдэд хэргийн хугацаа зогсдоггүй, өөрөөр хэлбэл мөрдөн шалгах ажиллагааны хугацаа үргэлжилж байдаг учраас мөрдөгчийн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай байна¹²⁷.

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд төрийн албанд баримтлах зарчмыг дараах байдлаар тодорхойлжээ.

- Ард түмэнд үйлчлэх;
- Мэргэшсэн тогтвортой байх;
- Улс төрийн алба хаагчаас бусад төрийн алба хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх;
- Монгол улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах;
- Төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах;
- Ил тод байх;
- Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- Захирах захирагдах ёсыг баримтлах.

Мөн хуулийн 37 дугаар зүйлд төрийн жинхэнэ алба хаагчийн нийтлэг үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсын үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;
- Өргөсөн тангарагтаа үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх;

¹²⁶ Цагдаагийн ерөнхий газрын албан ёсны сайт. Police.gov.mn.

¹²⁷ Сайнбаяр Н. Мөрдөгчийн эрх зүйн байдлын онол, практикийн асуудал. Уб., 2023. 146 дахь тал.

- Эх орон, ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх;

- Улс төрийн албан хаагчаас бусад төрийн алба хаагч төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, эвсэл, хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх;

- Харьяа дээд шатны албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх;

- Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

- Өөрийн мэдлэг чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;

- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх;

- Албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах¹²⁸.

Өмгөөлөгч О.Анхбаяр цахим хаягтаа нийтлэхдээ: “Би мөрдөн байцаагч байж үзсэн. Одоо ингээд бодоход хараат бус байдал нь хамгийн их хамгаалагдаагүй субъект бол цагдаагийн мөрдөгч нар байжээ. Ерөөсөө цагдаагийн мөрдөгчийн хараат бус байдлыг хамгаалах ямар ч дэд бүтэц алга байна. Мөрдөгч нар нийт мөрдөн шалгах ажиллагааны хамгийн их ажиллагааг хийж бана. Мөрдөгчид хэрэг шалгах үеийн хамгийн чухал хэсгийг гүйцэтгэж байгаа. Цагдаа нараас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүгч шиг, прокурор шиг эрх үүрэг нь заагдаж орсон ганцхан хүн бол цагдаагийн мөрдөгч юм. Мөрдөгч нь шүүгч, прокурортой эн тэнцүү чухал хүн мөртлөө түүний хараат бус байдлыг хэн ч тоохгүй хөсөр хаясан байжээ. Мөрдөгчийг зүгээр л эргүүлд гаргаж, хамгаалалтад зогсоох зэргээр хараат бус байдалд нь хэлбэрийн хувьд шууд халдаж байна. Ер нь мөрдөгчийн хараат бус байдлыг хамгаалах нь цаагуураа хэргийн хувь заяа болоод хэргийн оролцогчдын эрх хангагдах гээд давхар олон сайн үр дагавартай”¹²⁹ гэж мөрдөгчийн хараат бус байдалд үүсээд байгаа хүндрэл, бэрхшээлийг үндэслэлтэй илэрхийлсэн.

Дүгнэлт

Эрүүгийн хэрэг хянан ажиллагааг хэрэгжүүлэгч мөрдөгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх, хараат бус, бие даасан байдлыг нь бэхжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шударгаар ял оногдуулах, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээхэд мөрдөгчийн чиг үүрэг, оролцоо маш их билээ. Шүүх, прокурорын хараат бус байх зарчмыг хуульд тусгаж өгсөн байгаа нь шүүх, прокуророос шийдвэрээ гаргахдаа өөрийн дотоод итгэл үнэмшлийн хүрээнд гэм буруутай этгээдэд ял оногдуулах асуудлыг дэнсэлж байгаа бөгөөд мөрдөгчийн

¹²⁸ Мягмар Г. Төрийн алба хаагчийн ёс зүй. Гарын авлага. Уб., 2019. 73 дахь тал.

¹²⁹ Анхбаяр О. Мөрдөгчийн бие даасан, хараат бус байдал хангагдахгүй байна. Цахим нийтлэл. 2022.10.31.

хувьд хэн нэгний нөлөөнд автаж, хуулийг нэг мөр хэрэглэхгүй, хүний эрхийн ноцтой зөрчил гаргаж болзошгүй учраас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байхад гаднаас хэн нэгэн этгээд нөлөөлөхгүй байх оролдлогыг таслан зогсоох, албан тушаалын тодорхойлолтод заагаагүй ажлыг хийж гүйцэтгэхгүй байх, энэ хуульд зааснаар маш олон мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шийдвэр гаргаж, ажиллаж байгаа учраас үндсэн ажлыг нь хийлгэвэл мөрдөн шалгах ажиллагааны чанар үр дүн дээшилнэ.

Санал

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд мөрдөгчийн бие даасан байдлыг хангах, хараат бус байх зарчмын болон хамгаалалтын шинжтэй өөрчлөлт оруулах;

2. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх;

3. Мөрдөгч эрх бүхий албан тушаалтны цалингийн шатлалыг үе шаттай нэмэгдүүлэх;

4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг бүрэн судлуулж, хуульч ажиллагаа бүхий олон талын мэдлэг чадвартай алба хаагчдыг ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллуулах;

5. Хуульд заасан эрхээ бүрэн эдэлж, оновчтой санал, шийдвэр гаргаж, өөрийн хууль ёсны эрх ашиг сонирхлоо хамгаалж, эрсдэлээ тооцож, хянах чадвартай мэргэшсэн алба хаагч болгох тал дээр анхаарч, үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлэх.

Ашигласан материал

1. Анхбаяр О. Мөрдөгчийн бие даасан, хараат бус байдал хангагдахгүй байна. Цахим нийтлэл. 2022.10.31.

2. Ганболд Ч. Дэлхийн зарим улсын цагдаа. УБ., 2016. 328 дахь тал.

3. Мягмар Г. Төрийн алба хаагчийн ёс зүй. Гарын авлага. УБ., 2019. 73 дахь тал.

4. Сайнбаяр Н. Мөрдөгчийн эрх зүйн байдлын онол, практикийн асуудал. УБ., 2023. 146 дахь тал.

5. Цагдаагийн албаны хууль тогтоомжийн эмхэтгэл I. УБ., 2014. 11 дэх тал.

6. Цагдаагийн ерөнхий газрын албан ёсны сайт. Police.gov.mn.

7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №23.

ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, ЭНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙГ ИЛРҮҮЛЭХЭД ШИНЖЛЭХ УХААНЫ ОЛОЛТЫГ АШИГЛАХ НЬ

HOMICIDE IN THE CRIMINAL LAWS OF SOME FOREIGN COUNTRIES, A COMPARATIVE STUDY, AND THE USING OF SCIENTIFIC FINDINGS IN THE DETECTION OF THIS TYPE OF CRIME

Товч агуулга. Хүнийг алах гэмт хэргийг гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдлыг харьцуулан судалж, үндэсний онцлогт нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд шинжлэх ухааны ололтыг ашиглаж буй туршлагын талаар дурдсан.

Annotation. The homicide in the criminal laws of some foreign countries is compared, and the experience of using scientific findings in the detection of this type of crime is mentioned.

Түлхүүр үгс. Хүнийг алах гэмт хэрэг, эрүүгийн хууль тогтоомж, харьцуулсан судалгаа, полиграф, ДНК

Keywords. Homicide, Criminal Law, Comparative Studies, Polygraph, DNA

БНХАУ-ын Эрүүгийн заргын тухай хууль¹³⁰-ийн 1 дүгээр зүйлд “Эрүүгийн хуулийн оновчтой хэрэгжүүлэхийг баталж, ялт этгээдийг залхаан шийтгэж, ард түмнийг хамгаалж улс орны аюулгүй байдал болон нийгэм, нийтийн амар түвшнийг баталж, нийгэм журамт нийгмийн энх дэглэмийг хамгаалахын төлөө, Үндсэн хуулийг үндэслэн тус хуулийг тогтоов” гэж заажээ.

2 дугаар зүйл: БНХАУ-ын Эрүүгийн заргын хуулийн үүрэг бол ялын бодит явдлыг оновчтой бөгөөд цаг тухайд нь байцаан тодолж, хууль цаазыг зөв хэрэглэж, ялт этгээдийг яллан шийтгэж, ялгүй хүнийг эрүүгийн хэргээр үл нэхэмжлэхийг баталж, ард иргэдэд хуулийн цаазын ухамсар түүнийгээ сахин ялт ажиллагаатай идэвхтэй тэмцэх тухай хүмүүжил гэж нийгмийн журамт хууль дүрмийг хамгаалан, ард иргэдийн биеийн эрх, эд хөрөнгийн эрх, ардчиллын эрх ба бусад эрхийг хамгаалж, нийгмийн журамт бүтээн байгуулалтын үйлсийг урагштай явагдахыг батлах явдал болно” хэмээн Үндсэн хуулийнхаа үзэл баримтлал болон Эрүүгийн хуулиа хэрэгжүүлэх үндсийг тодорхойлсон заалттай байна.

Монгол Улсын Их хурлаас 2017 онд баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1-д “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино.” гэснийг БНХАУ-ын Эрүүгийн заргын хуулийн заалттай харьцуулан үзэхэд, Эрүүгийн болон Эрүүгийн процессын хуулиудын уялдаа холбооны мөн чанарын нэгээхэн илрэл болно.

БНХАУ-ын Эрүүгийн заргын хуулийн 42 дугаар зүйлд “Хэргийн үнэн байдлыг гэрчилсэн бодит явдал бүхэн цөм гэрч баримт юм. Гэрчийн баримтад доорх долоон үйл буй:

- Бодисын гэрч, бичгийн гэрч
- Гэрчлэгчийн гэрч үг

¹³⁰ Б.Батзориг, Э.Зууннасан. БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль. УБ., 2006. 69 дэх тал

- Хорлогдогчийн тоочилт
- Ял хийснээр сэжиглэгдэгч, заалдагдагчийн өчиглөл ба зөвтгөл
- Шалган тогтоолтын дүн
- Хайн шалгалт, байцаалтын тэмдэглэл
- Дуу, дүрс шингээлтийн материал

Дээрх гэрч баримтыг эрх биш харгуулан байцааж үнэн болохыг нотолсны хойно сая хэргийг тогтоохын үндэслэл болгож болно.

43 дугаар зүйл: Эрүүдэн өчүүлэх ба айлган сүрдүүлэх, өдөөн татах, хууран мэхлэх ба бусад аргаар гэрч баримт цуглуулахыг эрс цаазална. Хэрэгт холбогдох буюу хэргийн байдлыг мэдэх ард иргэд бүхэнд гэрч баримтыг бодит байдлаар бүрэн төгөлдөрөөр хангах нөхцөлтэй болгохыг эрхбиш батлах хэрэгтэй.

45 дугаар зүйл: Ардын шүүх хороо, Ардын байцаах хороо ба Дотоодыг хамгаалах байгууллага нь холбогдол бүхий нэгж хийгээд хувь хүнээс гэрч баримтыг цуглуулан шилжүүлэн аваачих эрхтэй. Холбогдол бүхий нэгж хийгээд хувь хүн гэрч баримтыг үнэн бодитойгоор хангах ёстой. Гэрч баримтыг хуурмаглан зохиосон, нууж далдалсан буюу үгүй хийсэн байвал аль талынх нь байсан ч эрхбиш хууль цаазаар нэхэмжлэх эрхтэй.

46 дугаар зүйл: Аливаа хэргийг таслан шийдэхдээ цөм гэрч баримтыг чухалчлах хэрэгтэй. Байцаан судлалыг чухалчлах хэрэгтэй, Аман өчгийг хөнгөнөөр итгэж болохгүй. Зөвхөн заалдагчийн өчиг байгаад өөр гэрч баримт байх үгүй бол заалдагчийг ялтайгаар магадлах ба эрүү шийтгэлээр шийтгэж болохгүй. Заалдагчийн өчиглөл байхгүй. боловч гэрч баримт нь бүрэн төгөлдөр үнэн бодитой байвал заалдагчийг ялтайгаар магадлах ба эрүү шийтгэлээр шийтгэх болно.

47 дугаар зүйл: Гэрчлэгчийн гэрч үгийг эрхбиш шүүх танхимд албан заалдагч, хорлогдогч, өмгөөлөгч, хоёр этгээдээрээ байцаан асууж, тулган гэрчлүүлээд, эл талын гэрчлэгчийн гэрч үгийг сонсох мөртөө байцаан тодорхойлсны хойно сая хэргийг тогтоохын үндэслэл болгоно. Шүүх тахимаас гэрчлэгч зориуд хуурмаг гэрч зохиосон буюу ялын гэрчийн нуун далдсаныг байцааж, тодолсон байвал хууль ёсоор шийдвэрлэх ёстой.

Ялын гэрч-гэмт хэргийн нотлох баримт

47 дугаар зүйл: Хэргийн байдлыг мэдэгч бүхэн гэрчлэх үүрэгтэй, бие махбод ба мэдрэлийн талаараа гэмтэй буюу нас багын харгайгаар **зөв** бурууг ялгаж чадахгүй, зөв оновчтой илтгэж чадахгүй хүн гэрчлэгч болж болохгүй.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 105 дугаар зүйлд¹³¹ хүнийг алах гэмт хэргийн

¹³¹ Хүнийг санаатайгаар ална гэдэг нь тодорхой хүнийг зориуд санаатайгаар үхэлд хүргэхийг хэлнэ. Энэ төрлийн гэмт хэрэгт 6-15 жилээр эрх чөлөөг нь хасч шийтгэнэ. 2. Дараах тохиолдлын санаатай аллагад 8-20 жил эрх чөлөөг нь хасах цаазаар авах ял оноох эсвэл бүх насаар нь хорих ял онооно:

- a) 2 болон түүнээс олон хүнийг
- b) Хүн хулгайлах, барьцаалах гэмт хэргийг үйлдэх явцдаа
- c) Жирэмсэн эмэгтэйд
- d) Онц харгис, хэрцгий аргаар
- e) Нийтэд аюултай аргаар
- f) Бүлэглэн, урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг, зохион байгууллалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдэгдэн
- g) Шунахайн сэдэлтээр
- h) Өс хонзонгийн сэдэлтээр
- i) Өөр гэмт хэргийг нуун далдлах зорилгоор
- j) Үндсэрхэг, арьс өнгөний, эсвэл шашны шалтгаанаар
- k) Хохирогчийн эд эрхтэнг авах зорилгоор үйлдсэн
- l) Давтан үйлдсэн

үндсэн болон хүндрүүлэн бүрэлдэхүүнийг хуульчилсан.

ОХУ-ын хүнийг санаатайгаар алах гэмт хэргийн зарим судалгаанаас үзэхэд, ОХУ-д жилдээ 35000-аас илүү хүн амины гэмт хэрэг бүртгэгддэгээс 2005 онд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хүнийг алах гэмт хэргийн тоо 5000-д хүрч өссөн байна.

ОХУ-д 2007 онд 20.53 сая гэмт хэргийн тухай өргөдөл гомдол иргэд, байгууллагаас хүлээн авснаас 2.991.4 мянгад нь эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан. Үүнээс 2007 онд үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоолдоогүй хүнийг санаатай алсан гэмт хэрэг 3341 шалгагдаж байна.

Хүн амины гэмт хэрэг ихэвчлэн галт зэвсэг, хүйтэн зэвсэг ашиглах, боох, шатаах, тэсэрч дэлбэлэх бодис ашиглах зэргээр үйлдэгдэхээс гадна мэргэжлийн алуурчин, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн гишүүдээс, урьд ял шийтгэл эдэлж байсан хүмүүсээс ихээр үйлдэгдэх болсон.

Хэдийгээр тус гэмт хэрэг үйлдэгдэх арга, ашиглаж буй багаж зэвсгээрээ манайхтай төстэй мэт боловч мэргэжлийн алуурчнаар, захиалга, хөлсөөр зохион байгуулалттай, урьдаас төлөвлөн үйлдэх болсныг анхааралтай судлах шаардлагатай.

Хөлсний болон захиалгаар 2005 онд ОХУ үйлдэгдсэн 207 эрүүгийн аллагын хэрэг дээр хийгдсэн ОХУ-ын судлаач нарын хийсэн судалгаагаар 50% нь хохирогчтой захиалагч, гүйцэтгэгч нь ямар нэгэн байдлаар харьцаатай байдаг.

Бүгд Найрамдах Турк Улсын Эрүүгийн хуулийн 2 дугаар бүлэг “Хүний эсрэг гэмт хэрэг” түүний дотор 1 дүгээр хэсэгт Амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийг

1. Хүнийг санаатай алах /Эрүүгийн хуулийн 81 дүгээр зүйл/

2. Хүнийг болгоомжгүй алах /Эрүүгийн хуулийн 85 дугаар зүйл/

Хүнийг санаатай алах нь БНТУ-ын Эрүүгийн хуулийн 81 дүгээр зүйлд зааснаар уг гэмт хэргийг үйлдэгч нь уг хэргийг санаатай үйлдсэнд оршино.

Хүнийг санаатай алах гэмт хэргийг дараах нөхцөлүүдээр үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэнд тооцно. Үүнд:

- Зохион байгуулалттай, урьдчилан төлөвлөсөн,
- Онц хэрцгий аргаар мөн тарчлаан зовоож,
- Галд шатааж, усанд живүүлж, тэсрэх бөмбөгөөр дэлбэлж, мөн цөмийн бөмбөг, биологийн болон химийн зэвсэг ашиглаж,
- Хамаатан болон эхнэр, ах дүүгийнхээ эсрэг,
- Хүүхэд болон өөрийгөө хамгаалах чадваргүй хүнийг,
- Жирэмсэн эмэгтэйг,
- Хууль ёсны албан үүргээ гүйцэтгэж явсан хүнийг,
- Гэмт эргийн талаар нуун далдлах, нотлох баримт үгүй хийх,
- Өс хонзон авах зорилгоор,
- Ёс заншлын зорилгоор зэрэг шалтгаанууд тогтоогдвол хүндрүүлэх нөхцөлтэйгөөр гэмт хэрэг үйлдсэнд тооцож насаар нь хорих ял оногдуудах учраас нотлох ажиллагаанд дээрх нөхцөл байдлыг заавал тогтоохыг шаарддаг байна.

БНТУ-ын ЭХ-ийн 85 дугаар зүйлд тодорхойлсон үйлдлийг шууд бус санаатай хүнийг алах гэмт хэрэг гэнэ. Уг хэргийг үйлдэгч нь өөрийн ажлын хариуцлагаас шалтгаалж бусдын амь насанд шууд бус санаатайгаар хүрэхийг хэлнэ. Уг хэргийг үйлдэгчийг 2-6 жил хорих ялаар оногдуулах бөгөөд 2 ба түүнээс дээш тооны хүнийг шууд бус санаатай алсан тохиолдолд хүндрүүлж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Хүнийг санаатай алах гэмт хэргийг нотлох үйл ажиллагаа нь шүүх эмнэлгийн дүгнэлт, хэргийн газраас олдсон эд мөрийн баримт болон гэрч нарын мэдүүлэг юм.

АНУ-ын Гэмт хэргийн тухай хуулийн эмхэтгэлийн 18-151-р зүйлд:

1111. Хүндрүүлэх нөхцөл байдалтай хүнийг алах талаар, 1112-т Хүндрүүлэх нөхцөл байдалгүй хүнийг алах талаар тус тус заасан. Үүнээс гадна АНУ-ын Ерөнхийлөгч, түүний тамгын газрын ажилтан, Конгрессын гишүүдийг алах гэсэн тусдаа зүйл байдаг.

Тус хуулийн 1102 Хүлээлгэх хариуцлагыг 1 дүгээр зэрэглэлээр ялын дээд хэмжээ, 2 дугаар зэрэглэлээр насаар нь хорих ялыг оноодог. Тухайн гэмт хэргийн учруулж буй хор аюул, хүнд ноцтой, үйлдлийн аргаар нь 2 зэрэглэлээр ангилан ялын бодлогоо урьд онуудын жишиг хэргүүдтэй харьцуулан хэрэгжүүлдэг байна.

Энэтхэг Улсын Эрүүгийн хуулийн 300 дугаар зүйлийн “в”-д заахдаа:

Аллага - Хүний амийг санаатайгаар хөнөөхийг аллага гэх ба мөн дараах байдлаар хүний аминд хүрэхийг аллагад тооцож мөрдөн шалгаж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тооцжээ. Үүнд:

- Хохирогчийг үхэлд хүргэх шархыг биед нь санаатайгаар учруулсан тохиолдолд,
- Хохирогчийг үхэлд хүргэх аюултай үйлдлийг санаатайгаар хийсэн тохиолдолд

Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэгт дараах тохиолдлуудыг хүнийг санаатай алах гэмт хэрэгт тооцож, мөрдөлт явуулах эрх зүйн үндэслэлийг хуульчилжээ. Үүнд:

1. 250 дугаар зүйлд хүн амины хэрэг үйлдсэн хүнийг цаазаар авах, бүх насаар нь хорих 5-аас доошгүй жилээр хорих,
2. Хэрэгтэн өөрийн эсвэл өөрийн гэр бүлийн болон шууд хамаатны амийг хөнөөсөн тохиолдолд цаазаар авах, бүх насаар нь хорих эсвэл 7-оос доошгүй жилээр хорих,
3. 251 дугаар зүйлд хэрэгтэн өөртэйгөө шууд холбоотой нярайг төрж байхад нь эсвэл төрсний дараа өсгөж чадахгүй гэсэн үндэслэлээр хөнөөсөн тохиолдолд 10-ээс дээшгүй жилээр хорих,
4. 252 дугаар зүйлд хүний хүсэлтээр эсвэл зөвшөөрөлтэйгөөр амийг нь хөнөөсөн тохиолдолд нэгээс доошгүй 10-аас дээшгүй жилийн ял онооно гэж тус тус заажээ.

Шинжлэх ухаан өндөр хөгжсөн АНУ, Япон, Энэтхэг, Солонгос зэрэг улсад полиграфыг хүнийг санаатай алах гэмт хэргийг илрүүлэхэд 1970-аад оны үеэс хэрэглэж эхэлсэн. Магадлалын хувь нь 98 хувиар тогтоогддог шалгарсан шинжлэх ухааны ололтын нэг арга юм.

Биотехнологийн шинжлэх ухааны ололтод тулгуурласан аргаар хийгдсэн генетик мэдээллийн санг дэлхийн ихэнх орнууд төрийн бодлогын хүрээнд авч хэлэлцэн хууль боловсруулан мөрдөж гэмт хэргийг илрүүлэхэд амжилттай ашиглаж байгааг цөөн орноор жишээ болгон дурдъя. Үүнд:

Англи, АНУ-д 1994 оноос ДНХ-ээр адилтган харьцуулах хуулийг мөрдөж эхэлсэн ба сэжигтэн, яллагдагчдын генетик мэдээллийг цуглуулж эхэлсэн байна.

Германд 1998 оноос ДНХ-ээр адилтган харьцуулах хуулийг баталсан бөгөөд гэмт хэрэг үйлдсэн сэжигтний ДНХ-ийн дээжийг хадгалдаг болсон. Одоогоор 1 сая гаруй дээжийн мэдээлэл генетик мэдээллийн санд хадгалаад байна.

Франц Улсад 1998 онд “Генийн тамга” бий болгох шийдвэрийг гаргасан байдаг

2009-2010 онд Итали, Грек, Ирланд, БНХАУ, БНСУ, Тайланд, Энэтхэг, Япон, Малайз, Вьетнам, Шинэ Зеланд, Маврити, Өмнөд Африк. Нигери, Бразил, Чили, Аргентин зэрэг улсад гэмт хэргийн холбогдолтой ДНХ-ийн сан бүрдүүлэхээр хууль батлуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа явагдаж байгаа тухай олон улсын илтгэлүүдэд тодорхой дурдсан байдаг.

ОХУ-ын Төрийн Дум “Холбооны Улсын геномын бүртгэлийн тухай” хуулийн анхны хэлэлцүүлгийг 2008 оны 6 дугаар сарын 27-ны өдөр, хоёр, гурав дахь хэлэлцүүлгийг 11 дүгээр сарын 14, 19-ний өдөр тус тус явуулж, 135 гишүүн дэмжин, нэг гишүүн түдгэлзсэнээр батлагдаж, Холбооны зөвлөлөөр 11 дүгээр сарын 26-ны өдөр дахин хэлэлцэлгүйгээр дэмжиж, 12 дугаар сарын 9-ний өдөр хэвлэгдсэн бөгөөд, 2009 оны 1 дүгээр сарын 1-ээс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн байна. Ийнхүү ОХУ-д геномын бүртгэл буюу гэмт хэрэг үйлдэгсдийн “Генийн мэдээллийн сан” бий болгох, түүнийг хэрэгжүүлэх, хууль эрх зүйн орчныг хуулиар зохицуулж эхлээд байна.

1996 онд АНУ-ын Холбооны мөрдөх товчоо CODIS (Combined DNA index system) гэсэн систем буюу аутосомын хромосом дээр байрлах микросателлитын 13 локусаар хүний генетик мэдээллийн санг бий болгож, улмаар хүмүүсийг хооронд нь адилтган харьцуулах шинжилгээг шүүхийн шинжилгээний практикт өнөөг хүртэл хэрэглэсээр байна.

Европын холбооны улсуудад ДНХ-ээр адилтгах Европын холбоо /European DNA Profiling Group (EBNAPG)/ 10 генетик маркераар хүнийг адилтган харьцуулах ДНХ-ийн шинжилгээ хийж, улмаар “генетик мэдээллийн сан”-г бий болгоод гэмт хэрэгтнийг эрэн сурвалжилж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх, үйлдэгдсэн гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэх, давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь хүчний байгууллагуудын үндсэн зорилт бөгөөд ард нийтийн ашиг сонирхолд нийцнэ.

Англи Улсын туршлагыг бодит жишээ болгон үзэхэд, Англид ДНК-ийн шинжилгээний арга хэрэглэхгүйгээр гэмт хэргийн илрүүлэлт 13% байсан бол, ДНК-ийн шинжилгээ хэрэглэснээр 31%, “Генийн мэдээллийн сан”-г ашигласнаар гэмт хэргийн илрүүлэлт 60% болж өссөнөөр одоогийн байдлаар 6 сая гаруй хүний мэдээлэл хадгалсан генийн сантай болсон байна. Энэ санг ашиглан 7 хоногт 850 орчим гэмт хэргийг илрүүлж байдаг гэсэн тооцоо судалгаа гаргаж хэргийн газраас олдсон эд мөрийн баримтын ДНК-ийг “Генетик мэдээллийн сан”-д байршуулсан мэдээлэлтэй адилтган харьцуулж хайхад тухайн гэмт хэргийн сэжигтэн буюу баривчлагдсан хүний ДНК-ийн 40%-тай нь тохирч байсан байна. Орон байрны хулгайг илрүүлэхэд “Хэрвээ хэрэг учралын газарт биологийн эд мөрийн баримт үлдсэн тохиолдолд” 14-44 хүртэл хувь ахиц гарсан байна.

Ийнхүү хэргийг илрүүлэхэд шинжлэх ухаан, техникийн ололтыг өргөнөөр ашигладаг болох нь дээрх туршлагаас харагдаж байна.

Дүгнэлт

Хүнийг алах гэмт хэргийг гадаадын улсуудын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байх бөгөөд ялын бодлогын хувьд харьцангуй хүнд ял оногдуулахаар нийтлэг байдлаар заажээ.

Хүнийг алах гэмт хэргийг өнөөгийн нотолж байгаа байдлыг судлахад гэмт хэргийн нотлох ажиллагааны дийлэнх хувийг гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, хэргийн газрын үзлэг, эд мөрийн баримт, сэжигтэн, яллагдагчийн мэдүүлгээр нотлогдож байна.

Сүүлийн үед гэрч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч ямар нэгэн хүчин зүйлээс болж мэдүүлгээс буцах нь элбэг байна. Иймд энэ төрлийн гэмт хэргийг

илрүүлэхэд мэдүүлгэн нотлох баримтыг чухалчлалгүй шинжлэх ухаан техник, технологийн дэвшлийг ашиглаж гэмт хэргийг илрүүлэх шаардлагатай байна.

Мэдүүлгэн нотлох баримтыг шинжлэх ухаан, техникийн ололт амжилтыг ашигласан нотлох баримтаар давхар нотолсноор гэмт хэрэг үйлдсэн гэмт этгээдийн үйлдлийг бүрэн дүүрэн нотлоод зогсохгүй гэмт хэрэг үйлдээгүй гэм буруугүй хүний гэм буруугүйг тогтоосноор хүний эрх, эрх чөлөөг давхар хангаж байгаа юм.

Нийгмийн хөгжлийн явцад хүнийг алах гэмт явдлын байдал, хөдөлгөөн, бүтэц, шинж чанарт өөрчлөлт гарч, хүч хэрэглэсэн болон шунахай сэдэлттэй, зохион байгуулалттай гэмт хэргийн эзлэх хувийн жин нэмэгдэж, гэмт хэрэг үйлдэх арга нь улам нарийн болж, олон нийтийн анхаарал татсан хүнийг санаатай алах онц ноцтой зарим хэргүүдийн илрүүлэлт, тэдгээрийг шийдвэрлэх хугацаа сунжирч эзэн холбогдогч нь тодорхойгүй байсаар байгаа нь хүний эрх, эрх чөлөөг дээдлэн энэхүү гэмт хэргийг нотлох ажиллагааны эрх зүйн зохицуулалт, мөрдөх арга зүйг боловсронгуй болгох зүй ёсны шаардлага тавигдаж байна.

Санал

- Онц хүнд гэмт хэргийн газарт үзлэг хийх шинжилгээний баг бүрэлдэхүүнийг бий болгох, тэдгээр албан хаагчид нь зөвхөн хэргийн газарт нэвтрэн орж ажиллах, багийн бүрэлдэхүүнд шүүх шинжилгээний байгууллагын төрөл, мэргэжлийн шинжээч нар орж ажиллаж өөр өөрсдийн чиглэлийн ул мөрөө илрүүлж, бэхжүүлэх, түүнийгээ шинжилж, судлан дүгнэлтээ гаргаж шүүхийн шатанд нотолдог байх. Өөрөөр хэлбэл, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэн процессын ажиллагаа явуулан нотлох баримт бүрдүүлдгийн нэгэн адил шинжээч нар хавтаст хэрэг нээгээд тухайн хэрэг дээр өөрсдийн чиглэлээр нотлох баримт бүрдүүлэх; /Эдгээр төрөл, мэргэжлийн албан хаагч нь өөр өөрсдийн чиглэлийн ул мөрөө бэхжүүлэн авч, дүгнэлт гаргаснаар мөрдөн байцаагчийн техник ажиллагаа багасах, хэрэгт шаардлагагүй эд зүйл хурааж авах ажиллагаа нь багасна гэж үзэж байна./
- Хүнийг алах гэмт хэргийн хувьд гэрч мэдүүлгээсээ буцах асуудал ихээхэн гарч байгаа тул мэдүүлгэн нотлох баримтаас гадна шинжлэх ухаан, техникийн ололтыг түлхүү ашиглаж давхар нотлох /ДНХ-ын шинжилгээ, генийн шинжилгээг түлхүү ашиглах, энэ шинжилгээг хийдэг боловсон хүчин, эдийн засгийн асуудлыг шийдэх, полиграф, профайлинг ашиглах/ Ингэснээр эргэлзээтэй мэдүүлгэн нотлох баримтаар хүнийг олон хоногоор албадан саатуулах, цагдан хорих асуудал гаргахгүй/

Ашигласан материал

- Ж.Авхиа. Хүн амины хэрэгтэй явуулах эрүүгийн эрхийн тэмцэл. УБ., 1972
- Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2004
- Б.Бат-Эрдэнэ. Байцаалт, түүний онцлог. УБ., 2005
- Ж. Бямбаа. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд. УБ., 2008
- Ж.Бямбаа. Г.Баясгалан ЭБШЭЗ-н үндсэн асуудал. УБ., 1998
- Б.Батзориг. Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол. УБ., 2008
- Б.Батзориг, Э.Зууннасан. БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль. УБ., 2006
- З.Төрмандах. Хүнийг санаатай алах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,

илрүүлэх ажиллагаа сэдэвт докторын зэрэг горилсон бүтээл. МУИС,
Цагдаагийн Академи. УБ., 2009

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТ БА ХҮНИЙ ЭРХ

CONSTITUTIONAL CONTROL AND HUMAN RIGHTS

Б.Наргулан

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах
багш, цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Үндсэн хуулийн хяналт, нийгэм, хууль зүйн агуулга, учир холбогдол нь юуны өмнө аливаа улсын үндсэн хуулийн шинж, төлөв, амьдралд хэрэгжих улс, олон улсын хэрэгцээ, шаардлагатай амин холбоотой. Онолын үүднээс үзвэл ямар ч улсын үндсэн хууль нь тухайн улсынхаа нийгэм, эдийн засаг, төрийн байгууламж, төрийн тусгаар тогтнол, хувь хүний эрх зүйн байдлын үндэс, төрийн байгууллагын тогтолцоо, тэдгээрийн зохион байгуулалт үйл ажиллагааны үндсэн зарчим, журмыг хуульчлан тогтоосон төрийн гол хууль байдаг. Ийм ч учраас үндсэн хуулийн хяналтын тухай асуудал бол нэн чухлаар тавигдах ёстой.

Abstract: Constitutional control, social and juridical content and importance are first of all related to the nature and status of any country's constitution, national and international needs and requirements. From a theoretical point of view, the constitution of any country is the main law of the country, which legislates the basic principles and procedures of the society, economy, state structures, independence of the state, the legal status of the individual, the system of state organizations, and the basic principles and procedures of their organization and operation.

Түлхүүр үгс: Үнэт зүйлс, захиргааны хэм хэмжээний акт, үндсэн хуулийн цэц, амар тайван амьдрах, хараат бус, төрт ёс, зохистой байдал.

Keywords: Values, administrative norms act, constitutional court, live in peace, independent, decency, appropriateness.

Үндсэн хуулийн ерөнхий дүр зургийг харахын тулд үндсэн хуулийн бүтцийг анхаарах хэрэгтэй. Үндсэн хуулийн бүтцээс үндсэн хуулийн бүтээлцэж, эх барьж авсан хүмүүс юунд нь ач холбогдол өгч байсныг харж болно¹³². Аливаа улсын үндсэн хуулийн бүтэц нь удиртгал хэсэг болон үндсэн хэсгээс бүрддэг. Удиртгал хэсэг нь албан ёсны оршил хэсэг бөгөөд ихэвчлэн үндсэн хуулийг батлах гол зорилго эрмэлзэл, өөрийн ард түмний онцлог, түүхэн замнал зэрэг тунхаглалын шинжтэй заалтуудаас бүрдэнэ. Үндсэн хэсэг нь бүлэг, дэд бүлэг, зүйл заалтуудаас бүрдэнэ. Үндсэн хуулийн эх баригчид улсын тусгаар тогтнол, өнгөрсөн үеийн түүхэн уламжлал, ард түмний хүсэл эрмэлзэл, ардчиллын үнэт зүйлсийг үндсэн хуульдаа тусгахыг хичээснийг харж болно. Ард түмний хүсэл эрмэлзлийг тусгасан тунхаглалын шинжтэй зүйл, заалт нь зөвхөн Үндсэн хуулийн удиртгал хэсэгт хамаарах бөгөөд Үндсэн хуулийн бусад хэсэгт тусгагдсан үг үсэг бүр хуулийн хүчинтэй эрх зүйн норматив хэм хэмжээ байна.

Үндсэн хуулийн зүйл, заалт өөр хоорондоо нягт уялдаатай байхаас гадна логикийн хувьд дотоод зөрчилгүй байх учиртай. Монгол Улсын Үндсэн хуулийн

¹³² Үндсэн хуулийн процессын эрх зүй. Гарын авлага. УБ., 2012. 15 дахь тал.

бүтцээс харахад Үндсэн хуулийг баталсан АИХ үндэсний аюулгүй байдал, төрийн тогтвортой байдал, ардчилал, төрийн эрхийг хязгаарлах асуудалд ихээхэн анхаарсан болох нь харагддаг. Мөн хүний эрхийг хамгаалах, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад ердийн хуулиас илүү хүнд журам баримтлах, үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих Үндсэн хуулийн шүүхийг байгуулах зэрэг асуудлыг тусгай бүлэг болгон оруулсан нь үндсэн хуульд ардчилсан дэглэм тогтоохыг эрмэлзсэнийг харуулж байна. Үндсэн хуулийн эхний бүлэгт үндэстэн улсын хувьд амин чухал үнэт зүйл болох улсын бүрэн эрхт байдлын үндсийг баталгаажуулжээ. Улс оршин тогтнож, тусгаар, бие даасан, бүрэн эрхийг хараат бусаар хэрэгжүүлдэг байж иргэн амар түвшин амьдрах боломж бүрдэнэ.

Үндсэн хуулийн эхний догол мөрийг судлаачид удиртгал хэсэг гэж нэрлэдэг бөгөөд энэ хэсэгт ард түмний зорилго, эрмэлзлийг тусгаж, төрийн эрх мэдэл ард түмний мэдэлд байгааг илэрхийлж, Монгол Улсын Үндсэн хуулийн удиртгал хэсэгт “Монголын ард түмэн бид... Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна¹³³” гэсэн нь үндсэн хуулийн эхийг баригчид үндсэн хуулийг хэн нэгэн дээд хүчин, эзэн хааны зарлиг, тушаалаар биш ард түмэн өөрсдөө тунхаглан зарлаж байгааг харуулж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн удиртгал хэсэгт үндсэн зургаан зорилгыг тусгажээ. Үүнд: тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж; төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх зорилго багтжээ. Үндэсний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх нь хоёр их гүрний дунд орших хүн ам цөөнтэй улсын хувьд тэргүүлэх зорилго гэж Үндсэн хуулийн эхийг баригчид үзсэн байна.

Төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөхийн сацуу гадаад улс орнуудын өмнө нээлттэй байж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн, хүмүүнлэг, энэрэнгүй ёсыг эрхэмлэсэн, арчилсан улс төрийн дэглэмтэй улс байх эрмэлзлийг Үндсэн хуулийн оршил хэсэгт тусгасан байна. Хүмүүнлэг, энэрэнгүй нийгэм гэхийн учир нь иргэдийн амар тайван амьдрах, хувь хүний хөгжих орчин, боломжийг бүрдүүлж, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлыг нь хангах төрийн үйлчилгээг тэгш, шударгаар хүргэхийг ойлгоно. Монгол Улсад ангит нийгэм, олигархи, нэг хүний дарангуйллын нийгмийн аль нь ч бус иргэний нийгмийн байгууллагуудын дуу хоолой, иргэний хоолой, иргэний оролцоонд тулгуурласан ардчилсан нийгэм байгуулах зорилгоор шинэ Үндсэн хуулиа баталсан байна. Үндсэн хуулийн оршил хэсгээс Үндсэн хуулийн эхийг баригчдын буюу тухайн үеийн Ардын их хурлын депутатуудын Үндсэн хуулийг батлахдаа баримталж байсан зорилго, эрмэлзлээс гадна ард түмний нийтлэг хүсэл зориг, Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалыг олж харж болно¹³⁴.

Үндсэн хуулийн эрх зүйн эх сурвалжид үндсэн хууль, олон улсын гэрээ, ердийн хууль тогтоомж, заншлын хэм хэмжээ, шүүхийн прецедент болон шударга ёс, ёс суртахууны зарчмууд орно. Тухайн улсын нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ нь Үндсэн хуулийн эрх зүйн эх сурвалж гэж тооцогддог. Холбооны улсын хувьд мужуудын хооронд холбоо байгуулах гэрээ нь үндсэн хуулийн эрх зүйн эх сурвалж болдог. Үндсэн хуулийн тухай олон янзын тодорхойлолт байдаг. Улсын гол хууль Бүх хуулийн үндэс суурь Нийгмийн суурь харилцааг зохицуулдаг Эрх мэдэл хуваарилсан хууль л «Эцэг буюу эх хууль» гэх мэт. Энэ бүгд нэг, нэг шинж нь мөн бөгөөд эдгээр болон бусад гол шинжийг нь

¹³³ Монгол Улсын Үндсэн хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 1992. №1.

¹³⁴ Үндсэн хуулийн процессын эрх зүй. Гарын авлага. УБ., 2012. 18 дахь тал.

багтаасан нийлмэл тодорхойлолт ч цөөнгүй бий. Тэдгээр нь мэргэжлийн буюу судалгааны зориулалттай байдаг ажээ. Хууль бүхэн тус тусын үүрэг зорилготой байдаг. Хүн өөртөө шууд хэрэг болдог хуулийг л илүүтэй сонирхдог. Тэтгэврийн хууль, халамжийн хууль, татварын хууль гэх мэт. Энэ нь ч зөв. Гэтэл эдгээр хууль ямар байж, хэнийг эрхэмлэн хамгаалах нь Үндсэн хуулийн зарчим, үзэл баримтлалаас шууд шалтгаалдаг.

Хүн төрөлхтний үнэт зүйлс, ардчилсан хууль хийгээд ёс суртахууны аль алины нэг иш үндэс бол шударга ёс мөн. Түүнийг чанд сахиж, хууль дээдлэх нь засаг төрийн аливаа байгууллага, ямар ч албан тушаалтны дур зоргоор авирлахыг зориуд хязгаарлаж хуулийн хүчээр хазаарлан барьдаг¹³⁵. Үүгээрээ үндсэн хууль эрх мэдэлтний зүгээс иргэнийг дарамтлан, хүний эрх, ашиг сонирхлыг зөрчихөөс сэргийлэх хүчин зүйл болж байдаг. Иргэн хүн хуулиар хориглоогүй зүйлийг хийж болох эрх чөлөөтэй байдаг бол засаг төрийн байгууллага, түүний албан тушаалтан гагцхүү хуульд заасан үүргийг мөн түүгээр олгосон эрхийн дотор биелүүлэх ёстой байдаг. Энэ бол, шударга ёсны хэмжүүр болсон хууль дээдлэхийн үндсэн шаардлага мөн. Эцсийн дүнд засаг төр, түүний байгууллага, албан тушаалтан улсынхаа, түүний иргэдийн нийтлэг ашиг сонирхлын төлөө бат зогсож хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын төлөө шударгаар үйлчлэх юм. Энэ бол үндсэн хуулийн гол чиг үүрэг мөн.

Улсын хууль бол нийтээр дагаж биелүүлдэг хэм хэмжээ гэж хүлээн зөвшөөрдөг. Энэ бол хамгийн ерөнхий шинж нь юм. Яагаад гэвэл Монгол улсад хуулиас гадна, зарлиг тогтоол, захирамж тушаал, заавар дүрэм гээд элдэв хэм хэмжээ байдгийг бид мэднэ. Тэдгээрийн дундаас хууль нь Улсын Их Хурал ард түмний өмнөөс батлан гаргадаг; Улс орны хэмжээнд дагаж мөрддөг аливаа зарлиг, тогтоол, бусад шийдвэрээс дээгүүр хүчин чадалтай байдаг. Тэдгээр (бусад) шийдвэрийн хууль зүйн үндэслэл болдог. Өөрөөр хэлбэл зарлиг, тогтоол, тушаал, заавар тэргүүтэн Ерөнхийлөгчийнх үү, Засгийн газрынх уу, Сайдынх уу, засаг даргынх уу гэдгээс хамаарахгүй заавал хуульд нийцсэн байх ёстой. Гэтэл бас бүх хуулиас давуу хүчин чадалтай хууль гэж байна. Ийм цорын ганц хууль бол Монгол Улсын Үндсэн хууль юм. Үүний гол учир нь уг хуулиар ард түмний туйлын хүслэн нийгэм, төрийн байгууллын үндэс болсон харилцаа, хүний суурь эрхийг бататгасан байдагт оршино.

Нэгэнт үндсэн хууль эрх зүйн дээд хүчин чадалтай акт болохын хувьд хууль тогтоох дээд байгууллага, төрийн бусад байгууллагаас батлан гаргасан хууль, эрх зүйн бусад актууд түүнд зайлшгүй нийцэж, түүнд үндэслэн гарах учиртай. Мөн төр, төрийн байгууллагууд, улс төрийн намуудын үйл ажиллагаа үндсэн хуулийн хүрээнд явагдаж, түүнийг зөрчихгүй байх шаардлагатай юм. Өнөөгийн манай улсын хувьд үндсэн хуулийн хяналтыг илүү чанга хатуу болгож, хуулийн агуулгыг тодорхой хэмжээгээр чангатгах шаардлагатай мэт санагдана.

Ардчиллын үнэт зүйлсэд шударга ёс, эрх чөлөө, эрх тэгш байдал гэх мэт олон зүйлс багтах агаад харин эдгээр нь шударга ёс гэх зүйлд тулгуурладаг. Шударга ёс бүрэн дүүрэн хэрэгжиж гэмээнэ ард түмэн эрх чөлөөтэй байж, хууль журмыг хүндэтгэн дагаж мөрдөн, хууль ч иргэдэд эрх тэгш үйлчлэх боломж бүрэлдэнэ. Харин шударга ёс бүрэн дүүрэн тогтоогүй цагт хүний эрх зөрчигдөх тохиолдлууд нийгэмд түгээмэл байсаар л байх юм. Өдгөө ардчиллын замналаар хөгжиж яваа улс орны жишээнээс ажихад юу юунаас илүүтэй шударга ёсыг эрхэмлэж буй болох нь тухайн улс орны төр нийгмийн зохион байгуулалтаас илэрхий ажиглагддаг. Ардчилсан улс гэдэг нь ард түмэн хүсэл эрмэлзэлд

¹³⁵ Баярсайхан Д. Эрх зүйн онол. УБ., 2016. 36 дахь тал.

тулгуурлан бүх нийтээрээ шударга ёсны зарчмыг баримталж, ардчиллын үнэт зүйлсийн хэм хэмжээг ойлгож ухаарсан байх учиртай.

Хэн бүхэн шударга байдлыг эрхэмлэн үздэг. Гэхдээ ардчилсан нийгэмд л шударга ёс бүрэн дүүрэн хэрэгжих боломжтой түүний үр дүнд амар тайван байдал буй болох юм. Шударга ёсыг өөрөөр нийтийн эрх зүйн хэм хэмжээний зохистой байдал хэмээн ойлгож болно. Олон улсын нийтийн эрх зүйн асуудлын хамрах хүрээ нь өргөн бөгөөд олон асуудлыг цогц байдлаар авч үзэх хэдий ч тэдгээрийн дундаас амар тайван байдал, аюулгүй аж төрөх нөхцөлөөр хангагдах явдал, хүний эрх, эрх чөлөөний тухай асуудал зэрэг нь зайлшгүй биеллээ олох ёстой гол тулгуур хүчин зүйлүүд мөн. Олон улсын нийтийн эрх зүй зөрчигдөхөд гол нөлөө үзүүлэгч хүчин зүйл бол нийгмийн зохисгүй үйл ажиллагаа. Нөгөөтэйгөөр байгалиас үүдэх олон янзын гарз хохирлууд билээ. Энэ мэтчилэн олон улсын нийтийн эрх зүйн асуудал зөрчигдөж дэлхийн өнцөг булан бүрд хүний амь эрсдэх хэрэг явдлууд гарсаар л байгаа нь шударга ёс бүрэн дүүрэн хэрэгжиж чадахгүй байгаагийн нэг илрэл. Зөвхөн манай улсын хэмжээнд жишээ харахад л өдгөө нийгэмд тэгш бус байдал, хуулийг бүрэн төгс дагаж мөрдөхгүй байгаагаас болж ард иргэд хохирч буй олон жишээнүүд байна. Ардчилсан улс орон хуулийг бүх нийтээрээ дагаж мөрдөхийн тулд буй болгодог атал харин манай улсад ард түмэнд л хууль хамааралтай мэтээр ойлгох нийтлэг ойлголт ялангуяа улс төрчид, төрийн түшээдийн хүрээнд байсаар буй нь ардчиллыг үнэгүйдүүлэхэд хүргэж буй.

Эрх зүй гэгч зүйлийн ерөнхий гол утга санаа бол ерөөс амар тайван, аюулгүй байдал. Ингээд үзэхэд дэлхий дээр оршин тогтнож буй хүн төрөлхтний хувьд дарангуйлал, дайн самуун, халдлага гэх мэт нийгмийн буруу үйл явдлууд гарахгүй байж гэмээнэ олон улсын нийтийн эрх зүй хангагдана гэсэн үг. Гэтэл өнөө үед дэлхийн өнцөг булан бүрд айдас түгшээсэн хэрэг явдлууд гарч бусдын харгислал, дээрэнгүйлэл, дарангуйлал нь хүмүүсийг зовоон олон талаар нь хохироож буй нь олон улсын нийтийн эрх зүйн хэм хэмжээ алдагдаж байгаагийн нотолгоо мөн. Мөн өнөө үед дэлхийн зарим улс оронд хүн амьдрахад хэцүү нөхцөл байдал үүсэж өлсгөлөн элдэв төрлийн өвчин эмгэгээс болж олон мянган хүн амь эрсдэж байгаа. Энэ нь ч бас бүх дэлхий даяар олон улсын нийтийн эрх зүйн тухай асуудлын түвшин маш доогуур хэмжээнд байж хүний эрх олон талаараа зөрчигдөж энэ нь эрх зүйн хэм хэмжээг алдагдах шалтгаан болж буйг илэрхийлнэ. Хүн төрөлхтөн аюулгүй аж төрж амар тайван амьдрахад хүрээлэн буй орчны нөлөө хамгаас их бөгөөд тухайн улс орны зүгээс таатай амьдрах орчин нөхцөл ба мөн аюулгүй аж төрөх боломжийг бүрэлдүүлсэн байх ёстой. Гэтэл харин өнөөгийн дэлхийн улс орнуудын жишээнээс анзаарахад хилийн мөргөлдөөн, терроризм гэх мэт олон үйл явдлын тоо баримт ба үр дүнгийн мэдээллээс ажихад олон улсын нийтийн эрх зүйн тухай асуудал нь төдийлөн хэрэгжихгүй байгаа мэт санагдана. Эрх зүй хэрэгжихгүй байгаа цагт шударга ёс хэзээ ч тогтохгүй. Үүнийг ардчилсан улс орон бүр ойлгож ухаарсан цагт ардчиллын үнэт зүйлс ба түүний талаарх үнэлэмж нэмэгдэх билээ.

Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, хөгжлийн бодлогын баримт бичиг, төрийн байгууллагын үйл ажиллагаа нь хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэхэд чиглэсэн байдаг. Монгол улсад хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо нь монгол улсын ерөнхийлөгч, улсын их хурал, засгийн газар, шүүх, прокурор, үндсэн хуулийн цэц, төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, хүний эрхийн үндэсний комиссоос бүрдэнэ хэмээн монгол улсын үндсэн хуулийн агуулгад тусгасан байдгаас үзэхэд хүний үндсэн эрхтэй холбоотой гомдлыг шийдвэрлэхэд үндсэн хуулийн цэц чухал нөлөөтэй болох нь илэрхий юм. Монгол улсад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагыг оролцуулж болох талтай. Монгол улсын үндсэн хуулийн цэц бол үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай

дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхтэй байгууллага, үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн хэмээн хуульд тусгасан байгаа нь хүний үндсэн эрхтэй холбоотой гомдлыг шийдвэрлэх эрх монгол улсын үндсэн хуулийн цэцэд л олгогдсон гэдэг нь тодорхой юм.

Цэц үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болох хувьдаа үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхээ энэ зүйлд заасан маргаантай асуудлаар дүгнэлт гарган, маргаантай асуудлыг дахин хянан үзэх замаар хэрэгжүүлнэ хэмээн монгол улсын үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8.1-т тусгасан байна¹³⁶. Мөн цэц үндсэн хуулийг зөрчсөн тухай дараах маргаантай асуудлыг хянан үзэж, дүгнэлт гарган улсын их хуралд оруулах бөгөөд хэрэв дүгнэлтийг нь улсын их хурал хүлээн зөвшөөрөөгүй бол цэц дахин хянан үзэж үндсэн хуулийн жаран зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг баримтлан эцсийн шийдвэр гаргана хэмээжээ. Энэ нь үндсэн хуулийн цэц хүний үндсэн эрхтэй холбоотой гомдлыг шийдвэрлэхэд чухал нөлөөлөл болохын бас нэгэн тод жишээ зайлшгүй мөн.

Цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээллийн шаардлагын зарим нь Цэцэд, зарим нь өөр шүүх буюу бусад байгууллагад харьяалалтай байвал Цэц зөвхөн өөрийн харьяалах маргааны шаардлагыг шийдвэрлээд бусдын харьяалах маргааны шаардлагыг шийдвэрлэхээс татгалзана. Гэхдээ энэ нь тухайн маргааныг харьяалах байгууллагаас хянан шийдвэрлэх ажиллагаанд саад болохгүй.

Үндсэн хуулийн цэц нь хууль, улсын их хурлын бусад шийдвэр үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, зарлиг ерөнхийлөгчийн бусад шийдвэр үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, засгийн газрын тогтоол, бусад шийдвэр үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, монгол улсын олон улсын гэрээ үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, ард нийтийн санал асуулгын талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, улсын их хурал, түүний гишүүний ба ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр үндсэн хуульд нийцэж байгаа эсэх гэх мэтэд хяналт тавин ажиллах ёстой. Дээрх бүхий л асуудал нь бүгд монгол улсад шударга ёс, эрх тэгш байдал хангагдахад чиглэгдэж байгаа бөгөөд энэ нь нэг талаасаа монгол улсын үндсэн хуулийн цэц хүний эрхтэй холбоотой гомдлыг шийдвэрлэхэд чухал байр суурь эзэлдэг болохын мөн батлан харуулж байгаа мэт санагдана. Үүнийг дараах хуулийн агуулгаар нотолж болно. Цэцийн тухай хуулийн 8.3-т зааснаар “цэц үндсэн хуулийг зөрчсөн тухай дараах маргаантай асуудлыг хянан үзэж, дүгнэлт гарган улсын их хуралд оруулна”¹³⁷ хэмээгээд Ерөнхийлөгч үндсэн хууль зөрчсөн эсэх, Улсын Их Хурлын дарга, гишүүн үндсэн хууль зөрчсөн эсэх, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн үндсэн хууль зөрчсөн эсэх, улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор үндсэн хууль зөрчсөн эсэх, Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл байгаа эсэх, Улсын их хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл байгаа эсэхийг хянаана гэсэн үг.

Хүний эрхийг хангах нэг чухал нөхцөл бол үндэсний болон олон улсын эрх зүйн орчин бүрдсэн байх ёстой. Хүний эрхийг хангах эрх зүйн иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх асуудал бол хүний эрхийг хангах тухайн улсын дотоодын нийгмийн байгууламж, гадаад талын олон улсын дэг журмыг зохицуулах хууль зүйн үндсэн баталгаа нь юм. Хүний эрхийг хэрэгжүүлэхийн тулд бүрэлдэн тогтсон

¹³⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай. УБ., 1992.

¹³⁷ Мөн тэнд.

нөхцөлүүдийг ашиглах талаар юуны өмнө иргэдийн санаачилга, эрхээ хамгаалахын төлөө тэмцэх үйл ажиллагаа чухал ач холбогдолтой. Үүний тулд иргэдийн эрх зүйн ухамсар боловсролыг дээшлүүлдэг тогтолцоо чухал. Нөгөө талд төр, засгийн зүгээс хүний эрхийг хангах материаллаг болон эрх зүйн баталгааг боловсронгуй болгох, төрөөс иргэдийн өмнө хүлээх хариуцлагын иж бүрдэл, тогтолцоог бүрдүүлж, тасралтгүй сайжруулах шаардлагатай.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал бол олон улсын харилцаанд бүх нийтээрээ сахин биелүүлэх хүний үндсэн эрх, эрх чөлөөний хүрээг дэлхийд анх удаа тодорхойлсон олон улсын эрх зүйн хэм хэмжээ билээ¹³⁸. Хүмүүн заяаг олж төрсөн хэн боловч ямар нэг ялгаваргүйгээр нийгмийн олон талт харилцаанд оролцож, эрх, эрх чөлөөгөө хэрэгжүүлдэг. Гэхдээ улс гүрнүүдийн уламжлалт ёс заншил, ухамсар сэтгэлгээ, нийгмийн баялгаас хүртэх боломж, хөгжлийн түвшингийн харилцан адилгүй байдлаас хамааралтайгаар хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх боломж тэнцвэртэй бус байна. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх үзэл хандлага зарим оронд өндөр байдаг бол зарим оронд хүний эрхийн зөрчил туйлдаа хүрч байна. Энэ бүх шалтгаанаас үүдэн хүний эрхийг судлах хэрэгцээ тулгарч байна.

Дүгнэлт

1. Өдгөө дэлхий дахинаа ардчилсан ёсыг эрхэмлэн үзэх улс орны тоо улам бүр нэмэгдсэн. Энэ нь ардчиллын үнэ цэнийг хүн төрөлхтөн ойлгон ухаарч буйн тод жишээ бөгөөд дэлхий даяараа ардчиллын үнэт зүйлс болох эрх чөлөө, шударга ёс, эрх тэгш байдлыг бүтээн байгуулахын төлөө нэгдмэл дуу хоолойгоор тэмцэж буйн нэгэн илэрхийлэл. Ерөөс хүн байхын утга учир нь эрх чөлөөтэй өөрийн дураар аж төрөх явдал. Харин эрх чөлөө нь өөрөө ардчилал хэмээх зүйлд агуулагдаж байдаг. Ардчилал гэдэг бол ийм л үнэ цэнтэй эрхэм зүйлсийн нэг юм. Улс үндэсний тусгаар тогтнолоо олж авсан, өөрийн орны баялаг, нөөц, бололцоогоо чөлөөтэй ашиглах эрхтэй байх, хүн бүрийг тэгш эрхээр хангах, харилцан ашигтай гадаад харилцааны орчныг бүрдүүлсэн байх, хууль эрх зүйн иж бүрэн тогтолцоо бүрдүүлэх асуудлууд нь цогц байдлаар шийдвэрлэгдсэн үед хүний эрхийг хэрэгжүүлэх нөхцөл бий болсон гэж үзэж болох юм. Хүний эрх нь хувь хүний хувьд төрөлхийн, салшгүй шинжтэй бөгөөд аливаа төр, шашнаас олгогддог зүйл биш юм. Эдгээр эрх нь хувь хүний нэр төр, алдар хүндийг төрийн болон төрийн бус хүчин урвуугаар ашиглаж, хохироохоос төрөөр хамгаалуулах эрх хэмжээ, боломжийг олгодог. Үүнийг мөн үндсэн эрх чөлөө гэж нэрлэдэг.

2. Хүн төрөлхтний үнэт зүйлс, ардчилсан хууль хийгээд ёс суртахууны аль алины нэг иш үндэс бол шударга ёс мөн. Түүнийг чанд сахиж, хууль дээдлэх нь засаг төрийн аливаа байгууллага, ямар ч албан тушаалтны дур зоргоор авирлахыг зориуд хязгаарлаж хуулийн хүчээр хазаарлан барьдаг. Үүгээрээ үндсэн хууль эрх мэдэлтний зүгээс иргэнийг дарамтлан, хүний эрх, ашиг сонирхлыг зөрчихөөс сэргийлэх хүчин зүйл болж байдаг. Иргэн хүн хуулиар хориглоогүй зүйлийг хийж болох эрх чөлөөтэй байдаг бол засаг төрийн байгууллага, түүний албан тушаалтан гагцхүү хуульд заасан үүргийг мөн түүгээр олгосон эрхийн дотор биелүүлэх ёстой байдаг. Энэ бол, шударга ёсны хэмжүүр болсон хууль дээдлэхийн үндсэн шаардлага мөн. Эцсийн дүнд засаг төр, түүний байгууллага, албан тушаалтан улсынхаа, түүний иргэдийн нийтлэг ашиг сонирхлын төлөө бат зогсож хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын төлөө шударгаар үйлчлэх юм. Энэ бол үндсэн хуулийн гол чиг үүрэг мөн.

Ашигласан материал

¹³⁸ Мөн тэнд.

1. Баярсайхан Д. Эрх зүйн онол. УБ., 2016.
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай. УБ., 1992.
3. Монгол Улсын Үндсэн хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 1992. №1.
4. Үндсэн хуулийн процессын эрх зүй. Гарын авлага. УБ., 2012.

СУДЛААЧДЫН ҮЗЭЛ БОДОЛ

ШҮҮМЖЛЭЛТ СЭТГЭЛГЭЭ БА БОЛОВСРОЛ

CRITICAL THINKING AND EDUCATION

Л.Одзаяа

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, хошууч*

Товч агуулга: Шүүмжлэлт сэтгэлгээ нь 2500 жилийн тэртээгээс хөгжиж ирсэн ойлголт бөгөөд түүний гол агуулга нь уншсан, сонссон, хэлсэн бичсэн зүйлийн талаар асууж лавлаж, дүн шинжилгээ хийн тайлбарлаж, дүгнэлт гаргадаг сэтгэлгээний нэг төрөл юм. Шүүмж гэдэг нь шүүн тунгаан бодох гэсэн утгатай үгнээс гаралтай. Шүүмжлэлт сэтгэлгээгээ хөгжүүлбэл найдвартай мэдээлэлд тулгуурлан найдвартай дүгнэлт гаргах боломжтой болдог.

Abstract: Critical thinking is a rich concept that has been developing throughout the past 2,500 years. The term "critical thinking" has its roots in the mid-late 20th century. Below, we offer overlapping definitions which together form a substantive and trans-disciplinary conception of critical thinking.

Түлхүүр үгс: Шүүмжлэлт сэтгэлгээ, асуулт, анализ, тайлбарлах, үнэлэх, дүгнэлт гаргах, үндэслэгээ

Keywords: Critical thinking, question, analyse, entrepret, evaluate, make a judgement, argument

Оксфордын толь бичигт "Шүүмж гэдэг нь аливаа асуудалд бодитой дүн шинжилгээ хийх, үнэлэх"¹³⁹ гэж тодорхойлсон байдаг. Энэ нь харьцангуй энгийн зүйл мэт боловч бид ихэвчлэн дүн шинжилгээ, үнэлгээний хэсэггүйгээр аливаа зүйлд дүгнэлт хийдэг.

Фридрих Ницше "Шүүмжлэхийн өмнө сайтар судлах, эргэцүүлэн бодох, зохиогчийг ойлгохыг хичээх, юуг хүсээд юунд хүрснийг нь тогтоох, бүтээлдээ хэрэглэсэн аргыг үгүйсгэх эсвэл үнэлэх явдал" гэжээ. XX зуунд Америкийн "шинэ шүүмжлэгчид"-ийн боловсруулсан шүүмжийг үзэх үзэл хандлага бүрэлдэн боловсорсон байна. Тэдгээр "шинэ шүүмжлэгчдийн" үзсэнээр шүүмж нь шүүх буюу үнэлэх, нээх буюу задлан шинжлэх, тодорхойлох буюу хамгаалах үүрэгтэй ажээ.

Орчин үед шүүмж нь нийгэм-соёлын бүхий л салбарт шүүмжийн бие даасан "дэд" хэлбэрүүд (видео тоглоомын шүүмжлэгч, нийгэм-эдийн засгийн шүүмжлэгч, улс төрийн шүүмжлэгч, олон улсын харилцааны шүүмжлэгч, авто машины загвар шүүмжлэгч, спортын шүүмжлэгч" зэргээр тодорхой мэргэжлийн хүрээнд шүүмжийн төрлүүд бий болж хөгжиж байна.

Сократ 2400 гаруй жилийн тэртээ шүүмжлэлт сэтгэлгээний онолын үндсийг боловсруулсан байдаг. Тухайн үед дэлхий ертөнц түүний санаа бодлыг хүлээн аваагүй бөгөөд нийгэмд үүнийг өргөн хүрээнд хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатайг ч ойлгодоггүй байв. Өнөөдөр ч мөн адил шүүмжлэлт сэтгэлгээ нь "үнэлэгддэг" боловч хөгжөөгүй чадваруудын нэг байсаар байна.

Шүүмжлэлт сэтгэлгээ гэдэг нь мэдээллийг эмхэлж цэгцлэх, шалгах, үнэлэх болон асуудалд хандахдаа магадлалт олон талаас нь дүн шинжилгээ хийж (дүн шинжилгээ хийхийн тулд баримт нотолгоо, учир шалтгаанууд, мөн орчин нөхцөлийг тодорхойлох шаардлагатай болдог) эцсийн зөв шийдэлд хүрэх

¹³⁹ <https://www.oed.com/search/dictionary/?scope=Entries&q=critic>.

чадварыг хэлнэ. Товчхондоо бол бодит нотолгоонд тулгуурлан асуудлыг шинжлэн дүгнэлт гаргах явдал юм.

Шүүмжлэлт сэтгэлгээ гэдэг нь тодорхой сэдвийн талаарх одоо байгаа мэдээллийг задлан шинжлэх, үнэлэх чадварын илэрхийлэл бөгөөд өгөгдсөн мэдээллийн үнэн зөвийг тодруулж, энэ талаар үндэслэлтэй шийдэлд хүрэх чадварыг илэрхийлдэг. Шүүмжлэлт сэтгэлгээг ашиглан ойлгосон зүйлийнхээ бодит байдлыг илрүүлж болно.

Бодит байдлын талаар үндэслэлтэй ойлголттой болтлоо бусдын хэлсэн зүйлийг “сохроор” хүлээж авахгүй байхыг эрмэлзэх хэрэгтэй. Энэ төрлийн сэтгэлгээ нь эргэлзээтэй холбоотой байдаг ба хүн төрөлхтний хөгжлийн явцад бий болж, ялангуяа өсвөр насандаа өөрийгөө танихад тусалдаг. Энэхүү ойлголт нь дэлхий ертөнцийг эсэргүүцэх тухай биш, харин өгөгдлийг нягтлах, баталгаажуулах, ялгаатай байдалд үндэслэн өөрсдийнхөө үзэл бодлыг нарийвчлан боловсруулах боломж юм. Шүүмжлэлт сэтгэлгээ нь бүтээлч болон логик эсвэл зөн совин гэх мэт ойлголтуудтай нягт холбоотой бөгөөд шинэ стратеги, аливаа зүйлийг өөр талаас харах, ойлгох арга хэлбэрийг боловсруулах боломжийг олгодог.

Шүүмжлэлт сэтгэлгээ нь бусдын үзэл бодолд авталгүй, олон сонголтуудад тулгуурлаж үнэн зөв дүгнэлт өгөхөд тусалдаг. Аль болох үндэслэлтэйгээр үнэнийг эрэлхийлж, хэлсэн хийсэн зүйл нь үнэн болохыг баримт, нотолгоогоор батлах чадвар юм. Жишээлбэл: Таны дэмждэг сагсан бөмбөгийн нэгэн тамирчин өөр багийн гишүүн болжээ. Тэгвэл ямар шалтгааны улмаас, түүнд ямар хүчин зүйл нөлөөлсөн эсэх гэх мэтийг задлан шинжилж, дүгнэлт гаргах явдал юм. Ингэхдээ хувилбарт фактуудыг дутуу тооцоолох хийдлийн улмаас таамаглалаас эсрэг шийдэлд хүрэхийг үгүйсгэхгүй. Гэвч шүүмжлэлт сэтгэлгээг амьдралдаа хэрэгжүүлснээр ихэнхдээ бид зөв шийдэлд хүрдэг.

Шүүмжлэлт сэтгэлгээ гэдэг нь тодорхой бөгөөд тууштай шалгуураар бидний үүсгэсэн эсвэл хүлээн авсан мэдээллийг зөв зохион байгуулах, шалгах, үнэлэх чадвар юм. Энэ нь юунд итгэх эсэхээ өөрөө шийдэх боломжийг олгодог бөгөөд тусгал эргэлзээг харуулах хандлага юм. Тиймээс өгөгдөл, баримт, илэрхийллийг тайлбарлах; хувийн дүгнэлт хийх; санаа, зорилго, үзэл баримтлал, аргументэд дүн шинжилгээ хийх чадвартай байхыг илэрхийлдэг. Шүүмжлэлт сэтгэлгээ нь оновчтой байдал, бие даасан сэтгэлгээний үндэс суурь юм. Энэхүү амин чухал ур чадварыг хөгжүүлэх нь тухайн хүнд юмсыг өөр талаас харах, үндэслэлтэй дүгнэлт хийх боломжийг олгодог ба түүний ур чадварыг нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл хувийн мэдрэмж, хэн нэгний үзэл бодлын нөлөөгүйгээр бодитой сэтгэж, дүгнэлт хийх чадвар юм. Шүүмжлэлтэй сэтгэгч бол ямар нэгэн үйлдэл ба хариу үйлдлийн хооронд логик холбоо тогтоож, асуудлыг олж засварлаж, системтэйгээр шийдвэрлэж, аргументэд шүүлт хийх, нийтлэг алдаануудыг олж илрүүлэх чадвар юм.

Шүүмжлэлт сэтгэлгээний талаарх эндүүрэл

Шүүмжлэлт сэтгэлгээ нь сөрөг байх, алдаа дутагдалд анхаарлаа хандуулах гэсэн үг биш юм.

Харин аливаа асуудал эсвэл мэдээллийг задлан шинжилж, тайлбар боловсруулан ашиглаж үндэслэлтэй шийдвэр болон дүгнэлт гаргах гэсэн үг юм. Олон хүмүүс шүүмжлэлт сэтгэлгээг мэдлэгийн цуглуулга гэж андуурдаг. Харин түүнийг эзэмшсэн хүн мэдлэгээ ашиглах хандлагатай байдаг ба шинэ мэдээллийг хайж олохыг зорьдог.

Өөр нэг нийтлэг эндүүрэл бол шүүмжлэлт сэтгэлгээ гэдэг нь бусад хүмүүсийн хэлж, хийж байгаа зүйлд хэт эргэлзэх, шүүмжлэлтэй хандах тухай гэж ойлгодог.

Өөрөөр хэлбэл шүүмжлэлт сэтгэлгээ гэдэг нь бүх зүйлд байнга сөрөг хандах тухай асуудал биш юм.

Шүүмжлэлт сэтгэлгээ	Шүүмжлэлт бус сэтгэлгээ
Үл итгэдэг	Цээжлэн тогтоодог
Таамаглалыг шалгаж нягталдаг	Бүлгийн сэтгэлгээ
Ухаан сорьсон оюун дүгнэлт	Бусдын үзэл санааг сохроор буюу ямар нэг анализ дүгнэлт хийхгүйгээр хүлээн зөвшөөрөх

Шүүмжлэлт сэтгэлгээний ач холбогдол

Шүүмжлэлтэйгээр сэтгэх чадвар нь өнөө үед маш эрэлттэй чадваруудын нэг бөгөөд үүнийг танин мэдсэнээр шаардлагатай тохиолдолд аливаа хүн өөрийгөө ч шүүн тунгааж чадах бөгөөд шинжлэх ухаанч хандлагатай хүн болж төлөвших ач холбогдолтой юм. Харин өөрийгөө өмөөрдөг, өрөвддөг, бусдыг буруутгадаг, хов зөөдөг, болзол тавьдаг хүнийг төлөвшөөгүй хүн гэж дүгнэж болно. Шүүмжлэлт сэтгэлгээг амьдралдаа хэрэглэснээр ихэнхдээ бид зөв шийдэлд хүрнэ. Мөн шүүмжлэлт сэтгэлгээ нь зөвхөн эрдэм шинжилгээ, ажлын байраар хязгаарлагдахгүй юм. Тухайлбал мэдээллийн эх сурвалжийг үнэлэх, санхүүгийн шийдвэр гаргахаас эхлээд хувийн харилцаагаа зохицуулах болон хүний амьдралын бүх талбарт тодорхой, ухамсартайгаар хандах боломжийг олгодгоороо ач холбогдолтой.

Шүүмжлэлт сэтгэлгээг хэрхэн ашиглах вэ?

Шүүмжлэлт сэтгэлгээг үр дүнтэй ашиглах нь мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргах, асуудлыг шийдвэрлэх зорилготой, арга зүйн хандлагыг агуулдаг. Шүүмжлэлт сэтгэлгээг чадварлаг хэрэгжүүлэх зарим практик алхмуудыг доор харуулав.

Шүүмжлэл сэтгэлгээ нь дасан зохицох чадвартай бөгөөд тухайн асуудлын нөхцөл байдал, нарийн төвөгтэй байдлаас хамаарч өөр өөр байж болохыг анхаарах нь чухал юм. Шийдвэр гаргах, асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагаанд шүүмжлэлт сэтгэлгээг ашиглахын тулд системтэй, бодитой, шинэ мэдээлэл, хэтийн төлөвийг хүлээн авах хүсэлтэй байх нь чухал юм¹⁴⁰.

Бодит амьдрал дээр шүүмжлэлт сэтгэлгээ гэж юу вэ? Шийдвэр гаргахаасаа өмнө шүүмжлэлтэй хандах нь ямар чухал болохыг энэ жишээ харуулж байна.

Та ахлах сургуулийн төгсөх ангийн сурагч, коллежийн мэргэжлийг сонгох шийдвэртэй тулгарлаа гэж төсөөлөөд үзье. Энэ бол таны эрдмийн болон карьерын замыг тодорхойлох амьдралын чухал сонголт юм. Энэ нөхцөлд шүүмжлэлтэй сэтгэлгээг хэрхэн ашиглаж болохыг эндээс үзнэ үү.

1. Асуудлыг тодорхойл:

Асуудал нь таны сонирхол, ур чадвар, ирээдүйн ажил мэргэжлийн зорилгод нийцсэн коллежийн мэргэжлийг сонгох явдал юм.

2. Холбогдох мэдээлэл цуглуулах:

Төрөл бүрийн мэргэжлүүд, тэдгээрийн сургалтын шаардлага, ажил мэргэжлийн боломжууд, эдгээр мэргэжлүүдийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг судлаарай.

¹⁴⁰ <https://www.indeed.com/career-advice/career-development/how-to-improve-critical-thinking>.

3. Асуултын таамаглал:	“Би өндөр цалин авах мэргэжлийг сонгох ёстой” эсвэл “Эцэг эхийнхээ хүссэн зүйлийг сонгох ёстой” гэх мэт таамаглалыг сорьж үзнэ. Ингэхдээ өөрийн хувийн сонирхол, хүсэл тэмүүллийг анхаарч үзээрэй.
4. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх:	Ажлын байрны хэтийн төлөв, дундаж цалин, мэргэжил бүрийн сургалтын хөтөлбөр гэх мэт цуглуулсан мэдээллээ шинжилгээ хийнэ.
5. Олон талаас харах:	Коллежийн зөвлөхүүд, профессорууд, янз бүрийн салбарын мэргэжилтнүүд, өөр өөр мэргэжлийг сонгосон үе тэнгийнхэнтэйгээ ярилц. Төрөл бүрийн үзэл бодлыг олж аваарай.
6. Нотлох баримтыг үнэлэх:	Цуглуулсан мэдээллийнхээ найдвартай байдлыг үнэл. Статистик болон хөдөлмөрийн зах зээлийн таамаглалын нарийвчлалыг шалгаарай.
7. Өөрийн үзэл бодлыг томъёолох:	Шинжилгээнд үндэслэн сонголтоо нарийвчилж, үнэхээр өөрийн сонирхож буй хэд хэдэн мэргэжлээ сонгож, урт хугацааны эрэл хайгуулдаа нийцүүлээрэй.
8. Санал хүсэлт, үе тэнгийнхний үнэлгээг хайх:	Итгэлтэй найз нөхөд, гэр бүлийн гишүүд, зөвлөгч нартайгаа өөр сонголтуудын талаар ярилцаарай.
9. Үр дагаврыг авч үзэх:	Мэргэжил тус бүрийг сонгоход гарах боломжит үр дүнгийн талаар бод. Өөрийнхөө зөвхөн санхүүгийн тал дээр төдийгүй урт хугацааны аз жаргал, сэтгэл ханамжийг анхаарч үзээрэй.
10. Мэдээлэлтэй шийдвэр гаргах:	Эцэст нь, өөрийн сонирхол, ур чадвар, карьерын хэтийн төлөв, хувийн үнэт зүйлсийг харгалзан коллежийн мэргэжлийнхээ талаар сайн мэдээлэлтэй шийдвэр гаргахын тулд шүүмжлэлтэй сэтгэлгээг ашигла.
11. Тунгаан бодож сур:	Шийдвэр гаргасны дараа ашигласан шүүмжлэлт сэтгэлгээний үйл явцаа тунгаан бод. Коллежийн аяллын үеэр илүү их туршлага, ойлголттой болохын тулд шаардлагатай бол мэргэжлээ өөрчлөхийн тулд нээлттэй сэтгэлгээтэй байгаарай.

Шүүмжлэлт уншлага

Боловсролын салбарын мэргэжилтнүүд дээд түвшний сэтгэн бодох чадварыг заах, үнэлэх талаар Блүмийн таксономийг ашигладаг ба түүний доод түвшин нь "сэргээн санах", "ойлгох" чадварууд багтдаг. Харин дээд түвшинд бүтээх, үнэлэх, задлан шинжлэх гэсэн ойлголтууд багтдаг бөгөөд энэхүү дээд түвшин нь шүүмжлэлт сэтгэлгээтэй холбоотой юм. Хүүхэд залуучуудын шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх нь дэлхийн улс орнуудын боловсролын гол зорилго юм. Хүүхэд залуучуудын шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх нь ардчилал,

хувь хүний хөгжил зэрэг ялгаатай чанаруудыг хөхиүлэн дэмжихтэй холбоотой тул нийгэмд үүнийг боловсролын маш чухал зорилт гэж үздэг¹⁴¹.

Мөн шүүмжлэлтэй унших нь шүүмжлэлтэй бичихийн чухал эх сурвалж юм. Мөн их уншдаг хүмүүс асуудлыг олон талаас харж, шийдэл олж мэддэг. Ийнхүү шүүмжлэлтэй уншихын тулд уран зохиолын бүтээлийг унших нь нарийвчилсан дүн шинжилгээ хийх үндэс суурь болдог. Мөн эрдэм шинжилгээний өгүүлүүдийг шүүмжлэлтэйгээр унших нь эх сурвалж болон тэдгээрийн найдвартай байдлыг үнэлэхэд тус болно. Харин хэн нэгний маргаанаас алдаа олох нь тогтворгүй байдлын үндэс байж болох юм. Мөн аливаа асуудлыг сошиал медиагаар шуурхай хэвлэн нийтэлдэг энэ эрин үед биднээс хэлж буй зүйлээ сайтар тунгаан бодохыг шаардах болсон тул таныг мэтгэлцэх ур чадвараа хөгжүүлэхэд тусална.

Шүүмжлэлтэй уншихын ач холбогдол

Шүүмжлэлтэйгээр уншиж сурснаар илүү сайн, илүү ухаалаг уншигч болохын зэрэгцээ уншиж буй зүйлээ илүү гүн гүнзгий ойлгож авдаг. Мөн аливаа хүн текстээс илүү ихийг олж авч, уншсан зүйлээ эргэн санах, үр дүнтэй мэдээллийг олж авч чадна. Энэ нь биднийг "мэдээ" эсвэл ямар нэгэн алдартай номд бичигдсэн эсвэл алдартай зохиолч бичсэн учраас текст дээрх үгсэд итгэмтгий буюу сохроор итгэж, хүлээж авахаас сэргийлнэ.

Энэ нь муу маргаан, баталгаагүй нотолгоо, төөрөгдөл, худал сурталчилгаа, худал мэдээ, суртал ухуулга, залилан гэх мэтийг илрүүлэхэд хялбар болгодог. Мөн биднийг шүүмжлэлтэй сэтгэх чадварыг дээшлүүлж, илүү ухаалаг болгодог. Номыг шүүмжлэлтэй уншихаасаа өмнө хамгийн эхний алхам бол уншихад үнэ цэнтэй мэдээлэлтэй эсэхийг мэдэх явдал юм.

Шүүмжтэй унших нь дүн шинжилгээ хийх, тайлбарлах, заримдаа үнэлэх үйл явц юм¹⁴².

- Текстийг гүйлгэн үзэх замаар ерөнхий тойм утгыг ойлгох;
- Текстийг гүйлгэн уншаад түлхүүр үгнүүдийн утгыг ойлгох;
- Текстийн агуулгыг гүнзгийрүүлэн судалж, өөрийн судалгааны найдвартай байдлыг хангахын тулд эх сурвалжийн талаар идэвхтэй асуулт асууна.

Яагаад шүүмжлэлтэй унших хэрэгтэй вэ?

Эрдэм шинжилгээний мэтгэлцээнд ороход бэлэн байх ёстой бөгөөд уншсан зүйлээ хэр зэрэг хүлээн зөвшөөрүүлэхэд бэлэн байгаа талаар өөрийн дүгнэлтээ боловсруулна.

• Тиймээс уншсан бүх зүйлээ баримт биш, харин зохиогчийн аргумент гэж үзэх нь эхлэлийн цэг юм. Энэхүү эхлэлийн цэгийг тодорхойлсноор шүүмжлэлтэй уншихад бэлэн болсон гэсэн үг.

• Шүүмжлэлтэй уншихдаа бүгдийг няцаах шаардлагагүй.

• Шүүмжлэлтэй уншихын зорилго нь алдаа хайх биш, харин нотлох баримт, аргументыг үнэлэх явдал юм. Судалгаа эсвэл нийтлэл нь хангалттай нотлох баримттай, үндэслэлтэй аргуудыг өгдөг гэж дүгнэх нь сул судалгаа, нийтлэлийг тодорхойлохтой адил ашигтай байдаг.

Өөрөөсөө асуулт асуух

• Би яагаад үүнийг уншиж байгаа вэ? Илтгэл, даалгавар, лекцийг уншихын тулд эсвэл санаа олохын тулд уншиж байна уу?

• Би хангалттай уншсан эсэхээ яаж мэдэх вэ?

Юуг, хэрхэн уншихаа сонгох

¹⁴¹ <https://library.leeds.ac.uk>, n.d.

¹⁴² <https://www.stetson.edu/other/writing-program/media/>, n.d.

- Бид ихэвчлэн ямар нэг сэдвээр олсон бүх текстийг уншиж чадахгүй, тэр ч байтугай унших жагсаалтад санал болгосон бүх зүйлийг уншиж чадахгүй. Харин сонголт хийж, чухлыг нь уншина.

- Мөн тоо хэмжээ биш чанарыг сонгон, найдвартай эх сурвалжийг сонгоно. Түүнчлэн сэдвийг тоймлон харуулах хялбар текстээр эхлүүлнэ.

Унших дөрвөн үндсэн стратегийн аль нэгийг сонгож болно. Эдгээр нь:

1. Урьдчилан таамаглах: Уншихаас өмнө тухайн текст юуны тухай өгүүлж буйг таамаглах;
2. Түлхүүр үгнүүдийг текстээс хурдан хайж олох;
3. Догол мөр бүрийн эхний хэсгийг уншаад текст юуны тухай болохыг олж мэдэх;
4. Хурдан унших: Текстийн богино хэсгийг удаан, анхааралтай унших¹⁴³.

	Ердийн уншлага	Шүүмжлэлтэй уншлага
Зорилго	Текстийн талаар ерөнхий ойлголттой болох	Бичигдсэн текстээс дүгнэлт гаргах
Унших үйл ажиллагаа	Ойлгох	Шинжилгээ болон тайлбар хийж, үнэлэх
фокус	Текст юуны тухай өгүүлж буйд Текст юу өгүүлж байна вэ? Би үүнээс ямар мэдээлэл авч болох вэ?	Текстийн гол утга юу болохыг Тексттэй хэрхэн ажиллах вэ? Маргаантай зүйл юу байна вэ? Ямар сонголт хийсэн бэ? Үүний үр дүнд ямар загвар бий болсон бэ? Ямар төрлийн үндэслэл, нотлох баримтуудыг ашигласан вэ? Таамаглалууд нь юу байв? Текст ямар утгатай вэ?
Чиглэл	Текстийн утга санааг зөв гэж зөвшөөрөх	Текстийн эсрэг байр суурь (түүний таамаглал, аргументыг асууж, утгыг нь тайлбарлах)
Хариулт	Хураангуй	Тодорхойлолт, тайлбар, үнэлгээ

Дүгнэлт

1. Өнөө үед шүүмжлэлт сэтгэлгээний ач холбогдол улам бүр нэмэгдэж байгаа хэдий ч түүний тухай тэр бүр нарийн мэддэггүйн улмаас аливаа асуудалд өрөөсгөл дүгнэлт хийх, буруу шийдвэр гаргадаг. Мөн энэхүү ойлголтыг буруугаар тайлбарлах, ойлгох явдал түгээмэл байдаг. Харин энэхүү өгүүлэлд энэхүү ойлголтыг хэрхэн нэг мөр болгон ойлгож, тодорхойлохоос илүү хүүхэд залуучуудад нэн чухал хэрэгцээтэй чадваруудын нэг болохыг онцлохыг оролдлоо. Үүнээс гадна академик түвшинд суралцаж буй оюутнууд хэрхэн яаж шүүмжлэлтэй уншиж сурах арга зүйтэй болох, түүний ач холбогдлыг судлахыг зорьсон бөгөөд энэхүү чадварыг хөгжүүлснээр хамгийн гол нь дараагийн шатны боловсролын байгууллагад амжилттай суралцах болон ирээдүйд ажлын байр, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн төгсөгч болоход нэн тустай чадвар болох нь дотоод, гадаадын олон судалгааны үр дүнгээс харагдаж байна.

2. Аливаа хүн шүүмжлэлт сэтгэлгээний онолын үндсийг бие даан гүнзгийрүүлэн судалж, өөрийн үйл ажиллагаанд ашиглахад тохиромжтой юм. Тухайлбал, багш нарын хувьд аливаа зүйлийг олон талаас нь харах буюу юмсыг өөр өнцгөөс харах, үндэслэлтэй сэтгэх, үнэлгээ, дүгнэлт хийх, шийдвэр гаргах

¹⁴³ https://library.leeds.ac.uk/downloads/download/37/critical_thinking_questions, n.d

зэрэгт хэрэгцээтэй ур чадвар юм. Мөн багшийн албан тушаал нь олон хүнтэй харилцдаг онцлогтой учраас сонсогч, суралцагчидтай зөв боловсон харилцах дадал, хэвшил суухад дөхөм болно.

Ашигласан материал

1. <https://www.oed.com/search/dictionary/?scope=Entries&q=critic>.
2. <https://www.indeed.com/career-advice/career-development/how-to-improve-critical-thinking>.
3. <https://library.leeds.ac.uk>, n.d.
4. <https://www.stetson.edu/other/writing-program/media/>, n.d.
5. https://library.leeds.ac.uk/downloads/download/37/critical_thinking_question, n.d.

ЗАЛУУСЫН ЭЛЕКТРОН ТАМХИ (ВЭЙП)-НЫ ХЭРЭГЛЭЭ, ТҮҮНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

THE USAGE OF ELECTRONIC CIGARETTES (VAPE) BY STUDENTS AND SOME ISSUES TO BE CONSIDERED IN LEGAL REGULATION

*Ц.Өнөболд
ДХИС-ийн ЭЗНУС-ийн
Нийгмийн ухааны
тэнхимийн багш, цагдаагийн
ахлах дэслэгч*

Товч агуулга: Монгол Улсын Их хурлаас 2005 онд Тамхины хяналтын тухай хуулийг баталсан. Монгол Улсын Их хурал 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улс Тамхины хяналтын суурь конвенцод нэгдэн орсныг 2014 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Тамхины хяналтын суурь конвенцын 33 дугаар зүйлийг үндэслэн Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай Протокол соёрхон батлах зэрэг бусад хөтөлбөр, тогтоолуудыг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Гэвч орчин цагийн оюутан залуусын дунд тамхин бүтээгдэхүүн ялангуяа шинэ төрлийн электрон тамхины хэрэглээ нэмэгдсээр байна. Үүнд нөлөөлж буй олон хүчин зүйл байгаа бөгөөд хууль эрх зүйн нарийн зохицуулалт төр, байгууллага ард иргэдийн санаа тавих асуудал болоод байгаа явдал нь сэдэв судлах үндэслэл боллоо.

Abstract: The Law on Tobacco Control in Mongolia was approved and implemented on 1 July, 2005. Thus, Mongolia joined the Basic Convention on Tobacco Control on 24 October, 2003. We are working on to ensure the implementation of other programs and resolutions, such as the ratification of the Protocol on the Elimination of Illegal Trade in Tobacco Products based on Article 33 of the Basic Convention on Tobacco Control law approved on 24 April 2014. However, the use of tobacco products, especially new types of e-cigarettes, is increasing among modern students. There are many factors that affect this kind of issue, and the Mongolian Government and organizations are concerned with the issue of legal regulations.

Түлхүүр үгс: Электрон тамхи, утаат тамхи, хэрэглээ, эрх зүйн зохицуулалт.

Keywords: Electronic cigarettes, smoking cigarettes, usage, legal regulation.

Технологийн хурдтай хөгжлийн зэрэгцээ (Нийгэмд) бидний хэрэглэдэг уламжлалт янжуур тамхи нь цахилгаан төрөл рүү шилжсээр байна. Гэвч энэ үзэгдэл нь зөв буруу гэх хоёр ойлголтын алинд нь ч бүрэн дүүрэн хариулт өгч чадахгүй цаг үед бид нэгэнт ирчихсэн байна. Тэгвэл бидний нэн тэргүүнд бодох асуудал бол (Утаат тамхи гэж юу юм? Татах буюу үнэрлэж хэрэглэхэд зориулсан, никотин агуулсан сэтгэц идэвхт бодис юм) Электрон тамхи гэж юу юм? (Электрон тамхи буюу "вэйп" нь татаж буй хүний амьсгалд орох аэрозол үүсгэхийн тулд шингэнийг (эсвэл "шүүс") халаадаг электрон төхөөрөмж юм) Энэ хоёрын хоруу чанар адилхан уу? Нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө өөр өөр байх боломжтой юу? Гэх зэрэг мэдвэл зохих үндсэн асуудлууд гарч ирнэ. Манай Монгол Улсад янжуур тамхинаас болж жилд 4300 хүн нас барж, 20.000 хүн шинээр өвчилдөг, дэлхий дээр жил бүр 8,6 сая хүн янжуур тамхинаас үүдэлтэй өвчлөлөөр нас барж байгаа бол электрон тамхины талаар манай улс болон дэлхийн түвшинд дүгнэлт хийж бүрэн дүүрэн судалгаа гараагүй байгаа юм... Харин өндөр хөгжилтэй улс орнуудын бие даасан болон албан ёсны судалгааны лабораториудын дүгнэлтээр электрон

тамхийг янжуурын хоруу чанартай харьцуулахад 95% бага байна гэдгийг хүлээн зөвшөөрсөн ба ойрын жилүүдэд дэлхийн зах зээлд янжуур тамхи болон, электрон тамхины ширүүхэн тулаан болох нь тодорхой харагдаж байна. Олон улсад тамхины хоруу чанарт нь татвар ноогдуулдаг ба (ямар хоруу чанар үзүүлж байна, яаж хүний биед сөргөөр нөлөөлж байна) татварыг авч үзвэл дунджаар (100 гаруй улс орон) янжуур тамхитай харьцуулахад электрон тамхины татварыг 80% багаар ноогдуулж байна. Зарим улсууд буюу Англи, Шинэ Зеландад татвар огт ноогдуулаагүй байна.

Энэ бүхнээс хамаарч электрон тамхины мандалт улс орнуудад хүчтэй явагдаж байгаа ба Монгол Улсад электрон тамхи дөнгөж орж ирсэн эхэн үед түүний хэрэглээ 3,5 хувь байсан боловч электрон тамхины сурталчилгаа эрчимжиж, зах зээл нь хүрээгээ улам бүр тэлж байгаагаас тархалт огцом нэмэгдэж, хэрэглээ газар авсаар байна. Электрон тамхины импорт эрс өсөж, 2021-2019 онд 68 дахин буюу анх удаа огцом өсөлтөө авч эхэлсэн ба 2021 онд БНХАУ-аас 1,0 сая, Камбож улсаас 1,6 сая ширхэг электрон тамхи импортлогдож ойролцоогоор 3,564,196 ам.доллартой тэнцэж байна.

Энэ бүх өсөлтийн үр дүнд манай орны хүүхэд залуус хамгийн ихээр өртөж байгаа нь илт байна. Өөрөөр хэлбэл тамхины орц найрлагыг өөрчилснөөр тамхины хорт шинж чанарыг багасгаж болдог гэсэн ташаа ойлголт залуусын дунд түгээмэл байна. Гэвч тамхинд агуулагдах никотины хэмжээг багасгахад тамхи хор багатай болдог талаар шинжлэх ухааны ямар нэгэн нотолгоо олон улсын хэмжээнд байхгүй бөгөөд энэ аргыг тамхи үйлдвэрлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнийг борлуулах маркетингийн нэг арга болгон ашигладгийг дэлхийн Эрүүл мэндийн Мэндийн Байгууллагаас улс орнуудад анхааруулдаг. Маркетингийн энэхүү аргыг электрон тамхин бүтээгдэхүүний шинэ төрөл бүрийг сурталчлахад өргөнөөр ашиглаж байна. Эдгээр шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний эрх зүйн зохицуулалт Монгол Улсад байхгүйн улмаас сурталчилгааны хяналтгүй орон зай бий болж, онлайн худалдаа цэцэглэж, нэн ялангуяа хүүхэд, залуусын дунд тамхи татах сэдэл, хэрэгцээг эрс нэмэгдүүлсэн тул хяналт, зохицуулалт сайжруулах бодит хэрэгцээ бий болоод байна.

Электрон тамхи татдаг оюутнуудын 82 хувь нь цахим сүлжээгээр дамжуулан захиалах хэрэглэх, 18 хувь нь гар дээрээс, дэлгүүр, ТҮЦ-нээс авч улмаар ахуйн орчин, сургуулийн орчинд электрон тамхи хэрэглэх явдал нэмэгдсээр байна. Үүнээс авч үзэхэд шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгжилтийг хангаж, хяналтыг сайтар тавих нь улс орон, байгууллага, сургуулийн бодлогын асуудал болоод байгаа юм¹⁴⁴.

Манай оронд тамхины хяналтын тухай хууль хэрэгждэг. Энэ хууль нь 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан ба 4 бүлэг 13 зүйлтэй. Тус хуульд Тамхины хяналтын талаар төрөөс баримтлах бодлого нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын салшгүй хэсэг бөгөөд дараах зарчмыг баримтална гэж заасан байдаг.

- Тамхины татварыг Тамхины хяналтын суурь конвенцод заасан түвшинд хүргэх замаар тамхины хяналт, хүн амын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг тогтвортой санхүүжүүлж, насанд хүрээгүй иргэнийг тамхинд орохоос сэргийлэх, тамхины хэрэглээг бууруулах;

- Нийгмийн эрүүл мэндийн бодлогыг тамхи үйлдвэрлэгчдийн сөрөг нөлөөллөөс хууль тогтоомжийн хүрээнд хамгаалах;

¹⁴⁴ Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн үзэл баримтлал.

- Тамхины хяналтын талаар бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тамхи үйлдвэрлэгчтэй холбоогүй хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын оролцоог дэмжих;

- Тамхины хэрэглээ, дам тамхидалтын улмаас хүний эрүүл мэнд, эдийн засаг, байгаль орчинд учруулах сөрөг үр дагаврын талаарх шинжлэх ухааны үндэслэлтэй, бодит мэдээлэл, сургалт, сурталчилгаа болон тамхинаас гаргах эмчилгээг хүртээмжтэй болгох.

- Тамхи үйлдвэрлэгч, түүний ашиг сонирхлын төлөө ажиллаж байгаа хуулийн этгээдийг нээлттэй, хариуцлагатай зарчмаар үйл ажиллагаагаа явуулахыг шаардах;

- Тамхи үйлдвэрлэгчийн үйл ажиллагаанд урамшуулал, татварын хөнгөлөлт болон бусад давуу тал олгохгүй байх;

- Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тамхи үйлдвэрлэгчтэй өмчийн хэлбэр харгалзахгүйгээр адил тэгш хандах;

- Тамхи үйлдвэрлэгч, түүний ашиг сонирхлын төлөө ажиллаж байгаа хуулийн этгээдийг тамхины хяналтын талаарх хууль тогтоомж боловсруулах, батлах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шууд оролцох болон хөндлөнгөөс нөлөөлөхөөс ангид байлгах;

- Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд тамхи үйлдвэрлэгч хөндлөнгөөс оролцох стратеги, арга, уул бодлогыг тамхи үйлдвэрлэгчийн ашиг сонирхлын нөлөөллөөс хамгаалах шаардлага болон тамхи үйлдвэрлэгчийн зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны талаар төрийн бүх шатны байгууллага, олон нийт мэдээллээр хангагдсан байх.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурал 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улс Тамхины хяналтын суурь конвенцод нэгдэн орсныг 2014 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Тамхины хяналтын суурь конвенцын 33 дугаар зүйлийг үндэслэн Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай Протоколыг тус тус соёрхон баталсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050”¹⁴⁵ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2,2,9 дэх заалтад “Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэрэглээг хязгаарлах, архи, тамхи эм, чихэрлэг ундааны онцгой албан татварын тодорхой хувийг эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэх, хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг санхүүжүүлнэ” гэж заасан байдаг.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө¹⁴⁶”-ний 2,1,5,6 дахь заалтад “Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.” гэж Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл¹⁴⁷”-ийн 1,15-ын “Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд”-ийн 136 дахь заалтад “Зарим шинэ төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүний сав баглаа боодол, шошгын стандартжуулсан зохицуулалтыг хуульд нэмэх, Түүнчлэн манай улсын нэгдэн орсон “Тамхины хяналтын конвенц”-д тамхигүй орчныг дэмжихээр

¹⁴⁵ Алсын хараа-2050. Монгол Улсын урт хугацааны бодлого.

¹⁴⁶ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.

¹⁴⁷ Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл.

тусгасныг Тамхины хяналтын тухай хуульд нарийвчлан зохицуулахаар” Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хүнс хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам, Эрүүл мэндийн яам хамтран боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Үүнээс авч үзэхэд, манай улс Тамхины хяналтын тухай хууль, хуулийн зорилго, бусад томоохон эрх зүйн актуудтай уялдуулан дараах ажил арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого УИХ-ын 2001 оны 81-р тогтоол;
- Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөр МУЗГ-ын 2005 оны 246-р тогтоол;
- Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах” Нийслэлийн дэд хөтөлбөр НИТХТ-ийн 2006 оны 265 дугаар тогтоол;
- Эрүүл мэндийг дэмжих сан” ЗГ-ын 2007 оны 92 дугаар тогтоол;
- НИТХТ-ийн “Тамхигүй орчин бүрдүүлсэн ресторан” шалгаруулах тухай 2008 оны 102 дугаар тогтоол;
- НЗД-ын “Тамхигүй орчин бүрдүүлсэн ажлын байр хөдөлгөөн өрнүүлэх тухай” 2010 оны 362 дугаар захирамж;
- НЭМГ-ын даргын “Тамхигүй ажлын байр бий болгох” 2011 оны 1а/31 дүгээр тушаалууд зэргийг баримтлан ажиллаж байна.

Монгол Улс тамхины хэрэглээгээр дэлхийд эхний 10-т жагсдаг ба нийт нас баралтын 17 хувь нь тамхинаас үүдэлтэй байгааг судалгаагаар тогтоосон байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын аргачлалаар бүх улс оронд хийгддэг “Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тогтоох судалгаа” –г манай улс анх 2019 онд хийхэд манай улсын хүн амын 24,2 хувь нь, үүнд эрэгтэйчүүдийн 43,7, эмэгтэйчүүдийн 5,3 хувь тогтмол тамхи татдаг гэсэн дүн гарсан нь бусад улсын үзүүлэлттэй харьцуулахад тамхины хэрэглээ өндөр байна. Мөн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас Монгол Улсад хийсэн “Дэлхий дахины залуучуудын тамхины тархалтын судалгаа”-гаар нийт сурагчдын 14 хувь нь утаат тамхи, 3,5 хувь нь электрон тамхи татдаг (Электрон тамхи татдаг оюутан залуусын тоо жилээс жилд өсөж байгаа), 42,9 хувь нь гэртээ, 52,3 хувь нь олон нийтийн газарт тамхины утаанд өртдөг болох нь тогтоогдсон бөгөөд бусад улс орны үзүүлэлтэй харьцуулахад өндөр хувьтай байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр¹⁴⁸ болон Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллагын хамтран 2021 онд хийсэн “Монгол Улс дахь Тамхины хяналтын суурь конвенцын хөрөнгө оруулалтын үр өгөөж” судалгааны дүнгээс Монгол Улс Эрүүл мэндийн салбарын нийт зардлын 8,7 хувийг тамхи, түүнээс үүдэлтэй өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд зарцуулж байна. Тамхины хэрэглээтэй холбоотой эдийн засгийн нийт дарамт нь батлан хамгаалахын салбарт жилд зарцуулж буй зардал (275 тэрбум төгрөг)-өөс 3,5 дахин их буюу 875 тэрбум төгрөг болж байгаа нь маш өндөр үзүүлэлт юм.

Монгол Улсад тамхи татахыг бүрэн хориглосон газар болон зөвшөөрөгдсөн цэг бүхий баар, рестораны агаарын чанарын харьцуулсан судалгаа хийхэд тамхи татдаг газарт нарийн ширхэглэг тоосонцор болох PM_{2,5}-ын хэмжээ тамхи татахыг бүрэн хориглосон газраас 27 дахин их буюу маш аюултай түвшинд байна. Учир нь PM_{2,5} нь амьсгалын замаар шууд нэвтэрч, амьсгал, зүрх судасны тогтолцооны эмгэгийн шалтгаан болдог тул Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Тамхины

¹⁴⁸ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр.

хяналтын суурь конвенцын дагуу дотоод орчныг тамхигүй орчин болгох зөвлөмжийг мөн ирүүлсэн байна.

Дүгнэлт

- Ихэнх хүмүүс электрон тамхийг утаат тамхинаас илүү хоруу чанартай гэж үздэг.
- Электрон тамхины дам утаанд утаат тамхинаас илүү их хүн өртөж байна. (Учир нь электрон тамхийг дотор орчинд хэрэглэх талаар ямар нэгэн эрх зүйн зохицуулалт байхгүй).
- Өдөр болгон утаат тамхи татахаас нэг удаа электрон тамхи аваад хэсэг хугацаанд татах нь эдийн засгийн хувьд илүү хэмнэлттэй гэж ихэнх хүмүүс үздэг.
- Электрон тамхины үнэр амт нь утаат тамхинаас илүү тааламжтай мөн утаат тамхинаас гарахын тулд, стрессээс ангижрахын тулд хүмүүс ихэвчлэн электрон тамхийг хэрэглэдэг.
- Тамхины хяналтын тухай хууль байдаг гэж сонсож байсан боловч ихэнх хүмүүс өөрсдөө уншиж судлаагүй мөн энэ хуулийн талаар хамаарах удирдах байгууллагаас зохион байгуулалттай үйл ажиллагаа хийдэггүй.
- Оюутан залуусын электрон тамхины хэрэглээ нэмэгдэж байгаа нь шалтгаангүйгээр найз нөхөд, бусдыг даган дуурайж, зарагдаж буй газар их, утаат тамхинаас цэвэрхэн учраас, тамхинаас гарах зорилгоор зэрэг шалтгаантай байна. (Электрон тамхи татаад утаат тамхинаас гарсан тохиолдлын судалгаа байхгүй. Харин эсрэгээрээ улам их тамхинд донтох үзүүлэлт зарим хүмүүс дээр их байдаг).
- Оюутан залуус ихэвчлэн утаат тамхинаас цэвэрхэн гэж үзэж электрон тамхи татдаг ба харамсалтай нь түүний ажиллах зарчим (шаталт) болох хүний биед маш олон хоруу чанарыг үзүүлж цаашлаад хорт хавдрын үндэс суурь болдгийг мэддэггүй.
- Утаат тамхи хэрэглэх боломжгүй учраас сургуулийн орчинд электрон тамхи хэрэглэх нь зөв гэж ихэнх оюутан залуус үздэг.
- Электрон тамхи татаж байгаа оюутан залуусыг хараад бусад оюутан, багш нар дуугүй байх нь электрон тамхийг өөхшүүлж байгаа нэг хэлбэр болж байна.
- Утаат тамхи ба электрон тамхины хяналтын бодлого манай улсад хэрэгжиж байгаа эсэх тал дээр ихэнх оюутан залуус эргэлзээтэй байдаг. Өөрөөр хэлбэл ихэнх хүмүүс хэрэгждэггүй гэсэн байр суурьтай байдаг.
- Тамхины хяналтын тухай хуульд электрон тамхийг томьёолж оруулах шаардлагатай гэж ихэнх оюутан залуус үздэг.
- Тамхинд ноогдуулах татварын хэмжээг нарийвчлан тодорхойлох нь зөв гэж ихэнх оюутан залуус үздэг.

Санал

1. Электрон, халаадаг, усан тамхи, тамхин бүтээгдэхүүний төхөөрөмжийг “Тамхин бүтээгдэхүүн”-д хамааруулж Тамхины хяналтын тухай хуульд нэр томьёоны тодорхойлолтыг оновчтой болгох;
2. Тамхин бүтээгдэхүүний (Электрон тамхи) хууль бус худалдааг илрүүлэх хяналтыг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
3. Тамхины хяналтын суурь конвенцод нийцүүлэн тамхинд ноогдуулах татварын хэмжээг тодорхойлох;
4. Тамхины (Электрон) хяналтын талаар төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор хуулийн хэрэгжилтийг зохицуулах орон тооны бус салбар дундын зөвлөл байгуулж, нэгдсэн удирдлагаар хангахтай холбогдсон зохицуулалтыг Тамхины хяналтын тухай хуульд тусгах;

5. Тамхи, электрон тамхины утаанд өртөлтийг багасгах зорилгоор барилгын дотоод орчин, орох, гарах хаалганаас 10-15 метр хүртэлх зайг тамхигүй орчин болгох, тамхи татах цэгт тавигдах шаардлагыг боловсронгуй болгож улсын төсвөөс хариуцдаг асуудлыг Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөх.

Ашигласан материал

1. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн үзэл баримтлал.
2. Тамхины хяналтын тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2005. №27.
3. Алсын хараа-2050. Монгол Улсын урт хугацааны бодлого.
4. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.
5. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл.
6. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр.

Хавсралт

Сэдвийн хүрээнд ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн нийт 50 суралцагч оюутнаас 12 асуулт бүхий судалгааг авч дүгнэсэн. Үүнд:

Асуулт 1

Д/д	Та утаат тамхи, электрон тамхины аль нь илүү хортой гэж боддог вэ?	Хариулсан байдал
1	Утаат тамхи	35
2	Электрон тамхи	9
3	Хоёулаа хортой	6

Асуулт 2

Д/д	Таны эргэн тойрны хүн чинь электрон тамхи хэрэглэдэг үү?	Хариулсан байдал
1	Тийм	45
2	Үгүй	5

Асуулт 3

Д/д	Өдөр болгон утаат тамхи татах, харин нэг удаа электрон тамхи аваад хэсэг хугацаанд татах хоёрын аль нь илүү эдийн засгийн хэмнэлттэй вэ?	Хариулсан байдал
1	Электрон тамхи	27
2	Утаат тамхи	23

Асуулт 4

Д/д	Оюутнууд ямар шалтгаанаар электрон тамхи хэрэглэдэг гэж боддог вэ?	Хариулсан байдал
1	Үнэр амт нь таалагддаг болохоор	10
2	Утаат тамхи хэрэглэх боломжгүй тул	2
3	Тамхинаас гарахын тулд	2
4	Стрессээс ангижрахын тулд тустай байдаг тул	8
5	Найз нөхдийн ятгалгаар	2

6	Догь харагдах гэж	1
7	Бүгд	25

Асуулт 5

Д/д	Та тамхины хяналтын тухай хууль мэдэх үү?	Хариулсан байдал
1	Мэднэ	23
2	Мэдэхгүй	27

Асуулт 6

Д/д	Оюутан залуусын дунд электрон тамхины хэрэглээ яагаад ихсэж байна гэж та бодож байна вэ?	Хариулсан байдал
1	Найз нөхөд бусдыг даган дуурайж	19
2	Тамхинаас гарах зорилгоор	4
3	Утаат тамхинаас цэвэрхэн учраас	3
4	Стрессээс ангижрах гэж	3
5	Зарагдаж буй газар их	20

Асуулт 7

Д/д	Та электрон тамхины ажиллах зарчмыг мэддэг үү?	Хариулсан байдал
1	Мэддэг	14
2	Мэддэггүй	36

Асуулт 8

Д/д	Утаат тамхи хэрэглэх боломжгүй учраас сургуулийн орчинд электрон тамхи хэрэглэх нь зохимжтой юу?	Хариулсан байдал
1	Тийм	42
2	Үгүй	8

Асуулт 9

Д/д	Электрон тамхи татаж байгаа оюутан залуусыг хараад бусад оюутан, багш нар дуугүй байх нь зөв үү? Таны бодол?	Хариулсан байдал
1	Зөв	25
2	Буруу	25

Асуулт 10

Д/д	Утаат тамхи ба электрон тамхины хяналтын бодлого манай улсад хэрэгжиж байгаа эсэх талаар саналаа чөлөөтэй илэрхийлнэ үү?	Хариулсан байдал
1	Хэрэгждэг	6
2	Хэрэгждэггүй	40
3	Мэдэхгүй байна	4

Асуулт 11

Д/д	Тамхины хяналтын тухай хуульд электрон тамхийг томьёолж оруулах шаардлагатай гэж бодож байна уу?	Хариулсан байдал
-----	--	------------------

1	Шаардлагатай	46
2	Шаардлагагүй	4

Асуулт 12

Д/д	Тамхинд ноогдуулах татварын хэмжээг нарийвчлан тодорхойлох нь зөв үү?	Хариулсан байдал
1	Зөв	47
2	Буруу	3